

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

ЖОН ба ЛИЗА
БИВЭР



ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ СУРГАЛТЫН
DVD ДОТОР БУЙ МАТЕРИАЛ

Эрхэм анд минь,

Энэ номыг та хүлээн авсанд би маш их баяртай байна! Та бол тэнгэрийн дивсажингийн баяр бахдал. Бурханы дээд хүсэл тэмүүлэл бол та түүнийг таньж мэдэж, тэр танд өөрийгөө таньж мэдүүлэх юм. Бурханыг таньж мэдэх бүр Бурхан танд өөрийн зүрх сэтгэлийн нууцнуудыг илчилж, тантай хамтрагч болохыг хүсдэг. Коринчуудад хандсан захидалдаа Паул, та бид бол Христийн элчин сайд, түүний төлөөлөгч, үг сургаалыг нь дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэгч гэж бичжээ.

Бурханы мөн чанарыг ойлгоход гэрлэлт маш чухал. Христ өөрийн сүйт бүсгүй болсон чуулгантай харилцах харилцааг ойлгоход ариун нандин холбоо болох гэрлэлт бидэнд ихийг зааж өгдөг. Аливаа нэгдэлд (хүнд байдал, бие биеэ гомдоох, эсвэл алдаа зөрчил байдаг шиг) хайр, баяр хөөр, амар тайвныг олох өч төчнөөн боломж байдаг.

Эзэн Бурхан бидний зүрхийг хөдөлгөж, дэлхий даяар байгаа удирдагч нарт энэ сургаалыг хуваалцахыг ятгасан юм. Зүрх сэтгэлээсээ өгч буй энэ бэлгийг минь баяр хөөртэйгээр хүлээн аваасай гэж хүсч байна. Энэ сургаал хэрэгтэй байгаа, тусламж хэрэгтэй байгаа бүх хүнд тарааж, зааж өгөөрэй. Мөрөөдлийн хайрыг тань Бурхан ивээх болтугай!

Бидний гэрлэлт тийм ч дардан замаар яваагүй ч, Бурхан бидэнд итгэмжтэй байсан. Гэрлэлтээр Бурхан бидний амьдралыг бүхий л талаар тэлсэн юм. Бурхан таны амьдралд ч тийм зүйл хийх болно. Номын хуудас бүрээс та урам ба үнэнийг олж мэдэх болно. Тэгээд бусдад гэрлэлтийнхээ сайхан түүхүүдээ хуваалцаарай.

Энэ сургаал таны амьдралд болон танай гэр бүлд ямархан нөлөө өгсөнийг бид үнэхээр их сонсохыг хүсч байна!

Христийн ах дүү,

Жон ба Лиза Бивэр



John Lisa



JohnBevere@ymail.com

LisaBevere@ymail.com

Messenger
International
MessengerInternational.org



ГЭРЛЭЛТИЙН
ТҮҮХ

ЖОН ба ЛИЗА
БИВЭР

Story of Marriage by John Bevere and Lisa Bevere Mongolian
© 2015 Messenger International
www.MessengerInternational.org

Originally published in English as Story of Marriage
Additional resources in Mongolian by John & Lisa Bevere
Are available for free download at: www.CloudLibrary.org
To contact the author: JohnBevere@ymail.com, LisaBevere@ymail.com

*This book is a gift from Messenger International,
the ministry of John and Lisa Bevere*

Гэрлэлтийн Түүх, Жон ба Лиза Бивэр
© 2015, Messenger International
www.MessengerInternational.org

Энэхүү номыг Христэд удирдагч нарт ҮНЭГҮЙ ТАРААХ зорилгоор хэвлэсэн бөгөөд худалдан борлуулахыг хориглоно. Номын зохиогч Жон Бивэр Монгол чуулганд бэлэг болгов.

Монгол хэл дээрх бусад материалыг www.CloudLibrary.org
цахим хуудаснаас үнэгүй татаж авах боломжтой.

Зохиогчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com, LisaBevere@ymail.com

Библийн ишлэл: Ариун Библи
© 1995, 1996, 1997, 1998, 1999, 2000 Монголын Библийн Орчуулгын Хороо
© 2004, Ариун Бичээс Библийн нийгэмлэг

Талархал

Насны минь баясгалан болсон хөвгүүддээ болон тэдний хань ижил, хонгор ач нар нартаа хязгааргүй баярлалаа. Үнэндээ та нарын төлөө л аав, ээж хоёрынх нь гэрлэлтийн түүх бичигдэх болсон юм шүү дээ. Та нарыг төрж, өсч өндийж, бие биеэ амь шигээ хайрлахыг харах нь аав ээжийнх нь сэтгэлийн жаргалан билээ.

Зоригт>Addison минь, чиний хувь нэмрийг гагцхүү өнө мөнх гэдэг хугацаа л харуулна. Чамгүйгээр бид хоёр энэ бүхнийг хийх нь бүү хэл, үнэнээс холуу хоцрох байсан. Бусдын амьдралыг өөрчлөх зүйл бүтээхийн төлөө үгсийг маань бичээсээр жинлэж, мятрашигүй тэмцсэнд баярлалаа.

Хонгор, цэцэн Жэйлин минь, чиний хайр хүргэм хандлага, онцсайн хичээл зүтгэл “Гэрлэлтийн түүх” номыг маань үнэхээр цэцэглүүлсэн бөгөөд энэ талбарт тариалсан бүхнээ элбэг баянаар хураах болтугай охин минь чи.

Винсент, Аллисон хоёр оо, энэ номын судлал хэсгийг урлахад хичээн зүтгэсэнд баярлалаа. Та хоёрын үйлс номыг маань машид баяжуулжээ.

Мессенжер Интернэйшинэл байгууллагынхаа гишүүд болон түншүүддээ өнөөг хүртэл бидэнтэй хамт зогсонд гялайлаа. Есүс Христийн сүр жавхланта Сайн мэдээг даян дэлхийд хүргэх аян замд мордсон цагаас өнөөг хүртэл та нараас давж гарах үнэнч хүмүүс, жинхэнэ нөхөд олноогүй билээ.

Тэгээд мэдээж яндашигүй хайрын тань төлөө Бурхан Аавдаа баярлалаа. Бидний төлөө үнэт амиа өгсөн Хаан Есүсдээ баярлалаа. Гайхамшигт хүч чадал, тайвшрал, сургаал, дотно харилцааны тань төлөө Ариун Сүнсэндээ баярлалаа. Биднийг хэзээ ч орхидоггүй бас хаядаггүйд баярлалаа, Бурхан минь баярлалаа!

АГУУЛГА

| | |
|----------------------------------|-----|
| Интерактив номын тухайд | 9 |
| Танилцуулга | 11 |
| 1. Анхны төлөвлөгөө | 13 |
| 2. Бариагаа харж эхлэ | 51 |
| 3. Тавцангаа цэвэрлэ | 93 |
| 4. Босогтун, байгуулагтун! | 139 |
| 5. Дотносол | 181 |
| 6. Шинээр эхлэ | 225 |
| Хавсралт | 265 |

Интерактив номын тухайд

Энэхүү номыг бусад номтой л адил хуудас хуудсаар нь уншина. Гэхдээ амьдралдаа нэг зүйл ч гэсэн аваад үлдэхийн тулд интерактив хэсгийг нь давхар судлахыг уриалж байна.

Номын бүлэг тус бүрийн ард таван өдөр хийх судлал хэсэг бий. Та нэг өдөрт нэгийг гүйцэтгэж болно эсвэл өөрийнхөө дур сонирхол, боломжоор хийж болно. Харин бүлгээрээ судлаж буй хүмүүст долоо хоног тутам нэг бүлгийг таван өдрийн судлалтай нь хамт багтааж хийхийг санал болгож байна.

Хэрэв та “Гэрлэлтийн түүх”- ийг сургалтын хөтөлбөрөөр нь судлаж байгаа бол, долоо хоног тутмын видео юмуу аудио хичээлийг бүлгээрээ сонсоод, дараа нь Хэлэлцэх асуултыг хоорондоо ярилцана уу. Харин үүнийхээ дараа номынхоо тухайн бүлгийг уншиж, арынх нь судлалыг гүйцэтгэнэ үү. Номын бүлэг бүрийн хойно таван өдрийн судлал бий. Харин судлалын хойно бүлгээрээ хэлэлцэх асуулт бий.

За, амжилт!

Танилцуулга

“Яахаараа дахиад л гэрлэлтийн талаар өгүүлнэ вэ?” гэж асуумаар байна уу? Бид ч анх яг ингэж бодсон юм.

Үнэндээ энэ ном гурван шалтгааны улмаас төрсөн билээ. Нэгдүгээрт- Бурхан биднээс хүссэн тул. Хоёрдугаарт- үр хүүхэд бас ажилчид маань хүссэн тул. Гуравдугаарт- та нар хүссэн тул.

Гэрлэлтийн талаар өгүүлсэн, сайхан сайхан ном зах зээлд уул овоо шиг л их байна. Бид ч тэдгээрээс ач тус хүртсэн. Гэхдээ жаахан ойроос ажбал, тэнд нэгэн цав үзэгдэв. Юув гэтэл, тэдгээр номын дийлэнх хувийг нэг бол эмэгтэй, нөгөө бол эрэгтэй хүн бичсэн байдаг. Харин мундаг гэрлэлт нь мундаг түншлэлийн бүтээгдэхүүн байдаг тул энэ сэдвээр хослон өгүүлэх нь үлэмж чухал гэдэгт бид итгэж байна.

Түүнчлэн гэрлэлт бүр өөр өөр түүхтэй. Бид хоёр хоёулаа тун өөрийнхөөрөө хүмүүс гэдгээ хэлэх хэрэгтэй. Гал голомтоо бадраасан гуч гаруй жилийнхээ хугацаанд бид өөрийн гэсэн онцгой замаа л туулсан. Туулсан зам маань онцгой байсан болохоор үзэл бодол маань ч онцгой байх нь гарцаагүй.

Цаашилбалгэрлэлт нь чөдөрбишгэдгийг эрчүүд, эмэгтэйчүүдэд ойлгуулмаар байна. Хүн бүр өөртөө таарч, зохицсон хослолтойгоо л дэгжин харагддаг шиг, хүн бүр өөрийнхөө арга ухаанаар өөртөө зохицсон, тэнгэрийн зорилгод нийцсэн гэрлэлтийг урлан цогцлооно.

Энэ номыг хэнд зориулав?

Энэхүү ном нь гэрлэж амжаагүй яваа, амжиж гэрлэхээр яваа мөн гэрлэлтийнхээ талаар таньж мэдье гэсэн хүн бүрт зориулагдав.

Учир нь өнөөдөр бид дураа хүрбэл нийлчихдэг, дургүйгээ

хүрбэл салчихдаг, гэрлэлтийн түүхэн хуудсаа нээхээс ч айдаг болчихсон эрин цагт аж төрж байна. Гэхдээ хүний өнгөрсөн амьдрал ирээдүйг нь тодорхойлохгүй.

Мөн зарим хос хамгийн хүнд түүхэн цаг үе дээрээ яваа байж ч болох. Гэхдээ тийм байсан ч номоо бүү хаагаарай. Хуудсаа эргүүлэхэд чинь бид туслая.

Түүнчлэн хайрын түүх нь хэзээ ч төгсөхгүй хэмээн итгэсэн боловч, салалт юмуу үхэл хагацлаар хань ижлээ алдаж, түүхэн хуудсаа тасдуулчихсан хүмүүс ч байна. Гэхдээ тэдний түүх ч дуусаагүй.

Энэ ном нь гэрлэлтийн нөхцлийг дэлгэрэнгүй өгүүлсэн тайлбар толь биш юм. Гэрлэлтийн талаар маш олон боть ном бичиж болох бөгөөд бид хоёр гэрлэлтийн бүх асуултад хариулж чадахгүй гэдгээ шударгаар хэлье. Тийм боловч гуч гаруй жил бичилцсэн, өөрсдийнхөө түүхийг сайнтай муутай, алдаатай оноотой нь аль болох илэн далангүй үзэглэхээр шийдлээ. Бидний туулсан амьдралын сургамж бусдад ач тусаа заавал өгнө.

Эцэст нь хэлэхэд, бид хоёрын гэрлэлтийн түүхээр Есүс бахархдаг гэдэгт бид эргэлздэггүй. Бидний гэрлэлтийн түүхэн уран зураг нь Түүний хайраар туурвигдсан буюу. Номын маань хуудас бүр ганц бие, гэр бүлтэй, хөгшин залуу бүх хүнд итгэл, найдвар, хайрыг дахин бадраахын төлөө бид залбирна. Тиймээс айж яана, дахин мөрөөд!



————— НЭГ —————

АНХНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЭЗЭН Бурхан тэнд янз бүрийн моддыг ургуулсан нь харахад үзэсгэлэнтэй, идэхэд сайхан байв. Тэр цэцэрлэгийн гол дунд бас амин мод хийгээд сайн мууг мэдүүлэгч мод байжээ.

— Эхлэл 2:9

Нэгдүгээр өдөр

Эрт урьдын цагт хоёр модыг хөвөөлөн саглайсан нэгэн их цэцэрлэг байжээ. Энэ цэцэрлэг нь энгийн цэцэрлэг байгаагүйг та бид мэднэ. Тэнд ялзрал, зовлон байхгүй. Едений хөндийгөөр сүлэлдэн сүлжилдэн урсах гол мөрөн нь цэцэрлэгийн оршин суугчдыг болор тунгалгаараа ундаалдаг байв.

Ийм газар ургасан мод юутай сүрлэг, сүрдэм байсныг төсөөлөхөд бэрх юм. Мод бүр баялаг хөрсөндөө үндэслэн, шимийн усаар шавьшуулж, илчит туяагаар илбүүлнэ. Цэцэрлэгт олон мод сүндэрлэвч, Бичээс “амийн” болоод “сайн мууг

мэдүүлэгч” хэмээгч хоёр модны талаар л өгүүлжээ. Энэ хоёр мод нь хоёулаа л гэмээр бузарлагдсан газар дэлхий хэзээ ч хуулбарлаж чадахааргүй, төгс төгөлдөр, хосгүй орчинд ургаж байсан ч, нэг нь амийг, нөгөө нь үхлийг даллаж байв.

Энэ түүхийг та мэдэх байх. Учир нь гэрлэлтийн түүх бүхэн нь Едений тэр хоёр модоос эхтэй билээ. Гэрлэлт олон талаараа амийн модтой адил юм. Гэрлэлт нь улирал бүр өөр өөр ханштай өсөх бөгөөд бат бэх үндэстэй бол бүр сайн өсдөг. Гэрлэлт нь үр жимстэй болон ургацгүй улирлын аль алийг үзнэ. Хэдийгээр гэрлэлт бүр төрөлх уур амьсгал, улирлын солилцоо, дэгдэх шуургыг туулдаг ч, нөгөө талаас гэрлэлт нь хүнийг амьдралын шуурганаас нөмөрлөх нөмөр газар болдог юм.

Энэ ном ч нэг талаараа модны амьдралын түүх гэж хэлж болно. Модны дотор олон тооны цагирган хээ байдаг бөгөөд хээ нэг бүр нь тухайн модны амьдралын түүх юм.

Дунд сургуульд бид модлог ургамлын талаар судлахдаа, модны цагирган хээгээр насыг нь барагцаалан тооцоолж болдгийг сурсан. Бид хоёр модонд хайртай. Тиймээс судлаачийн хэмжээнд хүрэхгүй ч, модны насыг дөхүүлээд тооцоолчихож чадна. Гэхдээ мод судлаач нар модны хээгээр тухайн модны насыг байтугай, туулсан амьдралыг нь ч нарийн хэлж чадна. Мэргэжлийн нүдээр харахад, модны цагирган хээ бүр нь түүх өгүүлдэг ажээ. Тухайлбал тэр мод дулаан эсвэл хүйтэн өвлийг давсан, хур ихтэй эсвэл ган гачигтай зуныг туулсан эсэхийг хэлдэг. Нарийн шинжилбэл ямар нэгэн гэмтэл авсан эсэх, хортон шавьжинд идэгдсэн эсэхийг ч мэдэж болно. Модны цагирган хээ бүр нь онцгой мөн чанар, загвартай дөрвөн улирлаас бүтсэн нэг жилийг илтгэнэ.

Гэрлэлтийн жил бүрийг модны нэг цагирган хээгээр төлөөлж болно. Гэрлэлтийн ой нь тухайн жилийн төгсгөл бас шинэ оны эхлэлийг тэмдэглэнэ.

Таны түүх

Бидэнтэй хамт аялалаа эхлүүлэхдээ, таны түүх (эсвэл ирээдүйн түүх чинь) гагцхүү таных гэдгийг бүү мартаарай. Амьдрал эсвэл гэрлэлт бүр нь баяр хөөр, ялалт, бэрхшээлийн цуглуулга юм. Олон

чуулган олон арван жил гэрлэлтийн бүх асуудлыг “Эхнэрүүд нь захирагд. Нөхрүүд нь хайрла.” гэсэн ганц л жороор шийдэх гэж оролдсоор иржээ. Энэ нь хэдийгээр үнэн бөгөөд үнэ цэнэтэй ч, гэрлэлтийн амьдрал тус бүр нь өөрийн гэсэн давтагдашгүй хээтэй учраас гэрлэлтийн амьдралыг хэзээ ч ерөнхий төлөвлөгөөгөөр байгуулдаггүй юм.

Ингэж харья л даа. Байшин бүрийн барилгын зураг төсөл нь суурь, хана, дээврээс бүтдэг боловч захиалагчийн онцгой хэрэгцээ, хүслийн дагуу архитектор бүтээлч сэтгэлгээгээ ашиглан, байшингийн дотоод заслын зургийг бүтээдэг. Гэрлэлтийн амьдрал ч яг ийм байдаг. Бид гэрлэлтийн амьдралаа тааллаараа урлан бүтээх эрх чөлөөтэй хүмүүс. Эзэмшил бүр нь өөр өөр байдаг бөгөөд улирлаа даган амьдрал нь ч өөр байна. Жишээлбэл бид хоёрын гэрлэлт үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүрэг давамгайлсан улирлаа ардаа орхиж байна. Өөрөөр хэлбэл манай гэрт урьдынх шигээ олон ор байхаа болино гэсэн үг. Иймэрхүү өөрчлөлт нь улирал солигдохтой л адил хэвийн үзэгдэл, хэвийн өөрчлөлт юм.

Таны гэрлэлтийг Бурханы дуудсан бүхэн рүү урагшлуулдаг мөнхийн, төгс үнэ цэнэ бий. Бурхан гэрлэлт бүрт хайр, хүндэтгэл, баяр хөөр, захирагдах, хангамж, итгэмжтэй байдал, арчлан тордох, дотносол, зэрэг хамаг л сайн сайхныг хүсдэг. Гэхдээ гэрлэлтийн амьдралыг цогцлоох эдгээр тоосгоо хэрхэн өрөхөө та өөрөө л шийднэ. Бурхан үндсэн зарчмыг нь гаргадаг ч, нарийн ширийн зүйлсийг нь таны мэдэлд үлдээдэг.

Бурхан олон төрөл зүйлд дуртай. Үүнийг бүтээлээс ч харж болно. Бүх гэрлэлт нэг л маягаар хэлбэрших ёстой гэдэгт бид итгэдэггүй. Орчин цагт эхнэр, нөхөр хоёр хоёулаа хөдөлмөрлөж (2012 онд Америкийн хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн 60% нь ажил хөдөлмөр эрхэлж байсан), гэргий нь нөхрөөсөө өндөр цалинтай байх нь элбэг болжээ. Эмэгтэй хүн орлого олж байна гэдэг нь тэрбээр захирагдахгүй байна, харин нөхөр нь удирдахгүй байна гэсэн үг биш юм. Энэ нь ердөө л тэд хоёулаа гэр бүлдээ орлого оруулж, тэр айлын аж амьдрал өвөө, эмээгийнхээ амьдралаас хавьгүй дээр болно гэсэн үг юм.

Бид хоёрын амьдрал ч яг ийм. Бид хоёулаа ажил хийдэг бөгөөд хоёулаа л хүмүүсийг удирддаг. Заримдаа бид хамтдаа ажилладаг

(энэ ном дээр ажилласан шигээ), заримдаа тус тусдаа ажилладаг ч, гэрлэлтийн маань зорилго болон суурь үнэ цэнэ өөрчлөгдөхгүй. Орлогын хэмжээнээс болж эхнэр нөхрийн харилцаа маань өөрчлөгдөхгүй.

Еден цэцэрлэгт Бурхан Адам, Ева хоёрт үр жимстэй байж, үржихийг айлджээ. Тэрбээр Еваг гэрийн мухар сахиад, Адамын үржүүлсэн бүхнийг зохицуул гээгүй. Сургаалт үгс 31 дээр гардаг эмэгтэй нь гэрээ ч, ажлаа ч гялалзуулдаг. Ажил хийх нь танай гэр бүлд зохицож байвал, айлтгүй хий! Эсвэл нэг нь үр хүүхдээ өсгөх гээд юмуу эсвэл зүгээр л гэртээ суухыг хүсч болно. Энэ хоёр хандлагын аль нь ч буруу биш юм.

Бусдын амьдралд хэрэгжиж болж байгаа зүйл бидний амьдралд ч бас хэрэгжиж болох юм шиг санагддаг. Гэхдээ хүн бүр өөрийнхөө фронтод өөрийнхөө онцгой тулааныг хийдэг. Бид таны гэрлэлтийг хүчтэй байгаасай гэж хүсч байна. Энэ нь та бусдын мөрөөдлийн гэрлэлтийг биш, өөрийнхөө мөрөөдлийн гэрлэлтийг босгон байгуулах эрхтэй гэсэн үг.

Таны гэрлэлт дэлхий бүтээгдэхээс ч өмнө таны төлөө Бурханы урлан бүтээсэн, тийм л гэрлэлт болох болтугай.

Хоёрдугаар өдөр

Хүнд хэцүү түүхэн өдрүүд ирэхэд

Аялалын хэсэгхэн хугацаа нь түүхийг бүрэн эхээр нь өгүүлж чадахгүй. Тавин жилийн гэрлэлтийн амьдрал нь тавин жилийн зовлон эсвэл тавин жилийн аз жаргал байж болох ч, ихэвчлэн тавин жилийн жаргал зовлон хослосон түүх байдаг.

Энэ номын хавтсан дээрх зургийг харбал, модны цагирган хээ бүрээр модны диаметр өсч байгааг харж болно. Тухайн жил нь хүнд хэцүү эсвэл сайн сайхан жил байсан эсэхээсээ үл хамааран, цагирган хээ бүр нь модны түүхийг баяжуулжээ.

Хүнд хэцүү урамгүй үеэ бүү нүд үзүүлрлэ. Харин ч хүнд хэцүү болох тусам, Бурханы нигүүсэлд улам шигдэж, таны сэтгэл санааны болон сүнсний багахаан хүчин чадлыг Бурханы тэнгэрлэг хүч яаж тэлж сунгахыг үз. Бид хоёр гуч гаруй жил

ханилахдаа, тухайн үедээ тас харанхуй харагдсан тэр л үе хожим замыг маань гэрэлтүүлэх бамбар болдгийг сурсан билээ. Тэр л үе биднийг өндийж босоод, бат зогсоход сургадаг. Одоогийн зөрчил чинь таны амьдралын хамгийн аугаа цаг үе болж хувирахыг хэн байг гэхэв.

Гэрлэлтийн Сүнс

Гэрлэлтийн түүх рүүгээ харайж орохоосоо өмнө зорилгоо мэдэх цаг гаргая. Гэрлэлт гайхамшигтай зүйл гэдэг нь тодорхой ч, заримдаа маш зовиуртай үйл явц байдаг. Зовлонгийн зорилгыг мэддэг хүн зовлонд тэвчээртэй ханддаг. Жишээлбэл таныг тарчлааж байгаа өвчтэй шүдээ эмчлүүлэхийн тулд та хүссэн хүсээгүй өвчтөний сандал дээр тэвчээртэй суудаг. Гэрлэлтийн амьдралд далайн эрэг дээрх наран шарлагийн сандал дээр хэвтэхээсээ илүү шүдний эмнэлгийн сандал дээр суух мэт санагдах өдөр олон бий. Эсвэл хараахан сууж үзээгүй байгаа бол, удахгүй сууна. Ийм хэцүү үед зорилгоо мэдэх нь хамгийн чухал юм шүү.

Өнөөдөр гэрлэлтийн зорилго бүдгэрсэн бөгөөд хүмүүс яах гэж гэрлэсэнээ мэдэхгүй учраас хүчит давалгаа завийг нь дайвалзуулах үед үтэр түргэн үсэрчихдэг. Харин зарим нь гэрлэлтийн институцийг бүхлээр нь өөрчлөх ёстой гэдэг. Зарим нь бүр “Гэрлэлтийн гэрээнд тодорхой хугацаа заасан заалт оруулах ёстой. Насан турш гэдэг чинь арай л удаан хугацаа байна” гэдэг. Хүн маргааш ч юу мэдрэхээ мэдэхгүй байж, хорин жилийн хойтох хайр сэтгэлийн төлөө өнөөдөр шийдвэр гаргана гэдэг чинь дэндүү хийсвэр гэсэн санал ч дэвшүүлдэг.

Хипхоп OutKast хамтлаг “Хатагтай Жэксон” гэдэг дуундаа яг энэ үзлийг хэлжээ:

Таны охин бидний дунд
 Нэжгээд юм болоод байна.
 Та “хүүхдийн явдал” гэдэг ч,
 Бид “жинхэнэ хайр” гэнэ.
 Мөнхөд ийм байна гэж найдъя.

Хүн зугаалгад бэлдэж чадах ч,
тэнгэрийн аашийг хэн таахав.

Энэ бол охиныг нь жирэмсэн болгочихоод хаячихсан залуу охины ээжээс хүлцэл өчиж буй дуу ажээ. Энэ дуу нь өнөөдөр дийлэнх хүмүүсийн хайр сэтгэл, гэрлэлтэд хандах хандлагыг яг онож хэлдэг нь даанч харамсалтай: тэр хүн намайг сайн сайхан болгох ёстой. Ийм үзэл бодолтой хүмүүс юу нь зөв, юу нь буруу болохыг мэдрэмжээрээ л шийддэг. Сайхан санагдахаа больбол, ямар нэгэн өөрчлөлт хийх хэрэгтэй болжээ гэсэн үг. Учир нь хүн улирлын өөрчлөлтийг хянаж чадахгүй ч, сэтгэл мэдрэмжээ хянаж чадна. Эсвэл OutKast хамтлагийн хэлснээр, хүн зугаалгад бэлдэж чадах ч, тэнгэрийн аашийг таахгүй ш дээ.

Бас гэрлэлтийн тодорхойлолтыг цаг хугацааны аяст тааруулахыг хүсдэг хүмүүс байна. Тэд “Бид яагаад арай жаахан уян хатан байж болохгүй гэж? Хэрэв энэ институци оршин тогтох ёстой л юм бол, хоёр эрэгтэй, хоёр эмэгтэйг хооронд нь нэгдүүлж өргөжүүлэх хэрэгтэй гэдэг. Зарим одод “гэрлэлтийн параметрийг өргөжүүлж, хоёр эрэгтэй, хоёр эмэгтэйг хооронд нь гэрлэхийг зөвшөөрдөг болохоос нааш хайртай хүнтэйгээ гэрлэхгүй” хэмээн “сүрдүүлж” байна. Гэрлэлт нь заавал өсч төлөвшиж, дасан зохицож байх ёстой ч, гэрлэлтийн тодорхойлолт болон гол дүр хэзээ ч өөрчлөгдөх ёсгүй.

Тэгвэл бид хэнийг сонсох вэ? Хэн гэрлэлтийг тодорхойлох юмуу дахин тодорхойлох эрхтэй вэ? Гэрлэлт бидний амьдралд хэрхэн нөлөөлдгийг хэлэх эрхтэй хүн нь хэн бэ?

Үүнийг хийх эрхтэй цорын ганц Нэгэн нь Бурхан гэдэгт бид итгэдэг. Мессеж Библийн хувилбарын Малахи 2:15-р ишлэлд гэрлэлтийг бүтээсэн нэгэн нь Бурхан гэдгийг хэлдэг.

“Та нар биш, Бурхан гэрлэлтийг бүтээсэн” гэдгийг энэ ишлэл хэлээд өгчээ. Тэрбээр гэрлэлтийг бүтээгээд зогсохгүй, хоёр хүн нэг болох энэ үйл явцад Өөрийн биеэр оролцсон. Гэрлэлт бүр энгийн болоод ярвигтай олон янзын бүтцээс бүрддэг ч, гэрлэлтийн хамгийн нарийн ажиллагааг Бурхан л Сүнсээрээ ажиллуулж амьдруулдаг юм.

Мессеж Библийн хувилбарын Малахи 2:15 дээр “Бурханы Сүнс гэрлэлтийн эд эс бүрт оршдог” гэдэг. Өөрөөр хэлбэл Бурхан

биднийг гэрлэлтээ бүтээлчээр урлахыг зөвшөөрдөг боловч, гэрлэлт гэж юу болох, үүнд хэн багтахыг мэдэх Бүтээгчийн бүх эрх нь Бурханд л хадгалагдана. Гэрлэлт нь Бурханы зөвшөөрөл болон оролцоогүйгээр бүтээгдэх аргагүй бөгөөд Тэрбээр суурийн тухайд маш тодорхой хэлжээ: “Учир нь ЭЗЭН Би өөрчлөгдөшгүй” (Малахи 3:6).

Эргээд Еден рүү

Бүгдээрээ эргээд Еден рүү явцгаая. Хоёр модыг санаж байна уу? Адам, Ева хоёр бүх моддын дундаас ганцхан сайн мууг мэдүүлэгч мэдлэгийн модны үр жимсийг идэх эрхгүй байв. Үүний үр жимсийг идэх аваас үхэх аюултай хэмээн Бурхан тэдэнд анхааруулжээ. Гэхдээ тэднийг Бурханы сэрэмжлүүлэгт дүлий хандахад хүргэсэн ямар нэгэн зүйл модонд байсан тул тэд хориотой жимсээс иджээ.

Тэгээд тэр модны жимс нь хүнс болоход шимтэй, нүд булаам, мэргэн ухаантай болгочихмоор, шунал хөдөлгөм сайхан харагдсан тул тэр эмэгтэй түүнээс авч иджээ. Тэр бас өөртэйгөө хамт байсан нөхөртөө өгч, тэр ч иджээ. (Эхлэл 3:6)

Мэдээж цэцэрлэгт сайн сайхан, нүдэнд таатай мод олон л байсан байж таараа. Гэхдээ хүнийг Бурханы зиндаанд аваачих чадалтай модны үр жимс гэхээр арай л өөр байв. Өөрт нь өгөгдсөнөөс хавьгүй илүү ямар нэгэн зүйл байх л ёстой гэж Ева боджээ. Тэр эмэгтэй хүрэх ёсгүй юмдаа хүрээд (Бурханы дайтай юм), эцэст нь эзэмшиж чадах байсан зүйлээ (цэц ухааныг) алджээ.

Адам, Ева хоёр Бурханы нөлөө, эрх мэдэлд захирагдахгүйгээр Бурханы дайтай болохыг хүсчээ. Тэд тоглох ёсгүй дүрдээ тоглосон нь хожим тэдний үр садын нэгний хийснээс тэс өөр сонголт байв.

Тэрээр хэдийгээр Бурханы мөн чанараар оршин байсан боловч, Бурхантай тэгш байх явдлыг Өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй... (Филиппой 2:6)

Адам Ева хоёр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэнээс биш, Бурханы зиндаагаар бүтээгдээгүй. Аль нэг зүйлийн дүр төрх нь тухайн бүтээлийг бүхлээр нь илэрхийлэх бус, харин тусгалыг нь л харуулна. Бурханы зиндаанд хүрнэ гэсэн худал амлалт нь эрэгтэй, эмэгтэй хоёр хүнд аль нэг зүйлийг олж авах мэт сэтгэгдэл төрүүлсэн боловч, хэрэг дээрээ тэд хамаг юмаа алдаж байсан юм. Тэд цэц ухааныг олох биш, худал хуурмагийг олжээ.

Хууртагдсан, дуулгаваргүй хос цэцэрлэгээс хөөгдөв. Тэд амийн модны үр жимст дахиж хэзээ ч хүрч чадахгүй. Амийн модны үр жимсгүйгээр Адам, Ева хоёр үхэх тавилантай болов. Тэд үхсэн бөгөөд цэцэрлэгээ алджээ. Гэхдээ тэр хоёр үр удмаараа дамжин амьдарсан гэж хэлж болно. Учир нь бид тэдний үр удам. Эрчүүд, эмэгтэйчүүд ганц ганцаараа дэлхий дээр мөнх наслахгүй ч, гэрлэлтээр дамжуулан үр удмаа үлдээх замаар амьдралаа залгамжлуулдаг.

Христийн загалмай нь эдүгээ бидний төгс амийн мод болсон юм. Загалмай цэцэрлэгт алдагдсан бүхнийг эргүүлэн сэргээх чадалтай. Бурханлаг гэрлэлт нь амьдрал тэтгэгч мод болж чадна. Тиймээс л бид гэрлэлтийг нандигнаж, сүнслэг чанарыг нь сахиж, бие биеэ халуунаар хайрлаж байх нь Бурханд амин чухал байдаг.

Еден цэцэрлэгийн үе болон орчин үеийн холбоо тасарсаныг ойлгохын тулд харилцааны мэргэжилтэн байх шаардлагагүй юм. Маш олон гэрлэлт амьдрал тэтгэгч мод шиг байж чаддаггүй. Салалт, завхайрал, гуниг гутрал, жаргалгүй байдал, гомдол нь бидний гэрлэлт, гэр бүлийг эрэмдэглэдэг. Хайранд гарсан энэ ан цавын улмаас хүмүүс сүүлдээ гэрлэлтийн зорилгыг ч, ер нь яах гэж гэрлэснээ ч мэдэхээ больж, зарим нь гэрлэлтийг хүлцэж амьдрахаас өөр хүсч горьдох юмгүй болжээ. Тэдний хувьд гэрлэлт нь амар амгалангийн тэнгэрийн улс биш, аюумшигт там болсон аж.

Гуравдугаар өдөр

Хайрын ундарга

Учир нь «Бурханы нэр та нараас болж харь үндэстнүүдийн дунд доромжлогддог» гэж бичигдсэн байдаг. (Ром 2:24)

Христийн Бие амьдарсан шиг амьдрахгүй, хайрласан шиг хайрлахгүй бол, хүмүүс Бурханы нэрийг гутаан доромжилно. Өөрийгөө Христийн элчин сайд, “Христэд итгэгч” гэдэг хүний хувьд энэ нь гайхаж балмагдаад байх мэдээ биш юм. Элч Паул:

Яагаад гэвэл Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, хүмүүсийн гэм бурууг үл харгалзсан бөгөөд эвлэрлийн үгийг бидэнд даалгасан билээ. Иймээс бид Христийн төлөөх элчин сайд нар юм. Бурхан биднээр дамжуулж ятгаж байгаачлан бид Христийн төлөө та нараас гуйя. Бурхантай эвлэрцгээ. (2Коринт 5:19-20) гэж хэлжээ.

Элчин сайд нь онц бөгөөд бүрэн эрхт төлөөлөгч, элч юм. Христэд итгэгч бид Христийг төлөөлөн ярьдаг. Энэ бол аугаа завшаан! Бид Бурханы эвлэрлийн үйлчлэлд оролцохоор уригдсан - уригдах нь байтугай тушаал хүлээж авсан. Бид үг ба үйлдлээрээ Бурханыг төлөөлж ярьдаг. Энэ нь бидний амьдралын зорилго юм. Бид газар дээр Бурханы Хаанчлалыг хөгжүүлэх үүрэгтэй Бурханы хамтран зүтгэгч нар юм.

Тэгвэл Бурхан элчин сайдууддаа юу хий гэж хэлсэн бэ? Есүс “Та нар бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун” хэмээн айлджээ (Иохан 13:34).

Энэ нь бидний өөрийн сэтгэлийн хүч, хатаар хийчихдэг зүйл биш юм. Бичээс биднийг зорилгоо биелүүлэхийн тулд эхлээд Христийн дотор байх ёстой - загалмай дээр үйлдэгдсэн авралын ажлаар дамжуулан Түүний нигүүлслийг өвлөгсөд байх ёстой гэжээ. Тэгсэн нөхцөлд л бид Бурханы Сүнсний өөрчлөх хүчээр ажиллаж, Тэр биднийг хайрладаг шиг бид бие биеэ хайрлаж чадна.

Нигүүлслийн гэрээ дор, Бурхан бидэнд эхлээд хийх хүчийг нь өгсөнийхээ дараа л аливаа зүйлийг хийхийг тушаадаг. Бид Христийн дотор байгаа учраас Ариун Сүнс бидний өөрийн болон гэрлэлтийн амьдралыг Түүний хайр ба оршихуйг дэлхийд гэрчлэн харуулах хүчтэй болгодог. Гэхдээ бид Түүний хайрыг эхлээд өөрсдөө мэдрээгүй бол, дэлхийд мэдрүүлж чадахгүй. Ефес 3:16-19 дээр Паул Христийн хайрыг хүлээж авах түлхүүрийг хэлж өгчээ:

Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж сууриалаад, бүх ариун хүмүүсийн хамт тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг ойлгох болтугай. Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай.

Христийн хайрын илчлэлийг хүлээж авахын тулд эхлээд Бурхан Ариун Сүнсээрээ дамжуулан бидний дотоод хүнийг хүчирхэгжүүлэг. Гэхдээ хэрэв та Бурханд бүрэн бууж өгөхгүй бол ийм зүйл болохгүй. Хэрэв таны амьдрал Түүнийх болбол, та Түүний дотор тасралтгүй өсч, таныг бүрэн бүтэн, цул амьдрал руу хөтлөх аялалаа үргэлжлүүлсээр байх боломжтой (Христэд амьдралаа бүрэн өргөх талаар сүүлийн хуудас 265-р хуудсаас дэлгэрэнгүй сурна уу).

Паул Христийн хайрыг мэдэх мэдлэгээс ирдэг хүчийг таньж мэдэх талаар бичээд, хоёр ишлэлийн хойно энэ хүчийн зорилгыг тайлбарлажээ:

Иймд та нар дуудагдсан тэрхүү дуудлагадаа зүй зохистой явахыг Эзэний хоригдол би хичээнгүйлэн ятгая. Ингэхдээ аливаа төлөв даруу байдлаар бөгөөд дөлгөөн сэтгэлээр хайр дотор бие биеэ хүлцэн тэвчиж, амар тайвны хүлээс дотор Сүнсний нэгдлийг хадгалахыг хичээгтүн. (Ефес 4:1-3)

Паул “дуудлагадаа зүй зохистой яв” гэж айлдсаныг тэмдэглэнэ үү. Бидний зорилго нь Бурханы хайр, үнэн, амийн замыг (хаанчлалыг) илчлэх гэдгийг Паул хэлжээ. Харин Бурханы хайрыг өөрийн биеэр эдлээгүй хүн үүнийг хийж чадахгүй. Ийм зүйлийг онолын мэдлэгээр хийж чадахгүй. Бурханы хайрыг өөрийн биеэр эдлэсэн хүн л дуудлагатаа эгнэсэн амьдрал, гэрлэлтийг цогцлооно.

Энэ хэсэгт Паул гэрлэлтийн амьдралын хамгийн сайн дадлуудыг тайлбарлажээ: даруу бай, эелдэг бай, тэвчээртэй бай,

бие биеийнхээ алдаа эндлийг хэлтрүүл, амар тайвнаар эв нэгдэлтэй байхын төлөө хичээнгүйл. Ефесийн дараагийн бүлэгт гэрлэлтэд хамаатай Библийн хамгийн алдартай ишлэлийн нэг байна (Бүлэг, ишлэл нь Паулын анхдагч захидалд байгаагүй, хожим 13-р зуунд л Чуулган зохиосон гэдгийг санана уу). Ефес 1-4-р бүлэгт Паул уншигч нарынхаа зүрхийг юу юугүй хуваалцах гэж буй үгтээ - Бурханы хайрын талаарх сочир мэдлэгийг шаардах гэрлэлтийн талаарх сочир үнэнд бэлтгэсэн юм болов уу.

Тэгэхээр та хайрлахаасаа өмнө (өөрийнхөө ханийг байна уу өөр нэг хүнийг) эхлээд таныг гэх Бурханы хайрын гүнийг мэд. Та Бурханы хайрын талаар хоёрдагч этгээдээс олж мэдэх биш, өөрийн биеэр мэдэх ёстой. Христийн хайрыг мэдэх аваас “та Бурханаас ирдэг бүрэн дүүрэн амьдрал, хүчээр дүүргэгдэнэ.” Тэр цагт л та дуудлагадаа зохистой амьдарна. Амьдрах болон хайрлах хүч нь таныг хайрлах Бурханы яндашгүй хайраас ирдэг.

Гэрлэлтийн зорилго

Хэрэв та хувь хүнийхээ хувьд газар дээр Христийн төлөөлөгч болох ёстой юм бол, гэрлэлтийн зорилго нь юу юм бэ?

Тэгэхээр Бурхан бол хайр гэдгээс эхэлье. Хайр нь Бурханы хийдэг юм биш, хайр нь Бурханд байдаг юм биш, Бурхан Өөрөө хайр юм. Гэрлэлт нь хайрын институци буюу Бурханы байгуулсан хамгийн анхны институци юм. Гэрлэлт нь Бурханы үүсгэн байгуулсан анхны институциэс гадна Түүний биднийг буюу Чуулганаа болон сүйт бүсгүйгээ хайрлах хайрынхаа гүн, бүрэн зориулалтаа илчилдэг уран яруу билэгдэл юм. Сүйт хархүү болон сүйт бүсгүй нь үнэндээ Чуулган, Христ хоёрын зураглал билээ.

Гэрлэлт нь ийм гүн гүнзгий билэгдэл учраас л үүний эсрэг асар хүчтэй хорлон сүйтгэх үйл ажиллагаа өрнөдөг ажээ. Харин үүний сэдлийг тун цөөхөн хүн ойлгож ухаардаг. Гэрлэлтийн нэр, утга учир, тэнгэрлэг угшил гарлын эсрэг өрнөх халдлага нь улс төр, нийгмийн үйл явцсаас хавьгүй нүсэр зүйл юм. “Бидний тэмцэл нь махан бие ба цусны эсрэг өрнөөгүй, бидний дайсан засгийн газар, байгууллага биш” гэдгийг Бичээс маш тодорхой хэлсэн (Ефес 6:12). Тэр нь тэнгэрлэг нэгдлийг бузарлахын тулд тайзны араас ажиллаладаг, бидний сүнсийг онилогч, өнө эртний дайсан

юм. Дайсан Бурханы хүмүүсээ хайрладаг, харилцан холбогддог хүрээ хязгаарыг нураах хүртлээ гэрлэлтийг довтолсоор л байна. Сатаны туйлын зорилго нь Бурханы өөрчлөгч хайрыг бидэнд мэдүүлэхгүй, хүлээж авахуулахгүй байх юм. Тэгэвч Бурханы нигүүлслээр бид дайснаа дарж, Бурханы зүгээс бидний гэрлэлтэд өгсөн болон хандсан бүхнийг хүлээн авч чадна.

Есүс юу гэж боддог вэ?

Бурхан гэрлэлтийг бүтээснээр барахгүй, Түүнд гэрлэлтэд зориулсан, өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй төлөвлөгөө, зорилго бий. Хэдийгээр хэдэн мянганы турш гэрлэлтийн нарийн ширийний талаар халуун мэтгэлцээн өрнөсөөр ирсэн ч, Бурхан анхдагч төлөвлөгөөнийхөө ард хөдлөшгүй зогссоор буй. Гэрлэлтийн талаарх хамгийн алдартай нэгэн мэтгэлцээндээ Есүс Фарисайчуудад юу айлдсаныг үзнэ үү:

Түүн дээр хэсэг фарисайчууд ирээд, Түүнийг сорьж,
—Ямар нэг шалтгаанаар эхнэрээсээ салах нь хуулийн дагуу мөн үү? гэж асуухад Тэр хариуд нь
—Бүтээгч анхнаасаа тэднийг эр, эмээр нь бүтээснийг та нар уншаагүй гэж үү? гээд
—Тиймээс эр хүн эцэг эхээ орхин эхнэртэйгээ нийлж, хоёулаа нэг бие махбод болдог. Тиймд тэд цаашид хоёр бус, харин нэг бие махбод юм. Иймээс Бурханы хамтад нь нийлүүлснийг хэн ч бүү салгаг гэж айлдав (Матай 19:3-6).

Фарисайчууд хуулийг яс мэдэж байсан. Харин Есүс тэднийг хайрын хүчийг мэдээсэй гэж хүсчээ.

Бурхан анхнаасаа эрэгтэй, эмэгтэй хүнд зориулсан тэр үнэнийг бид няцааж чадахгүй. Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн нэгэн биеийг цогцлоохоор аав, ээжээ орхин гэрлэдэг. Тэр хоёр хүн нэгэнт нэгдсэн бол, хэн ч тэдний нэгдлийг бүү хорлог.

Бурхан яагаад салалтыг үзэн яддаг вэ?

Мессеж Библийн хувилбар салалтыг Бурханы урлалыг гутаан доромжилсон явдал гэдэг. Гэрлэлт нь Бурханы бүтээсэн урлал учраас л салалт нь тийм ноцтой асуудал юм.

Гутаан доромжлох гэдэг нь ариун нандин зүйлийг харгислан хүчирхийлэхийг хэлнэ. Гутаан доромжлохтой ижил утгатай үгс нь жигших, хорлох, бузарлах, хорлон сүйтгэх, доромжлох, хүчирхийлэх юм. Эдгээр эрс тэс нэр томъёо нь бүгд л хүчирхийллийг илэрхийлнэ. Тэгэхээр энэ бүхэн нь Бурханы нэгтгэсэн зүйлийн тэнгэрлэг жинг л харуулж байна.

Хэрэв алдарт Леонардо Да Винчигийн Мона Лизаг хорлон сүйтгэбэл, дэлхий яах бол? Бүх мэдээний сувгаар ярина биз дээ? Хорлон сүйтгэгчийг хотол олноороо жигшиж, магадгүй шоронд хатаах биз. Хүн төрөлхтөний сор болсон бүтээлийг хорлон сүйтгэж яаж чадаж байна аа? Талийгаач Леонардо Да Винчигийн яс ч өндөлзөнө.

Тэгвэл Бурхан ч гэрлэлтийг Өөрийнхөө хамгийн хайртай бүтээлээр дамжуулан илэрхийлсэн сор бүтээлээ гэж үздэг. Тэрбээр гэрлэлтийг яаж хайрладгийг Фарисайчуудад хэлсэн үгээс нь харж болно. Есүсийн үг Фарисайчуудад хэт хүндэлсэн учраас тэд зүгээр л хариулахаас татгалзжээ. Гэрлэлтийг Бурханы анхны санааны гэрлээр харж чадахгүй учраас тэд зогсоод үлдэх хүчийг биш, арилад өгөх эрх олгодог хандлага болох Мосегийн хуулиар бамбай хийв:

Гэтэл тэд Түүнд

—Тэгвэл Мосе яагаад эхнэртээ салалтыг гэрчилсэн бичиг өгөөд, түүнийг явуулахыг тушаасан юм бэ? гэхэд, Тэр тэдэнд

—Яагаад гэвэл та нарын зүрх хатуу тул Мосе эхнэрээсээ салахыг та нарт зөвшөөрсөн юм. Гэвч анхнаасаа ийм байгаагүй. Би та нарт хэлье. Хэн садар самуунаас өөр шалтгаанаар эхнэрээсээ салж, өөр эмэгтэйтэй гэрлэнэ, тэр нь завхайрсан болно гэв (Матай 19:7-9).

Хүний хатуу зүрх сэтгэлийн улмаас Мосегийн хууль онцгой тохиолдолд салахыг зөвшөөрдөг байжээ. Энэ хангамж нь Бурханы анхны зорилго байгаагүй. Бүү эндүүрээрэй. Бурхан салалтын үр дагаварыг үзэн яддаг. Нөхөр эхнэр хоёр салахад, Бурханы бүтээлийн нэгэн нууц (Ефес 5:31-32 дээр гэрлэлтийг ингэж тайлбарласан) хүчирхийлэгдэж, зэрэмдэг болдог.

Дөрөвдүгээр өдөр

Шинэ зүрх

Би та нарт хэлье. Хэн садар самуунаас өөр шалтгаанаар эхнэрээсээ салж, өөр эмэгтэйтэй гэрлэнэ, тэр нь завхайрсан болно гэв. (Матай 19:9)

Есүс хийх хүч чадлыг нь өгөлгүйгээр биднээр ямар нэгэн зүйл хийлгэхгүй гэдгийг дахин хэлье. Тэр биднийг Өөрийнхөө анхдагч төлөвлөгөөний дагуу амьдрах хүчээр хангах учраас л энэ төлөвлөгөөг сахиулах гээд байгаа юм. Мосегийн Хууль нь хатуу зүрх сэтгэлтэй хүмүүст зөвшөөрөл олгосон хэдий ч, Есүсийн золиосоор дамжуулан бид чулуун зүрхийг биш, шинэ зүрхийг хүлээн авна.

Түүнээс гадна Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг оруулна. Би та нарын махан биеэс чулуун зүрхийг зайлуулж, та нарт махан зүрхийг өгнө. (Езекиел 36:26)

Энэ үг нь Шинэ гэрээнд ч гардгийг бид мэднэ. Элч Паул биднийг ийнхүү урамшуулжээ:

Найдвар нь урам хугалдаггүй. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг. (Ром 5:5)

Зүрх сэтгэлийн энэ шинэчлэлийг бид хийхгүй, харин Бурханы хүч, Түүний хайрын хүч чадал хийнэ. Харин бид тэр хүчийг хүлээж авах үүднээс Өөрийгөө даруу болгох ёстой. Бурхан жинхэнэ Жентельмэн учраас хэзээ ч хэнд ч хайраа хүчилдэггүй.

Бидэнд Христийн хайрыг хүлээн авах чадалтай шинэ зүрх байгаа учраас өдгөө бид гэрлэлт, салалтад хандсан Бурханы анхдагч төлөвлөгөөны талаарх хүнд хэцүү мэдэгдлийг хүлээн авч чадна.

Мессеж Библийн орчуулга итгэмжтэй хань ижлээсээ салж байгаа хүний нөхцөл байдлыг дүрслэхдээ үүрэг хариуцлагатай (хуулийн дагуу үүрэг хариуцлагатай) гэдэг үгийг хэрэглэжээ. Энэ нь хүнд тушаал шиг сонсдож байж магадгүй ч, Бурхан биднийг энэ жишгээр тооцож байгаа бол, үүнийг биелүүлэх хүчийг нь өгч л таараа. Гэвч энэ аян зам нь амархан бас автомат биш учраас, маш олон хүн цаашаа гүрийх ёстой байтал, замаасаа хаяад гардаг.

Нэгэн судалгааны үр дүнг үзбэл, аз жаргалгүй гурван гэрлэлтийн хоёр нь салахгүй үлдбэл, таван жилийн дотор аз жаргалтай болдог гэжээ. Тиймээс бүү бууж өг! Таны гэрлэлт яг одоо ямар байдалд буйг мэдэхгүй. Гэхдээ ямар ч тусгүй санагдсан ч, найдвар байгаа шүү. Булан тойроод гэнэтийн өөрчлөлттэй золгохыг хэн байг гэжээ. Есүс сайн гэрлэлтийг бүр сайхан болгох гэж, нурсан гэрлэлтийг бүтэн болгох гэж ирсэн юм шүү. (Гэхдээ та үр хүүхдэд чинь аюул заналтай нөхцөл байдалд байгаад байж хэзээ ч болохгүй. Гэрлэлт чинь хүчирхийлэл дор байгаа бол, даруй аюулгүй байх арга хэмжээ ав. Дэмжлэг, чиглүүлэг авахын тулд чуулгандаа юмуу нутгийн эрх баригчдад хандана уу).

ОНЦГОЙ ТОХИОЛДОЛ

Би та нарт хэлье. Хэн садар самуунаас өөр шалтгаанаар эхнэрээсээ салж, өөр эмэгтэйтэй гэрлэнэ, тэр нь завхайрсан болно гэв. (Матай 19:9)

Анхдагч төлөвлөгөөнөөс зөрөх онцгой тохиолдол гэж байна. Гэхдээ завхайрсан тохиолдолд ч гэсэн гэрлэлтээ цэглэх нь сонголт ажээ. Хэрэв хань ижил чинь итгэмжгүй байсан бол, та үлдэх

албагүй ч гэсэн бас явах албагүй юм. Та аль ч замыг нь сонгосон бай, заавал уучлах хэрэгтэй.

Уучлал ба эвлэрлийн хооронд том ялгаа бий. Танаас хулгай хийсэн хүнийг та уучлах хэрэгтэй ч, энэ нь хулгайчийг гэртээ уриад бай гэсэн үг биш юм. Хос нь гэрээ, итгэл, найдварын гашуун зөрчлөөр туулсанахаа дараа дахин нэгдэж чадах газраа ирэх үедээ л сэргээн босгогдож чадна.

Бид хэзээ ч завхайрлын нүгэлд орж байгаагүй ч, завхайрсан найзыгаа энэ аймшиг дундуур туулахад нь дэргэд нь байсан. Зарим хос дахин эвлэрэх сонголт хийдэг. Тэд үйрсэн гэрээгээ хэсэг хэсгээр нь эвлүүлэх хүнд бэрх ажлыг хийдэг. Итгэмжгүй хань нь нурж, гэмших газраа ирдэг. Нэг зүйлийг шууд хэлье: гэмшилгүйгээр эвлэрэл гэж байхгүй. Яндашгүй нигүүлсэнгүй, өр зөөлөн Бурхан ч бидэнтэй эвлэрэхээсээ өмнө биднээс гэмшихийг - өөрчлөгдсөн тархи ба зүрхтэй байхыг шаарддаг.

Түүнчлэн бид эвлэрээгүй хосыг ч мэднэ. Тэд ялын хүнд жинд дарлагдах хэрэггүй. Есүс урвалтын зовиурыг мэддэг учраас зайлшгүй нөхцөлд онцгой гарц зааж өгчээ. Тэдгээр хүмүүс салалтын зовиурыг ардаа орхиж, эдгэсэн хойно Бурхан тэднийг тус тусад нь ерөөхийг бид харсан билээ.

Та хэрэв ийм аймшиг дундуур туулсан бол, үүгээр өөрийгөө бүү тодорхойлуулаарай. Энэ нь таны өнгөрсөний хэсэг учраас ирээдүйг чинь шийдэх учиргүй.

Өнгөрсөн таных биш. Өнгөрсөн Бурханд хамаатай. Таны ирээдүйд хандсан Бурханы төлөвлөгөөг нураахын тулд сүнсний чинь дайсан таны өнгөрсөнийг ашиглахыг хүсдэг. Бурхан танд өнөөдрийг өгсөн бөгөөд өнөөдөр таны хийж буй сонголт өчигдрийг биш, маргаашийг чинь тодорхойлно. Хэрэв та муу сонголт хийсэн бол, Бурханы цэц ухаан, хүчийг ав. Гэмшлээр өөрийгөө даруу болгож, нөхцөл байдлын баргар байдлыг өөрчлөх хүчтэй Бурханы нигүүлслийг эдлэ.

Бид өнгөрлөө гэж үү?

Гэрлэлтэд зориулсан Бурханы урлалыг дүрсэлсэн Есүсийн үг нь хэвийн хэв хэмжээнээс эрс тэс байсан байх. Учир нь Түүний үг дагалдагч нарыг тэвдүүлжээ. Тэд юу гэж гомдоллосныг үзнэ үү:

—Хэрэв гэрлэлтийн болзол нь ийм бол, бид ч өнгөрчээ. Гэрлээгүй нь дээр юм байна. (Матай 19:10)

Өнгөрчээ? Гэрлэлтийн амьдралын талаарх ямар аймшигтай үзэл бодол вэ! Тийм боловч, дагалдагч нарын нэгэн адил бид ч бас гэрлэлтийг дөнгө, чөдөртэй гэж боддог. Өнөөдөр хичнээн залуус буруу хүнтэйгээ гэрлэж, “өнгөрөхөөс” айдаг билээ?

Гэрлэлт нь зөв хүнээ олох асуудал биш, өөрөө зөв хүн байх асуудал юм. Биднийг буруу ташаа бүү ойлгоорой. Мэдээж ханиа хайж байгаа хүн бурханлаг зөвлөгөө хайж, Сүнсний амар амгалан дор байх нь чухал. Гэхдээ бид “тэр заяаны хань маань бидний хамаг өө сэв, ан цавыг битүүлнэ” гэж итгэдэгт л хамаг асуудал бий. Гэтэл тэр даалгаврыг ямар ч хүн хийж чадахгүй. Энэ даалгаврыг зөвхөн Бурхан л хийнэ. Тэгээд ч хүний нөхцөл байдлыг зохицуулж, тэднийг өөрийнхөө санаагаар өөрчлөх нь таны хийх ажил биш. Үүний оронд та Бурханы шинэтгэн өөрчлөх ажлыг хүлээн авч, одоогийнхоо эсвэл ирээдүйнхээ ханьд амь амьдралаа харамгүй өгч чаддаг эрэгтэй эсвэл эмэгтэй хүн болох хэрэгтэй.

Матай 6:22 дээр нүд нь биеийн гэрэл гэжээ. Энэ нь таны үзэл бодол нь таны бодит байдал болно гэсэн үг юм. “Өнгөрчээ” гэдэг үзэл бодол нь таны амьдралд эвсэл танаар дамжуулан хийж чадах Бурханы үйлсийг хязгаарлана. Хэрэв та гэрлэлтээ найдваргүй байдлын урхи гэж харж байгаа бол, яг л тийм болно. Бодит нөхцөл байдал нь яваандаа таны сүнслэг алсын харааг шийдвэрлэх бөгөөд гэрлэлтийн хувьд ч ялгаагүй юм.

Та Жон Лиза, та хоёр дэндүү их юм хүсч байна. Та хоёр намайг ханийхаа төлөө амьдралаа өг гэж байна. Энэ чинь инээдтэй хэрэг. Тэгвэл миний хэрэгцээ, найдвар, мөрөөдөл яах билээ? Есүс намайг аз жаргалтай байгаасай гэж хүсч байгаа. Та хоёрын яриад байгаа зүйл чинь ердөө л сэтгэл хөдлөм, сайхан бодол төдий юм. Тийм ээ, Бурхан үнэхээр таныг аз жаргалтай байлгахыг хүсч байгаа. Гэхдээ жинхэнэ аз жаргал нь том хэрэг зоргын төлөө явсаны дайвар бүтээгдэхүүн юм. Аз жаргал нь том хэргийг биелүүлэхээс ирдэг бөгөөд зохистой зорилго бүр нь хүнээс амиа өргөхийг шаарддаг. Амиа бодохоо больсон хүн л жинхэнэ аз жаргалыг олдог. Гэрлэлт нь өөр дээрээ төвлөрсөн занг тайлж хаях төгс уур амьсгал юм.

“Хэрэв хосын хэн хэн нь “амиа хичээх явдал нь гэрлэлтийн хамгийн том асуудал” гэж тооцбол, тэдэнд гайхамшигтай гэр бүлийн амьдрал цогцлоох ирээдүй байна” хэмээн Тимоти болон Кэйти Келлер хэлжээ. Өөр дээрээ төвлөрсөн зангаасаа болж л бид олигтой гэр бүлийн амьдрал байгуулж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл бүрэн дүүрэн гэрлэлтийн амьдрал нь өөрийгөө үгүйсгэх юм. Хэрэв та хань ижилтэйгээ харилцаа байгуулж чадахгүй байгаа бол, асуудлын чинь гол эх ундарга нь амиа хичээх явдал юм.

Тавдугаар өдөр

Гэрлэлтийн өргөжилт

Есүс:

“—Ингэж хэлэхийг бүх хүн хүлээн зөвшөөрч чадахгүй, харин энэ нь өгөгдсөн хүмүүс л чадна. Учир нь эхийнхээ хэвлийгээс төрөхдөө тайган төрсөн хүн байдаг. Хүмүүсийн тайган болгосон тайган хүмүүс ч байдаг. Мөн тэнгэрийн хаанчлалын төлөө өөрсдийгөө тайган болгосон тайган ч байдаг юм. Үүнийг хүлээж авах чадвартай нэг нь хүлээн аваг” гэж айлдав. (Матай 19:11-12)

Дагалдагч нар өнгөрчээ гэдэг бодол дээрээ төвлөрч байтал, Есүс тэдний оршин буй хязгаараа тэлэх хүчин чадлынх нь талаар мэдэгджээ. Есүс гэрлэлтийг чөдөр гэж үзээгүй. Тэрбээр үүнийг амьдралыг өргөжүүлэн тэлэх чадалтай зүйл гэж үзжээ.

Гэрлэлт нь оролцогч нарынхаа тоо, үнэ цэнийг бууруулдаг юм шиг харагддаг. Тэгээд ч хоёр нь нэг болно гэж хэлдэг биз дээ? Гэхдээ гэрлэлт нь хувааж, бууруулдаггүй, харин өсгөн үржүүлдэг юм. Хоёр нь нэг болоход амьдралын тал бүр дээр үржил өрнөдөг. Еваг бүтээгдэхээс өмнө Бурхан Адамд үр жимстэй бай, үрж гэдэг тушаал өгөөгүй. Тэгээд ч энэ тушаал нь гагцхүү хүүхэд үйлдвэрлэхэд хамаатай биш юм. Гэрлэлтийн үржлийн жинхэнэ хүчин чадлыг тооцож, хэмжих арга байхгүй.

Бид хоёр гэрлээгүй бол, та энэ номыг (болон өөр бас бусад номыг маань) уншихгүй байсан. Бид хоёр тус тусдаа өчүүхэн амьдралаар аж төрөх байсан. Жон миний бие Бурханы нигүүлслээр болон Бурханаас надад хайрласан Лизагийнхаа ачаар өдий зэрэгт хүрсэнээ хүлээн зөвшөөрнө. Бидний гэрлэлт амархан байсан уу? Ердөө ч үгүй! Гэхдээ Бурхан гэрлэлтээр минь дамжуулж амьдралыг маань өргөжүүлэн тэлсэн юм.

Лиза миний хувьд ч бас ялгаагүй бөгөөд нөхрөөр минь дамжуулж, амьдралыг маань тэлсэн Бурхандаа талархаж байна. Биднийг анх гэрлэх үед би хүн амьтнаас ухаан алдталаа айдаг, бүрэг охин байлаа. Энэ нь тавтай байхдаа хорт хавдраар нэг нүдээ алдсантай маань яриангүй холбоотой байв. Жон миний айдсыг мэддэг ч, гагцхүү надад хайрласан Бурханы бэлэгийн талаар л ярьдаг байв. Түүний урам зориг намайг Бурханы төлөвлөгөө, амьдрал руу алхуулсан бөгөөд энэ нь дандаа хүмүүсийн төлөө, хүмүүстэй ажиллах үйлчлэл байсан нь намайг гайхшруулсан юм.

Бурхан биднийг үрж гэж тушаахдаа, зөвхөн хүүхэд хийх талаар хэлээгүй гэдгийг дахин хэлье. Бурхан эрэгтэй, эмэгтэй хоёрыг нэгдүүлсэнээрээ (энэ нь “1+1” гэсэн энгийн л нэмэх үйлдэл юм) үлэмж үржил бий болгож болохыг мэджээ. Энэ зарчим нь ажил, гэр бүлийн амьдрал, сүнслэг амьдрал гэх мэтчилэн бидний амьдралын тал бүрт хамаатай буюу. Бурхан гэрлэлтэд нэгэн тэмдэг тогтоож өгчээ. Хэрэв таны амьдралд ерөөл, үржил дутагдаж байвал, хань ижилтэйгээ тэмцэлдэх биш, хүндэтгэн хайрлах цаг нь болжээ гэсэн үг.

Амархан биш

Том тулаанд орохдоо дайснаа болон дайсныхаа тулааны арга барилыг сайтар мэдсэн байх ёстой (Яагаад тамирчид өрсөлдөгчийнхөө бичлэгийг өчнөөн цагаар үздэг гэж бодоов?) Дайсан гэрлэлт рүү - тэр дундаа Христчин гэрлэлт рүү халдахдаа хагаралдуулж, булаан эзлэх зорилгыг л агуулдаг. Тиймээс үүнийг мэдсэн юм чинь бид дайсныхаа схемийг сөрөн зогсох мэдлэгтэй байх учиртай.

Бид гэрлэлтийнхээ төлөө дайтахдаа, Бурханы санааны төлөө дайтаж байгаа юм. Та биш, Бурхан гэрлэлтийг бүтээсэн гэдгийг

бүү мартаарай. Гэрлэлт нь бэлгийн харилцаанаас хавьгүй гүн зүйл учраас Сатан гэрлэлтийг үзэн яддаг. Гэрлэлт нь сүнслэг нэгдэл юм. Таны гэрлэлт ийм том ач холбогдолтой учраас л эсэргүүцэлтэй тулгардаг. Гэхдээ та шагналынхаа төлөө урагшилсаар л байх ёстой (Филиппой 3:14-г үзнэ үү). Энэ бүхнийг амархан байна гэж Есүс хэзээ ч хэлээгүй. Гэрлэлт нь бидний төлөвшөөгүй талыг илчилнэ. Гэхдээ хэрэв бид Түүний нигүүлсэл дотор өссөөр байвал (үүний тулд даруу, амиа бодохгүй, гэвчээртэй байх хэрэгтэй), эцэстээ бид гэрлэлтийн өргөжилтийг үзэх л болно.

Хүмүүс гэрлэлтийг гэрээ гэж боддог. Энэ нь том асуудал юм. Гэрээ нь ердөө л зарим үйл хөдлөлийг хязгаарласан зөвшилцөл юм. Энэ нь зүгээр л “Ийм ийм хориг байна. Та энэ зөвшилцлийг зөрчихгүй. Эдгээрийг зөрчих аваас би энэ гэрээг хүчингүй болгох эрхтэй” гэдэг.

Өөрөөр хэлбэл би өнгөрөөгүй

Түүнчлэн Англи хэл дээр контракт гэдэг үг байдаг. Мириам Вебстерийн толь бичигт үүнийг “шүүслэн шахаж хорогдуулах” хэмээн тодорхойлдог. Энэ нь Есүсийн хэлсэн гэрлэлтийн өргөжилтөөс тэс өөр сонсдож байна. Гэрлэлт нь бидний амьдралыг өргөжүүлэх ёстой болохоос, жижиглэхгүй.

Бурхан гэрлэлтийг гэрээнээс томоор үздэг. Бурхан гэрлэлтийг сүнслэг гэрэгэ гэж хардаг. Энэ нь “Би өөрийгөө бүхлээр нь бүрэн чамд өгч байна. Өнөөдөр би бүхлээрээ чинийх. Надад байгаа бүхэн чинийх бөгөөд чамд байгаа бүхэн минийх юм. Энэ гайхамшигтай солилцооны улмаас бидний хийх бүхэн үржиж, томорч, өснө” гэж тунхаглах зөвшилцөл юм. Гэрэгэ нь “Тийм ээ, би өнгөрсөн хүн! Гэхдээ би үүндээ тун баяртай байна!” гэдэг. Энэ бол өргөжилт.

Паул Ефес чуулганд:

“Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла” хэмээн айлджээ. (Ефес 5:25)

Христ Чуулганыг яаж хайрласан яг түүнчлэн эхнэрээ хайрла хэмээн Паул нөхрүүдэд заажээ. Энэ хайр нь гэрээнээс хавьгүй

том гэрээний хайр юм. Нөхрүүд ээ, та нар хайрлуулахын аргагүй үедээ ч Есүсээр хайрлуулахдаа баяртай байдаг биз дээ? Есүс тантай тогтоосон харилцаагаа хэзээ ч “өнгөрсөн” гэрээ шиг үздэггүйд та нар баярладаг биз дээ? Тиймээс бид сүйт бүсгүйгээ хайрлахдаа, яг л Есүсийн хайрыг даган дууриах ёстой (Гэхдээ Паул хайрла гээд л дуусгачихаагүй, цааш нь эхнэрийнхээ төлөө амиа өгөх талаар өгүүлжээ. Ямар мундаг тушаал вэ!)

Паул Ефес 3-р бүлэгт дээрх үгээ бичихийнхээ өмнө хүмүүсийнхээ төлөөх Бурханы хайрын гүнийг дүрсэлжээ. Үүнээс хоёрхон бүлгийн дараа тэрбээр “Христ чуулганыг яаж хайрласан” яг ийм хайрыг гэрлэлтийнхээ амьдралд байлга гэсэн юм.

Бидний гэрлэлт Сүйт бүсгүйгээ хайрлах Христийн хайрыг үлгэрлэн харуулах ёстой. Хүмүүстэйгээ тогтоосон Христийн харилцаанд хайр, хүч, хослон зохицол, бүрэн зориулалт байхгүй бол, яагаад Христийг мэдэхгүй хүмүүс Түүнтэй харилцаа тогтоохыг хүснэ гэж? Таны гэрлэлт яагаад тийм чухал болохыг харж байна уу? Энэ нь дан ганц таны асуудал биш, харин Бурхан хайраа дэлхийд хүргэх асуудал болж байна.

Өмнө хэлсэнлэн, хань ижлээ хайрлах хайр нь Бурханы хайрыг хүлээж авсаны халил байх ёстой. Ийм төрлийн хайр хүнээс гарах аргагүй. Энэ хайр нь хүний ойлголтод хязгаарлагдашгүй хайртай Нэгэнээс ирдэг.

Гэхдээ гэрлэлтэд хандах Бурханы хандлага нь амархан биш гэдгийг бид танд нэн түрүүнд хэлэх ёстой. Гэр бүлийн амьдралдаа цэг тавьчихмаар үе бидний амьдралд олон байсан. Яг л хамаг итгэл найдвар тасарчихсан юм шиг. Гэхдээ гуч гаруй жил гэрлэсэн хойноо бид өнөөдөр хамгийн аз жаргалтай амьдарч, ирэх гучин жилийнхээ амьдралыг итгэл найдвар, хүсэл зорилгоор дүүрэн, догдлон харж байна.

АМИЙН МОД УУ ҮХЛИЙН МОД УУ?

Лиза миний бие мод тарьж, цэцэг ургуулах дуртай. Харин Жон энэ талаар сонирхдоггүй. Тэр цэцэрлэгийн цэцэг, жимсэнд дуртай болохоос, арчилж тордох дургүй. Цэцэрлэгийн арчилгаа нь маш их цаг, хүч хөдөлмөр авдаг.

Яг цэцэрлэгтэй адил гэрлэлтийн арчилгаа нь маш их цаг, эрч хүч авдаг. Гэрлэлтээ эрүүл саруул байлгахыг хүссэн хүний хувьд зайлшгүй хийх ёстой ажлыг товчлох түргэн цэс байдаггүй. Энэ нь ч сайн хэрэг. Яагаад? Яагаад гэвэл бид юуны төлөө ажиллаж байгаагаа мэднэ. Гэрлэлтээ үнэлэх хэрэгтэй.

Та гэрлэлтийнхээ амьдралд тариалсан бүхнээ амьдралынхаа өөр өөр талбараас хурааж авдаг нь сайн (заримдаа муу) мэдээ юм. Энэ бүлгийн эхэн хэсэгт бид гэрлэлт нь амийн модтой адил гэдгийг үзсэн. Гэхдээ эсрэг зүйл нь ч бас үнэн юм. Таны гэрлэлт бас үхлийн мод ч болж чадна.

Едений хоёр модны дүрслэлийг дахин нэг харъя:

Энэ хоёр мод нь хоёулаа төгс төгөлдөр орчинд ургаж байсан ч, нэг нь амийг, нөгөө нь үхлийг төрүүлдэг байв.

Гэрлэлтэд хандсан Бурханы институци нь хөрс бөгөөд таны одоогийн юмуу ирээдүйн гэрлэлт чинь мод юм. Гэрлэлтэд хандсан анхдагч төлөвлөгөө нь нэгдлийг өсгөх сайн хөрс боловч, гэрлэлтээ амийг төрүүлдэг мод болгож, үүгээр дамжин хань ижил, гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллагсад чинь хайр, баяр хөөр, амар тайвныг эдлэх эсвэл үүний үр жимсээс идсэн хүмүүс урам алдаж, амиа бодож, гашуудах эсэхийг та өөрөө л шийднэ.

Хүмүүс гэрлэлтийг л хамаг асуудлын үндэс гэж бодоод байдаг. Зарим нь хань ижлээ ялладаг. Аль аль үзэл бодол нь өөрийнхөө зүрхний бузар чанарыг хүлээн зөвшөөрөхөөс таггалзаж байгааг л илчилж байна. Харин таны хувьд одоо байдал өөрчлөгдсөн гэдэгт найдаж байна.

Аялалаа үргэлжлүүлэхээсээ өмнө нэгэн шийдвэр гаргах ёстой. Та хоёрын гэрлэлт яг л Бурханы товлосон гэрлэлт болж чадна, болох ч болно гэдэгт та итгэхийг сонгох ёстой.

Харж байж итгэе гэдэг хүмүүс байдаг. Гэхдээ аливаа өөрчлөлтийн өмнө ямагт өөрчлөлтөд итгэх итгэл ордог. Учир нь Бурханы бүх амлалтыг итгэлээр л хүлээж авах боломжтой. Гэрлэлт нь таны тухай биш, харин Түүний тухай гэдэг нь хамгийн сайхан мэдээ болой. Таны хийх ёстой зүйл бол ердөө л өөрийгөө хойш тавьж, Бурханд Бурхан байх байр суурийг нь олгох. Эцсийн эцэст таны гэрлэлт бол Бурханы урлал юм. Түүнд боломжийг нь олгобол, Тэрбээр гэрлэлтийг чинь үзэсгэлэнтэй урлагийн бүтээл болгоно.

Нэгдүгээр өдрийн судлал

ГЭРЛЭЛТИЙН УЛИРАЛ

Тэнгэрийн доорх бүх юмс цаг хугацаатай бөгөөд бүх юм тогтоогдсон цаг мөчтэй ажээ.

- Номлогчийн үгс 3:1

Хавар, зун, намар, өвөл хэмээх дөрвөн улирал нь бүгд өөрийн гэсэн сайн муутай, асуудал бэрхшээлтэй байдаг. Гэрлэлт ч ялгаагүй. Хүний гэрлэлтийн амьдрал олон улирлыг туулдаг бөгөөд нэгээр нь арай жаахан удаан, нөгөөгөөр нь арай түргэн туулдаг. Улирал бүрээс сурах юмтай, улирал бүрт өсөх боломжтой. Зохиолч, пастор **Чарльз Свиндол** улирлын талаарх ухаарлаа ийнхүү хуваалцжээ;

“Бурхан цаг хугацаа улирлыг өөрчилдөгт би баярладаг. Та баярладаггүй гэж үү? ... Эзэн маань цаг хугацаа, улирлыг солбихдоо хэзээ ч таг дүлий эсвэл салан аятай ханддаггүй. Шинэ нууцыг нээж, шинэ дуу дуулахгүйгээр нэг улирлаас нөгөө рүү зүгээр л нүдээ тас аниатай, хөлөө чирч явах юутай буруу! Улирал нь биднийг улам бэхжүүлж, Бурханы арга зам, цэц ухаанд сургадаг. Эн нь биднийг яг л урсгал усны дэргэд таригдсан мод шиг болж өсгөхийн төлөө юм.”

Хань ижилтэйгээ туулсан хамгийн сайхан улирал чинь юу вэ? Төвч дүрслээд, яагаад тийм онцгой чухал байгааг хэлнэ үү.

Хань ижилтэйгээ туулсан хамгийн аймшигтай шуурга чинь юу байв? Та хоёр үүнийг хэрхэн туулсан? Эзэн та хоёрт юу зааж өгсөн бэ?

Номлогчийн үгс 3:11; Ром 8:28; 2Коринт 2:14 танд урам хайрлах болно.

Эргэн тойрноо хар. Таны гэрлэлт яг одоо ямар улиралд байна? Энэ улирлын сайн сайхныг эдлэхийн тулд та юу хийж чадах вэ?

Түр зогсоод залбирна уу. “Эзэн минь, бид яг одоо байгаа энэ улирлынхаа сайн сайхныг үзэхийн тулд юу хийх вэ? Бүхнийг Таны нүдээр харахад туслаач. Энэ улирлын ачаар хурааж болох сайн сайхнаа харах нүдийг өгөөч. Есүсийн нэрээр. Амень.”

Он жилүүд өнгөрөхөд, таны гэрлэлтийн “цагирган хээ” улам тод болдог. Тиймээс яг одоо тайван байж, талархаж сур. Таны гэрлэлтийг юу онцгой болгодог вэ? Өөрийнхөө болон ханийнхаа бэлэг, авъяас, зан чанар, хүсэл, зорилго, туршлага зэргийг бодолцож үзнэ үү.

Ариун Сүнснээс та хоёрын харилцааны онцгой чанарыг илчилж өгөхийг бас та хоёроор дамжуулан яг юу хийхийг хүсч байгааг асуу. Ариун Сүнсний илчилсэн зүйлийг бичээд дараа нь ханьтайгаа хуваалцах цаг гарга.

Хоёрдугаар өдрийн судлал

БУРХАН ГЭРЛЭЛТИЙГ БҮТЭЭСЭН

Та нар биш, харин Бурхан гэрлэлтийг бүтээсэн бүлгээ. Түүний Сүнс гэрлэлтийн эд эс бүрт оришино. Бурхан гэрлэлтээс юу хүснэ вэ? Бурханы хүүхдүүдийг хүсдэг буюу...

- Малахи 2:15 (Мессеж Библи)

Бүх институци дундаас хамгийн түрүүнд гэрлэлт бүтээгджээ. Пастор, өгүүлэхүйн мастер **Макс Лукадо**:

“Бурхан гэрлэлтийг бүтээсэн. Үүнийг засгийн газрын өөр ямар ч дэд хороо хараагүй. Үүнийг нийгмийн байгууллага хөгжүүлээгүй. Гэрлэлт нь Бурханы оюун ухаанд бүрэлдэн мэндэлсэн юм” гэж хэлжээ.

Бурхан гэрлэлтийг бүтээсэн. Тиймээс гэрлэлт нь Түүнд маш чухал. Чухал учраас л Тэрбээр энэ харилцааны хэсэг бүрт оролцохыг хүсдэг. Бурханы Үгт “Түүний бидний дотор нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг” гэжээ. (Иаков 4:5)

Түр зогсоод эргэцүүлэгтүн. Та гэрлэлтийнхээ хэсэг бүрт Бурханы Сүнсийг урьсан уу? Түүний зөвлөгөө таны өдөр тутмын төлөвлөгөөнд чухал уу? Та Түүнийг хааяа хааяа л урьдаг бол, Түүнийг оролцуулаагүй үед амьдрал чинь аль зэрэг өөр байдгийг хэлнэ үү.

Танд хэзээ ч, хаана ч, юунд ч Бурханыг оролцуулах завшаан байна. Та айдас, санхүү, харилцааны асуудалтай зөрчилдөж байна уу? Яагаад асуудлаа Бурханд хэлж болохгүй гэж? Эдгээр хэсгийг анхааралтай уншаад, Ариун Сүнсний танд хэлж буй үгсийг бичнэ үү.

Филиппой 4:6-7 • Матай 6:25-34 • 1Петр 5:7 • Иаков 5:13-16

Матай 7:7-11 • Иохан 14:13-14 • 1Иохан 5:14-15

Бид Түүний хүслийн дагуу юуг ч гүйсэн, Тэр биднийг сонсдог гэдэг нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. Бид юуг ч гүйсэн, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан болохыг мэднэ.

- 1Иохан 5:14-15

Бурхан таны гэрлэлтийг дайны талбар байгаасай гэж хүсэхгүй. Бурхан таны гэрлэлтийг газрын Еден байгаасай гэж хүснэ. Еден гэдэг нь “сайн таалал ба сайн таашаал” гэсэн утгатай. Бурхан таны гэрлэлтийн юуг өөрчлөөсэй гэж та хүсч байна? Хариулсаныхаа дараа Бурханаас “Энэ өөрчлөлтийг биелэл болгоход миний талаас юу хийх хэрэгтэй вэ? Миний дотор ямар өөрчлөлт гарах хэрэгтэй вэ?” гэж асууна уу.

Гуравдугаар өдрийн судлал

ХРИСТИЙГ ТӨЛӨӨЛӨХ

Иймээс бид Христийн төлөөх элчин сайд нар юм. Бурхан биднээр дамжуулж ятгаж байгаачлан бид Христийн төлөө та нараас гуйя. Бурхантай эвлэцгээ.

- 2Коринт 5:20

Аугаа хүчирхэг Бурхан бидэнд Өөртэйгээ хамтран ажиллах завшаан олгосон бөгөөд Өөрийнхөө зан чанар, арга замыг илчилдэг. Энэ нь ганц бие хүмүүсийн хувьд ч, гэр бүлтэй хүмүүсийн хувьд ч үнэн юм. Зохиолч, илгээлтийн эзэн **Рик Реннер** ингэж хэлжээ:

“2Коринт 5:20 дээрх Паулын үгээс үзбэл, бид газар дээр Тэнгэрийг төлөөлөхөөр ирсэн тэнгэрийн төлөөлөгч нар - сайдууд ажээ. Бид Христийн төлөөлөгч нар учраас бас Тэнгэрийн дуу хоолой мөн. Тиймээс Эзэний нэрээр ярьж, үйлдэх бүрэн эрхтэй. Түүнчлэн Тэнгэрийн элчин сайдуудынхаа хувьд бид Тэнгэрийн эх үүсвэрээр бүрэн чиглүүлэгдсэн, бүрэн хамгаалагдсан, бүрэн суурьлагдсан, ар тал маань бүрэн найдвартай гэсэн үг.”

Та болон таны хань ижил дэлхий дээр Бурханыг төлөөлөхөөр иржээ. Бурхан та хоёроор дамжуулж, дэлхий дээр Өөрийнхөө хайрыг харуулж, үл итгэгч хүмүүсийг Өөр рүүгээ дууддаг. Тэгвэл та хоёр аль зэрэг хайраар дүүрэн харагддаг вэ? Хэрэв та хоёрыг үлгэрлэн дагадаг хос байсан бол, тэд та хоёрын ямар зан чанарыг хараад Бурхан руу ойртох бол? Ямар зан байдал чинь тэднийг Бурханаас холдоход хүргэх бол?

Христийн бие олигтой амьдрахгүй, хайрлахгүй бол, хүмүүс Бурханы нэрийг доромжилдог (Ром 2:24-г үзнэ үү). Бурханыг сайнаар төлөөлөхгүй байгаа гэрлэлтийн хандлага, үйлдэл, өөрчлөх хэрэгтэй талыг чинь Ариун Сүнс танд харуулж байна уу? Ямар тал байна?

Өөрийгөө ялаж, итгэл найдваргүй царайлах шаардлагагүй! Сүнс харуулж байгаа бүхнээ өөрчлөхийг хүсдэг. Та ердөө Түүнд бууж өгөөд, Түүнээс тусламж гуйх хэрэгтэй.

Өсөх төлөвшиж Эзэнийг илүү сайнаар төлөөлөх хэрэгтэй тал бидний амьдралд бий. Үүнийг хэрхэн хийх вэ? Бурханы Сүнсний хүчээр! Бид Сүнсний хайрыг хүлээж авахдаа, хань ижлээ болон эргэн тойрныхоо хүмүүсийг хайрлах чадвартай болдог. Эдгээр хэсгийг анхааралтай уншаад, Түүний хайрыг хүлээж авахын тулд юу хийх талаар Ариун Сүнсний илчилсэн зүйлийг бич.

Ром 5:5 • Ефес 3:16-19 • 1Иохан 4:7-17

...Бурхан бол хайр. Хайрын дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна. Үүгээр шүүлтийн өдөрт биднийг зоригтой байлгахын тулд хайр нь бидний дунд төгс болов.

Дөрөвдүгээр өдрийн судлал

ШИНЭ ЗҮРХ

Түүнээс гадна, Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг оруулна. Би та нарын махан биеэс чулуун зүрхийг зайлуулж, та нарт махан зүрхийг өгнө. Би Өөрийн Сүнсийг та нарын дотор оруулж, та нарыг Өөрийн тогтоолуудаар явуулна. Та нар Миний зарлигийг сахихад анхаарах болно.

- Езекиел 36:26-27

Та гэрлэлтэд бага зэрэг айдас, зовнилтой хандаж байж болно. Магадгүй хувийн туршлага юмуу соёлын хэм хэмжээнээс болж та гэрлэлтийг ачаа дарамт шиг үздэг болсон байж болох. Магадгүй та бүтэлгүйтлээс айсандаа зүрхээ хатууруулсан байж болно. Магадгүй та “Би өнгөрлөө гэж үү?” гэсэн асуултыг өөртөө тавьсан байх. Гэхдээ Бурхан танаар дамжуулан анхдагч төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд бүх саадыг зад татаж, таныг цэцэглүүлэх, Түүний хайрын хүрэлтэд мэдрэг, зөөлөн зүрхийг хайрлахыг хүсдэг.

Таны зүрхнээс илүү чухал зүйл Есүст байхгүй. Лук 8:5-15 дээрх Есүсийн үгийг үзнэ үү. Энэ хэсэгт Ариун Сүнс танд юу харуулж байна? Ариун Сүнс таны зүрхний талаар юу өгүүлж байна?

Энэ сургаалт үгийг мөн Матай 13:3-23, Марк 4:3-20-с үзэж болно.

Зүрхэнд чинь юу байгааг та өөрөө мэдэж чадахгүй. Гэхдээ Эзэн илчилж бас эдгээж чадна.

Эдгээр үнэнийг тунгаан бод.

... Учир нь ЭЗЭН бүх зүрхнүүдийг шалгаж, бодол санааны хандлага бүрийг мэддэг юм. Хэрэв чи Түүнийг хайвал, Түүнийг олно.

- Шастирын дээд 28:9

“Зүрх бол бүх зүйлээс илүү хуурамч бөгөөд эдгэршгүй өвчтэй юм. Үүнийг хэн ойлгож чадах билээ? ЭЗЭН Би зүрхийг эрэлхийлж, оюун бодлыг шалгадаг нь хүн бүрд замуудынх нь дагуу, үйлсийнх нь үр дүнгийн дагуу өгөхийн тулд юм.”

- Иеремиа 17:9-10

“Өө, Бурхан, намайг судлан, миний зүрхийг мэдээч. Намайг шалгаж, миний бодлуудыг мэдээч. Миний дотор ямар нэгэн хөнөөлт үйл буй эсэхийг харж, мөнхийн зам уруу намайг залаач.”

- Дуулал 139:23-24

Түр зогсоод ийнхүү залбирна уу: “Эзэн минь, намайг гэрлэлтдээ яаж хандаж байгааг харуулаач. Тэгээд Есүсийн нэрээр эдгээгээч.” Дараа нь хэсэг чимээгүй байгаад, Ариун Сүнсний илчлэх зүйлсийг чих тавин сонс. Тэдгээрийг нь бичиж аваад, нэг нэгээр нь Ариун Сүнсэнд даатгана уу.

Танд Бурханы хайр, нигүүлслийг хүлээж авах хүсэлтэй, шинэ зүрх хэрэгтэй байна уу? Тэнгэрийн Аав тань танд биелүүлэх хүч чадлыг нь өгөлгүйгээр, ямар ч төлөвлөгөө өгөхгүй. Тиймээс Ааваасаа тусламж гуй.

“Аав аа, надад гэрлэлтийг бэлэглэсэнд баярлалаа. Гэрлэлтдээ буруу ташаа хандсанаасаа болж, хамаг ерөөлөө алдахыг бүү зөвшөөрөөч. Таны хүрэлтэд мэдрэг бөгөөд зөөлөн, цоо шинэ зүрхийг хайрлаач. Гэрлэлтээ Таны нүдээр харах, цоо шинэ харааг надад хайрлаач. Хамгийн муу муухайг төсөөлөх биш, хамгийн сайн сайханд итгэхэд минь туслаач. Амьдралынхаа бүх тал дээр Таныг тэргүүнд тавихад минь туслаач. Баярлалаа Аав аа, Есүсийн нэрээр. Амень.”

Тавдугаар өдрийн судлал

ГЭРЛЭЛТИЙН ӨРГӨЖИЛТ

... *“харин Есүс тэдэнд*

—Ингэж хэлэхийг бүх хүн хүлээн зөвшөөрч чадахгүй, харин энэ нь өгөгдсөн хүмүүс л чадна. Учир нь эхийнхээ хэвлийгээс төрөхдөө тайган төрсөн хүн байдаг. Хүмүүсийн тайган болгосон тайган хүмүүс ч байдаг. Мөн тэнгэрийн хаанчлалын төлөө өөрсдийгөө тайган болгосон тайган ч байдаг юм.

Үүнийг хүлээж авах чадвартай нэг нь хүлээн аваг гэж айлдав.”

- Матай 19:11-12

Гэрлэлтээ өргөжүүл. Энэ нь өсөх, тэлэх, сунгах, дэлгэрүүлэх гэсэн үг. Гэрлэлтийг бүтээсэн Бурхан та хоёрын нэгдлийг өргөжилтийн зэвсэг шиг хэрэглэхийг хүснэ. Хэрэв та Түүний шилдэг төлөвлөгөөнд захирагдбал, Бурхан хань ижлээр чинь дамжуулан таныг улам л Есүстэй адилхан болгож, хийсэн бүхнийг чинь цэцэглүүлнэ.

Төмөр төмрөө ирлэдэг. Тийнхүү хүн хүнээ хурцалдаг.

- Сургаалт 27:17

Гэрлэлтэд хос эсрэг хүнээ тагдаг гэдэг. Энд ч өөрийн гэсэн давуу тал бий: Ялгаатай тал нь биднийг нэгтгэдэг. Гэхдээ цаг хугацааны явцад бидний таталцуулсан яг тэр зүйл нь биднийг түлхэлцүүлэхэд хүргэж мэднэ.

Та хосынхоо ямар гурван чанарт хамгийн их татагдсан бэ? Та хосынхоо ямар гурван чанарт хамгийн дургүй вэ? Эдгээрт ямар нэгэн холбоо байна уу?

Миний сэтгэлийг хамгийн их татсан 3 зүйл

Миний дургүйг хүргэдэг 3 зүйл

**Хосын ялгаа нь хуваах биш, нэгдүүлэх зорилготой
гэдгийг бүү мартаарай.**

Бурханы Сүнс танд болон таны хосод цэц ухааны үгийг хэлдэг бөгөөд цэц ухаан нь гагцхүү та хоёрыг хамтдаа залбирч байхад л ирдэг юм биш. Та хоёрын хоёулангийн чинь мэдэх хэрэгтэй зүйлийг Ариун Сүнс хэн нэгэнд чинь ганцааранд нь хэлж болно. Бурханаар удирдуулсан, ерөөгдсөн шийдвэр гаргахад Ариун Сүнс та хоёрын хэн хэнд хайрласан ухаарал хэрэгтэй. Дараах асуултад шударгаар хариулна уу:

Би хань ижлийнхээ хувь нэмэрт (цэц ухаан, чиглүүлэг, зөв зүйтэй шүүмжлэлд) аль хэрэг нээлттэй/хаалттай байдаг вэ?

Аль тал маань түүний хувь нэмэрт илүү нээлттэй байна вэ? Аль тал маань арай хаалттай байна вэ? Яагаад тэр вэ?

Таныг өдий зэрэгтэй хүн болоход Бурханаас хайрласан хань ижил чинь маш том үүрэг гүйцэтгэжээ. Энэ хүнтэй гэрлэсний

ачаар таны зан чанарт гарсан нэг сайн зан чанарыг нэрлэнэ үү. Та хоёрын амьдралыг өргөжүүлэхийн тулд Бурхан үүнийг чинь хэрхэн ашиглаж байна?

Амьдралыг чинь хурцалж, өргөжүүлэхэд тусласных нь төлөө та ханьдаа талархаж байсан уу? Талархаагүй бол, чин сэтгэлээсээ таларх.

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

Мессенжер Интернэйшнэлийн “Гэрлэлтийн түүх” сургалтын хөтөлбөрийн 1-р видео хичээлийг үзнэ үү.

1. Гэрлэлт нь анхнаасаа л Бурханы санаа байжээ. Бурхан гэрлэлтийг бүтээсэн бөгөөд гэрлэлтэд хандсан төлөвлөгөө, зорилготой байв. Эхлэл 1:27-28, 31; Малахи 2:15-р ишлэлийг анхааралтай уншаад, Бурханы зүгээс гэрлэлтэд хандсан таван зүйлийг тодорхойлно уу. Тэгээд дараа нь эдгээр таван зүйлийн оронд Сатаны бий болгохыг хүсдэг таван дууриамал завхралыг бичнэ үү.

Бурханы зорилго

Сатаны дууриамал завхрал

2. Бурханлаг гэрлэлт нь бусдын амьдралд нөлөөлдөг. Яг ингэж амьдарч чадаж байгаа хосыг нэрлэж чадах уу? Тэд яаж гэрлэлтэд сайн нэр авчирч байна? Гэрлэлтийн сүнсээ хамгаалахын тулд та тэднээс юу сурах вэ?

3. Матай 19:6 дээр Есүс “Тиймд тэд цаашид хоёр бус, харин нэг бие махбод юм. Иймээс Бурханы хамтад нь нийлүүлснийг хэн ч бүү салгаг” хэмээн айлдсан. Махбод гэхээр таны санаанд юу орж байна? Эдгээр санаа нь танд гэрлэлтийг шинэлэг, эерэг гэрлээр харахад хэрхэн туслаж байна?

4. Матай 19:10-12 дээр Есүс “Ингэж хэлэхийг бүх хүн хүлээн зөвшөөрч чадахгүй, харин энэ нь өгөгдсөн хүмүүс л чадна. Учир нь эхийнхээ хэвлийгээс төрөхдөө тайган төрсөн хүн байдаг. Хүмүүсийн тайган болгосон тайган хүмүүс ч байдаг. Мөн тэнгэрийн хаанчлалын төлөө өөрсдийгөө тайган болгосон тайган ч байдаг юм. Үүнийг хүлээж авах чадвартай нэг нь хүлээн аваг” гэж айлдсан. Гэхдээ хэрэв та гэрлэлтээ тултал нь өргөжүүлж чадна гэвэл, өргөжүүл. Гэрлэлтийн өргөжилт гэж чухам юу вэ?

5. Гэрлэлт нь нэг эрэгтэй, нэг эмэгтэй хоёрын дунд насан турш үргэлжлэх, ариун гэрээ юм. Энэ хэсгээс та гэрлэлтийнхээ төлөө тэмцэх ёстой гэсэн бодолд хүргэсэн ямар нэг зүйл сурсан уу? Цоо шинэ үзэл бодол хүлээж авсан уу?

6. Есүс “Нүд нь биеийн гэрэл гэж хэлсэн (Матай 6:22). Энэ нь та юмсыг хэрхэн үзнэ - яг л тийм болно гэсэн үг. Энэ нь нэн ялангуяа гэрлэлтийн амьдралд үнэн байдаг. Гэрлэснээрээ “Би өнгөрлөө!” гэдэг үзэл бодолд та хэрхэн ханддаг вэ?

Бичээс биднийг сүнслэг тулаан хийж байна гэсэн (Ефес 6:12-13 болон 2Коринт 10:3-4). Энэ үг нь та хоёрыг зөрчил, бэрхшээлийг арай өөрөөр харахад тус болдог уу? Тус болдог бол хэрхэн тусладаг вэ?

7. “Гэрлэлтийн түүх” нь сүй тавьсан эсвэл ганц бие эвсэл хэдийнээ гэрлэсэн хүмүүст туслахын төлөө бичигдсэн юм. Тэгвэл та энэ судлалаас юу олж авахыг хүсч байна?

Та гэрлэсэн (эсвэл байсан) бол “Зөвшөөрч байна” гэж хэлэхээсээ өмнө юуг мэддэг байсан болоосой гэж боддог вэ? Бүлгийнхээ хараахан гэрлээгүй яваа хүмүүст юу гэж зөвлөх вэ?

Бүлгийн хураангуй:

- Бурхан бусад ямар ч институциэс өмнө гэрлэлтийн гэрэгээг бүтээжээ. Бурхан гэрлэлтийг тодорхойлсон бөгөөд үүнийгээ хэзээ ч өөрчлөхгүй.
- Бурханлаг гэрлэлт нь яг л амийн мод шиг байх ёстой. Бид Бурханы хайрыг үлгэрлэн харуулах ёстой. Нэгэнтээ Еденд алдагдсан бүхнийг Бурхан биднээр дамжуулан эргүүлэн сэргээхийг хүсч байна.
- Гэрлэлтийнхээ хэсэг бүрт Бурханыг урьсанаараа гэрлэлтийнхээ сүнслэг байдлыг сахин хамгаал. Бурхан танд хайрлаж, хайрлуулах шинэ зүрхийг, гэрлэлтээ Бурханы нүдээр харах шинэ нүдийг өгнө.
- Өөр дээрээ төвлөрөх нь Бурханы танд өгөхийг хүсч буй гайхамшигтай гэрлэлтийг эдлэхэд тээг болдог хамгийн том саад юм.
- Гэрлэлтийг довтлох нь хүмүүстэйгээ тогтоосон Бурханы харилцаа руу довтлохтой адил юм.
- Бурхан бидний амьдралын хэсэг бүрийг өргөжүүлэх гэж бүтээсэн юм.



ХОЁР

Бариагаа харж эхлэ

Нэгдүгээр өдөр

Хамгийн романтик ном кино нь хайр сэтгэлийн эхлэлийг л үзүүлдэг болохыг та анзаарсан уу? Хамгийн дуртай романтик сонгодог зохиолоо сана даа (зарим нь амархан санах байх, зарим нь санах гэж зүдрэх байх). Ямар түүх гардаг билээ? Кино үйл явдлынхаа эргүүлгээр танаар даажигнаж, дурлалт хосын анхны үнсэлтийг хойшлуулах тоолонд та суудал дээрээ өндөлзөнө. Мэдээж тэр хооронд өрсөлдөгч, хүсээгүй хэрүүл маргаан, шарх гэх мэт түр зуурын саад тотгор тохиовч, эдгээр нь бүгд төгсөнө гэдгийг бид мэднэ. Амьдралын эрээн барааныг үл харгалзан, нүдэнд нь оч бутарсан хос маань саар бүхнийг ялан дийлж, түүх “амар сайхандаа жаргана.”

Тэд амар сайхандаа жаргадаг юм байж. Гэхдээ яг яаж? Гайхамшигтай эхлэл нь хамгийн амархан хэсэг юм. Түүхийн дунд ба төгсгөл нь л хамгийн хэцүү байдаг.

Манай өнөөгийн соёл хайрын түүхийн эхлэлээр л бүхнийг дүгнэдэг болсон. Хос хуримдаа бэлтгэх гэж хамаг цагаа зардгаас биш, хуримын маргаашаас хэрхэн амьдрахаа ердөө боддоггүй. Сүйт бүсгүй нь төгс даашинз олох гэж улаа эргэтэл гүйдгээс биш, харилцаа гэдэг энэ уудам ертөнцөд хэрхэн алхах талаар нэг ч зөвлөгөө сонсдоггүй. Тэгээд шидэт үлгэр төгсөхийн цагт бодит асуудалтай жинхэнэ харилцаанд тун цөөхөн хос л бэлтгэлтэй байдаг.

Хуримын өдөр бол итгэл найдвар, гоо үзэсгэлэн, баяр хөөрөөр халгиж цалгисан цаг байх ёстой. Гэхдээ энэ их итгэл найдвар, гоо үзэсгэлэн, баяр хөөрөө яаж насан турш хадгалахыг хос маань хуримынхаа өдөр л бодож санах ёстой. Амар сайхандаа жаргах нь бидний туйлын цэг биш, харин бидний мөрдөх ёстой, маш нарийн няхуураар сүндэрлүүлэхээр шийдсэн эцсийн зогсоол билээ.

Эргэн тойронд чинь хүний ур ухаанаар бүтсэн, сор сод болсон, үзэсгэлэнтэй сайхан бүтээл байна уу? Энэ нь барилга байшин, машин, тэр бүү хэл таны сууж байгаа сандал ч байж болно. Энэ нь суу ухаантай, алтан гартай хүнээс төрсөн гайхамшигтай бүтээл ажээ. Гэхдээ энэ бүтээл хоёр удаа урлагдсаныг та бид анзаардаггүй байх. Бүтээл нь эхлээд бүтээгчийн тархинд төрөөд, үүнийхээ дараа бодитоор урлагдсан. Мэдээллийн ур хийц нь ямагт материаллаг ур хийцийн өмнө ордог. Эхний угсралт нь эцсийн бүтээгдэхүүний талаарх маш тодорхой алсын хараа шаардана. Хоёр дахь угсралт нь энэ алсын хараандаа хүрэх материал, хөдөлмөрийг шаардана. Бидний барьж байгуулж буй бүхэн энгийн байна уу, төвөгтэй байна уу, ярвигтай байна уу хамаагүй - бодитоор биелэхээсээ өмнө эхлээд төсөөлөлд мэндэлдэг.

Зураг төсөл гаргахгүйгээр байшин барьдаг хүн байхгүй. Зураг төсөлгүй барьсан байшин нь байшин биш, гамшиг болно! Сайхан байшин бүр нь маш сайн төлөвлөсөн дизайнаас эхэлнэ. Зураг төслийн дараа л байшин хүч хөдөлмөр, сайн материалаар баригдана.

Түүнчлэн зураг төслийг бас барилгын үнэ өртгийг тооцоход ашигладаг. Байшингийн үнэ өртгийг тооцохгүйгээр байшин барьдаг хүн байхгүй. Есүс бидэнд амьдралаа хэрхэн сүндэрлүүлэхийг заахдаа энэ асуултыг тавьжээ:

Та нарын хэн чинь цамхаг барья гэж хүсвэл, эхлээд үүнийг дуусгах хангалттай хөрөнгөтэй юу гэдгээ үзэхийн тулд суугаад зардлыг нь тооцоолдоггүй вэ? Тэгэхгүй бол, түүнийг сууриа тавьчихаад дуусгаж чадахгүйг нь харсан бүхэн түүнийг шоолж, “Энэ хүн барьж эхэлсэн ч, дуусгаж чадсангүй” гэх болно.
(Лук 14:28-30)

Байшин барихад хэрэгжих тэр л үнэн гэрлэлтийг барьж байгуулахад хэрэгжинэ. Тэгэхээр та ямар төрлийн гэрлэлт барьж байгуулж байна? Гэрлэлтийг барьж байгуулахад танаас шаардагдах үнэ өртгийг та тооцсон уу?

Бурханбиднийгэрлэлтийгзовиуршаналал,ичгүүрээртөгсөөсэй гэж хүсдэггүй. Тэрбээр биднийг гэрлэлтээ барьж дуусгахаасаа өмнө бууж өгөөсэй гэж хүсдэггүй. Таны гэрлэлт дөнгөж эхэлж байна уу эсвэл зөрчил тэмцэл дунд байна уу хамаагүй - Бурханы төлөвлөөг хэрэгжүүлж эхлэхэд хэзээ ч оройтохгүй. Бид Бурханы дотор л Түүний аугаа мөн чанарыг тусган харуулсан гэрлэлтийг барьж байгуулж чадна. Гэхдээ биднээс илүү Бурхан л бидэнд амар сайхан төгсгөлтэй, төгс төгөлдөр урлагдсан гэрлэлтийг хүсдэг.

Энэ бүлэг нь таныг гэрлэлтийнхээ түүхийг сайхнаар бичүүлэхийн тулд төлөвлөх чадвартай болгох үнэнийг зааж өгнө. Түүнчлэн бид хоёр хожим ирэх амьдралын шуургийг даван туулахын тулд гэрлэлтийнхээ эхэнд хэрхэн бат бөх суурь цутгасан түүхээсээ хуваалцана. Тэгээд таныг амар сайхан жаргааж төлөвлөгөөгөө гаргахад тань боловсруулж бас тушаал өгнө. Ном маань зарчмаар эхэлж, практик заавраар төгсөнө. Энэ бүлэг нь зөвхөн шинээр гэрлэсэн хүмүүст юмуу гэрлээгүй хүмүүст зориулагдаагүй. Ахмад хос ч бас харилцаагаа шинэчилж болно. Учир нь бид хоёр ч бас шинэчилсэн!

Бурхан төгсгөлөөс эхэлдэг

Эхлээд “Бид яагаад үүнийг хийж байна? Бид хаашаа явж байна?” гэдэг асуултыг тавихгүйгээр гэрээний харилцаанд орох утгагүй юм. Гэрээ бүр тохирох алсын хараатай байх ёстой. Жишээлбэл

Бурхан байна. Бурхан Абрахамтай гэрээ байгуулахдаа, тархиндаа хэд хэдэн тодорхой зорилготой байжээ.

Бурханяагаад Абрахамыг сонгосон хүмүүсийнхээ эцэг болгосон гэж бодож байна? Бид “Учир нь Абрахам аугаа итгэлтэй байсан” гэж хариулах байх. Мэдээж итгэл нь Бурханы төлөвлөгөөтэй хамтран ажиллахад амин чухал ч, Бурхан Абрахамыг итгэлээс нь болж сонгоогүй юм. Бурхан Абрахамыг сонгосон нь үр удамд нь Өөрийгөө хэрхэн дагахыг зааж өгөхийн төлөө байжээ:

Би түүгээр, түүний хүүхдүүд болон гэр бүлийнхэнд тушаалгаж ЭЗЭНий замаар дагуулан, зөв ба шударга ёсыг үйлдүүлэхээр Би түүнийг сонгож авсан юм. Энэ нь ЭЗЭН түүний тухай хэлснээ Абрахамд биелүүлэхийн тулд болой. (Эхлэл 18:19)

Бурхан тэр үр хүүхэдгүй нүүдэлчинг сонгохдоо, дээгүүр нь өнгийж, үр удмыг нь харжээ. Абрахам “үр удамдаа Эзэний замыг дагахыг тушаах” нь Бурханы хувьд амин чухал байв. Учир нь Бурхан Абрахамын угсаагаар авралын түүхийг бичихийг хүсчээ. Абрахам, Сара хоёр алдана гэдгийг Бурхан мэдэж байсан ч, тэд зөв түүхий эд гэдгийг бас мэдэж байв. Бурхан бидэнтэй гэрээ байгуулах бүрийдээ, ямагт үр удмыг маань бодож байдаг. Учир нь Бурхан маргааш руу айлчилсан бөгөөд бидний маргааш байгуулагдахын тулд өнөөдөр юу хийгдэх ёстойг Тэр мэднэ.

Бурханы Абрахамтай байгуулсан гэрээ биднийг хүртэл тэлжээ. Абрахам итэлээрээ үр хүүхэдгүй өвгөнөөс тэнгэрийн одод шиг олон үр садтай эцэг болж хувирчээ. Ямар ч улс үндэстэнгүй тэнүүлчин бүх үндэстний итгэлийн эцэг болсон юм.

Абрахам агуу их, хүчирхэг үндэстэн болж, дэлхийн бүх үндэстэн түүгээр дамжуулан ерөөгдөх биш үү? (Эхлэл 18:18)

Бидний амьдрал Абрахамынхаас өөр боловч, зарчим нь ялгаагүй юм. Бурхан Өөрийнх нь гэрээг өөрөөрөө дамжуулж дэлгэрүүлдэг хүмүүсийг эрэн хайдаг. Тэгэхээр таны түүх нь зөвхөн таны хань ижил та хоёрын түүх биш юм.

Бурхантай тогтоох харилцаагаар дамжин илэрхийлэгдэх Бурханы гэрээний бүрэн үр нөлөөг гагцхүү тэнгэр л илчилнэ. Бурхан үүнийг танаар (таны өвөөр) дамжин өнгөрөх хүн бүрийн амьдралд, таны нөлөөний цар хүрээнд багтах хүн бүрийн амьдралд хүргэхийг хүснэ. Та Бурханаас танаар төгсөхгүй бас таны хязгаарлагдмал ойлголтоор төгсөхгүй алсын харааг хүлээж авах ёстой. Бурхан таны гэрлэлтийн түүхэнд ямагт үр садыг чинь багтаадаг.

Хоёрдугаар өдөр

Бурханы хүүхдүүд

Та нар биш, харин Бурхан гэрлэлтийг бүтээсэн бүлгээ. Түүний Сүнс гэрлэлтийн эд эс бүрт оршино. Бурхан гэрлэлтээс юу хүснэ вэ? Бурханы хүүхдүүдийг хүсдэг буюу... (Малахи 2:15)

Бурханы хүүхдүүд. Бурхан гэрлэлтээс үүнийг л хүсдэг. Энэ нь Бурхан газар дэлхийгээр дүүрэн хүүхэд хийхийг хүсч байна гэсэн үг үү? Тийм бөгөөд үгүй.

Малахи 2:15 дээр Бурхан гэрлэлтээр дан хүүхэд хийхийг хүсдэг гэж хэлээгүй, харин Бурхан бурханлаг хүүхдүүдийг хүсдэг гэжээ. Бурхан Өөрийг нь алдаршуулж, Өөрийнх нь замаар алхлах бүх насны хүүхдүүдийг хүсдэг. Бид Бурханы элчин сайдууд гэдгийг бүү мартаарай. Бурханы Өөрийгөө бидэнд бөгөөд биднээр дамжуулан илчлэх хүсэлтэй.

Та хэзээ ч хүүхэд өсгөж үзээгүй байсан ч, Бурхан таны гэрлэлтээр дамжуулан Бурханы хүүхдийг өсгөхийг хүсч байна. Бурхан таныг Өөрийнхөө алдрын төлөөлөгч болгон шинэчилж, Аавтай чинь адилхан болгож хэвлэхийг хүснэ. Амьдралаа өөр хүнтэй хуваалцах нь танд Бурхантай адилхан болох олон боломжийг олгоно. Бурханлаг зан чанар нь аз жаргалын давалгаа дунд бүрэлддэг биш, гэрлэлтийн галт зууханд хатаагддаг болохыг бид сурсан билээ.

Жон миний бие гэрлэлтийг зуухтай, харин амьдралаа төмрийн хайлштай адилтгадаг. Дүрэлзсэн зуух хайлшийг яадаг вэ? Гал нь

төмрийн бохирдлыг ил гаргадаг. Миний хуримын бэлзэг цэвэр алт шиг харагдаж байж болох ч, орцынх нь тавин хувь нь өөр бусад хольц байдаг. Хэрэв би бөгжөө зууханд хийбэл, эдгээр хольц нь ил гарна. Үүнтэй адил гэрлэлтийн амьдралд бидэнд тулгардаг асуудал нь бидний амьдралын бохирдлыг шал дэмий маргаанаас авахуулаад хурц асуудал хүртэл бүгдийг ил гаргана. (Зарим бохирдол нь бусдаасаа хавьгүй өндөр температурын гал шаардана).

Гэрлэлт бидний төгс бус талыг илчлэх үед хань ижлээ буруушаах амархан. Тэгээд ч биднийг гэрлэхээс өмнө тийм асуудал гардаггүй байсан шүү дээ. Хань ижил маань бидний сул талыг улам ил болгодог учраас, бид хань ижилдээ уурлах үедээ гэрлэлт биднийг Есүстэй адилхан болгож байгаад Бурхандаа талархах хэрэгтэй. Энэ чинь л бидний туйлын зорилго биз дээ? Зуухны аналогийг нь баярламаар эд биш боловч, амар сайхандаа жаргах аян зам нь үлгэрээс тэс өөр байдаг юм шүү. Цэцэгт талаар алхалж байгаа биш, Эверест рүү л авираад байх шиг санагдах үе зөндөө шүү.

Хүнд хэцүү, аюултай Эверест рүү авирахын тулд цаст Гималайг давах зоригтон нь тархиндаа хоёр зүйлийг хийх ёстой. Нэгдүгээрт - энэ байлдан дагуулал нь тэдний сэтгэл санааны болон махан биеийн тэвчээрийг шалгана. Эдгээр эрэлхэг эрчүүд бүсгүйчүүд нь айсуу аюулыг бүгдийг нь нэг бүрчлэн мэдэхгүй ч, юутай ч асуудал бэрхшээл ирнэ гэдгийг мэддэг. Хоёрдугаарт - тэд дэлхийн хамгийн өндөр уулын оргилд гарах гэж яваа зорилгоо санах хэрэгтэй. Тэдний хувьд далайн төвшнөөс 8,848 м өндөр газарт хүрч байж л ялалт байгууллаа гэж ярина. Үүнийг ойлгоогүй аялагчид эхний хүндхэн даваан дээр л буцдаг.

Гэрлэлтийн хувьд ч ялгаагүй. Бэрхшээл нь бидний түүхийн амин чухал хэсэг гэдгийг мэдэх аваас сэтгэл санааны, махан биеийн, сүнслэг хүчин чадал маань шалгагдах үед бид үйрэхгүй. Хэрэв бид бариагаа бодож эхэлж, байгуулбал хэцүү цаг ирэхэд эргэж буцахгүй.

Сүнслэг төлөвшлийн талаар зааж байхдаа Есүс “Өөрсдөд нь бат үндэс байхгүй, харин тэд түр зуурынх бөгөөд дараа нь үгнээс болж зовлон, хавчлага тохиолдоход тэд тэр даруй унадаг” гэжээ (Марк 4:7). Эдгээрийг Грекээр *thlipsis* болон *diogmos* гэдэг. *Thlip-*

sis нь “шаналал, дарамт, золгүй байдал, зовлон” юм. Diognos нь “хэн нэгнийг сүрдүүлж, дарамтлах” хөтөлбөр юмуу үйл явц юм. Аль аль нь таатай сонсдохгүй байгаа ч, эдгээр хүч нь Бурхан доторх бидний өсөлтийг дэмжиж өгдөг юм. Паул ч Есүсийн үгийг давтаж хэлсэн:

Түүгээр ч барахгүй, мөн зовлонтойдоо баярладаг. Учир нь зовлон зүдгүүр нь тэвчээрийг, тэвчээр нь туршлагатай байхыг, туршлагатай байх нь найдварыг төрүүлдэг. Найдвар нь урам хугалдаггүй. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг. (Ром 5:3-5)

Паул биднийг зовлон, сорил дунд баярла гэжээ. Сорил нь бидэнд хүчтэй зан чанарыг хөгжүүлэх боломж олгодог. Асуудал биднийг Бурхантай адил болох байр сууринд гаргадаг. Тийнхүү бид Бурхан бидэнд хайртай, бидний сайн сайхны төлөө байдаг - хамгийн аймшигтай тэмцэл дунд ч зүрхийг минь дүүргэхээр Ариун Сүнсээ өгтлөө бидэнд санаа тавьдаг гэдэг мэдлэгт хамаг найдвараа тавьж болно.

Түүнчлэн хүний асуудлын зохиолч нь Бурхан биш гэдгийг Бичээс маш тодорхой хэлдэг. Хамаг гай гамшиг, хавчлагын ард Сатан байдаг ч (Марк 4:15, Иаков 1:12-13), Бурхан дайсны схемийг өөрийнх нь эсрэг хэрэглэнэ. Аугаа Аврагчийн мутар дор биднийг Бурханаас салгах учиртай зүйлс нь биднийг Түүнтэй улам адилхан болгох зэмсэг болдог юм.

Дайсан гэрлэлтийг болон үүний төлөөлдөг бүхнийг үзэн яддаг. Бидний нэгдлийг салгахын төлөө дайсан үнэхээр хүнд хүнд сорил өгч, чадах мэдэх бүхнээ л хийнэ. Нэгдлийнхээ алсын харааг тээж, Бурхан биднийг хүнд байдлаас гаргана гэдгийг мэдэх нь биднийг дайсны довтолгооны өмнө дийлдэшгүй болгодог. Бурхан биднийг гэрлэлтийг маань довтолох цохилтыг дааж гарах төдий л амьтай голтой байгаасай гэж хүсдэггүй. Бурхан биднийг цохилтоор дамжуулан улам хүчирхэгжээсэй гэж хүсдэг. Харин үүний гол түлхүүр нь юуны (Бурханы зорилго) төлөө тэмцэж буйгаа, хэнтэй (Сатантай) тэмцэж буйгаа, Хэн (Бурхан) бидний тал болохыг санаж байх юм. Бидний итгэл хийгээд найдвар нь үнэндээ

бэрхшээлээр дамжин хүчирхэгждэг. Гагцхүү бид бидний доторх Бурханы ажлыг дуусахаас нь өмнө больчихгүй л байх хэрэгтэй.

Есүсийн амар сайхан төгсгөл

Есүс ямар ч хүнээс илүү зовсон. Тэр төгс Бурхан боловч шударга бус үхлээр үхэхээр, өвчин, доромжлолыг эдлэхээр бидэн шиг болсон. Есүс биднийг Бурхантай эвлэрүүлэх арга замыг гаргаж өгсөн боловч, хүн төрөлхтөний дийлэнх хувь нь Түүнийг эсэргүүцээр л байна.

Есүс яаж энэ их өвчин, эсэргүүцлийг тэвчив ээ? Хариулт нь тун энгийн боловч, гайхалтай гүн гүнзгий юм: Тэрбээр хэзээ ч амар сайхандаа жаргах төгсгөлөө мартаагүй. Түүний амьдралаас бид түүхээ бичих жишээг авна:

Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс рүү хараагаа чиглүүлье. Тэр Өөрийнх нь өмнө тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшгийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийн баруун гарт заларсан юм.
(Еврей 12:2)

Есүс хаашаа явж буйгаа мэдсэн учраас энэ бүхнийг тэвчсэн. Тэрбээр зовлонг сэтлэн амлалтыг харжээ.

Энэ тухай Еврей 12:1-2-р ишлэл хэлдэг:

Өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе.
... Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлье. Тэр Өөрийнх нь өмнө тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшгийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн... .

Ойлгож байна уу? “Түүний өмнө баяр баясгалан тавигдсан байсан.” Есүс цовдлуулна гэхээс хөл газар хүрэхгүй хөөрч байсан уу? Мэдээж үгүй. Тэрбээр цовдлуулахынхаа өмнөх шөнө Аваасаа өөр арга зам бий эсэхийг асуун шаналсан. Гэхдээ маш олон гэрлэлтэд байдаггүй нэгэн зүйл Есүст байв. Түүнд ер бусын

алсын хараа байжээ. Тэрбээр нөхцөл байдал өнгөрч хүч ба амлалт ирэхийг сонголтоороо харж чаджээ. Есүс хаашаа харж байсан бэ? Хариултыг нь Ефес 5-р бүлгээс олж үзнэ:

Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла. Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад түүнийг ямар ч толбогүй, ямар ч үрчлээсгүй бөгөөд тиймэрхүү ямар ч зүйлгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн ажээ. (Ефес 5:25-27)

Есүсийн амар сайхан төгсгөл нь бид юм. Түүний өмнө тавигдсан баяр хөөр нь бид юм. Өөрийнхөө Сүйт бүсгүй болох бидэнтэй эвлэрэхийн тулд Есүс загалмайг хүлцсэн билээ. Чуулган өдгөө Есүсийн дотор өмнөх байдлаасаа ичэх ичгүүргүй болж, цоо шинээр тодорхойлуулах болсон юм. Бидний гэрлэлтэд ийм төрлийн тууштай байдал, нигүүлсэл, болзолгүй хайр байх ёстой. Түүнчлэн бидэнд айсуу зүйлст найдах, бэрхшээл дундуур гаргах алсын хараа байх ёстой.

Еврей номын бичээч цааш нь ийнхүү бичжээ:

Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүйн тулд Түүнийг санагтун. Тэрээр Өөрийнх нь эсрэг нүгэлтнүүдээс тийм эсэргүүцлийг тэвчсэн ажээ. (Еврей 12:3)

Хүн бүр л итгэлдээ муурах үе байдаг. Тиймээс л Еврей номын зохиогч тэр үедээ тэнхээгээ барахгүйн тулд гэж хэлжээ. Сайн сайхан гэрлэлтэд аугаа итгэл хэрэгтэй. Энэ нь итгэлээр дүүрэн байхыг шаардана. Гэрлэлт чинь асуудалтай байгаа бол, Христ юун дундуур гарсаныг сана. Түүний түүхийг ахин дахин сана. Таны түрхэн зуурын зүдгүүр нь хэцүү боловч, загалмайн хажууд юу вэ? Ханиасаа хариугүй урвах гээд унабал, Христ танд хичнээн итгэмжтэй байсныг сана. Тэр тантай эвлэрэх гэж юу туулсаныг бүү март. Түүний үлгэр жишээ таны сүнсэнд сэргээш тарих ёстой!

Хамгийн сайн сайханд итгэх

Өнө эртний, урьдын зүйлсийг санагтун.
 Учир нь Би бол Бурхан, өөр байхгүй.
 Би бол Бурхан. Надтай адил өөр байхгүй.
 Би эхлэлээс төгсгөлийг тунхаглаж, хийгдээгүй
 байгаа зүйлсийг өнө эртнээс мэдүүлсэн. “Миний
 зорилго хэрэгжинэ. Би Өөрийн тааламжит бүхнийг
 гүйцэтгэнэ” гэж айлдаж байна. (Исаиа 46:9-10)

“Бидний Бурхантай эгнэх бурхан үгүй” гэж бичих нь дэндүү хийсвэр санагдаж магадгүй ч, бид энэ мэдэгдлийн хүч ба үнэнийг таг мартдаг. Бурханы хүүхдүүд бид Аавтайгаа адилхан байж, Аавынхаа мөн чанарыг даган дууриах учиртай. Итгэлээр бид бариагаа бодож гараанаасаа гарсанаараа амьдрал, үр хүүхэд, гэрлэлтээ хэлбэршүүлж, ирээдүйгээ урлаж чадна.

Тэгэхээр бид амар сайхандаа жаргах нь даваад л болчихдог босго биш, харин бидний гараар бүтээн байгуулагддаг зүйл гэдгийг бид маш тодорхой сурлаа. Тэгвэл “Яаж амар сайхан төгсгөлөө байгуулах вэ?” гэдэг асуулт ургана. Та эдгээр ишлэлийг олон удаа уншсан байх. Гэхдээ дахиад унш;

Итгэл бол бидний найддаг зүйлсийн бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн. ...Бурханы үгээр ертөнц бүтээгдсэн бөгөөд тийнхүү харагдах зүйлс нь үзэгдэх зүйлсээс бий болгогдоогүйг бид итгэлээр ойлгодог. (Еврей 11:1,3)

Бидний зорилго нь одоогоор хараахан байхгүй байгаа амар сайхан төгсгөлийг байгуулах бөгөөд итгэл нь одоогоор хараахан байхгүй байгаа барилгын материал юм.

Бид Бурханы итгэлийг хүлээх юу ч хийж гийгүүлээгүй боловч, Бурхан бидэнд итгэсэн юм. Бурхан Өөртөө бат итгэдэг учраас л танд бат итгэдэг. Түүний хүч таны амьдралд юу ч хийж чадна гэдгийг

Бурхан мэднэ. Бурханы үлэмж хүч чадлыг эдлэхээс хойшлуулдаг цорын ганц зүйл нь бардамналаас үүдэлтэй үл итгэл юм.

Бардам зан нь нэг бол мэдлэггүй муйхар байдлаар эсвэл өөрийнхөө чадварт бардах байдлаар илэрдэг. Өөрийгөө жигших нь бас л зүсээ хувиргасан бардам байдал мөн. Эдгээр нь бүгд Христийн загалмай дээрх үйлсээр гүйцэлдсэн Бурханы үлэмж хүчирхэг хүчийг хүлээж авахаас татгалзах татгалзал юм. Есүс таныг ер бусын болгох гэж үхсэн. Бид “эгэл жирийн” гэдэг нэрдээ сэтгэл ханаж болно. Гэхдээ Бурхан арай л өөр төлөвлөгөө хэрэгжүүлэхээр шийджээ. Тэр төлөвлөгөөгөөс ухрах нь даруу зан биш, харин залхуу, явуургүй зан юм. Тэр төлөвлөгөөнд нэгдэх нь өөртөө эрдэж бардсан явдал биш, харин дуулгавартай зан юм” хэмээн Си. Эс. Льюис бичжээ. Бид санал бодлоо Бурханы хангамжийн зэрэг өөд өргөхдөө, Бурхан бидэнд санал болгож буй гайхамшигтай амьдралыг хүлээн авна.

Та гайхамшигтай сайхан гэрлэлтийн амьдралаар аж төрөх хувьтай гэдэгтээ итгэж байна уу? Эсвэл тархи чинь дараах бодлоор бөглөрөөд байна уу?

Надад хэтэрхий их ачаа байна.

Би олигтой гэр бүлээс гаралгүй.

Аав, ээжийн маань гэрлэлт бүтээгүй.

Би маш их алдаа гаргасан.

Гэр бүлийн амьдрал маань амьтай байгаа нь дээдийн заяа.

Бурхан асуудалд дуртай гэдгийг та ер нь анзаарсан уу? Гэхдээ итгэлгүй байдлаараа бид амьдрал дахь Бурханы хүчийн үр нөлөөг хязгаарладаг. Түүний аугаа байдлын талаарх илчлэл нь нэгэн зэрэг биднийг Түүнд бат итгэлтэй байхад урамшуулж бас даруу байлгах учиртай. Даруу байдал нь амьдралд маань Бурханы хамгийн сайн сайхныг нэвтрүүлнэ. Исаиа 5:8-9-р ишлэлд Бурхан ийн айлдруун:

Учир нь Миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр” гэж ЭЗЭН айлдаж байна. Тэнгэр нь газраас өндөр байдаг

шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол та нарын бодлоос өндөр билээ.

Түүнчлэн Бурхан биднээс ухаантай, ухамсартай, хүчин чадалтай гэдгийг бид ойлгох ёстой. “Бурханы дотор та өөрөөсөө хавьгүй хүчирхэг зүйлтэй халз тулж чаддаг” хэмээн Си. Эс. Льюис бичсэн байдаг. Та гэрлэлтээ хүчирхэг байлгахыг хүсбэл, энэ үнэнийг үг дуугүй хүлээж авах ёстой.

Та гэрлэлтээ өөрийнхөөрөө төсөөлж мөрөөдөж байгаа. Гэтэл Бурханд үүнээс чинь илүү аугаа том мөрөөдөл бий. Тэрбээр таны гэрлэлтийн талаар ихийг санахаар барахгүй, хэдийнээ төлөвлөгөө гаргачихсан байгаа.

“Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт ирээдүй ба найдварыг өгөхийн тулд гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм” гэж ЭЗЭН тунхаглаж байна. (Иеремиа 29:11)

Энэ амлалт нь бидэнд хоёр сонголт үлдээнэ: энэ мэдэгдэл үнэн гэдэгт итгэж, гэрлэлтэд маань хандсан Бурханы алсын харааг хүлээн авах эсвэл Бурхан худалч гэж итгэх. Бурхан та хоёрын нэгдлийг харахдаа, Хүүгийнхээ тусгалыг олж харахыг хүсдэг. Энэ алсын хараа биелэх цорын ганц зам нь Бурханы нигүүсэлийг (хүчийг) даруухнаар болон итгэлээр хүлээж авах юм. Амар сайхандаа жаргах нь хүний төлөвлөдөг зүйл ч гэлээ, хүний хүчээр хийдэг зүйл биш юм. Энэ нь биднээр дамжин ажиллах Ариун Сүнсээр гүйцэтгэгдэх, Бурханы хайрын илэрхийлэл юм.

Та “Бурхан миний гэрлэлтийг тоодоггүй ш дээ. Бидэнд ямар ч найдвар алга. Бидэнд ирээдүй алга. Бидэнд бие биеэ гэх хайр алга” гэж бодож байж магадгүй.

Та өөрийнхөө хүчээр л зүтгээд байгаа юм шиг санагдаж байна уу? Гэрлэлтдээ хандсан хүчин зүтгэл, мөрөөдлөө Бурханыхаар сольвол ямар вэ? Гэрлэлтээ Түүнд даатгабал, Тэрбээр таны мөрөөдлийг аваад, амиар дүүргэж, тэнгэрлэг хувилбарыг нь зүрхэнд чинь тариална.

Энэ нь нөхрүүд ээ, Бурхан та нарыг өөр дээрээ төвлөрсөн бодлоо орхиж, Христ Чуулганыг яаж хайрласан - яг тийм хайраар эхнэрээ хайрлах хүчтэй болгоно. Эхнэрүүд ээ, Христ та нарыг нөхрөө хүндэтгэх хүндлэлээр хүчирхэгжүүлнэ. Ийм арга замаар та хоёр хоёулаа гэрлэлтээ өсгөн тэлнэ.

Итгэлгүйгээр Бурханд таалагдах боломжгүйг Библи тодорхой хэлсэн (Еврей 11:6). Бурхан яагаад итгэлд тийм дуртай вэ? Учир нь Түүнд итгэх итгэлээр бид Түүнтэй адилхан болох хүчийг олдог бөгөөд Бурхантай адилхан байх амьдралаас чухал амьдрал гэж байхгүй. Бурхан таны сайн сайханд баясдаг. Бид зуурдхан үргэлжилдэг аз жаргалын мэдрэмжийн талаар яриагүй, харин насан турш үргэлжлэх баяр хөөр, сэтгэл ханал, бүрэн дүүрэн байдлын талаар ярьж байна. Бурхан таны гэрлэлтэд хамгийн сайн сайхныг хүсдэг бөгөөд харин Түүний шилдэг нь гагцхүү Түүний дотор суурилсан нэгдэл дээр л байгуулагддаг юм.

Хар зураг

Итгэл найдвар хоёрыг хүмүүс их андуурдаг ч, эдгээр нь өөр өөр зүйл юм. Итгэл нь аугаа гэрлэлтийг барьж босгох барилгын материал бол, найдвар нь хар зураг юм. Өөрөөр хэлбэл найдвар нь хэв, харин итгэл нь хэвийг дүүргэдэг материал аж. Найдваргүйгээр итгэл нь ямар ч хэлбэргүй эд юм. Яг л ямар ч хар зураггүй барилгын материал шиг.

Бурхан Абрахамыг тодорхой зорилгоор гэрээний хүлээн авагч болгон сонгосныг та санаж байгаа. Тэр зорилго нь Абрахам үр саддаа Бурханы замаар явахыг зааж өгөх байв. Бурхан Абрахамыг энэ амлалтад дуудах үед Абрахам үр хүүхэдгүй байсан боловч, Бурхан түүнийг агуу их үндэстний эцэг болно хэмээн баталгаажуулжээ.

Абрахам яриангүй аугаа итгэлтэй хүн байсан. Бичээс түүнийг “Бурханы амлалтын талаар тэр үл итгэн тээнэгэлзэлгүй, харин ч итгэлээр хүчирхэгжсэн...” гэдэг. (Ром 4:20). Тэгэвч Эхлэл 15-р бүлэгт Абрахам итгэлийн талбарт хөл тавихаасаа өмнө ганхсан тухай гарна.

Түүний дараа ЭЗЭНий үг Абрамд үзэгдлээр ирж,

—Абрам аа, бүү ай!

Би бол чиний бамбай,

Чиний шагнал агуу их болно.

гэжээ. Абрам

—Эзэн БУРХАН! Та надад юу хайрлахсан бол? Би

үр хүүхэдгүй учир миний өв залгамжлагч нь энэ

Дамаскийн Елиезер юм гэв. Абрам цааш өгүүлрүүн

—Та надад ганц ч үр заяагаагүй. Тиймээс гэрт минь

өссөн хүн л миний өв залгамжлагч болно гэсэнд

ЭЗЭНий үг түүнд ирж

—Тэр хүн чиний өв залгамжлагч болохгүй, харин

өөрийн чинь биеэс төрөх хүн л чиний өв залгамжлагч

болно гээд, түүнийг гадагш дагуулан гараад

—Чи тэнгэр өөд хар, хэрэв оддыг тоолж чадваас тоол

гэв. Тэр бас дахин түүнд

—Чиний үр удам ийм олон болно гэв. Тэгээд Абрам

ЭЗЭНд итгэсэнд ЭЗЭН түүнийг зөвт байдалд

тооцуулав (Эхлэл 15:1).

Бурхан Абрахамд илүү том хэмжээний итгэлийг өгнө гэж бид бодох байх. Гэтэл Бурхан Абрахамын итгэлд зуурах алсын хараа хайрлажээ. Бурхан Абрахамын найдварт бичээс хайрлаж, итгэлийг нь хүчирхэгжүүлсэн. Бурхан Абрахамыг хамтдаа од тоолохыг урьжээ. Шөнийн тэнгэр нь Абрахамын итгэлд оддын хар зургийг гаргаж өгсөн. Бурхан Абрахамд зүгээр л одод шиг үй түмэн хүүхэддээ болно гээд хэлчихийн оронд, хувь заяанд нь мартагдашгүй, барьцтай, тод зураглал өгчээ. Тэнгэрийн үзүүлэнтэй танилцуулгаар дамжуулан Бурханы алсын хараа Абрахамын төсөөлөлд хэвлэгдсэн юм.

Бурхан бидний гэрлэлтэд хандсан алсын хараагаа яг ийм арга замаар бидний төсөөлөлд суулгахыг хүсдэг ажээ. Учир нь алсын хараа байгаа газар найдвар байна. Ийм учраас л Паул биднийг Бурханы мэдлэгээс дээр өөрийгөө өргөмжилсөн бүх төсөөллөө хаяхыг уриалдаг (2Коринт 10:4-5). Та оюун санааныхаа далбааг харгалзах ёстой. Учир нь энэ нь таны үйл хэргийн үнэ цэнэ ба үйлдлийг тодорхойлно. Таны төсөөлөл бол таны найдварыг зурах самбар юм.

Бурхан биднийг найдвараар дүүргэнэ гэсэн боловч, бид үүнд хэрхэн хүрэх билээ? Бидний залбирлаар дамжуулан Бурханы Сүнс биднийг ер бусын найдвараар цэнэглэдэг биш үү?

Ариун Сүнсний хүчээр та нар найдвараар бялхсан байхын тулд найдварын Бурхан та нарыг итгэл дотор бүх баяр баясгалан болон амар тайвнаар дүүргэх болтугай. (Ром 15:13)

Бурхан бидний найдварын эх ундарга. Бид асуух аваас Тэрбээр биднийг баяр хөөр, амар тайвнаараа дүүргэнэ. Бид үүнийг л гэрлэлтийнхээ амьдралд хүсдэг бус уу? Бид Түүн рүү даруухнаар ирбэл, Ариун Сүнсний хүчээр дамжуулан баг найдвараар цалгина. Юутай хосгүй амлалт вэ!

Сургаалт үгс 29:18 дээр “Алсын хараагүй хүн замхардаг” гэсэн. Үнэхээр ч бурханлаг алсын хараагүй гэрлэлт нь хонгио болно. Тиймээс аймшиггүй томоор мөрөөд! Хүсэл мөрөөдөл, зорилгоо цаасан дээр буулгахаасаа өмнө зүрхийг тань Өөрийнхөө төлөвлөгөө рүү сэргээхийг Бурханаас залбиран гуй.

Дөрөвдүгээр өдөр

Хятад гуанз

Бид дөнгөж гэрлээд байхдаа, тухлан суугаад ирээдүйгээ ярилцдаг бяцхан газартай байлаа. Энэ нь манай байраас холгүй байршдаг, жижиг Хятад зоогийн газар байв. Бид хоёр нимгэн хармаатай коллежийн оюутан байсан тул ганц таваг му-шу тахиа, ахиухан мантуу, нэмэлт чавганы сүмс захиалаад хувааж иддэг байлаа. Тэр нь олны хөлөөс зайдуу, даруухан атлаа харийн уур амьсгалтай, залуу хосын хувьд цайгаа оочингоо ямар газар нутгийг эзлэх талаар мөрөөдөхөд тун тохиромжтой газар байсан юм.

Тэр үед бид хоёр нэг их юм мэддэггүй байсан ч, нэг л зүйлд итгэлтэй байсан юм: хамтдаа Бурханд бүх зүрх, чадал, хүчээрээ үйлчлэхийг хүсч байлаа. Бид хоёр хачин сайхан гэр бүл байгуулж,

амьдарсан шиг амьдрахыг хүсч байсан юм. Хэдийгээр амьдралын аянаа хаашаа хийхээ огт мэдэхгүй байсан ч, хэрхэн аялахаа харин мэдэж байв. Бид Бурхан биднээр дамжуулж цоо шинэ өвийг байгуулах, тийм л арга замаар аж төрөхийг хүсч байсан юм.

Жон миний бие маш сайн сайхан гэр бүлээс гаралтай хүн бүлгээ. Аав, ээж хоёр маань жаран тав гаруй жил ханилсан. Аав маань ээжийг минь насан турш үнэнчээр хайрлаж, гэр бүлээ итгэмжтэй тэжээж, харин ижий минь гэрийн эзэгтэйн сонгодог жишээ байлаа. Аав, ээж хоёр маань надад амьдралын ч, гэрлэлтийн ч үлгэр жишээ болсон бөгөөд үүнийх нь төлөө би тэдэндээ насан турш талархаж явна.

Лиза миний бие харин Жоноос тэс өөр гэр бүлээс гаралтай хүн. Архи, завхайрал, хүчирхийлэл, урвалт, шунал, үхэл, салалтаар зэрэмдэглэгдсэн миний гэр бүлийн хажууд Жоны аав, ээж хоёр төгс амьдралтай байсан юм. Жон бид хоёр гал голомтоо бадраах үед би мэдээж гэр бүл гэж юу болох талаар сайн ойлголтгүй байсан ч, гэр бүлтэй байхыг үнэн голоосоо хүсч байлаа.

Хятад гуанзанд ярилцаж байхдаа, бид хоёр өөрөөр амьдрахыг хүсч байгаагаа мэдэж байсан юм. Хэдийгээр би Жоныхоо аав, ээж хоёрыг гүнээ хүндэтгэдэг ч, тэдний гэр бүлийн амьдралын загвар бидэнд арай л тохирохгүй байлаа. Гэрлэлт үүнээс хавьгүй том зүйл гэдгийг бид хоёр хоёулаа мэдэж байв - гэрлэлтийн институци нь өөрөө тэнгэрлэг дуудлагатай зүйл байв. Гэрлэлт нь эрэгтэй эмэгтэй хоёр хүн насан турш хамтдаа байна гэдгээс илүүтэй нэгдлээрээ дамжуулан мөнхийн өвийг байгуулах учиртай юм. Мэдээж үүнд үр хүүхэд, үр хүүхдийн маань үр хүүхэд бас тэдний үр хүүхэд багтахгаас гадна өөр бас олон хүний амьдрал багтана.

Бид гэрлэлтээ зураглаж эхлэв. Бид бие биеэсээ асуулт асууж, хил хязгаар тогтоож, чадлаараа л томоор мөрөөдөв. Бидний хамгийн гол зорилго нь хамтдаа Бурханд үйлчилж, сонголтоороо Түүнийг хүндэтгэх байлаа. Харин бусад зүйлс нь тэр шүүлтүүрээр дамжих ёстой байлаа.

Бид гучин хоёр жил ханилахдаа, зөвхөн Бурханыг хүндэтгэнэ гэсэн үгдээ хүрэхийн тулд л хамтдаа үлдсэн үе амьдралд маань бишгүй байлаа. Заримдаа Лиза миний бие Жоныг хайрлах ямар ч хайр мэдрэхгүй мөн Жон ч надад сэтгэлгүй болсоноо хэлж байсан удаатай. Тэрбээр намайг хэдэн жаахан хүүхэдтэй минь үлдээчихээд, зориуд удаан хугацаагаар байн байн аялаад явчдаг байв.

Үнэнийг хэлэхэд, ирээдүйн амьдрал маань тас харанхуй харагдаж байлаа. Сүнс минь шархалж, бөөн бөөн сорвитой болов. Би сэтгэл зүрхээрээ ч, бие махбодоороо ч шоовдорлогдсон санагдаж байв. Хэрэв би салах талаар бодсон бол, дуртайяа салах байсан байх. Надад энэ гэрлэлтийн талаар ямар ч алсын хараа байхгүй, ердөө л байж болох байсан зүйлсийн сүүдэр л байв. Би нэгэнтээ “Бурхан минь, Та намайг тэнгэрт Жонтой хамт амьдруулахгүй гэж амлал, би энэ гэрлэлийг тэвчье” гэж хэлж байсан удаатай юм шүү. Би маш их ганцаардаж байсан боловч, үйлчлэгч хүний эхнэр зовлонгоо өөрөө л үүрэхээс өөр хэнд хэлэх билээ.

Жон миний бие ч тэр үед бас л ямар ч найдваргүй байдалтай зөрчилдөж байлаа. Би юу ч хийсэн тэр нь Лизад таалагдахгүй. Тэгээд Лизагийн хүндэтгэлгүй хандлага, хатуу үг миний дүгнэлтийг батлах шиг л санагдана. Бид хоёрын хэнд нь ч энэ гэрлэлтийн хайр, хүндэтгэл, тордолгоо сэргэнэ гэсэн найдвар байгаагүй учраас бид хоёр маш эрчтэй унаж байлаа.

Тэр хүнд хэцүү улирлын сэтгэл санааны бөгөөд сүнслэг зовиур махыг минь идэж байв. Аймшигтай хэцүү байсан гэхээс өөр үг олохгүй нь. Гэхдээ энэ нь зөвхөн нэг л улирал байсан бөгөөд харин улирал ямагт солигддог. Шөнөжин уйлаан байж болно, харин өглөөд баярын хашхираан ирдэг (Дуулал 30:5). Одоо эргээд харахад, тэр цаг нь яг л өөр хүмүүст тохиолдсон юм шиг хийсвэр санагддаг юм. Бурханы нигүүлслээр бид хоёр Бурханыг хүндэтгэх зорилгодоо үнэнч үлдсэн билээ. Бурханлаг цэц ухаанд дуулгавартай байж, амиа хичээсэн байдлаа үнэн голоосоо гэмшихдээ бид, гэрлэлт болон хайр маань аугаа хүчирхэг болж өсөхийг харсан юм.

Бидний амьдралыг үзэх үзэл л биднийг энэ их хүнд хэцүү цагаар туулуулж гаргасан юм. Бид гэрлэлтээ дал юмуу наян жилийн хугацаа гэж хараагүй, харин мөнхийн үзэл бодлоор харсан билээ. Дал юмуу наян жил нь өнө мөнхлөлтэй харьцуулахад уур юм. Загалмайд хэрхэн хандсанаараа бид хаана өнө мөнх амьдрахаа шийднэ, харин итгэгч хүнийхээ хувьд хэрхэн амьдарсанаараа бид өнө мөнхөд хэрхэн амьдрахаа шийднэ гэдгийг Бичээс хэлдэг. Паул ингэж бичжээ:

Бид урамтай байдаг бөгөөд биеэсээ холдон явж, Эзэнтэй хамт гэртээ байх нь хавьгүй дээр гэж боддог. Тиймд гэртээ байсан ч, гэрээсээ холдсон ч Түүнд таалагдах нь бидний эрмэлзэл билээ. Учир нь хүн бүр мууг ч бай, сайныг ч бай, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахын тулд бид бүгдээрээ Христийн шүүхийн суудлын өмнө гарч ирэх ёстой. (2Коринт 5:8,10)

Паул итгэгч бус хүмүүсийн талаар хэлээгүй нь тодорхой байна. Учир нь итгэгч бус хүмүүс Эзэний оршихуйд байхгүй, тэд биеийн хэсэг биш юм. Паул Есүс Христийн аврах нигүүлслээр Бурханы гэр бүлд орж ирсэн хүмүүсийн талаар хэлжээ. Бид Түүний өмнө зогсоод, итгэгч хүнийхээ хувьд амьдарсан арга зам, гаргасан шийдвэр бүрийнхээ төлөө тайлан тооцоо тавина. Тийнхүү Христийн шүүлтээс бидний мөнхийн шагнал эсвэл мөнхийн гарз шийдэгдэнэ. Энэ суурь доктрин л биднийг зам дээр минь үлдээж дөнгөсөн юм. Бидний хэн хэн нь Есүсийн сэнтийн өмнө зогсоод, Түүний гэрлэлтийн нэгдлийн урлалыг гутааснаа тоочихыг хүсээгүй юм.

Бид хоёр хоёулаа Бурханыг хүндэтгэх зорилготой байсан. Гэхдээ бас амьдралаа дуусгахдаа бие биедээ анх хайрлан дурлаж байснаасаа ч илүү хайртай байхыг хүсч байсан юм. Энэ зорилго л биднийг хүнд бэрх замыг давж, Си. Эс. Льюисийн хэлсэнтэй ижил мэдрэмж тээж чадахгүй байсан ч, бие биеэ хайрлах чадалтай болгосон юм. Си. Эс. Льюис хайрын талаар ингэж хэлжээ:

“Хайр бол сэтгэлийн хагаар сахидаг, зориудын дадал хэвшлээр бэхжүүлдэг, (Христигэлт гэрлэлтэд) аав, ээж хоёрын аль алийнх нь Бурханаас гуйж, хүлээж авдаг нигүүлслээр бэхэждэг, гүн гүнзгий нэгдэл юм. Тэд бие биедээ дургүй болох үедээ ч энэ хайрыг тээж чадна.”

Бид бие биедээ дургүй хүрэх үе бишгүй гардаг. Тийм бэрх үед Бурхан биднийг чиглүүлсэн бол та хоёрыг ч бас чиглүүлнэ. Бид хоёр өнөөдөр бие биеэ хуримынхаа өдөр хайрлаж байснаасаа ч илүү хайрладаг! Тэгээд цаг хугацаа өнгөрөх тусам улам л их хайртай болно гэдэгт итгэлтэй байна.

Бурхан тэмдэглэл хөтөлж буй

Зоогийн газрын амны цаасан дээр тэмдэглэл хөтөлж байхдаа бид үр хүүхдээ хэрхэн хүн болгох, мөнгөтэй харилцахыг сургах, гэрийн ажилд сургах, өрөөг нь яаж хувиарлах зэрэг хараахан төрөөгүй буй үр хүүхдээ хэрхэн өсгөхөө ярьсан юм. Бид үр хүүхэддээ болон ач нартаа ямар өв үлдээх талаар ярилцсан. Үр удамдаа сүнслэг бөгөөд санхүүгийн өв үлдээх нь сайн юм (Сургаал үгс 13:22-г үзнэ үү).

Бид ирээдүйнхээ гэрийг төсөөлсөн. Бидэнд том, тансаг байшин чухал биш, харин зочид гийчдийн хөл тасардаггүй, орж ирсэн хүмүүс аюулгүй, амар тайван байдаг, халуун дулаан, үр хүүхэд маань найз нөхдөө авчирдаг хөгтэй, хөгжилтэй гэр чухал байлаа.

Дараа нь бид Бурхан биднээр хийлгэхээр дуудсан хэмээн итгээ буй зүйлсийнхээ талаар мөн энэ дуудлага бидний гэр бүлийн эрч хүчид хэрхэн нөлөөлөх талаар ярилцана. Тэгээд үлгэр жишээ авдаг эрэгтэй, эмэгтэй баатрынхаа талаар ярилцана. Мөн мөнгөө хэрхэн зохицуулж, өргүй амьдрахаа ярилцана. Бид ярилцсаар ярилцсаар, гарт буй зүйлээ хартал мөнөөх амны цаас нь бидний сүндэрлүүлэхийг хүсч буй амьдралын хар зураг болсон байхыг ухаарсан юм.

Биднийг амьдралаа амны цаасан дээр бичиж байхад, Бурхан бас хамт тэмдэглэл хөтөлсөн юм шиг надад санагддаг.

Тэгээд ЭЗЭНээс эмээдэг хүмүүс бие биентэйгээ ярихад ЭЗЭН анхаарал тавин сонссон. ЭЗЭНээс эмээдэг болон Түүний нэрийг үнэлдэг хүмүүсийн төлөө дурсгалын ном Түүний өмнө бичигдсэн билээ.
(Малахи 3:16)

Тэдгээр өдрүүдэд бид маш олон зүйл ярилцсан бөгөөд одоо ихэнхийг нь мартсан ч, Бурхан өдий хүртэл санасаар, биелүүлсээр ирсэн юм. Бурхан Өөрийг нь эмээн хүндэтгэдэг хүмүүсийн яриаг бичдэг. Та амьдралын Зохиолчийг алдаршуулсан гэрлэлтийн газрын зургийг гаргаж байхад, тэнгэр үүнийг чинь тэмдэглэн бичдэг.

Алсын хараагаа бич

Үзэгдлийг (алсын харааг) уншсан нэгэн гүйн
зугтахын тулд түүнийг тэмдэглэн,
хавтангууд дээр сийлэн бич. (Хабаккук 2:2)

Гэрлэлтийнхээ алсын харааг бичихэд хэзээ ч оройтохгүй. Ойлгомжтой тодорхой зураг гаргаж иртлээ ахин дахин бичих нь зүйтэй. Тодорхой алсын хараа нь танд замаараа сайн гүйж, бариандаа орох хүч хайрлана.

Хань ижилтэйгээ (эсвэл гэрлэх гэж буй хүнтэйгээ) хамтдаа гэрлэлтийнхээ талаар хуваалцаж, алсын хараагаа ярилцах цаг гарга. Хэрэв та ганц бие бол алсын харааныхаа өөрийнхөө талыг одооноос эхэлж бич. Мөрөөдөх газар ол. Хүсэл, найдлагаа тодорхой гаргаж ир. Хүрэх оргилоо тодорхойл, том мөрөөд! Энэ алсын хараа нь таны ирээдүйн алтан гадас од тань байна.

Гэрлэлт нь яг л гараа барианы хооронд арав арван жилээр хөврөх, холын зайны гүйлт юм. Маш олон хос гэрлэлтийг ойрын зайны гүйлт гэж боддог. Тэд байшин худалдаж авах, гэр бүлээ өсгөх талаар боддог нь уул шугамдаа тун сайн зорилго боловч, эдгээрийн аль нь ч биднийг хол аваачихгүй. Гэрлэлтийн амьдрал үүнээс хавьгүй том юм. Мөрөөдсөөр бай!

Та энэ гүйлтэд ханьтайгаа өрсөлдөж биш, хамтран гүйж байгаа гэдгээ бүү март. Та энэ гүйлтээ ганцаараа дуусгаж чадахгүй учраас багаараа ажиллаж сур. Хэрэв та тааруухан эхэлсэн бол, яаж дуусгах нь яаж эхэлсэнээсээ хавьгүй чухал гэдгийг санаж, өөрийгөө зоригжуул. Төлөвлөгөөгөө бичих нь барианы шугамаа тодорхойлох арга зам юм. Өмнөө тавих алсын хараатай хүн зорьж гүйх зорилготой болно.

Учир нь энэ үзэгдэл тогтоогдсон цагийн төлөө өгөгдсөн. Энэ нь биелэл уруугаа яарч буй бөгөөд хөсөрдөхгүй юм. Энэ нь түр саатаж байгаа боловч түүнийг хүлээгтүн. Учир нь энэ нь хоцролгүй заавал

ирнэ. Харагтун, бардам нэгний хувьд, доторх сэтгэл нь зөв бус байдаг юм. Харин зөвт хүн итгэлээрээ амьдарна. (Хабаккук 2:3-4)

Таныг гүйлтээ дуусгатал Бурханаар үлээгдсэн алсын хараа тань үргэлж өмнө тань байна. Та алсын хараагаа хараандаа байлгабал, энэ нь таныг хэзээ ч хөсөрдүүлэхгүй. Заримдаа Бурханы хэлсэн зүйл үнэн байх боломжгүй мэт санагдах үе байна. Зам чинь таныг таны очихыг хүсээгүй эсвэл очино гэж бодоогүй газар руу хөтөлнө. Үйл явцад итгэ. Таныг алсын хараагаар өрдсөн Нэгэн хэрэгцээтэй цагт таныг хүчирхэгжүүлнэ. Гагцхүү алсын хараагаа бүү алд.

Таны төлөвлөгөө амьд, амьсгалтай, органик баримт байх ёстой. Энэ нь хоёр зүйлийг багтаах ёстой гэсэн үг:

Нарийн тодорхойлсон туйл

Зарим итгэл ба бүрэн зориулалт нь таны алсын хараанд шаардлагатай хүрээ татаж өгнө. Тухайлбал “бидний гэрлэлт Бурханыг хүндэтгэнэ” эсвэл “бид бусдын хэрэгцээг өөрийнхөө хэрэгцээний өмнө тавина” гэх мэт. Зарим зүйл нь хөсөрдүүлж болохгүй зүйлс байдаг. Тэдгээр нь хэзээ ч өөрчлөгдөхгүй, буулт хийж болохгүй зүйлс юм.

Өсч дэвших орон зай

Сайн төлөвлөгөө нь асуулт бүрт хариулт өгөхгүй ч, асуудлыг тодорхой болгож өгдөг. Өмнө тань байгаа бүх зүйлийг гагцхүү Бурхан мэддэг ч, та Бурханы Сүнсний хөтөлгөөг алдалгүй дагаснаараа, Бурханы төлөвлөгөөний хэсэг бүрийг мэдэж чадна. Цаг хугацааны аясаар таны алсын хараа улирал бүрийн давуу тал, бэрхшээлд дасан зохицож, хэмжээгээрээ өсөн, улам тодорхой болон гялалзана.

Гэрлэлтийн төлөвлөгөө гаргахдаа хэрэгжүүлэх таван практик алхмыг танд санал болгоё:

1. Залбир

Таны ярилцлага, бодол, онгодыг Сүнсээрээ дүүргэхийг Бурханаас гуй. Таны итгэлийг дүүргэхийг хүсч буй найдварыг гуй.

2. Хүсэл мөрөөдлөөр дүүргэх материал цуглуул

Танд хүсэл мөрөөдөл хайрлах бичээс, нийтлэл, түүх, зураг, дууны үг, сэтгүүлийн зурвас зэрэг зүйлсийг цуглуул.

3. Мөрөөдөж чадах газраа оч

Тэр нь хачин үнэтэй, тансаг газар байх албагүй. Гудамжны мухарт байдаг, чимээгүй зоогийн газар эсвэл ойролцоо байдаг цэцэрлэгт хүрээлэнгийн модон сандал байж болно.

4. Зорилгоо тодорхойл

Том мөрөөд! Одоогийн нөхцөл байдал эсвэл өнгөрсөн амьдралаараа өөрийгөө бүү хязгаарлуул.

Бид: санхүү, үр хүүхдээ хүн болгох, гэр бүлийн динамик, хувь хүний хөгжил, сүнслэг өсөлт, харилцаа, амралт болон зугаа, ажил мэргэжил, ахуйн ажил үүрэг, чуулганд оролцох, нийгэм зэрэг сэдвийг бодолцох ёстой.

5. Тэдгээрт хэрхэн хүрэхээ шийд

Та нэгэнт алсын хараагаа байгуулсан бол, өөр дээрээ тусган бод: яг одоо таны харилцаа хаана явж байна? Хаана байлгахыг хүсч байна? Одоогийн нөхцөл байдлаа тодохойлоод, таныг цааш нь хөдөлгөх жишиг, алхам, өөрчлөлтийн стратеги гарга.

Таны төлөвлөгөө амьдралын олон улирлыг туулах даацтай байх ёстой. Тархиндаа зорилгоо бодон, дараах асуултад хариулна уу:

Дараах нөхцөлд бидний гэрлэлт яах вэ?

Хүүхэдгүй байхдаа?

Үр хүүхдээ өсгөхийн цагт?

Өсвөр насны хүүхдээ өсгөхийн цагт?

Үр хүүхэд маань үүрээ орхихын цагт?

Ач зээгээ эрхлүүлэхийн цагт?

Амьдралынхаа адаг үед?

Хэрэв та ганц бие/ болзож байгаа/ сүй тавьсан бол цаашидынхаа гэрлэлтийн амьдралд өөрийгөө хэрхэн бэлтгэх вэ?

Танд санхүүгийн, хүмүүжлийн гэх зэрэг олон төлөвлөгөө байгаа. Эдгээр нь хэтийн зорилго боловч, таны өдөр бүр даган мөрдөх жишиг, сонголт, дадал хэвшлээр тэтгэгддэг юм. Дараах асуултыг бодолцоно уу:

Та сарынхаа төсвийг хэзээ, хэрхэн гаргах вэ?

Та ямар амралт авч, амралтаа хэрхэн төлөвлөх вэ?

Та хоёр хамтдаа ямар төрлийн үйл ажиллагаа, зугаа цэнгэлд оролцох вэ?

Та ханьтайгаа хэрхэн насан турш болзоор байх вэ?

Ялгаатай талаа хэрхэн шийдвэрлэх вэ?

Үр хүүхэдтэйгээ цагийг хэрхэн өнгөрөөх вэ?

Үр хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх вэ?

Та хоёр хоёулаа карьер хөөх үү? Хөөх бол амьдралаа хэрхэн зохицуулах вэ?

Та хоёр бие биеийнхээ ажил карьер, томоохон зорилгыг хэрхэн дэмжих вэ?

Та хоёр боловсролоо хэрхэн хөгжүүлэх вэ? Үр

*хүүхдийнхээ боловсролыг хэрхэн хөгжүүлэх вэ?
 Үр хүүхдээ хөгжүүлэх ямар боломж байна вэ? Тэдний
 сонирхол ба авъяасыг хэрхэн дэмжих вэ?
 Эрүүл мэнддээ яаж хөрөнгө оруулах вэ? (дасгал,
 амралт, хоол хүнс).
 Хүүхдүүдээ яаж Бурханыг танин мэдэх мэдлэг дотор
 өсгөх вэ?
 Таны гэрлэлт болон гэр бүл эргэн тойрондоо яаж
 хувь нэмэр авчрах вэ? (чуулгандаа, нийгэмдээ,
 хөршидөө, ажлын газартаа гэх мэт).*

Таныг цэц ухаан тэлж, туршлага хураах тусам таны төлөвлөгөө улам л нарийн болж цэгцэрнэ гэдгийг өмнө хэлсэн. Энэ нь ч сайн. Гэхдээ та төлөвлөгөөнийхөө яс модыг анхнаасаа зөв тогтоож, үүнийхээ жишигт бүрэн зориулагдах ёстой. Учир нь энэ чинь л айсуу амьдралын чинь суурь болно.

Эверест өөд

Нэгэн хос онгоцонд суув. Тэд аялалдаа догдловч, хаашаа явж буйгаа мэдэхгүй. Ямар ч байсан энэ онгоц тэднийг аугаа аялалд гаргана гэдгийг л мэднэ. Тэд дулаан оронд очино гэж бодсон тул хамгийн хөнгөн нимгэн хувцсаа түүж авчээ. Олон цагийн нислэгийн дараа тэд зорьсон газартаа газардтал Непалд ирсэн байв. Халууны орны далайн эргийн амралт гэж санасан аялал нь Эверест ууланд авирах хүнд бэрх авиралт болж таарчээ. Тэд ийм аюултай, хүнд аялалд бэлтгэлгүй учраас тэр даруй гэртээ харив.

Үүнтэй адил олон хос гэрлэлтийг далайн эргийн амралт гэж санадаг ч, гэрлэлт нь уулын оргилд гарахтай илүү адил буюу сэтгэл догдлом бөгөөд бахдалтай хэдий ч, тун хүнд ажил байдаг. Хэдийгээр дээрх дүрслэл нь жаахан хошин боловч, гэрлэлтийн “үхлийн” тоо нь Эверестэд амиа алдсан хүмүүсийн тооноос бараг хорин тав дахин өндөр байдаг аж.

Тэгвэл яагаад Эверестийн уулчид гэрлэсэн хосоос хавьгүй илүү амжилттай байдаг вэ? Яагаад гэвэл тэдэнд аялалд гарсан

алсын хараа байгаа, тэд юунд явж буйгаа мэднэ. Тэд хүчил төрөгч дутагдаж, тас хөлдөж, хүйтэн салхинд нүдүүлэхдээ сочирдож балмагддаггүй. Харамсалтай нь маш олон гэрлэлт алсын хараагүй, бодит бус найдлага тээдэг учраас бүтэлгүйтдэг байна. Тиймээс яг одоо цаг гаргаж байгаад, төлөвлөгөө гаргасан нь өлзийтэй бүлгээ.

Хичээнгүй ажиллах

Түүх задрах явцад Бурхан таны алсын харааны хүрээг өргөжүүлж, үүнд маш үзэсгэлэнтэй сайхан чимэг нэмэхээс биш, та хоёрын сүндэрлүүлж буй амьдралыг хэзээ ч гутаан доромжлохгүй. Сорил дунд орох үед Бурхан л таны амьдралыг нураах гээд байгаа юм шиг санагдаж, та Түүн рүү хамаг уур хилэн, гутралаа бөөлжиж гаргамаар болдог. Гэхдээ Бурхан зовлонгийн зохиогч биш бөгөөд бүхнийг таны сайн сайхны төлөө ажиллуулдаг гэдгийг санаарай (Ром 8:28). Түүний нигүүсэл хийгээд Сүнс таныг хэзээ ч орхихгүй бөгөөд Бурхан таныг давж чадахгүй зовлонгоор чинь хэзээ ч туулуулахгүй.

Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт гарах замыг ч өгдөг юм. (1Коринт 10:13)

Заримдаа хамаг юм чинь салж унах шиг санагдах үе байвч, найдвараасаа атгасаар байвал, давалгааг намжаахдаа л намжаана. Тэгээд ажлынхаа дараа Эзэнээсээ:

“Сайн байна, итгэмжит сайн зарц минь!”

(Матай 25:23) гэсэн үг сонсоно доо.

Эзэн “Төгс байна” гэж хэлэхгүй, “Сайн байна” гэж хэлж буй нь сонирхолтой байгаа биз? Юмыг төгс хийдэг хүн байхгүй. Гэхдээ сайн гэрлэж, сайхан амьдарч чадна. Энэ нь гэрлэлтээ эрүүл саруул байлгаж, алдаанаасаа даруухнаар суралцаж, Бурханы

сайн сайхныг хүртэхийн төлөө нигүүсэлийнх нь араас явна гэсэн үг. Хэрэв та энэ замаар алхах сонголт хийлбэл, таны гэрлэлт амь гарах биш, харин жинхэнэ утгаараа амьдарч, бүр цэцэглэн гялалзана. Бурхан таныг тэр өндөрлөг өөд аваад л гарна.

Харин бидний хүсэл нь та нарын хүн нэг бүр найдварын бүрэн баталгааны төлөө эцсээ хүртэл адилхан хүчин чармайлт гарган, хойрго байлгүй, харин итгэл ба тэвчээрээр амлалтуудыг өвлөдөг хүмүүсийг дуурайгсад байцгаа. (Еврей 6:11-12)

Бурхан таныг гэрлэлтэд хандсан Түүний амлалтыг өвлөөсэй гэж хүсдэг. Бурханы Сүнсний өгч буй найдварыг өөрийн болгож тунхагла. Хань ижилдээ тэвчээртэй хандаж, гэрлэлтээ чухам ямар байгаасай гэж хүсч байна, түүндээ итгэ. Хоёр төгс бус хүний дотор болон хүнээр дамжуулан Бурхан юу хийж чаддагийг хараад та алмайрна. Бурхан өчүүхэн эхлэлтэй ч, аугаа төгсгөлтэй гэрлэлтийг байгуулах ажилд тун дуртай.

Нэгдүгээр өдрийн судлал

СОР БҮТЭЭЛ

*Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор
бүтээгдсэн, Түүний бүтээл мөн. Бурхан биднийг тэдгээрийн
дотор яваасай гэж урьдаас бэлтгэсэн билээ.*

- Ефес 2:10

Бурханы бүтээсэн бүхэн - тэр дундаа таны гэрлэлт өөрийн гэсэн зорилготой байдаг. Бурхан Ариун Сүнсээрээ таны гэрлэлтийг Өөрийнхөө нигүүлслийн сор бүтээл болгохыг хүсдэг.

Ганц бие эсвэл сүй тавьсан байсан үеэ эргэн дурсана уу. Та гэрлэлтийг хэрхэн төсөөлж байв? Та зүрхэндээ болон тархиндаа гэрлэлтийн талаар ямар төгс дүр төрх, санаа тээж байв?

Гэтэл гэрлэлт чинь төсөөллөөс чинь аль зэрэг өөр байна?

Бурханы гэрлэлтийг гэрээний хэв хийцээр урласан юм. Энэ нь “үхэл салгах хүртэл” үргэлжлэх, насан туршийн гэрээ юм. Гэрээнд хоёр тал бие биедээ бууж өгөөд, өөрт байгаагаа бие биедээ санал болгодог. Нэгийнх нь бэрхшээл нөгөөгийнх нь асуудал болж, хоёр биеийнхээ хэрэгцээг хангана гэдгээ бие биедээ амладаг.

Зохиолч, номлогч **Боб болон Одри Мэйснер** гэрээний талаар ингэж бичжээ:

“Гэрээ нь Бурханы зүйл юм. Библи Бурханы таалал, санхүүгийн ерөөл, аюулгүй байдал, итгэлцэл, урт удаан амьдрал ба бурханлаг зан чанарыг багтаасан гэрээн дор алхах талаар байнга хэлдэг! Жинхэнэ гэрээний орчинд бид амьдралын алдаа, асуудлаа айдасгүйгээр хүлээн зөвшөөрнө. Учир нь бид шударга байснаасаа болж хэзээ ч ад үзэгдэхгүй. Тэр цагт хань маань бидэнд туслахын төлөө хайраар үнэнийг эрх чөлөөтэй ярьж, бэрхшээл дундуур бидэнтэй алхана. Бид ингэж л Христийн доторх гэрээний амьдралаар амьдарсан шиг амьдардаг.”

Бурхан танд гэрээний талаар юу хэлж байна? Өөрөөсөө асуу. Би гэрээний гэрлэлтийн сайн сайхныг эдлэж байна уу? Би үүнийг эдлэхийг хүсч байна уу? Таныг хэрэгтэй бүхнээр дүүргэхийг Ариун Сүнснээс гуй.

Бурхан таны гэрлэлтийг таны хань та хоёроор хязгаарлаж боддоггүй. Бурхан та хоёроос хол давсан, хүчирхэг зорилгыг таны гэрлэлтэд бэлтгэжээ. Абрахам, Сара хоёр шиг та хоёрын нэгдэл ч бас хойч үедээ Бурханы хайр ба үнэнийг хүргээсэй гэж хүсдэг. Миний гэрлэлт хэнд нөлөөлж байна, ямар үр нөлөө үлдээж байна? гэж өөрөөсөө болон Эзэнээс асуу.

Түр завсарлаад: “Ариун Сүнс минь, би чухам яаж Таны гэрээг үр хүүхэд, ач зээ нартаа болон миний нөлөөлөл дор Таны тавьсан хүмүүст хүргэх вэ?” гэж залбирна уу.

Бурханы өмнө очоод, одоо болон ирээдүйд хэлэх Түүний үгийг анхааралтай сонс. Бурханы зөвлөгөөг бичээд, үгийг нь дагах нигүүлслийг гуй.

Хоёрдугаар өдрийн судлал

ЗУУХАНД ШАТААГДСАН

Хайртай хүмүүс минь, та нарыг сорихын тулд дунд чинь ирдэг галт сорилтод ямар нэгэн хачирхалтай юм та нарт тохиолдсон мэт бүү гайх. Харин та нар Христийн зовлонгуудыг хуваалцдагтаа баярла. Ингэснээр мөн Христийн алдар илчлэгдэхэд та нар баяр хөөртэйгөөр баярлах юм.

- 1Петр 4:12-13

Гэрлэлт нь сүнсээр шинэтгэх үйл явц бөгөөд Шинэтгэгч нь Бурхан билээ. Бурхан хэдийгээр таны асуудлын урхаг биш боловч, асуудлыг ашиглан та хоёрыг Есүстэй улам бүр адилхан болгодог.

Хэн ч зовохыг хүсдэггүй гэдгийг хүлээн зөвшөөр. Боломжтой бол хүн бүр зовлонг тойроод л гарна. Гэхдээ хүнд хэцүү зам нь үнэ цэнэтэй юм.

Зовлонгийн талаарх энэ үнэнийг тунгаан бодох цаг гаргана уу. Бид үүнийг таны гэрлэлтэд зориулаад хялбарчлаад өглөө.

“Тэвч Тэр миний болон миний ханийн замыг мэддэг.

Тэр намайг шалгасан бөгөөд би алт мэт урагш гарч ирнэ.

- Иов 23:10

Бурхан, Та биднийг сорьсон билээ. Мөнгийг цэвэршүүлдэг мэт Та намайг болон миний ханийг цэвэршүүлсэн. ...Бид гал ба усан дундуур гарсан, Гэлээ ч Та биднийг элбэг баян газарт авчирсан билээ.

- Дуулал 66:10-12

Нөхрүүд болон эхнэрүүд ээ, элдвийн сорилтод орохдоо үүнийг бүрэн баяр хөөр гэж үз. Та нарын итгэлийн сорилт тэсвэр хатуужлыг төрүүлдэг гэдгийг та нар мэдэх билээ. Тэсвэр хатуужил нь төгс үр дүнтэй байг. Тэгвэл та нар юугаар ч дутахгүй төгс, бүрэн бүтэн байна.

- Иаков 1:2-4

... Ингэснээр таны болон таны ханийн итгэлийн шалгуур нь галаар шалгах боловч мөхөх алтнаас ч илүү үнэтэй байн, Есүс Христийн илчлэлт дээр магтаал, алдар, хүндэтгэлд хүрэх юм.

- 1Петр 1:7

Яг одоо та хоёрын туулж байгаа зовлонгийн (зөрчлийн) зуухыг товч дүрслэнэ үү.

Дээрх бичээсээр дамжуулан Ариун Сүнс таны болон таны ханийн талаар бас та хоёрын нөхцөл байдлын талаар юу илчилж байна?

Ханийнхаа болохгүй талыг мэдлээ гээд та түүнийг өөрчилж чадахгүй. Тиймээс өөрийнхөө асуудлыг нэрлэхээс л эхлэ. Тэгээд түр зогсоод ингэж залбирна уу: “Ариун Сүнс минь, миний тархи, зүрхэнд ер нь юу байна? Та юуг өөрчлөхийг хүсч байна? Би өөрийнхөө талаар ямар худлаа зүйлд итгэж явна? Таны үгийг сонсож, Таны тушаалыг дагахад туслаач. Есүсийн нэрээр. Амень.”

Миний талаар Ариун Сүнсний илчилж буй үнэн...

Ариун Сүнсний хэрэгжүүлэхийг сануулж байгаа зүйл...

Гуравдугаар өдрийн судлал

ИТГЭЛ, НАЙДВАР, ДАРУУ БАЙДАЛ

Ариун Сүнсний хүчээр та нар найдвараар бялхсан байхын тулд найдварын Бурхан та нарыг итгэл дотор бүх баяр баясгалан болон амар тайвнаар дүүргэх болтугай.

- Ром15:13

Итгэл нь гайхамшигтай гэрлэлтийг бүтээн байгуулах барилгын материал болдог бол, найдвар нь тун удахгүй сүндэрлэх зүйлийн хар зураг юм. Харин найдварын эх ундарга болох Бурхан та хоёрт итгэж байна. Бурханд итгэхэд, Тэрбээр таны гэрлэлтэд хар зураг гарган өгч, мөрөөдлийнхөө гэрлэлтийг эдлэх хүчээр дүүргэнэ.

“Абрахам буюу Итгэлийн дуулгавартай байдал” гэдэг номдоо зохиолч **Эф. Би. Мэйер** ингэж бичжээ:

“Итгэл нь Христитгэлт амьдралын хамгийн тансаг үнэр, өнгө будгийг алаглуулсан, зөвхөн Бурханы тордолгоог хүсэн хүлээх үртэй адил. Хүн итгэсэн л бол дотор нь тогтсон үр боловсрох нь гарцаагүй. Гагцхүү цаг хугацаа болон боловсрол л хэрэгтэй. Итгэл биднийг Бурханы Хүүтэй мөнхийн мөнхөд нэгдүүлчихсэн учраас Түүний зан чанарын алдар бидэнд уусчээ.”

Тэгэхээр итгэл гэж юу вэ? Итгэл хаанаас гардаг вэ? Таны итгэл өсч буйг та хэрхэн хардаг вэ? Эдгээр хэсгийг анхааралтай тунгаан бодоод Ариун Сүнсний илчилж буй зүйлийг бичнэ үү.

Ром 1:11-12; 10:17; 12:3 • Еврей 11:1, 6 • Ефес 2:8 •
Колоссай 2:6-8

Та хоёрт итгэлээс гадна та хоёрын нэгдэлд хандсан Бурханаас өгөгдсөн хар зураг болох найдвар та хоёрт хэрэгтэй. Тиймээс түр зогсоод: “Эзэн минь, бидний гэрлэлтэд хандсан таны тэнгэрлэг диаграммыг бид хоёрт суулгаач. Та Абрахамд тэнгэрийн оддыг үзүүлсэн шигээ бидний зүрхэнд бидний ойлгож, мөнхөд хадгалж чадах дүр төрхийг сийлээч. Есүсийн нэрээр. Амень.” Хараад, сонсоод, Эзэний илэрхийлсэн зүйлийг бичнэ үү.

Итгэл, найдварыг хүлээж авахын тулд танд хэрэгтэй нэг түлхүүр чанар бий. Энэ нь даруу зан юм. Даруу зан “Эзэн минь, Тангүйгээр би юу ч хийж чадахгүй. Харин Танаар би бүхнийг хийж чадна” гэдэг. Даруу зүрхтэй байвал, таны гэрлэлтэд Бурханы хамаг л сайн сайхныг авчрах үүд нээгдэнэ!

Арван есдүгээр зууны зохиолч, пастор Эндрю Мюррей ингэж бичжээ: “Есүс газар дээр даруу байдлыг эргүүлж авчирч, биднийг даруу болгож, даруу байдлаар минь дамжуулан биднийг аврах гэж иржээ. ...Түүний даруу байдал нь бидний аврал болой. Түүний аврал нь бидний даруу байдал. ...Гагцхүү Христийн тэнгэрлэг даруу зан чанарын оршихуй дотор л бид жинхэнээсээ даруу болдог.”

Дараах ишлэлийг анхааралтай тунгаан бодно уу. Бурхан танд юу илчилж байна?

Матай 11:28-30 • Иохан 13:1-17 • Филиппой 2:1-11 •
Иаков 4:6 • 1Петр 5:5

*Ингэхдээ аливаа төлөв даруу байдлаар бөгөөд дөлгөөн
сэтгэлээр хайр дотор бие биеэ хүлцэн тэвчиж, амар тайвны
хүлээс дотор Сүнсний нэгдлийг хадгалахыг хичээгтүн.*

- Ефес 4:2-3

Дөрөвдүгээр өдрийн судлал

ХАМТДАА ТОМ МӨРӨӨД

Ганцаараа байснаас хоёул байх нь илүү дээр болой. Тэгвэл тэд ажил үйлсээ сайнаар эргүүлэх болно. ...Гоонь хүнийг хэн нэгэн нь дийлж чадах бөгөөд хоёул байх аваас түүнийг няцааж чадна. Гурамсалж гөрсөн сур тийм ч амар тасардаггүй.

- Номлогчийн үгс 4:9,12

Гэрлэлтийн өргөжилтийг эдлэх нь нөхөр бүрт, эхнэр бүрт Бурханаас заяасан тэнгэрлэг хэв загвар юм. Нэгдлийнхээ төвд Ариун Сүнсийг залсан бол, та хоёр аугаа амьдралаар аж төрөх нь гарцаагүй!

Та том амьдармаар байна уу? Томоор мөрөөдөх цаг гарга. Тус бүлгийн төгсгөлд та гэрлэлтдээ хандсан алсын харааг бичиглэх чадвартай болно. Харин одоо та энэхүү алсын хараагаа сонгох цагтаа бэлтгээрэй.

Та хоёрын хамтдаа байж, чөлөөтэй мөрөөдөж чадах газрыг бодно уу.

Хоорондоо ярилцаад, хэд хэдэн удаа хамтдаа мөрөөдөх болзоо тогтоох газраа сонго.

Хамтдаа мөрөөдөх нь та хоёрт зүрхээ чөлөөтэй уудлаж, Бурханы хангамж, таалал, хүчээр дамжуулан хамтдаа хийж чадах гайхамшигтай зүйлсийг зураглан бодох бололцоо олгоно.

“Аялалаа илүү үр нөлөөтэй болгохын тулд таны хань та хоёр юу хийж болох вэ?” хэмээн зохиолч Билл болон Пам Фаррел асуужээ.

Бүгдээрээ дараагийн уншлагаараа зорилгоо төлөвлөнө. Харин одоогоор таны зүрхэнд ямар төлөвлөгөө байна? Хоорондын харилцаа, гэр бүл, санхүү аюулгүй байдал, боловсрол болон ажил, байшин орон сууц худалдаж авах болон барих, тэтгэвэр зэрэг бас бус зүйлсийн талаар ямар хүсэл мөрөөдөл тээж яваагаа хуваалцана уу.

Миний гэрлэлтдээ хандсан хамгийн том мөрөөдөл...

Мөрөөдлөө хуваалцаж, бичсэн бол, ханиасаа асууж, хэлсэн зүйлийг нь бичнэ үү.

Миний ханийн гэрлэлтдээ хандсан хамгийн том мөрөөдөл ...

Та хоёрын аль мөрөөдөл давхцаж байна? Нийтлэг зүйл нь юу байна? Үүнийг харилцан ярилцана уу.

Бидний гэрлэлтдээ хандсан хамгийн мөрөөдөл...

„Бурхан эдүгээ, бидний дотор ажигладаг хүчний дагуу гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай” (Ефес 3:20) гэдгийг бүү мартаарай. Залбирлаарай мөрөөдлөө Эзэн өргөөд, тэдгээрийн төлөө хийх ёстой бодитой алхмыг зааж өгөхийг асуугаарай.

Тавдугаар өдрийн судлал

АЛСЫН ХАРААГАА БИЧ

“Үзэгдлийг уншсан нэгэн гүйн зугтахын тулд түүнийг тэмдэглэн, хавтангууд дээр сийлэн бич.

- Хабаккук 2:2

Таны хань та хоёр хамтдаа мөрөөдөж эхэлсэн бол, дараагийн алхам нь алсын хараагаа бичих юм. Алсын хараатай байна гэдэг нь Бурханы удирдамж ба нигүүлслээр дамжуулж та хоёр хэн болохоо харах бодитой мөрөөдөл тээнэ гэсэн үг юм.

Амжилттай гэрлэлтийн алсын хараа нь хил хязгаар тогтоож өгдөг. Таны хань та хоёр хэзээ ч ямар ч нөхцөлд буулт хийлгүй, цээжээрээ хамгаалах, хувирашгүй жишиг тогтооно уу.

Эдгээр нь хэрүүл маргаанд өдөөхгүй байх, ер тавихгүй байх, үргэлж уучлах хүсэлтэй байх, бие биеийнхээ итгэлийг хэзээ ч хөсөрдүүлэхгүй байх зэрэг байж болно.

Та хоёрын гэрлэлтэд тухайлбал **жилийн дотор** биелүүлэхийг хүсч буй ойрын зайны ямар мөрөөдөл байна?

Та хоёрын гэрлэлтэд тухайлбал дараагийн **таваас арван жилд** биелүүлэхийг хүсч буй дундын зайны ямар мөрөөдөл байна? Тодорхой бас бодитой төлөвлөгөө гаргаж, харахыг хүсч буй зүйлс дээрээ төвлөрөхөө мартуузай.

Та хоёрын гэрлэлтэд тухайлбал дараагийн **хориос гучин жилд** биелүүлэхийг хүсч буй алсын зайны ямар мөрөөдөл байна? Тэтгэвэр, ач зээ, үйлчлэл, сайн дурын үйлчлэл, аялал зэргийг бодолцоно уу.

Учир нь энэ үзэгдэл тогтоогдсон цагийн төлөө өгөгдсөн.

Энэ нь биелэл уруугаа яарч буй бөгөөд хөсөрдөхгүй юм.

Энэ нь түр саатаж байгаа боловч түүнийг хүлээгтүн.

Учир нь энэ нь хоцролгүй заавал ирнэ.

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

Мессенжер Интернэйшнэлийн “Гэрлэлтийн түүх” сургалтын хөтөлбөрийн 2-р видео хичээлийг үзнэ үү.

1. Маш олон гэрлэлт “амьтай байх” горим дээр л ажилладаг. Гэтэл Бурхан гэрлэлтийг амьтай төдий байгаасай гэж хүсдэггүй, цэцэглэж, гялалзаасай гэж хүсдэг! Хүн яагаад гэрлэлтийнхээ амьдралыг өөрөөсөө давж төсөөлөх ёстой вэ?

2. Та заавал гэрлэлт, гэр бүлийн асуудалтай тулгарна. Таны хань та хоёр нэгдэх үйл явц дундаа яваа хоёр бие даасан хүн юм. Еврей 12:2-3-р ишлэл бидэнд бэрхшээлийг даван туулах баталгаатай төлөвлөгөө зааж өгчээ. Тус хэсгийг анхааралтай уншаад, таныг ариутгалын зуухнаас шижир алт болгон гаргаж ирэх Бурханы стратегийг хэлнэ үү.

Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлье. Тэр Өөрийнх нь өмнө тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшигийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы ээнтийн баруун гарт заларсан юм. 3Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүйн тулд Түүнийг санагтун. Тэрээр Өөрийнх нь эсрэг нүгэлтнүүдээс тийм эсэргүүцлийг тэвчсэн ажээ.

- Еврей 12:2-3

3. Бидэнд зориулсан Бурханы сайн сайхнаас бардам зан л биднийг хагацаадаг. Бардам зангаасаа болж та гэрлэлтийнхээ алсын харааг хязгаарласан уу? Танд хадгалсан Бурханы гэрлэлтийг бодит биелэл болгохын тулд та ямар өөрчлөлт хийх ёстой вэ?

4. Өсч хөгжиж буй аз жаргалтай, эрүүл гэрлэлт нь заавал алсын хараатай байдаг. Сайн алсын хараа тодорхой, нарийн төлөвлөгөөтэй байдаг. Хос бүр өөртөө зохицсон төлөвлөгөө гаргах ёстой бөгөөд түүнийгээ биелүүлэхийн төлөө нөхөр нь ч, эхнэр нь ч өөрийгөө дайчлах ёстой. Таны гэрлэлтийн ямар тал дээр тодорхой нарийн төлөвлөгөө хэрэгтэй байгааг хэлнэ үү. Тодорхой төлөвлөгөө гаргах нь яагаад тийм чухал бөгөөд тустай байдаг вэ? Алсын хараа нь цаг хугацаатайгаа зохицох ёстой байдаг. Энэ нь яагаад чухал вэ?

Удирдагч нарт: Танай бүлэг Хабаккук 2:2-3, Сургаалт үгс 29:18-г уншсан уу?

5. Матай 25: 23 дээрх “итгэмжтэй сайн зарц” нь эзнийхээ итгэлийг “сайн” даажээ. Гэрлэлтийн амьдралаа сайн сайхан авч явах нь төгс авч явахаас тэс өөр утгатай юм. Бид дэндүү төгс юмыг хүссэнээсээ болж, гэрлэлтээ сайн сайхан болгож чаддаггүй. Жишээ дурьдана уу. Бидний хувьд “сайн байх” гэдэг нь юу гэсэн үг вэ?

Бүлгийн хураангуй:

- Таны гэрлэлтийн түүх нь танаас хавьгүй өргөн утгатай юм. Энэ нь таны хань та хоёрын амьдралынхаа турш харилцаж, нөлөөлөх хүн бүрийг хамрах бөгөөд үр хойчид чинь ч нөлөөлнө.
- Гэрлэлт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст Христийн дүр төрхөөр хэлбэршиж, шинэчлэгдэх төгс орчинг бүтээдэг. Энэ нь Бурханд агуу алдрыг авчирч, Түүнийг таниулдаг.
- Итгэл нь хараахан бий болоогүй буй аугаа гэрлэлтийг барих барилгын материал юм. Харин найдвар нь итгэлээр бүтээн байгуулах Бурханаас өгөгдсөн алсын харааны хар зураг юм.
- Даруу байдал нь бидний амьдралд хандсан Бурханы хамаг л сайн сайханд үүд нээнэ. Даруу байдлаар дамжуулан бид Бурханы нигүүлслийг (хүчийг) хүлээн авч, Түүний урласан гэрлэлтийн өсөн тэлэлтийг үздэг.
- Таны гэрлэлт одоогоор ямар ч нөхцөл байдалд байсан төгсгөлд нь амар сайхандаа жаргаж болно.
- Гэрлэлтдээ хандан цаг хугацаа өнгөрөх тусам есдөг, таны найдвар, мөрөөдөл, буулт хийшгүй жишгийг багтаасан амьд, амьсгалтай алсын хараа бичнэ үү.



———— ГУРАВ ————

Тавцангаа цэвэрлэ

Тавцангаа цэвэрлэ - Тодорхой нэгэн үйл явдал юмуу зорилгод бэлтгэхдээ, үйл явцад саад болж болзошгүй бүхнийг нэг мөр зайлуулах, бэлтгэл ажлыг энэхүү хэлц үгээр нэрлэдэг

Нэгдүгээр өдөр

Энэхүү далайн нэр томъёо нь анхандаа давшилтад орох гэж буй усан онгоцны ахмадын өгдөг тушаал байжээ. Энэ тушаалыг өгмөгц, далайчин тавцан дээгүүр чөлөөтэй хөдлөхөд саад болох багаж, олс, гэх мэт бүх эд хэрэгслийг зайлуулдаг байжээ. Гэхдээ өнөөдөр энэ үг нь аль нэг амин чухал үйл ажилд бэлтгэхэд хэрэглэдэг нэр томъёо болжээ.

Бид гэрлэлтийн хар зургийг гаргах талаар өмнөх бүлэгт ярьсан. Харин энэ бүлгээрээ бид таны гэрлэлтээ өргөжүүлэн тэлэх үйл явцад саад хийж болзошгүй асуудлын талаар ярина. Усан онгоцны тавцанг цэвэр байлгахын тулд тэр олон олсыг хооронд нь

орооцолдуулахгүй байх хэрэгтэй. Хэрэв усан онгоцны тавцан эмх замбараагүй байвал, далайн шуурга зэрэг хүнд асуудал дэгдэх үед далайчин энхийн цагт зүгээр л тойроод гарчихдаг байсан зүйлдээ бүдчиж унах аюултай. Дэндүү олон хүн “тавцан дээрээ бүдчиж” гэмтээд зогсохгүй, хөл алдан далайн усанд унаж алдардаг.

Бурхан гэрлэлтэд төгс төлөвлөгөө зэхсэн. Гэвч гэрлэлт шиг эр, эм хоёрын сул талыг ил гаргадаг институци байхгүй. Эвдэрхий сэлүүртэй, хамаг ачаа бараагаа алдчихсан, энд тэндээ цөмөрчихсөн, сэмэрч муудсан олстой, замаасаа төөрчихсөн усан онгоцоо залах гэж зүдрэх нөхцөл байдалд орохоос чинь өмнө бид таныг зөв зам дээр тавьмаар байна.

Харилцааны суурийн асуудлыг ухамсартайгаар авч хэлэлцэхээс татгалзах нь зүгээр л шал нь цөмөрхий усан онгоцтойгоо далайд гараад явчихтай адил юм. Усан онгоц хэсэгтээ зүгээр байвч, даралт нэмэгдэхийн цагт тэсэхгүй, живнэ.

Би таныг бүдрээд живчихээсэй гэж хүсэхгүй байна. Таны гэрлэлт ямар ч шуургыг үл ажрах авдар шиг том усан онгоц байг. Та өмнөх бүлэгт гэрлэлтийнхээ хар зургийг гаргаж байхдаа, тэр алсын харааныхаа төлөө хөдлөхөөсөө өмнө эхлээд шийдэх ёстой бас бус асуудал байгааг мэдсэн байх. Тэгэхээр амиа бодох, бардамнах, гомдлоос үндэслэсэн тэдгээр дутагдал нэг бүрийг шинжиж үзье. Биднээс зүүгдэх хараал, боомилогч айдас бүрээс өөрийгөө чөлөөлж, найдварыг зангуугаа болгоё.

Бидний эхлэл

Тавцангаа цэвэрлэх нь тун чухал юм. Учир нь бид хоёр тавцангаа цэвэрлэлгүйгээр аянаа эхлүүлж байлаа. Бид гэрлэхээс өмнөх зөвлөгөөнд хамрагдсан боловч, үнэндээ сонсоогүй юм. Зөвлөгч маань бидэнд зөрчил болон шуурган дунд хэрхэх талаар зөвлөх гэж оролдох үед бид “Юун хэрүүл маргаан? Бид хэзээ ч хэрэлдэхгүй! Бурхан бид хоёрыг нийлүүлсэн. Наад зөвлөгөө чинь бие биедээ дурлаагүй хүмүүст л зохих байх. Харин бид өөр хүмүүс шүү. Бидний амьдрал дээр Бурханы мутар буй!” гэж боддог байлаа.

Тэгтэл гэрлээд хэдхэн долоо хоногийн дараагаас л асуудал ундрал. Хичнээн буруу бодолтой явсан маань тэр даруй л илрэв. Бид гэрлэлтийн амьдралд төгс амьдралын төсөөлөлтэйгээр хөл

тавьсанаас биш, тийм хурдан бие биеийнхээ эрээн цоохрыг олж харах юм чинээ санаагүй билээ. Тэгээд бие биеэ өөрчлөх ажилд ханцуй шамлан оров. Үүнээс болж гэрлэлтийн амьдрал маань тун дураараа хоёр хүний нэгийгээ үзэх тулааны талбар болж хувирав. Төмөр төмрөө ирлэхэд тас нас хийж, гал бутарч байлаа.

Нэгдэл маань үнэндээ маш сул байсныг бид мэдээгүй юм. Тийм ээ, бид хоёр бие биедээ гүн гүнзгий зориулагдсан байсан ч, өөрийгөө нэн ялангуяа тэвчээр, амиа бодох тал дээр хэт дөвийлгөж бодсон байв. Бидэнд хүлээн зөвшөөрөх ёстой асуудал нилээд байснаас гадна, арай гайгүй гэж хэлж болох тал маань ч айсуу бэрхшээлийн өөдөөс тулж зогсох хангалттай хүчтэй байсангүй.

Бурханаар тавцангаа цэвэрлүүлэхийн оронд бид бие биеэ л цэвэрлэж хаях гээд байжээ. Өөрсдийгөө тэнгэрийн хос гэж бодож байсан хүмүүс маань шууд л хамраараа газар хатгав. Мэдээж чуулганд юу ч болоогүй царай гаргавч, гэр маань баасан гаригийн үдэш бүр зурагтаар гардаг зодооны спорт шиг л байлаа.

Гэрлэлтийнхээ эхэн үед бид хоёр өөрсдийнхөө хэлдгээр “ана мана” үзэлцдэг байв. Маргах үед Жон намайг өрөөнөөс гаргахгүй, “орон дээрээ сууж бай” гэдэг байв. Харин би маргааш өглөө амаа барих үг хэлэхээсээ өмнө өрөөнөөсөө гарахыг хүснэ. Жон намайг орон дээрээ сууж бай гэхэд, харин би эсэргүүцэн өндөлзөнө. Жон намайг дахиад л суулгах үед амнаас маань болох болохгүй үг гарна. Миний түрсэн хөдөлгөөн, Жоны түлхсэн хөдөлгөөний үр дүнд би газар пидхийтэл унав.

Би хөл дээрээ год үсрэн босохдоо, гартаа босоо гэрлээ шүүрч авлаа. Харин Жон айдас хурсан царайгаар гайхшран ширтээд: “Чи наадахаараа яах нь уу?” гэж асуув.

“Мэдэхгүй ээ, мэдэхгүй.” Энэ хөгтэй явдал бид хоёрт тайвширч, асуудлаа хэлэлцэх боломж олгосон ч, бид асуудлынхаа үндсийг бас л шийдэж чадсангүй.

Энэ явдлаас хэдэн өдрийн дараа би найзтайгаа өдрийн хоол идэж байлаа. Тэрбээр намайг бодвол, нилээд олон жил гэрлэчихсэн учраас би түүнд гэрлэлтийнхээ асуудлаас уудалмаар болов. Тэгээд мөнөөх чийдэнтэй явдлыг шууд дэлгэлгүйгээр, арай жаахан тойруулан: “Чи нөхөртэйгээ маргалдаад, дараа нь шалан дээр унаад, гартаа чийдэн шүүрч авах явдал чамд тохиолдож байсан уу?” гэж асуулаа.

“Тэрбээр нүд орой дээрээ гарсанаа: “Үгүй!” гэлээ.

Би ч өөдөөс нь бушуухан: “Би ч бас үгүй!” гэж хариулав.

Би мэдээж худал хэлсэн. Миний гэнэтийн асуулт нь аврал эрсэн хашхираа байсныг найз маань гадарласан л байх. Гэхдээ хэн хэн маань юу ч болоогүй юм шиг жүжиглээд л өнгөрөв.

Жон бид хоёрт туслах хүн байсангүй. Бидний гэрлэлтэд том асуудал байсан ч, бид хэнд хандахаа мэдэхгүй байлаа. Чуулган дотор бид хамаг зөрчлөө тас нууж, аз жаргалын баг зүүнэ. Харилцааны маань зөрчил улам хурцадсаар байгааг хэн хэн маань мэдэж байсан ч, хэрхэхээ мэдэхгүй байлаа. Итгэл найдваргүй байдал болон ичгүүрээсээ болж нөхцөл байдал маань муугаас шал дордов. Эцэстээ манай гэрийн хурцадмал байдал тэсэхүйеэ бэрх болсон юм.

Тэгтэл тэр нэгэн аймшигтай явдал болов. Жон миний бие Лизадаа гар хүрэх үед бидний хэрүүл туйлдаа хүрсэн юм. Энэ явдлаас өмнө бид хоёр угзрах, түлхэх зэрэг зөөлөн нудралцаг байсан ч, энэ удаа би анх удаа гэргийгээ цохиод авсан юм. Би тэр даруй үйлдлээ ухаарч, хийсэн зүйлээсээ айн, голоосоо харамслаа. Лиза ч намайг хариу цохиж аваад, дараа нь угаалгын өрөөндөө ороод түгжчихэв. Тэр орой бид хоёр хоёулаа хов хоосон сэтгэлтэй орондоо орсон юм.

Маргааш өглөө нь ажилдаа явах гэж байх үед Лиза надаас хөндий хүйтэн, дуугүй байлаа. Харилцаа маань ямар ч ариун нандин зүйлгүй, итгэлцэлгүй болчихсон мэт байлаа. Бид хоёр хоёулаа бүтэн цагаар ажилладаг байсан бөгөөд долоо хоног өнгөрөх тусам, бид бие биеэсээ улам л хөндийрсөөр байлаа. Тэр үед Лиза худалдагчаар ажилладаг байсан агаад надтай уулзахгүй гэж зориуд ажил дээрээ оройтно. Тэгээд гэртээ ирсэн ч, надтай хамт хооллохоос дургүйцэж, шууд л номоо уншихаар орондоо орно. Харин би учраа олохоор амралтын өдрийг харуулдан хүлээж байлаа.

Миний тангараг

Лиза миний бие охин байхдаа, “ирээдүйн нөхөр надад гар хүрэх л юм бол, би шууд сална” гэж тангарагладаг байлаа. Би

өөрөө хүчирхийлэлтэй гэр бүлд өссөн учраас бас дахиад нэг хүчирхийлэгчийн гарт орохыг хүсээгүй юм. Жон надад гар хүрэх үед би тангарагаа санаж, амьдрал өөрчлөгч шийдвэртэй нүүр тулсан юм. Би энэ хүнтэй хамт үлдэх үү? Намайг цохисон хүнийг би хайрлаж, түүнд зориулагдсан хэвээрээ байж чадах уу?

Ажлын газрынхан маань миний шаналалыг мэдсэн болтой, нэгэн ахлах маань болсон явдлыг гадарлаад, шууд л Жоныг хаяхыг зөвлөв. Би амралтын өдрөөр Жоныг гэртээ оруулахгүй гэж шийдэв. Ахлахын зөвлөгөө, дээрээс нь Др. Жэймс Добсон “Хайр хатуу байг” номыг уншиж байсныг ч хэлэх үү - би энэ асуудлыг хямралын хэмжээнд авч үзсэн юм.

Тэр орой Жоныг ирэхэд, би түүнийг гэртээ оруулсангүй. Дотроос нь түгжчихсэн учраас гаднаас нь онгойлгох боломжгүй байв. Жон гэртээ орж чадахгүй учраас бас тэр үед гар утас байхгүй учраас гаднаас: “Лиза, би ирчихлээ! Хаалга онгойлго!” гэлээ. Би цонхоор “Би чамайг оруулахгүй. Тиймээс явж хонох газар ол” гэж хэллээ. Жон итгэсэнгүй. Хэсэг хугацааны дараа Жон үнэхээр орж чадахгүй гэдгээ мэдээд, найзындаа мацаг барьж залбирахаар яваад өгөв.

Гэрт надаас өөр хүнгүй тул би Бурхантай ноцтой ярилцахаар шийдэв. Миний санаж байгаараар нэг иймэрхүү залбирлаар эхэлж билээ: “За тэгэхээр Бурхан минь, надад танд хэлэх үг байна. Жон гуай гэрээсээ хол явахдаа, надад ямар муухай хандсанаа ухаараг. Та түүнд хар дарсан зүүд өгөх юмуу эсвэл түүнийг аянга цахилгаанаар ниргэж айлгаач. Гэхдээ түүнд амь насны даатгал байхгүй учраас битгий алчихаарай.”

Би Бурхантай хичнээн Жоны талаар ярьсан ч, Бурхан надтай ганцхан миний талаар л ярих гээд байв. Бурхан надтай Жоны талаар ярихыг хүсэхгүй байв. Бурхан надтай миний зүрхний талаар л ярихыг хүсч байлаа. Бурхан надад: “Лиза, чиний гэрлэлтэд тэнгэрийн ер бусын оролцоо хэрэгтэй. Харин тэнгэрийн ер бусын оролцоог хүсч байвал, чи ер бусын үйлдэлтэй байх ёстой. Энэ нь чи зохисгүй хүнийг ч уучлах ёстой гэсэн үг. Лиза, чи Жонтой тооцоо бодохыг хүсч байна.”

Тооцоо бодох

Жон бид хоёр муудахаараа, зөвхөн тухайн асуудлын талаар муудалцдаггүй байлаа. Бид гэрлэснээсээ хойш хоёр биеэ гутаан доромжилж байв. Улам бүр хүндрэх гомдол, ял, гашуудал нь бидний хамаг хэрүүлийн үндэс болж байлаа. Өчүүхэн маргаан ч түүхэн дайны хэмжээнд тулна.

Эвдрэлцлийн гол хэрэгтэн Лиза миний бие Жоны өнгөрсөн алдааг уучлах хүсэлгүй байлаа. Харилцаанаасаа олсон сэтгэлийн шарх зовиураасаа болж, надад хэрэв Жоныг уучилчихбал, өөрийнхөө сэтгэл санааны болон бие махбодын аюулгүй байдлаараа дэнчин тавих юм шиг санагдаж байв. Гэтэл Бурхан надад Жон төгс биш учраас түүнийг уучлах ёстойг хэлэв.

Би Бурханы анхаарлыг буцаагаад Жон дээр хандуулахыг хүссэн ч, Тэр надтай гар нийлэхгүй байсан тул би аргаа баран: “Би яахаараа өөрчлөгдөх ёстой юм? Та тэр Жондоо өөрчлөгд гэж хэлээч” гэв.

Гэхдээ Бурхан надад миний зүрхний дүр төрхийг л харуулж байлаа. Төд удалгүй бардамнал ба амиа бодох чанар нь үзээрийн муухай толгойгоо өргөв. Тэгээд би “Хэрэв бүтэн сайн өдөр Жон бид хоёр зэрэгцэж суугаад, гар гараа барихгүй бол, хүмүүс юу гэж бодох билээ?” гэж бодлоо. “Би Жоныг гэртээ ирж хувцсаа солиод, чуулгандаа хамт явахыг нь зөвшөөрье. Тэгж байж л амьтаны нүдэнд өртөхгүй” гэж тооцооллоо. Би Жоныг юмуу харилцаагаа бодсонгүй. Би хүмүүс бидний талаар юу гэж бодох бол гэж л бодож байлаа. Би бардам зангаасаа болж өөрт хамгийн их хэрэгтэй, өөрчлөгч үр нөлөөг хүлээж авч чадахгүй байв.

Тэгж тэгж эцэстээ би сөхөрч, Бурханд бууж өгсөн юм. Жоны “хэрэг” дээр ч би өөрийнхөө далд оролцоог хүлээн зөвшөөрөв. Тэгээд өөрийгөө даруу болгомогц, Бурханы нигүүлсэл айлчилсан юм. Даруу байдал ямагт нигүүлсэлд үүд нээдэг:

Залуус аа, та нар мөн түүнчлэн ахлагчиддаа захирагд.
Та бүгд бие биедээ даруу хандах байдлаар өөрсдийгөө хувцасла. Учир нь Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, харин даруу хүнд нигүүлслээ өгдөг. (1Петр 5:5)

Би Жоныг өөрчилж чадахгүй гэдгээ ухаарлаа. Үүнийг зөвхөн Бурхан л хийнэ. Гэхдээ би Бурханд намайг өөрчлөх боломжийг нь олгож чадна.

Тэр амралтын өдрийн дараа Жон гэртээ тэс өөр хүн эргэж ирлээ. Гэрлэлтийн тэр эхний жилээс хойш гуч гаруй жил өнгөрөхөд, Жон надад дахиж хэзээ ч гар хүрээгүй. Бид хоёр хоёулаа Бурханы болоод бие биеийнхээ өмнө даруугаар үйлдэхэд, бидний нэгдэл сэргэлтийн бүрэн төгс найдвараар дүүрэв.

Түүхэн сургамж

Бидний амьдралын тэр улирлын шарх ганц шөнийн дотор эдгэсэн гэж хэлмээр байвч, даанч тийм юм болоогүй юм. Гэр бүлийнхээ амьдралын дараагийн хоёр жил бид хоёр Бурханыг хүндэтгэдэг амьдралд суралцах гэж оролдоход, бас л асар их сэтгэл санааны зөрчил тэмцэлтэй байлаа.

Бурхан бид хоёрын тус тусын маань амьдрал дээр ажиллаж байхад, бид төлөвшөөгүй зангаасаа болж байнга бие бие рүүгээ довтолно. Ингэж бид гэрлэлтийнхээ эхний дөрвөн жилд асар их туйлдав. Нэг талаараа бид алдааныхаа үр дагаварыг засах гэж л амьдарч байлаа. Үнэндээ бид сэтгэл санааны төдийгүй, эвдэрхий хөргөгч, хагархай цонх зэрэг зэрэг эд материалын үлэмж хохирол амссан юм. Гэхдээ Бурхан л бидэнд итгэл найдвар алдраагүй юм. Тэрбээр бидний алдааг тавцангаа цэвэрлэх боломж болгон хувиргаж байлаа. Бидний гэрлэлтийг сөнөөх гэсэн дайсны хорон ажлыг Бурхан айсуу аугаа амьдралын маань суурь болгон цутгаж байжээ.

Бид гэрлэлтийнхээ амьдралд зөрчилдөж явсанаа байнга ярьдаг ч, хэзээ ч энэ удаагийнх шиг дэлгэрэнгүй ярьж байгаагүй юм. Бид танд хов жив дуулгаж байгаа биш, харин юмс өөрчлөгддөгийг л хэлэх гэсэн юм. Гэхдээ бүх хүчирхийлэл сайн сайхнаар төгсдөггүйг бид бас мэднэ. Тиймээс үр хүүхдийн чинь амьдрал аюул занал дор байгаа нөхцлийг хүлцсээр тэвчсээр байхыг бид ямар ч эрэгтэй, эмэгтэй хүнд зөвлөхгүй. Хэрэв та ийм нөхцөлд байгаа бол, аюулгүй газар яваарай. Хүн амьтнаас бүү ич. Гол нь аюулгүй байж, туслалцаа хай. Энэ талаар удахгүй дэлгэрэнгүй ярина.

Тэр хүнд хэцүү өдрүүдэд хонгилын үзүүрт гэрэл харагдахгүй байсан ч, гучин жилийн дараа бид хоёр ёстой л жаргаж сууна. Бид хоёрын өнөөдрийн гайхамшигтай амьдрал нь үнэндээ Бурханы гайхамшигийг бүтээгч хүчийн гэрчлэл билээ. Гэхдээ бид хайрлах шийдвэр гаргах үед Бурхан биднийг хоёр биеэр маань дамжуулж, итгэмжтэйгээр дагуулдаг.

Та хоёрын харилцаа яг одоо ямар байгааг бид мэдэхгүй ч, найдвар байгааг баттай хэлье! Бурхан руу бүх зүрхээрээ эргээд, Түүгээр шийдүүл. Та ханиа өөрчилж чадахгүй. Гэхдээ Бурхан чадна. Бүх хариуцлагыг Бурханд өг. Бурханд өгвөөс Тэрбээр гайхамшигтай өөрчлөлтийн ажлыг хийнэ.

Хүчирхийллийн талаар хэдэн үг

Энэ талаар маш тодорхой болгомоор байна. Нөхрүүд ээ, эхнэртээ гар хүрч хэрхэвч болохгүй. Түүнийг сул дорой сав гэж хандахыг Библи хэлсэн (1Петр 3:7). Эхнэр чинь таны бие рүү эсвэл сэтгэл рүү давшлах нь танд адилхан дайрах эрх олгохгүй. Ийм үед шаардлагатай бол холдоодявчих хэрэгтэй. Эхнэрийнхээ дайралтыг хариулах цорын ганц арга байсан ч, биеийн хүчирхийлэл үйлдэж болохгүй. Учир нь та гэргийдээ гар хүрбэл, энэ нь түүний биед хор хохирол учруулахаас гадна итгэлийг нь хөнөөдөг. Эхнэр чинь цаашид тантай байхдаа аюул занал мэдэрнэ. Хэрэв та эхнэртээ гар хүрсэн бол, Бурханы өмнө үнэн голоосоо гэмшээд, ханиасаа уучлал эр.

Эхнэрүүд ээ, нөхрийн чинь угийн хүсэл бол таныг хамгаалах. Энэ зорилгын улмаас л Бурхан эр хүнд илүү хүч чадал суулгасан. Та уурандаа нөхрөө цохиод авахдаа, нэг их хор хөнөөлгүй дайралт гэж боддог бол, энэ нь түүний хувьд маш хүнд тусдаг. Зөв ч байна уу, буруу ч байна уу - эр хүн рүү дайрах үед тэрбээр хариу дайрдаг нь түүний төрөлх араншин юм. Бид бие биеийнхээ муу муухайг үзэх биш, сайн сайхныг үзэх ёстой. Хэрэв та нөхөртөө гар хүрдэг бол, даруй гэмшээрэй.

Магадгүй та хүчирхийлэлтэй гэр бүлд өссөн байж болно. Магадгүй таны гэр бүл хэл яриа, сэтгэл зүй, махбодын хүчирхийллээр дүүрэн байсан байж болно. Энэ нь асуудлыг

шийдэх эрүүл арга зам биш шүү. Амьдралын иймэрхүү асуудлыг эрүүл саруулаар шийдэхэд чинь Христчин зөвлөгөө туслана. Энэ асуудлаар жижиг бүлгээр хийдэг сургалт бараг чуулган бүрт бий. Сүнслэг болоод мэргэжлийн туслалцаа хайхаасаа хэзээ ч бүү ай.

Энэ нь нөхөрт ч, эхнэрт ч хамаатай: хань ижил чинь таны дэргэд байхаасаа айж байвал, түүнээс хол байгаад, итгэлийг нь эргүүлэн олж ав. Тэднийг дургүй эсвэл айж байхад нь хүчээр ярилцах гэж бүү оролд. Тэгэх юм бол, асуудал улам хурцдаж, та магадгүй хожим толгойгоо шаагаад ч нэмэргүй зүйл үйлдэж магадгүй юм.

Хоёрдугаар өдөр

ГОМДОЛ

Уучлал гэдэг нь хоригдлыг чөлөөлөх үйл хэрэг бөгөөд тэр хоригдол нь та өөрөө байсныг мэдэх юм.

— Льюис Би. Смидес

Гэрлэлтийн тавцангаасаа цэвэрлэж хаях ёстой хамгийн эхний зүйл нь гомдол юм. Учир нь гомдол нь хортой бөгөөд энэ бүлэгтээ бид энэ талаар илүү их ярина.

Уучлахаас татгалзах явдал нь бидний сэтгэлийн галыг унтрааж, эрх чөлөөгүй болгодог. Үүнээс болж өшөө авах бусармаг таашаал төрнө. Энэ нь гагцхүү муу муухайг л авчирдаг, төгсөшгүй “гэмцээн” юм. Харин уучлал нь гомдсон болон гомдоосон хоёр талын аль алинд эрх чөлөө авчрах үйлдэл билээ.

Олон хүн зохистой хариу хүлээж авч байж л уучилна гэдэг. Бид юм л бол “Түүнийг өөрчлөгдөхөөр нь уучилъя” гэдэг. Гэхдээ Бурханы хаанчлалд уучлал нь сонголт биш, харин амьдрах цорын ганц зам юм. Бид уучлах тусам, тэнгэрийн Аавтайгаа улам л адилхан болно. Бид Түүний аугаа чанарын төлөөлөгч болно. Бид уучлалын хүчийг хүлээж авах ёстой.

Колоссай 3:13 дээр Паул бидэнд:

“Ингэхдээ нэг нэгнээ хүлцэж, бие биеэ уучилж, хэрэв хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал та нарыг Эзэн уучилсны адил та нар бас уучил” хэмээн тушаажээ.

Үүнийг хүлээж авахад хэцүү л дээ, хэцүү. Учир нь энэ нь зөвлөгөө биш, тушаал юм. Энэ тушаалын өмнө хэн ч шалтаг тоочиж чадахгүй. Бурхан бидэнд биднийг гомдоосон хүнийг уучлаарай л гэсэн. Тэгээд л гүйцээ.

Бид заримдаа өөртөө эрх чөлөө олгож, алдаагаа хаацайлдаг бөгөөд бусдаас ч адилхан зүйлийг хүсдэг. Гэхдээ бусдын - тэр дундаа ханийхаа алдааг уучлах хамгийн хэцүү. Гэвч уучлахаас татгалздаг нэгэн нь өөрөө юунаас уучлагдсанаа мартжээ. Олон хүн мөнхийн тамд хаягдах байснаа мартаж, өөрийгөө зөвтгөдөг. Бурханыг гомдоосон бидний гомдол аймшигтай байсан тул үүний үр нөлөөг Бурхан ганц Хүүгийнхээ амиар төлөн байж эргүүлжээ. Загалмай дээр Христ гомдож болох байсан атал уучиллыг тунхагласан юм. Бид уучлалд зохистой хүмүүс болохоос ч өмнө Христ биднийг уучилсан тул бид ч бас адилхан зүйл хийх хэрэгтэй.

Таны хань төгс биш гэдгийг та хэлүүлэлтгүй мэдэж байгаа байх. Төгс хүн гэж байхгүй! Гэхдээ алдаа нь Бурханы нигүүлслийг өргөжүүлэх сайхан боломж олгодог. Уучлах хүсэл нь Христ бидэнтэй хамт байгаагийн хамгийн том гэрчлэл юм.

Шархаа анагаах

Биднийг анх гэрлэхэд, Лиза миний бие “Чамайг өөрчлөгдөхөөр чинь уучилъя” гэж хэлдэг хүний нэг байлаа. Жон алдаагүй хүн болохоос нааш, миний хөтөлдөг, түүний алдаа эндлийн жагсаалт бичиг улам л уртассаар байх байлаа. Үл уучилбал Жон улам бүр өөрчлөгдөх хүслээр эрчлэгдэнэ хэмээн санасан ч, энэ маань улам л ялтай, найдваргүй, хүчгүй болгосон юм.

Харин Бурхан яаж Өөрөө уучилдгаа надад харуулах үед бүх зүйл өөрчлөгдөж билээ. Бурхан хүнийг өөрчлөгдсөн хойно нь уучлалаар мялаадаг Нэгэн биш ажээ. Бурхан өөрчлөгдөөгүй хүнийг уучлалаар мялаадаг. Энэ нь Бурхан Өөртөө ямар итгэлтэйг л харуулж буй юм. Бурхан уучлалын талаарх миний ойлголтыг

шинэчлэхдээ, аман дахь үгийг минь Түүний зүрхийг тусгасан үгсээр сольсон юм: “Чамайг өөрчлөгдөхийг хүсч байгаад чинь итгэж байгаа учраас би чамайг уучилж байна.”

Жоныг уучлах нь надад өөрт маань хичнээн чухал байсныг би ойлгодоггүй байв. Нөхөртөө хорсох нь миний өөрийн өөрчлөгдөх чадварыг боомилж байсныг би бүр хожим нь л ухаарч билээ. Учир нь Есүс ингэж айлдсан юм:

Та нар хэний нүглийг уучилна, тэд уучлагдана. Та нар хэний нүглийг үл уучилна, тэд үл уучлагдах болно.
(Иохан 20:23)

Хэдэн зууны турш энэ ишлэл нь айдас болон дарамтыг ухуулах багаж мэт буруу ташаа ашиглагдсаар ирсэн юм. Гэтэл Есүс ингэж хэлээгүй. Бид Есүсийн үйлчлэлийн бүхэл Биеийг судласнаараа, Түүний энэ үгийн зорилго, ач холбогдлыг ухаарна. Уучлалын хүчийг Есүсээс өөр хэн ч ойлгохгүй. Учир нь Тэрбээр уучлагдашгүйг уучилсан юм.

2Коринт 5:17-20-р ишлэлээс үзбэл, Бурхан биднээр дамжин дэлхийтэй эвлэрдэг ажээ. Христ доторх уучлалыг бид баталгаажуулж, дэлгэрүүлэх ёстой. Гэтэл бид өөрсдөө гомдоод байх юм бол, Бурханы найдварыг тунхаглахаа больж, ахан дүүсийг маань яллагч гэгдэх нэгэнтэй зөвшилцөнө. Бурхан шинэ эхлэлийг өгөхийг хүсч буй тэдгээр хүмүүст бид ялын тогтоол уншина.

Уучлал нь тэнгэрлэг үйлс юм. Ийм их золиос шаарддаг өөр сайн чанар байхгүй. Энэ нь нотолгооны оронд ухамсартайгаар гаргадаг өр зөөлөн сэтгэл юм. Гэхдээ биднийг золиос гаргах үед Бурхан биднийг тэвэрч авдаг. Уучлалыг сонгосноороо бид өөрийнхөө мэдрэмжид мөргөхөөс татгалзаж, өөрийгөө Бурханы үнэнд өргөдөг. Хань ижлээ уучилсанаараа бид түүнд дахин Бурханы нигүүлслээр хэлбэрших боломж олгодог.

Бид Бурханы өмнө гэмшихэд Тэрбээр: “Би Бурхан. Тиймээс чи энэ алдаагаа хоёр долоо хоногийн дараа дахиад л хийнэ гэдгийг чинь мэдэж байна” гэж хэлдэггүй. Бурхан ердөө л “Би чамайг уучиллаа” гэж хэлээд, өөрчлөгдөх хүчийг санал болгодог. Бурхан бидний ирээдүйг бүтэлгүйтлээр хараадаггүй. Бурхан бидний зөрчил бүр дээр найдвар, амлалт тунхагладаг. Тиймээс бүгдээрээ ч бас тэгье.

СҮНСЭЭ НЭЭХ

Гомдол бидний сүнсийг хаадаг. Бид дахиад шархлахгүй гэж хичээхдээ, зүрхээ тойруулан хана босгодог. Тэгээд тэр хана биднийг хамгаалж байна гэж боддог ч, үнэндээ тэр нь бидний Христийн хайрыг хүлээн авч, өгөх чадварыг боомилдог юм. Бид биеэ хурааж, гагцхүү амиа хичээсэн авир л гаргана. Эцэстээ зүрх маань чулуужиж, бусдыг ойшоохоо болино. Гэтэл энэ нь сайн мэдээнд таарахгүй байна.

Та Галил далай, Мөхсөн тэнгисийг мэднэ байх. Эдгээр нь Израилийн хамгийн том хоёр усан сан юм. Галил далай нь усаа Хойд зүгээс авч, Урд зүгт цутгадаг. Энэ тасралтгүй урсгал нь Галил далайг олон төрлийн амьд биетэй, амьд ус болгодог. Гэтэл Мөхсөн тэнгис хүлээж авсан усаа хаашаа ч цутгадаггүй, зөвхөн өөртөө л хадгалдаг. Мөхсөн тэнгис нь цутгалангүй учраас давстай эко системд нь өчүүхэн бактер, мөөгөнцрөөс өөр амьд амьтан байхгүй. Нэр нь ч үүнийг нь хэлээд өгнө.

Бид гомдол тээхдээ яг л Мөхсөн тэнгис шиг болдог. Бидний хаагдсан сүнс нь гэрлэлтийг маань ямар ч сайн сайхан зүйл амьдарч цэцэглэх нь бүү хэл, амьд амьтан байхын аргагүй орчин болгодог. Уучлалаар дамжуулан бид зүрхээ дахин нээж, Бурханы хүчийг дотогш гадагш чөлөөтэй нэвтрүүлнэ.

Уучилж, уучлагдахаас татгалзах явдал нь зайлшгүй сүнсний хорлол руу хөтөлдөг. Бид өөрийгөө хангаж чадахгүй. Зөвхөн Бурхан л чадна. Бидний амьдрах чадвар нь хамт амьдарч байгаа нэгэнтэйгээ хослон зохицох солилцоо шаарддаг бөгөөд бид эрх чөлөөтэйгээр өгч бас хүлээн авах ёстой.

Уучлалын хязгаар

Та магадгүй “Миний нөхөрт/эхнэрт байнга л уучлал хэрэгтэй. Миний уучлал чинь хязгааргүй биш шүү дээ. Юманд чинь хэмжээ хязгаар гэж байх ёстой!” гэж бодож байж магадгүй. Дагалдагч нар ч бас ингэж л бодож байсан. Учир нь Есүс, Петр хоёрын хооронд ийм яриа өрнөжээ:

Дараа нь Петр ирж Түүнд:

—Эзэн, ах дүү маань миний эсрэг нүгэл үйлдэхэд би хэдэн удаа түүнийг уучлах вэ? Долоон удаа юу? гэхэд нь Есүс айлдсан нь

—Би чамд долоон удаа гэж хэлэхгүй. Харин дал дахин долоон удаа гэж хэлье. (Матай 18:21-22)

Петр ингэж асуухдаа нилээд өгөөмөр сэтгэл гаргажээ. Петр бол “Иймээс өршөөнгүй харцаар бүү хар. Амийг амиар, нүдийг нүдээр, шүдийг шүдээр, горы гараар, хөлийг хөлөөр” гэдэг хууль дор өссөн хүн. Тиймээс долоо дахин уучлахыг санал болгох үедээ Есүсээс: “Тийм ээ, Петрээ чи зөв ойлгож!” гэдэг хариу сонсоно гэж найдсан.

Энэ нь Петрийн хувьд хүнийг нэг өдөрт уучлах тоо байжээ (Лук 17:3-4). Тиймээс Есүсийн “дал дахин долоон удаа” гэдэг үг нь хүний амьдралдаа үзүүлэх ёстой уучлалын тоог хэлсэн биш, харин ямар ч хэмжээ хязгааргүй үзүүлэх ёстой уучлалын тухай үг ажээ.

Есүсийн ярьсанаар бол, тэр хүн нэг хоногт 490 удаа нүгэл үйлдсэн байх ёстой аж! Ийм аймшигтай нүгэлтэй байхын тулд таны хань танд унтах ч зай завсар өгөхгүйгээр гурван минут тутамд таныг гомдоох ёстой ажээ. Ямар ч аймшигтай нүгэлтэй амьтан ийм хэмжээнд нүгэл хийж чадахгүй байх аа. Гэхдээ хань тань таны эсрэг хоногт 490 удаа нүгэл үйлдчихсэн бол, 491 дэхээс нь авахуулаад та түүнийг уучлахгүй байж болно гэсэн үг биш юм.

Бичээст долоо дугаар нь бүрэн төгс гэсэн утга илэрхийлдэг - нэн ялангуяа тэнгэр газрын хооронд. Есүс дал дахин долоон удаа гэсэн тоо хэрэглэхдээ, биднийг тэнгэрлэг Аавынхаа жишгийг даган, бүрэн гүйцэт уучлаарай гэсэн юм. Бид Христээр дамжин Аавтай эвлэрүүлэгдсэн учраас л өдгөө өгөөмрөөр уучлах боломжтой болжээ. Христийн дотор Аав, хүүхдүүдийн хооронд хослон зохицол буй болжээ. Бидний зүрх Түүний уучлалыг чөлөөтэй хүлээж авсан бөгөөд сүнсээр эрүүл саруул байхын тулд бид бусдыг чөлөөтэй уучлах ёстой.

Есүс бидний уучлалыг цуцашгүй байгаасай гэж хүсдэг. Учир нь Есүс Петртэй ярилцсаныхаа дараа өршөөлт хаан, өршөөлгүй зарцын тухай үлгэрээ ийнхүү төгсгөжээ:

...ихэд хилэгнэн уурлаж, өр ширээ бүгдийг буцаан төлөх хүртэл нь түүнийг зандалчинд тушаажээ. Түүнчлэн хэрэв та нарын нэг бүр чинь ах дүүгээ зүрх сэтгэлээсээ уучлахгүй бол Миний тэнгэрлэг Эцэг ч та нарт мөн тэгж хандах болно. (Матай 18:34-35)

Бид уучлахгүй бол, өөрөө уучлагдахгүй. Үүнд ямар ч шалтаг байхгүй. Бид уучилж чаддаг байх нь Бурханд яагаад тийм чухал вэ? Учир нь бид уучлахдаа Бурханы мөн чанарыг танин мэдэж, даган дууриадаг. Бурханы уучлалаар бид өөрсдөө бүрэн бүтэн болоод зогсохгүй, Бурханы бүрэн бүтэн чанарыг уучилж буй нэгэндээ өргөжүүлэх тушаалтай юм. Хань чинь байнга л уучлал гуйж байгаа бол, Бурхан таныг Өөрийнхөө эдгэрлийн хүчийн төлөөлөгч байх боломжоор ерөөжээ.

Гомдол, уучлалын талаар Жоны “Сатаны урхи” номоос дэлгэрэнгүй судлана уу.

Гуравдугаар өдөр

Хэрүүл: Жоны түүх

Бид хоёр нэг удаа бүтэн арван найман сарын турш түнжин хагарсан юм. Бид нэг л зүйлийн талаар өдөр бүр өдөржин шахуу маргана. Бид хүүхдүүдийнхээ нүдэн дээр ч бие биеэ үгээр иддэг байлаа. Арай том болсон нь учрыг ойлгохтойгоо учраас: “Та хоёр хоолон дээр битгий хэрэлдээд бай л даа” гэдэг байв. Бид хоёрын зовиур, эв нэгдэлгүй байдал манай гэрийг байнгын түгшүүртэй байлгаж, бидний гэр бүл, гэрлэлтийг цуслаж байлаа.

Нэгэн шөнө бид хоёр бие биеэ дахиад л хэмлэж эхлэхэд, Жон миний бие хаалгаа тас саваад гарч одов. Би Лизад дургүй хүрч, энэ талаараа Бурханд гомдоллов. Би Лизагийн дутагдал, богино ухаанд үнэхээр гашуудав. Бурхан намайг эр нөхрөө дэмждэггүй, аймшигтай шүүмжлэгч эхнэрээр залхаан цээрлүүлж байгаа юм шиг л санагдав. Би цаашид яаж ийм байдлаар амьдарна аа” гэж ч бодогдов.

Гэтэл Бурхан хэрхэн хариулсаныг би хэзээ ч мартахгүй. Ариун Сүнс намайг хичнээн их өрөвдөж байгаагаа, миний зовлонг ойлгож байгаагаа хэлсэнгүй, харин “Хүү минь, чи Лизагийн нэг сайн талыг санаад, үүнийх нь төлөө Надад таларх” гэж шивэглэв.

Би хариулж чадахгүй нилээд удсанаа: “Лиза сайн ээж” гэж бувтнав. Миний амнаас тэр үг гарахтай хамт сэтгэлд минь амь бургилж эхлэхийг мэдэрлээ. Бурхан намайг үргэлжлүүл гэв. Би “Эзэн минь, Лиза маш сайхан хоол хийдэгт баярлалаа” гэж хэллээ. “Бас Лиза маш үзэсгэлэнтэй.” Амнаас минь үг ундарсаар, би Лизагийн сайн талыг пулемёт шиг л дуржигнуулж гарав.

Тэр үед би Лизад дургүй хүрэхээ больсон байлаа. Тэр үед би өөртөө дургүй хүрч байлаа. Дүүрчихсэн толгой! Ийм сайхан гэргийтэй байж, адгийн амьтан шиг л авирлах юм. Яачихсан амьтан бэ? Би түүндээ ямар муухай хандаж байснаа ухаараад сэтгэл өвдөв. Би түүнийг сонгож суусан, тэр миний үр хүүхдийн ээж, Бурханаас өгөгдсөн төгс бэлэг боловч, би түүнийг дуудлагынхаа саад шиг л санаж байлаа.

Намайг гэрээсээ харайж гарах үед Лиза миний хоолойд тулсан, би Лизагийн хоолойд тулсан байсан ч, харин одоо би гэртээ харайж очоод, түүндээ хичнээн талархаж байгаагаа хэлмээр байв. Би гэр рүүгээ яарахдаа: Лиза намайг таагүй хүлээж авсан ч, би түүний төлөө хичнээн их талархаж байгаагаа хэлэх ёстой гэж бодож явсан юм.

Би гэртээ ирээд, Лизаг харуутаа: “Лиза, намайг уучлаарай! Би ёстой дүүрчихсэн амьтан. Намайг өршөө. Чи бол гайхамшигтай ээж, мундаг эхнэр. Чи миний зүрхний хүслэн” хэмээн дуу алдав. Тэгээд Бурхан надад юу сануулсан, дараа нь түүний гайхамшигтай зан чанар, давуу тал бэлгийг магтан, яг л ургал ус шиг дуржигнуулав.

Намайг ярих хооронд Лиза зөөлөрч, уйлж эхлэв. Гэтэл тэрбээр намайг байхгүй байхад “Бурхан минь, хэрэв та Жоныг буцааж авчраад, тэр надад уучлаарай гэж хэлбэл, би түүнд зүрхээ дахин нээнэ” хэмээн залбирсан юмсанж.

Хэрүүл: Лизагийн түүх

Тэр арван найман сарын турш байдал дэндүү хэцүү байсан болохоор би сүйн бөгжөө хүртэл зүүхээ больсон юм. Би Жонд “Бид гэрлэсэн боловч, сүй тавиагүй” гэж хэлдэг байлаа. Би Жонд хайргүй болсон гэдэгтээ итгэсэн юм. Үл уучлалаас болж зүрх минь хөлдөж, бидний харилцаа мөхлийн ирмэгт туллаа.

Тэр үед Жон дэндүү их аялдаг байсан учраас, сүүлдээ түүний эзгүй байх нь гэртээ байхаасаа илүү сайхан санагддаг болов. “Түүнийг явсан хойгуур амьдрал хавьгүй сайхан. Жон гэртээ ирэхээр л бөөн хэрүүл уруул - ёстой ядаргаатай” гэж бодогдоно.

Сүүлдээ бүр цөхөрч Эзэн рүү: “Бурхан минь, гүйцээ. Жон намайг хүн гэж тоодоггүй. Та ч түүний зан авирт сэтгэл дундуур байгаа биз!” гэж хашхирав.

Би энэ үгээ Бурханд өдөр бүр хэлж байлаа. Тэгээд намайг үгээ хэлж дууссан тэр нэг өдөр Бурхан надад: “Лиза, чи Надад “надад Та л байхад хангалттай” гэж хэлээч” гэх шиг болов.

Би эхлээд айлаа. Тэгээд Бурханаас: “Надад Та л байхад хангалттай гэдэг чинь Жон хэзээ ч өөрчлөгдөхгүй гэсэн үг үү?” гэж асуусан ч, араас нь “Аав аа, надад Та л байхад хангалттай” хэмээн цуурайтуулав.

Тэгсэнээ дараа нь “Тэгээд Жон яах болж байна?” гэлээ.

Гэтэл Бурхан дахиад л “Надад Та л байхад хангалттай гэж хэлээч!” гэлээ.

“Надад Та л байхад хангалттай.”

Энэ үг нь миний дахилт болов. Ямар нэг хэрүүл маргаан гарах тоолонд би “Есүс ээ, надад Та л байхад хангалттай” гэж хэлдэг болов. Цаг хугацааны явцад энэ илчлэл миний зүрхэнд үндэслэж, залбирал минь өөрчлөгдөж эхэлсэн юм. Эхэндээ цөхрөлөө барсан “Есүс ээ, надад Та л байхад хангалттай” гэдэг тунхаглал маань эцэстээ Бурхан доторх сэтгэл ханамж болж хувирав: “Есүс ээ, надад Та л байхад хангалттай!”

Төдөлгүй Бурхан Жон бид хоёрын хоёулангийнх нь зүрхэнд ажлаа хийв. Жон аялалаасаа гэртээ ирэхэд би түүнийг мишээсээр онгоцны буудлаас тосч авлаа (өмнө нь би Жоныг гэртээ битгий ирээсэй гэж боддог байхдаа, энэ даалгаврыг бусдаар хийлгэдэг

байлаа). Би нөхрөө тосохдоо баяртай байсан бөгөөд тэрбээр надад маш хөөрхөн бэлэг авчирсан байлаа.

Тэр эгшин бидний гэрлэлтэд цоо шинэ эхлэл тавьсан юм. Гэхдээ өөрчлөлт гарахаас өмнө Бурхан бид хоёрын зүрхийг талархлаар нээсэн байсан нь тун сонирхолтой юм шүү.

Гэрлэсэн хос бие биедээ адгийн муугаар хандсан байсан ч, Есүсийн уучлалын зүрх сэтгэлийг даган дуурайбал, бидний нэгдэл эрүүл саруул байх төдийгүй, бүр цэцэглэнэ. Тэр үед бидний үр хүүхэддээ үзүүлсэн хамгийн сайн үлгэр жишээ нь бид бие биедээ уучлаарай гэж хэлээд, бие биеэ уучилсан явдал байсныг бид бүр хожим мэдсэн юм. Үр хүүхэд маань ч биднийг төгс бус дэлхий дээр аж төрж буй төгс бус амьтад гэдгийг ойлгосон боловч, бидний зүрхэн дэхь Бурханы төгс уучлал нь ямар ч нүглийг хаацайлдаг. Бидний эв нэгдлийг нурааж, хоосролыг тарих зорилготой нүгэл нь үр хүүхдэд маань Бурханы хайр, нигүүлсэл, уучлалыг сургах хичээл болж дууссан юм. Тэгээд манай гэр бүлийг Сургаалт үгс 17:9-р ишлэлийн цэц ухааны үг дүүргэсэн юм.

Алдаа уучлагдахад хайр цэцэглэдэг.

Та гомдлоо хадгалахаар шийдбэл, бүгд ялагдана. Учир нь тэнд хайр үгүйрнэ. Харин хэрэв та уучлахаар шийдсэн бол, хайр цэцэглэх учраас танай гэр бүлийнхэн бүгд ялна.

Айдас

Шийдэх ёстой харилцааны өөр нэг асуудал нь айдас юм. Манай гэр бүлийн эхний арван жил, Лиза миний бие гологдож хаягдахаас айх айдастай байнга зөрчилдөж байлаа. Миний аав ч, миний пастор ч эхнэрээ залуу эмэгтэйгээр сольсон. Тэгээд харсан үзсэн зүйлээсээ болоод би айдсыг өөрөө ч мэдэлгүй, тархиндаа нэвтрүүлчихжээ. Тэр бодол хашхичилгүй, ямагт шивэгнэж ярина: “Эрчүүд эцэстээ бүгд л явдаг. Тэднийг өөртөө хэтэрхий бүү ойртуул. Тэгж байж л чи шархлахгүй.” Иймэрхүү бодлоос болоод би хайр сэтгэлийн жаахан ч илэрхийллийг эсэргүүцдэг байлаа. Тухайлбал Жон намайг тэврэх үед би түүний тэврээс год хийн сугарч оддог байлаа.

Нэг өдөр яг ийм явдал болоход, Жон надаас: “Би чамайг хаяхгүй гэдгийг чи хэзээ ухаарах вэ? Дал хүрч байж ойлгох уу?” хэмээн пал хийтэл асуув. Би зог туслаа.

Жон надад “Би чамайг ойлгох хүртэл чинь хүлээнэ. Гэхдээ бид хоёр олон сайхан зүйлээ эдлэж чадахгүй, дэмий л өнгөрөөнө” гэж хэлэв.

Бусад эрчүүдэд итгэл алдарсаны маань төлөөсийг Жон төлж байгааг би ухаарлаа. Тэгээд бодлоо: “Яагаад бусдын алдааг Жон төлөх ёстой гэж? Энэ чинь шударга биш. Би өөрийгөө хамгаалах гэж харилцаагаа хөнөөж байна.” Ирээдүйд Жоныг алдах айдас маань биднээс одоогийн сайн сайхныг маань хулгайлж байлаа. Тэгээд Жоныг хагас дутуу хайрлаад, өнгөрсөн хойноо харамсаж байснаас, алдсан ч хамаагүй, бүрэн дүүрэн хайрлахаар шийдсэн юм.

Айдас болон үл итгэл нь гэрлэлтийн амьдралыг цэцэглүүлдэггүй. Учир нь айдас нь ирээдүйд болох сайн сайхан зүйлд итгэлгүй, зөвхөн өнгөрснөөс зуурдаг. Бурханаас гэрлэлтдээ ямар нэгэн сайн сайхан зүйл хүсч байгаа бол, айдсаа хаяж, ирээдүйд болох зүйлсийг зөгнөдөг хайрыг хүлээж авах хэрэгтэй. Айдас бүтэлгүйтлийг хүлээдэг бол, хайр хэзээ ч бүтэлгүйтдэггүй.

Айдас нь бидний амьдралд хандсан Бурханы хайр, хамгаалалтаас тэс өөр сүнслэг хүч юм. Энэ нь хайрын эсрэг зүйл. Учир нь хайр ба айдсын аль аль нь хараагүй зүйлдээ итгэх итгэлээр ажилладаг. Хайр биднийг харсан зүйлдээ эргэлзэж, хараагүй зүйлдээ итгэхийг уриалдаг бол, айдас нь биднийг харагдаж буй зүйлдээ итгэж, хараагүй зүйлдээ эргэлзэхийг уриалдаг. Бүтэлгүйтлээс айх айдастай юмуу хайранд найдах найдвартай нүүр тулах үед бид аль нэгд нь итгэх сонголт хийж болохоос биш, хоёуланг нь сонгож чадахгүй. Айдас хайрыг хөөдөг, хайр айдсыг хөөдөг.

Хайрын дотор айдас байдаггүй. Харин төгс хайр нь айдсыг хөөн зайлуулна. Учир нь айдаст ял байдаг. Айдаг нэгэн бол хайрын дотор төгс болгогдоогүй байна. Эхлээд Тэр биднийг хайрласан тул бид хайрладаг юм. (1Иохан 4:18-19)

Хайрын өөрчлөх чадвар нь айдсын урхихаа чадвараас хавьгүй аугаа. Айдсыг хөөдөг төгс хайрыг гагцхүү Бурханы хайрын туршлагаас л олж авна. Бурханы хайрын хүчээр бид өөрийгөө

бодох бодлоо орхиж чадна. Учир нь бидний хэрэгцээг Бурхан итгэмжтэйгээр харгалзана гэдгийг бид мэднэ. Гэхдээ хэрэв бид Бурханы оршихуйд цаг өнгөрөөхгүй бол, Түүний хайрын мөн чанарыг дотно таньж мэдэж чадахгүй. Учир нь Түүний итгэмжтэй байдал Түүний оршихуй дотор л харагддаг.

Бурханы жинхэнэ мөн чанарыг мэдэхгүй хүн насан турш, Бурханд юмуу ханьдаа хаягдахаас айж амьдардаг. Энэ нь нэгэн төрлийн шийтгэл юм. Бурханы хайранд бат итгэдэг хүн айдсаас чөлөөтэй байж, амиа бодоогүй хайраараа ханиа хайрладаг.

Хайртууд минь, бие биеэ хайрлацгаая. Учир нь хайр бол Бурханаас ирдэг. Хайрладаг хүн бүр Бурханаас төрсөн бөгөөд Бурханыг мэддэг юм. Хайрладаггүй нэгэн нь Бурханыг мэддэггүй. Учир нь Бурхан бол хайр билээ. (1Июхан 4:7-8)

Айдсын цайз биднийг: “Нөхөр маань миний араар тавьбал, би түүнийг хэзээ ч уучлахгүй” гэх мэтийн үг унагахад хүргэдэг юм. Ирээдүйд өөрийгөө хамгаалах зорилгоор хэлсэн иймэрхүү үг нь өнөөдөр биднийг Бурханы хайранд эрх чөлөөтэй байхад саад болдог. Зүрхээ Бурханд даатгабал, хань ижил маань биднийг гомдоож, шархлуулж, урвасан ч, Бурхан бидэнд санаа тавина. Бурхан “Айдсаа Надад өг” гэдэг. Үүнээс татгалзах нь биднийг Бурханд итгэхгүй байгааг бас Тэр бидний амьдралыг чиглүүлнэ гэдэгт итгэхгүй байгааг л харуулна. Бурхан бидний амьдралыг чиглүүлэх чадвартай. Бид айдсаа Есүст өгөхгүйгээр Есүсийг Эзэнээ болгоно гэж байхгүй.

Дөрөвдүгээр өдөр

Гэр бүлийн хараал

Бид хоёр анх гэрлэхдээ, Бурхан бидний болон үр хүүхдийн маань дотор ямар нэгэн шинэ зүйл хийхийг хүсч байгааг мэдэж байлаа. Хоёр талын маань аав, ээж, эмээ өвөөгийн дунд архи, ёс бус

байдал, илбэ шид зэрэг олон үе дамнасан хүчтэй цайз хэрмүүд байлаа. Бид шинэ өвийг хүлээж авахаасаа өмнө манай гэр бүлийг олон үе дамнан нэрвэсэн, зүйл бүрийн хараалтай тулалдах ёстой байлаа. Иймэрхүү зүйлтэй гагцхүү залбиралаар болон Бурханы үгээр л тэмцэнэ.

Гэр бүлийн хараалын хувьд айл бүрт ялгаатай ч, бид энд нэг жишээ өгье. Бид хоёр тэнгэр газар шиг ялгаатай хоёр гэр бүлээс гаралтай болохоо өмнөх бүлэгт ярьсан. Лиза миний бие Жоны аав, ээж миний замаа алдсан гэр бүлийг яаж хүлээж авах бол хэмээн сэтгэл зовж байлаа. Бид хоёрын сүйн зоог дээр миний аав шал согтчихоод, ямар ч ичгүүр сонжуургүйгээр Жоны аавын нүүрэн дээр ээжийг нь эргүүлэв. Үнэндээ тэр Жоны ээжийг эргүүлэхээсээ илүүтэй ээжийн минь зүрхийг л эмтлэхийг хүсч байсан юм. Хадам ээж маань Жон бид хоёрыг тахилч удамтай тэдний ургийн модны салсан анхны гэр бүл болох нь хэмээн үнэн голоосоо зовж байлаа. Би түүнийг “Манай удамд салсан гэр бүл байхгүй” гэж хэлэхийг нь дуулсан юм.

Тэгээд би: “Намайг ингэж л харж байна. Би энэ удмыг бузарлах гэж үү?” гэж бодлоо.

Зоогийн дараа би ээжийнхээ шаналлыг бас өөрийнхөө ичгүүрийг мэдрэв. Хэрэв гэр бүлийн “сайн” “мууг” жинлэдэг жин гэж байсан бол, хамаг сайн нь Жоны талд, хамаг муу муухай нь манай талд дарах байлаа.

Гэхдээ Бурханд Жоны сайн сайхан, миний муу муухай ямар ч хамаагүй гэдгийг ойлгох үед би жинхэнээсээ чөлөөлөгдсөн юм. Бурхан ариун удмыг хүсдэг.

Сонс, охин оо, анхааран чагна.

Өөрийн ард түмэн хийгээд эцгийнхээ гэрийг март.

Тэгвэл Хаан чиний гоо үзэсгэлэнд сэтгэл татагдана.

Тэр чиний Эзэн учир Түүнд бөхийн мөргө.

Тирийн охин бэлэгтэй ирж,

Хүмүүсийн дундах баячууд чиний

хайр хишгийг гуйна.

Та нарын эцэг өвгөдийн байранд хөвгүүд тань байна.

Та тэднийг бүх дэлхийд хаад болгоно.

Би Таны нэрийг үеийн үед сануулна.
 Тиймээс ард түмэн Танд мөнхийн мөнхөд
 магтаалуудыг өргөнө.
 (Дуулал 45:10-12, 16-17)

Энд бүлэгт бид гол төлөв Есүсийн тухай болон Түүний сүйт бүсгүйн талаар ярих боловч, Бурхан энэ дүрслэлээр миний гэр бүлд хандсан амлалтыг зурагласан юм. Энэ амлалт нь миний гэр бүлийн тааруухан гарал угсаагаар хязгаарлагдашгүй амлалт байв. Би “Өө язгууртан охин минь” гэдэг үгийг уншихад энэ үг миний дотор амилаад л явчихав. Бурхан намайг Өөрийнхөө язгууртан охин гэжээ. Тэр эгшинд би Христ дотор хэн болсоноо мэдэж авсан юм. Би өнгөрсөнийхөө бат цайзыг нурааж, миний гэр бүлийн ирээдүйд хандсан шинэ найдварыг хүлээж авсан юм.

Миний үр хүүхэд миний аавтай (завхай, архичин, бүрэн завхарсан хүн) адилхан болохын оронд махан биеийнхээ аавтай (бурханлаг хүн) адилхан болоод зогсохгүй, хамгийн гол нь Эзэнтэйгээ адилхан болж өснө гэдгийг би ухаарсан юм. Тэгээд миний хөвгүүд Хамгийн дээд Нэгэний ханхөвгүүд болно гэдэг амлалт дээр би зогссон юм.

Бид гэр бүлийн хараалыг авч хэлэлцэж байхдаа, Бурханы Үг үнэн болохыг харсан юм. Тэрхүү залбирал болон тунхаглалын цагаар Бурханы байгуулсан амлалт дотор манай гэр бүл цэцэглэсэн билээ.

Гэр бүлийн хараалыг таслах залбирал

Галат 3:13 дээр: “Христ бидний төлөө хараал болсноороо биднийг Хуулийн хараалаас зольсон юм. Учир нь “Модон дээр өлгөгдөгч хүн бүр хараагдсан юм” гэж бичигдсэн байдаг. Танай гэр бүлд хэдэн үе дамжсан ямар хараал байсан ч, Христийн дотор та хараалын хоригдол биш юм” гэжээ.

Гэр бүлдээ байгаа хараалыг мэдэж байгаа бол, бид таныг өвийг чинь хязгаарлаж, хумиж байсан юмсыг хуга цохих байр сууринд гаргая. Энэ залбирал нь танд Сатаны цайзыг Бурханы Үгийн илдээр тас цавчихыг зааж өгнө. Гэр бүлийн хараалаас чөлөөлөгдөх чөлөөлөлт нь хар аяндаа болчихдог зүйл биш

юм. Та Сатаны схемийг тодорхойлж, тийшээ онилох хэрэгтэй. Сатан таныг Бурханы танд хүссэн баяр хөөр, амар тайван, ололт амжилтаас хорьдог. Гэхдээ дайсан яаж арчигдахыг та Христ доторх эрх мэдлээрээ харж болно.

Залбирлаа эхлүүлэхээсээ өмнө түр завсарлаад, цагаа товлло. Хэрэв та яг одоо залбирах гэж байгаа бол, ганцаараа юмуу эсвэл зөвхөн хань ижилтэйгээ эсвэл дотно нөхөр юмуу залбирлын найзтайгаа байх хэрэгтэй. Та залбирлаа чангаар дуудаж хэлэх хэрэгтэй учраас энэ нь амин цаг юм.

Бид яг манай удам, гэр бүл, гэрлэлтэд байсан хараалыг доор бичлээ. Бид энэ залбирлыг өөрсдөө нэгтгэж гаргасан юм. Учир нь Бурханы Үг нь Сүнсний ар, өвөртөө иртэй, хүчирхэг, хурц Сэлэм билээ. Хэрэв танай гэр бүлд доорх залбиралд дурьдагдаагүй асуудал байгаа бол, тухайн асуудлын чинь талаар хэлсэн бичээсийг олоод, асуудлаа Бурханы үнэн ба амлалтаар онил. Бурханы Үгтэй зөвшилцсөн хүчирхэг тунхаглал бүтээгээд, амьдралдаа буй бүх хараалыг Есүсийн нэрийн хүчээр тасла. Энэ талаар дэлгэрэнгүй мэдэхэд чинь тус болох ишлэлийг залбирлын төгсгөлд бас бичлээ.

Тэнгэрлэг Аав минь ээ,

Би Таны өмнө Таны Хүү Есүс Христийн эрхэм нэрээр ирж байна. Би талархлаар Таны үүдэн хаалгаар орж, магтаалаар Таны талбайд орж байна. Намайг нигүүлсэж, хайрлаж, аварсанд баярлалаа.

Одоо би Израилийн Бурхан ЭЗЭНтэй гэрээ байгуулах гэж байна. Та бол ЭЗЭН, тэнгэр газрын аугаа гайхамшигт Бурхан бөгөөд Өөрийг нь хайрлаж, тушаалыг нь дагадаг хүмүүстэй байгуулсан хайрын гэрээгээ сахидог Бурхан. Зарцынхаа залбирлыг сонсооч. Би Таны эсрэг үйлдсэн өөрийнхөө болоод эцэг өвгийнхөө хамаг л нүгэл зөрчлийг мэдэгдэн улайж байна. Бид Таны өмнө ёрын муухай юмс үйлдсэн тул Та биднийг өршөөх болтугай. Бид ичгүүрээр хучигдсан. Учир нь бид Таны эсрэг нүгэл үйлдсэн. Гэхдээ хэдийгээр бид Таны өөдөөс тэрсэлж, Бурхан ЭЗЭНээ

дагаагүй, зарц нараараа дамжуулан бидэнд өгсөн хуулийг сахиагүй ч, бидний Бурхан Эзэн Та бидэнд өршөөнгүй хандаж, уучилсан билээ. Зүрхэнд минь хөвч хөндөж, өнгөрсөний минь нүгэл, ичгүүр, бузрыг зайлуулаач.

Би аливаа нэгэн нууц шүтлэг, ид шид, илбэ увидаст оролцсон эцэг өвгийнхөө болон өөрийнхөө оролцоог мэдэгдэж, хүчингүй болгож байна. (Энд түр зогсоод, Ариун Сүнсний нэмж сануулах бүх зүйлийг нэг бүрчлэн анхааралтай тоочоорой. Магадгүй астрологи, янз бүрийн сеанс, аймшигийн кино, тоглоом, ном гэх мэт зүйл орж болно). Би эдгээр зүйлст оролцооноо хүчингүй болгож, өөрийнхөө амьдралаас, үр хүүхдийнхээ амьдралаас, тэдний үр хүүхдийн амьдралаас болон тэдний үр хүүхдийн амьдралаас бүх хараалыг таслан, хүчингүй болгож байна.

Би өөрийнхөө болон эцэг өвгийнхөө хар тамхи, архины донтолтын нүглийг таслан, хүчингүй болгож байна. Аав аа, эдгээрийн урхагаар сүнслэг талбарт нүгэл, хүлээс, дарамтад нээгдсэн бүх хаалгыг хаагаач. Би хар тамхины бүх хэрэглээгээ (хэрэгтэй бол хар тамхины төрлөө нэг бүрчлэн нэрлэ) мэдэгдэж, өөрийнхөө амьдралаас, үр хүүхдийнхээ амьдралаас, тэдний үр хүүхдийн амьдралаас болон тэдний үр хүүхдийн амьдралаас бүх хараалыг таслан, хүчингүй болгож байна. Есүсийн нэрээр. Амень.

Дараагийн бүлэгт бид яг энэ зарчмаар сексийн хараалыг таслана. Загалмай дээр байгуулсан Есүсийн ялалтын ачаар та одоо эдгээр хараалаас эрх чөлөөтэй болсон. Тиймээс эдгээр нь таныг болон үр хүүхдийг чинь дагана гэхээс айж, санаа зовох хэрэггүй. Та сая гэр бүлдээ шинэ өвийг байгууллаа.

Энэ талаар дараах ишлэлээс дэлгэрэнгүй судлаарай. Дуулал 100:4, Шастирын дэд 29:10-11, Нехемиа 1:5-7, Даниел 9:8-10; Иошуа 5:9; Еврей 4:12; Шастирын дэд 29:5-6

Дураараа хадам

Хадмын асуудал нь гол төлөв залуу хосын асуудал байдаг ч, үүнээс ч олон жил үргэлжилж болно. Гэр бүлийн дунд хэрүүл маргаан дэгдэхэд хүн төрсөн гэр бүлээ өмөөрөх нь ойлгомжтой. Бид бүгдээрээ аав, ээжийгээ хүндэтгэх ёстой. Аав, ээжийнхээ зөвлөгөөг сонсох нь сайн боловч, гэр бүл зохиож, тусдаа гарсан хүн нөхөр юмуу эхнэрээ л нэн тэргүүнд тавих ёстой.

Жон миний бие ууган хүү Аддисоноо гэрлэхэд нь: “Аддисон, одооноос эхлэн чи өөрөө л надаас зөвлөгөө авъя гэхгүй бол, би чамд ингэ тэг гэж хэлэхгүй шүү. Аав нь цаашид амьдралд чинь хошуу дүрэхгүй. Чи өөрийнхөө гал голомтыг бадраах учраас би чамд сурч, хөгжих орон зай өгмөөр байна” гэж хэлсэн юм. Үүний минь төлөө Аддисон надад талархаад, хэрэгтэй үед заавал зөвлөгөө авна гэж хариулж билээ.

Би хүүгээ өөрийнхөө бяцхан хувилбар болгож хэвлэхийг бас хянахыг хүсэхгүй. Бурхан миний хүүг хүссэн хүнээ болгог. Хэрэв би түүний гэр бүлийн амьдралд хошуу дүрээд байвал, түүнийг гэрийнхээ удирдагчийн үүргээ алдахад хүргэж ч мэдэх. (Гэхдээ түүний гэр бүлээ авч явж буй нь намайг гайхшруулдаг юм. Би түүний насан дээр ингэж чадаагүй!)

Бичээс маш тодорхой хэлсэн:

Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлэн, тэр хоёр нэгэн бие болох ажгуу. Хүн ба түүний эхнэр хоёулаа нүцгэн байсан бөгөөд тэд огт ичсэнгүй. (Эхлэл 2:24)

Аав ээжээ орхино гэдэг нь аав, ээжийнхээ гэр бүлийн эрх мэдлийг орхино гэсэн үг. Энэ нь мөн танд нөлөөлж байсан аав, ээжийнхээ аливаа нэг эрүүл бус нөлөөг орхино гэсэн үг. Аав, ээжээ хүндэтгэх нь чухал ч, та тэдний үг бүрийг дагалгүйгээр хүндэтгэж болно. Та өөрийнхөө гэрийн шинэ эзэн болсон. Аав, ээж чинь цаашид эрх мэдэлтэн байхаа больсон учраас, тэд таны амьдралыг чиглүүлэх ёсгүй.

Хадам чинь та хоёрын амьдралд хошуу дүрээд байна уу? Өмнө нь бид хоёрын нэг хамаатан биднийг дарамталж, хагаралдуулахаар оролдсон юм. Бид хоёр хүлцэнгүй хандаж байсан ч, түүний энэ байдал хэрээс хэтрэв. Эцэстээ бид хоёр тэр хамаатантайгаа (мэдээж бид хоёр түүнд маш их хайртай бөгөөд хүндэтгэдэг) нүүр тулан уулзаад, санал бодлоо шууд хэлсэн юм.

Жон миний бие “Та миний гэрийн хэрэгт оролцохгүй, миний гэрийг удирдахгүй. Энэ бол миний шинэ гэр. Бид таныг хүндэтгэдэг ч, та энэ гэрийн асуудлыг шийдэхгүй. Та өөрийнхөө дураар хийхгүй” гээд л хэлээд гавьчихав. Эвээр ярих гээд болоогүй учраас, бид түүнтэй хатуу үгээр шууд ярилцах хэрэгтэй байлаа. Зол болоход тэрбээр бүхнийг ойлгож, өдгөө бидний харилцаа зүй зохистой байрандаа орсон юм.

Хосынхоо хувьд бид эв нэгдлээ алив төрлийн дайралтаас - тэр дундаа гэр бүлийнхээ гишүүдээс хамгаалах ёстой. Эдгээр дайралт нь голдуу гэмгүй дүртэй ч, хорон үртэй байдаг.

Би хүмүүсийн гэр бүлийг батлахдаа, хоёр талынх нь ар гэрийнхэн рүү харж байгаад: “Энэ нэгдлийн эсрэг ярьсан хэн ч болов золгүй еэ. Энэ бол Бурханаас тогтоогдсон нэгдэл. Тиймээс аливаа дарамт хэрэглэж, салгах гээд оролдоод үзээрэй. Бурханы өнөөдөр бий болгосон зүйлийн дээр зөвхөн амийг л тунхагла” гэж хэлдэг юм.

Аддисоныг гэрлэх үед бид түүнийг эхнэрийгээ эсвэл аав, ээжийгээ сонгох нөхцөлд оруулахгүй гэж шийдсэн юм. Үнэндээ тэрбээр гэрлэсэн өдрөө сонголтоо хийсэн бөгөөд бид ч түүний сонголтод баяссан билээ. Хайр хүнийг хэзээ ч сонголт хийхэд хүргэдэггүй. Хайр нь хуучин ба шинийн хооронд гүүр барьж, дэмжиж тэтгэдэг. Бид Аддисоны гэргий Жюлид хайртай. Тэр бэр маань биш, охин шиг маань л санагддаг. Бид түүний шинэ гэр бүлийг хүндэтгэж, Аддисон тэр хоёрт өөрсдийнхөө түүхийг бичихийг зөвшөөрсөн учраас л энэ ойр дотно харилцаа тогтсон билээ.

Бодитой бус хүсэн хүлээлт

Бодитой бус хүсэн хүлээлт нь Америкийн гэр бүл салалтын тэргүүн шалтгаан болжээ. Олон хүн гэрлэлтээс дуусашгүй аз жаргал, тасралтгүй секс, амархан харилцаа хүсдэг. Гэтэл биднийг

хүссэн хүсээгүй - гэрлэлт бидний болоод хань ижлийн маань амиа хичээсэн, сул дорой чанарыг маш итгэмжтэй илчилдэг. Бидний буруу ташаа хүсэн хүлээлт нь хорсол, сэтгэл дундуур байдлын эх үүсвэр болж, үүнээсээ болж бид бурханлаг нэгдлийг байгуулж чаддаггүй.

Бодитой бус хүсэн хүлээлт нь голдуу ухаалаг бус харьцуулалтаас болдог. Бид зугаа цэнгэл төвтэй соёлд аж төрж байна. Тиймээс бид байнга л гэрлэлтээ дэлгэцэн дээрх гэрлэлттэй жишдэг. Зурагт, кино нь бидэнд хүчин зүтгэлгүй хайр, золиосгүй гоо үзэсгэлэн, эрсдэлгүй итгэлцлийг дүрсэлдэг.

Хэрэв та гэрлээд удаж байгаа бол, гэрлэлт нь романтик болзоо, үүрэг хариуцлагаас чөлөөтэй өдрүүдээс хавьгүй том агуулгатай зүйл гэдгийг мэдэж байгаа. Гэрлэлт нь хэцүү ажил бөгөөд ихэвчлэн ямар ч эмх замбараагүй байдаг.

Гэрлэлт нь хүнд ажил боловч, энэ нь та гэрлэх шаардлагагүй гэсэн үг биш юм. Гэрлэлтийн асуудал нь таныг сунгаж тэлдэг учраас сайн юм. Тэдгээр нь таны зан чанарыг хатааж, хүчин чадлыг тань өсгөдөг. Гэрлэлтийн харилцааны зорилго нь өсөлт тэлэлт гэдгийг мартаагүй биз дээ? Хүн ер нь өсөлт төлөвшил шаардсан асуудалтай нүүр тулахаасаа өмнө өсөлт төлөвшил гэдэг санаанд дуртай байдаг.

Бодитой бус хүсэн хүлээлт гэдэг нь зөвхөн гэрлэлтийн талаарх хэвлэл мэдээллийн дүрслэлийг хэлээгүй юм. Бид заримдаа гэрлэлтээ хөршийнхөө эсвэл найзынхаа гэрлэлттэй жишдэг. Энэ нь маш буруу юм. Тэдний харилцааны хөшигний цаана юу болж байгааг бид мэдэхгүй. Бүх зүйл нь сайн сайхан, тансаг харагдаж болох ч, хаалганы цаана тэд бие биеэ алж байж ч болох шүү дээ.

Түүнчлэн харилцааныхаа улирлыг өөр хооронд нь жиших нь шударга биш юм. Магадгүй бид одоогийнхоо нялх хүүхэдтэй, живхтэй, чөлөө завгүй улирлыг хүүхэдгүй байсан үетэйгээ жишиж байж болох. Гэтэл энэ нь логикийн хувьд ямар ч утгагүй зүйл юм. Хүүхэдтэй хүний амьдрал хэзээ ч хүүхэдгүй хүнийх шиг байж чадахгүй. Хүүхдийг хүн болгох нь маш бага эрх чөлөө, маш их үүрэг хариуцлага шаардана. Хүүхэдтэй болох нь хүний амьдралыг өөрчилдөг учраас гэрлэлт чинь тэс өөр харагдах нь аргагүй. Тиймээс тэнэг харьцуулалт хийж, одоогийнхоо аз жаргал, баяр хөөрийг бүү үгүй хий.

Теодор Рүзвельт “Харьцуулалт нь баяр хөөрийн хулгайч” гэж хэлжээ. Гэр бүлээ аз жаргалтай байлгая гэж л байгаа бол, нүдэнд сайхан харагдсан болгонтойгоо жишихээ боль. Та харьцуулалтаас хэзээ ч баяр хөөр олохгүй. Баяр хөөр нь өрөвдөлтэй биш учраас баяр хөөрийг өрөвдөлтэй байдлаар олохгүй. Баяр хөөрийн хүч нь танд хандсан Бурханы төлөвлөгөөг бүрэн эхээр нь ухаарах ухааралд оршдог учраас мэдрэмжид баригдалгүй, нөхцөл байдлыг сэтлэн гардаг юм.

Баяр хөөр нь нөхцөл байдлаас биш, Бурханаас хүлээж авсан, Сүнсний үр жимс юм (Галат 5:22-23). Үүнийг хүний хүслээр дамжуулж болохгүй. Аз жаргал нь түрхэн зуурын зөрчлөөр сарнидаг мэдрэмж бол, баяр хөөр нь ямар ч бэрхшээлийг сэтлэдэг. Энэ нь бидний Христ доторх байр сууриас хүлээж авсан найдвараас ундардаг юм. Хэрэв бид Бурханд баярлахгүй байвал, гэрлэлтээ сайн сайхан байлгах хүчээр дутна. Учир нь Эзэний баяр хөөр нь бидний хүч чадал юм (Нехемия 8:10). Паул үүнийг Филиппой чуулганд хэлжээ:

Эзэний дотор үргэлж баярла. Би дахин хэлнэ. Баярлагтун! Та нарын тэвчээр бүх хүмүүст мэдэгдэг. Эзэн ойрхон байна. Юунд ч бүү санаа зов. Харин аливаа зүйлд залбирлаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл. Бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван нь Христ Есүс дотор та нарын зүрх сэтгэл, санаа бодлыг хамгаална. (Филиппой 4:4-7)

Хэрэв та харилцаандаа итгэлгүй байвал, асуудлаа Бурханы өмнө талархалтайгаар авчир. Бурхан таны зовнилыг баяр хөөртэй талархлаар солино гэж амласан. Энэ бол сайн солилцоо!

Бодитой бус хүсэн хүлээлт нь таны баяр хөөрийг хулгайлж, тийнхүү таны гэрлэлтийн хүчийг сордог. Энэ хавханд бүү ор. Харилцааг чинь цайзаар хүрээлсэн алив хүсэн хүлээлтийг тодорхойлоод, үүнийг Бурханы Үгийн үнэн, таны амьдралд хандсан онцгой төлөвлөгөөнөөс дээгүүр залсандаа Бурханы өмнө гэмш.

Таны ЭЭЛЖ

Энэ бүлэгт гарсан зүйлийн талаар хань ижилтэйгээ ярилцах цаг гарга. Гэрлэлтийн амьдралдаа цэвэрлэх шаардлагатай зүйлсийг бичихдээ, Ариун Сүнснээс удирдамж ав. Заримдаа аль нэг зан чанар, хандлагаа зайлшгүй өөрчлөх хэрэгтэй болдог бөгөөд эдгээрийг Бурханы нигүүлслээр хийх боломжтой. Удам дамжсан хараал зэргийг залбирлаар шийдэх ёстой.

Жагсаалт чинь хэдэн хуудас болсон ч, бүү ай. Энэ нь таны амьдралд яг одоо хичнээн “буруу” байгааг эсвэл аль тал нь хамгийн их асуудалтай байгааг оношлох дасгал биш юм. Үүнийг таны ирээдүйд авчирч болох аугаа зүйлсийн төлөө хийж байна. Эдгээр асуудлыг одоо шийдсэнээрээ, та гэр бүлээ гайхамшигтай түүхийг - газар дээр илчлэгдсэн тэнгэрийн өвийг бичих байр сууринд аваачина. Тавцангаа одоо цэвэрлэ. Учир нь тэгж байж л Бурханы танд өгөхийг хүссэн бүхнийг саадгүй хүлээн авна. Харин одоо танд тусгайлан гаргаж өгсөн залбирлыг хэлнэ үү:

Аав аа, Та бидэнд цоо шинэ эхлэл, шинэ өв өгсөнд баярлалаа. Харилцаанаасаа цэвэрлэж хаях ёстой зүйлсийг бичиж байхдаа тэнгэрийн уур амьсгал биднийг хүрээлэхийн төлөө залбирч байна.

Ариун Сүнс минь, биднийг удирдаж, зааварлаач.

Бурханы тэнгэрэлч нар биднийг хүрээлэн суурьшиж, гэр бүлийг маань хэдэн үе дамнан гамшигаар нэрвэсэн дайсны дээр шүүлт гүйцэтгэх болтугай.

Бид уучилж, өөрчлөгдөх хүчний төлөө нигүүлсийг тань гуйж байна.

Бид Таны Үгийн дагуу оюун санаагаа шинэчлэхийн төлөө залбирч байна.

Би Таны хайр илчлэгдэж, бүх айдсыг үлдэн хөөхийн төлөө залбирч байна.

Бид итгэлцэл сэргээж, харилцаа шинэчлэгдэхийн төлөө залбирч байна.

Салан тусгаарлал байсан газар Бурхан Та нэгдэл авчрахын төлөө залбирч байна.

Бурханлаг бус хүсэн хүлээлтийн дагуу биш, харин Таны амлалтын дагуу мөрөөдөхөд маань сэргээгээч.

Бид гэр бүлийнхээ дээр эрх чөлөөг тунхаглаж байна. Бид Есүс Христийн нэрээр гэрлэлтийнхээ дээр, бие биеийнхээ дээр эрх чөлөөг тунхаглаж байна. Бурханы хаанчлал бидэн дээр ирэхийн төлөө бид залбирч байна. Бурханы хүсэл тэнгэрт шигээ бидний гэрлэлт, гэр бүлд, газар дээр, биелэхийг тунхаглаж байна. Есүсийн хүчирхэг нэрээр. Амень.

Нэгдүгээр өдрийн судлал

ГЭР БҮЛИЙН ШАЛГАН

*Та нар итгэл дотор байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө батал.
Эсвэл Есүс Христ та нарын дотор байгааг та нар өөрсдөө
мэддэггүй юм уу? Та нар үнэхээр шалгалтандаа
унадаггүй л юм бол...*

- 2Коринт 13:5

Урагш явахын тулд яаж энэ байр сууринд хүрсэнээ эргэн нэг харах хэрэгтэй. Ингэж байж л та гэр бүлийнхээ тавцангаас цэвэрлэж хаях ёстой зүйлсийг олж харна. Түр зогсоод, эргэцүүлээд, чин үнэнээр хариулаарай.

Хүүхэд ахуй наснаасаа эхлэж бод. Тэр үеийн гэр бүлийнхээ ерөнхий уур амьсгалыг та яаж дүрслэх вэ?

Жишээлбэл: амар тайван, тайван бус, хайраар дүүрэн, хайр байхгүй, нээлтэй, хаалттай, өгөөмөр, харамч, айдастай, гайхамшигтай, халуун дулаан, уриалгахан эсвэл хөндий хүйтэн.

Аав, ээжийнхээ харилцааг ерөнхийд нь дүрслэнэ үү (харилцаа, бие биедээ хайр энхрийллээ үзүүлэх, нөхөрлөл гэх мэт).

Аав, ээж тань үл зөвшилцил, маргааныг яаж шийддэг байсан бэ?
Бие биедээ хэрхэн ханддаг байсан бэ?

Таныг овлигогүй авирлах үед хэрхэн засч залруулдаг байсан бэ?
Засварын дараа ч таны алдааг ахин дахин чичлэдэг байсан уу
эсвэл бүрэн уучилж, хайрладаг байсан уу?

Дараах өгүүлбэрийг гүйцээнэ үү:

“Би өсч бойжиж байхдаа гэр бүлдээ хамгийн дуртай байсан зүйл нь...”

“Би өсч бойжиж байхдаа гэр бүлдээ хамгийн дургүй байсан зүйл нь...”

Асуултаа эргэцүүлэн хянаад, одоогийнхоо гэрлэлт, гэр бүлийнхээ амьдралтай харьцуулна уу. Одоогийн гэр бүлийн чинь уур амьсгал, хань ижилтэйгээ тогтоох харилцаа, хэрүүл маргаанаа шийдэх арга барил, үр хүүхдээ хүмүүжүүлэх арга байдалд чинь аав, ээжийн чинь гэр бүлтэй адил төстэй зүйл байна уу?

Энэ санаачилга дээр үндэслэн, та болон таны хань ижил гэрлэлтийнхээ тавцангаас юу юуг цэвэрлэж хаях хэрэгтэй байна?

Хариултаа хань ижилтэйгээ ярилцаад, Ариун Сүнсээр юу юугаа өөрчлүүлэх хэрэгтэй буйг залбиран асуу.

Хоёрдугаар өдрийн судлал

ОРОН ЗАЙ ӨГӨХ

Ингэхдээ нэг нэгнээ хүлцэж, бие биеэ уучилж, хэрэв хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал та нарыг Эзэн уучилсны адил та нар бас уучил.

- Колоссай 3:13

Та ханьдаа орон зай өгдөг үү? Би алдаа гаргах орон зай - Бурханы нигүүлслээр Түүний дүр төрхтэй адилхан болж өсөх орон зайн талаар ярьж байна. Бид бүгдээрээ алдаатай учраас бүгдэд маань орон зай хэрэгтэй. Бид уучлах үедээ тэнгэрлэг аавыгаа дуурайж, хань ижилдээ өөрчлөгдөх хүчийг өгдөг Бурханы нигүүлслийн суваг болно. **Си. Эс. Льюис** ийнхүү бичжээ:

“Христэд итгэгч байна гэдэг нь уучлах боломжгүйг уучлахыг хэлнэ. Учир нь таны уучлагдашгүй нүглийг Бурхан уучилсан юм. Энэ амархан биш. Магадгүй ганцын зэргийн шархыг уучилж болох ч, өдөр бүр тасралтгүй ирэх өдөөн хатгалгыг - дээрэнгүй хадмаа, дарангуй нөхрөө, яншаа эхнэрээ, амиа бодсон охиноо, зальжин хүүгээ яаж уучилсаар байх вэ? Миний бодлоор шөнө бүр “Бусдыг уучилсаны адил биднийг бас уучлаач” хэмээн залбирах бүртгээ бид хаана зогсож байгаагаа санаснаараа л хийж чадах байх. Ингэхээс татгалзах нь Бурханы нигүүлслийг хүлээж авахаас татгалзаж буй явдал юм. Үүнийг эс дагах шалтаг байхгүй бөгөөд Бурхан юу хэлж буйгаа мэднэ.”

Та ямар талбар дээр хань ижилдээ орон зай олгох ёстой вэ? Та өөрөө ямар талбар дээр алдаж, бурханлаг зан чанараар өсөх орон зай хүсч байна? Сайн мэддэг бөгөөд засахын төлөө ажиллаж байгаа гурван талбараа нэрлэнэ үү.

Хань ижилдээ орон зай олгох ёстой гурван талбарыг нэрлэнэ үү. Та орон зайг нь олгож байна уу? Үгүй бол яагаад?

Хань ижилдээ гомдол тээсээр байвал, юу болно гэж Бурхан хэлсэн бэ? Матай 6:14-15; 18:21-35; Марк 11:25-г уншаад, Ариун Сүнсний илчилсэн зүйлийг бичнэ үү.

Бурханы уучлал хязгааргүй! Та хань ижлээ уучлах гэж зүдэрч байгаа бол, өөрийнхөө амьдралыг эргэцүүлэн бодох цаг гарга. Та Эзэнийг бодол, үг, үйлдлээрээ хэрхэн гомдоосон бэ? Өөрийнхөө аймшигтай нүглийг, үүнийг чинь төлөхийн төлөө Есүсийн хүлцсэн тамлалыг санах үед чинь Ариун Сүнс таны зүрхийг зөөллөж, бусдыг уучлах нигүүлсэл өгнө.

ГЭМШИЛ БА ЧӨЛӨӨЛӨЛТИЙН ЗАЛБИРАЛ

“Эзэн минь, хань ижлээ уучлаагүйг минь өршөөгөөрэй. Би цаашид түүний нүглийг тэмдэглэхийг хүсэхгүй байна. Та миний нүглийг хэзээ ч санахгүйгээр өршөөсөн. Надад ч бас ингэх хүчийг хайрлаач. Би ханиа Таны мутарт даатгаж байна. Бидний зүрхэнд хайр, нигүүлслээ цутгаач. Надад түүнийг жинхэнээсээ уучилж, алдаж бас өсөх орон зай олгоход минь туслаач. Би түүнийг эрүүл мэнд, цэц ухаан, амар тайван, баяр хөөр, хайр, таалал, итгэлтэй байдал, Таны үгийн илчлэл, Тантай тогтоох гайхамшигтай, дотно харилцаагаар ерөөж байна. Бидний гэрлэлтийг эдгээсэнд баярлалаа. Есүсийн нэрээр. Амень.”

Бурханы оршихуйд байж, дараах ишлэлийг тунгаан бодохдоо таны дотор хайрын, өршөөлийн мөн чанараа суулгахыг Ариун Сүнсэнд зөвшөөрнө үү.

1Коринт 13; Ром 5:5; Ефес 3:16-19; 1Петр 3:8-9

Гуравдугаар өдрийн судлал

ЭНЭ НЬ ҮЗЭЛ БОДЛЫН Л АСУУДАЛ

Эцэст нь, ах дүү нар аа, юу нь үнэн, юу нь хүндэтгэлтэй, юу нь зөв, юу нь цэвэр ариун, юу нь сайхан, юу нь сайшаалтай байна, хэрэв аливаа сайн үйл байгаа бол, хэрэв магтууштай ямар нэгэн юм байгаа бол тэдгээр юмсыг бодож санацгаа.

- Филиппой 4:8

Хань ижлийнхээ талаар бодохдоо та яг юун дээр нь төвлөрдөг вэ? Цаг үргэлж түүний алдаа дутагдлыг хараад байвал, гэрлэлтийн чинь асуудал улам л томорно. Нөгөөтэйгүүр талархах талыг нь харбал, харилцаагаа цоо шинэ гэрлээр харна! Ер нь амьдрал тэр чигээрээ үзэл бодлын л асуудал байдаг. Гэрлэлт ч ялгаагүй.

Ханийгаа харж буй линз чинь таны харилцаанд шууд нөлөөлнө. Ер нь та ханьдаа яаж ханддаг вэ? Үзүүлдэг үг, үйлдэл, хандлагаа эргэцүүлэн бодно уу.

Таны хандлага байдлыг илчилж өгөхийг Бурханаас асуу. Филиппой 4:8-г анхааралтай тунгаан бод. Тэгээд ханийнхаа төлөө талархах тэргүүний арван зүйлийг жагсааж бич.

Эдгээрийг гуч хоногийн турш үргэлжлүүлэн тунгаан бодно уу. Ханийнхаа эдгээр чанарыг хичээл зүтгэл гарган байж илэрхийлээрэй. Хараагаа алдахаас болгоомжил. Энэ нь биднийг өөрийнхөө, ханийхаа эсвэл нөхцөл байдлын буруу дээр төвлөрүүлдэг. Айдас нь бодитой мэт харагддаг худал баталгаа юм. Та харилцааныхаа юун дээр хамгийн их айж байна? Эзэнээс залбиран асуу.

Айдсыг Филиппой 4:8-р ишлэлээр шүүн тунгаа. Айгаад байгаа зүйлс чинь сайн юм байна уу, муу юм байна уу? Цэвэр бөгөөд хайрламаар байна уу? Тэдгээрийг санахаараа Бурханыг магтмаар болж байна уу? Энэ шалгуураар даваагүй бүхэн нь гадагш хаягдаж, үнэнээр орлуулагдах ёстой.

Бидний одоогийн айдас нь өнгөрсөний гомдол, гутралаас эх үүсвэртэй байх нь элбэг байдаг. Тэгээд дахиад шархлахаасаа айсан хүн өөрөө ч мэдэлгүй, аав, ээжийнхээ, өмнөх найз залуу/бүсгүйнхээ дутагдлын төлөөсийг хань ижлээрээ төлүүлэх гээд байдаг.

Одоо түр зогсоод “Ариун Сүнс минь, энэ айдас хаанаас вэ? Юун дээр үндэслэсэн айдас вэ? Би Танд яаж илүү их итгэж, айдас миний амьдралаас үндсээрээ булгарахыг харах вэ? Чимээгүй хүлээгээд, сонс. Бурхан танд юу илчилж байна?

Дөрөвдүгээр өдрийн судлал

УДМЫН ХАРААЛААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

Христ бидний төлөө хараал болсноороо биднийг Хуулийн хараалаас зольсон юм. Учир нь “Модон дээр өлгөгдөгч хүн бүр хараагдсан юм” гэж бичигдсэн байдаг.

- Галат 3:13

Бурхан таны гэр бүлд цоо шинэ зүйл хийхийг хүсч байна! Тэрбээр “Үзэгтүн, Би шинэ зүйл хийнэ. Одоо тэр нь бий болно. Та нар үүнийг мэдээгүй гэж үү? Би хээр талд зам тавьж, цөлд гол урсгана” гэж байна. **Жойс Мэйер** ингэж хэлжээ:

“Есүс шоронгийн хаалгыг тайлж, хоригдлуудыг чөлөөлөхөөр ирсэн. ...Таны өнгөрсөн амьдрал аймшигтай, одоогийн амьдрал чинь дарамттай, сөрөг байж болно. Таны нөхцөл байдал ямар ч найдваргүй, муу байж болно. Гэхдээ би нэг зүйлийг зоригтой хэлье: таны ирээдүйг өнгөрсөн юмуу одоо чинь шийдэхгүй! Шинэ сэтгэлгээтэй бол. Бурхантай бүх зүйл боломжтой гэдэгт итгэ. (Лук 18:27)

Христ таныг болон ханийг чинь чөлөөлөхөөр хэдийнээ үнийг нь төлчихсөн бөгөөд үр хүүхэд чинь таны цусан удамд байсан бүх хараалаас чөлөөлөгдсөн юм. Таны зүгээс гагцхүү тэр ялалт дээр тууштай зогсож, тунхаглах хэрэгтэй. Эзний өмнө чимээгүй байж, “Ариун Сүнс минь, миний удамд миний ханийн удамд ямар бурханлаг бус зан үйлдэл байна? Биднийг бүрэн чөлөөлөгдөхийн

тулд нэг бүрчлэн илчилж өгөөч” гэж залбирна уу.

Ариун Сүнс хараалыг илчилбэл, тэдгээрийг Ариун Сүнсэнд өг. Энэ бүлэгт бичсэн залбирлыг хэлж, чөлөөлөлтийн төлөө Ариун Сүнсэнд итгэ.

Заримдаа бид өөрөө ч мэдэлгүй элдэв янзын ам тангараг (амлалт) өргөснөөрөө, гэр бүлээ элдэв асуудалд өртүүлдэг. Ам тангараг өргөгдөхөд, бидний зүрхийг хүрээлэн хана босдог. Эдгээр амлалт нь биднийг ирээдүйн асуудлаас хамгаалах зорилготой атлаа биднийг хорьж, илүү том зовлон авчирдаг.

Амныхаа үгээр өөрийгөө занганд оруулсан бөгөөд
өөрийгөө барьж өгсөн.

- Сургаалт үгс 6:2

Түр зогсоод “Ариун Сүнс минь, би өөртөө элдэв янзын ам тангараг тавьсан уу? Тавьсан бол, тэдгээр нь юу вэ?” Чимээгүй байж, сонс. Түүний ичилсэн алив ам тангаргийг гэмшиж, таныг бүх айдсаас чөлөөлөхийг залбиран гуй. Есүсийн нэрээр. Амень.

Бид айснаасаа болж ам тангараг өргөдөг. Дахиад шархлахаасаа айсандаа бид “би дахиад хэзээ ч хүнд тэгэхийг ингэхийг зөвшөөрөхгүй. Нөхөр/эхнэр маань намайг (хууран мэхлэх, зодох гэх мэт) -х л юм бол би тэгнэ ингэнэ гэдэг. Хэрэв та дотроо эвсэл гаднаа иймэрхүү байдлаар амлалт өргөсөн бол, гэмш. Аюулгүй байдлын албыг Эзэнд даатга.

Чиний эсрэг бүтээгдсэн нэг ч зэвсэг бүтэлтэй болохгүй. Шүүх дээр чиний эсрэг боссон хэл бүр яллагдана. Энэ бол ЭЗЭНий зарцуудын өв бөгөөд Надаас ирэх тэдний зөвтгөл юм” гэж ЭЗЭН зарлиг болгов.

- Исаиа 45:17

Есүстэй тогтоох харилцаагаараа та бүх хараалаас чөлөөлөгдөж, бүх сүнслэг ерөөлийг өвлөсөн (Ефес 1:3). Дараах ишлэлийг анхааралтай уншаад, Христийн дотор танд болоод таны гэр бүлд боломжтой болсон ерөөлөөс тоочино уу: Матай 11:28; 16:19; Лук 10:19; 11:13; Иохан 4:14; 7:38-39; 14:27; 15:11; 1Коринт 1:30; 2Коринт 5:21; 2Петр 1:3-4. Эдгээр ишлэлд Ариун Сүнс өөр юуг танд илчилж байна?

Тавдугаар өдрийн судлал

ХҮСЭН ХҮЛЭЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ

Учир нь Тэр Өөрөө “Би чамайг хэзээ ч орхихгүй. Би чамайг хэзээ ч мартахгүй” гэж айлдсан.

- Еврей 13:5

Хүсэн хүлээлт. Энэ нь ямар нэгэн зүйл болно гэсэн хүчирхэг итгэл юм. Бид хүмүүсээс ямар нэгэн зүйл хүсэн хүлээхдээ, сайн мэдээ сонсоно, сайн сайхан болно гэсэн хүчирхэг итгэл, мэдрэмжтэй болдог. Бид нэн ялангуяа ойр дотны хүмүүсээсээ буюу хань ижлээсээ асар том зүйл хүсэн хүлээдэг. **Патрик Эмь. Морли** ингэж хэлжээ:

“Ихэнх хүн нэн ялангуяа гэрлэлтийн тухайд бодитой бус, тэс өөр юм хүсч горьддог. Тэдгээр хүсэл горьдлого нь 1. бидний гэрлэлтийн талаарх төсөөлөл дээр 2. бидний хангагдаагүй хэрэгцээ дээр суурилдаг. Хүн бүр л төгс гэрлэлтийг өөр өөрийнхөөрөө төсөөлнө. Бид магадгүй тэр төсөөллөө аавынхаа хэлсэн, хийсэн зүйлээс, эцэг өвгөөсөө, найз нөхдийнхөө аав ээжээс, зурагтаас, номоос, киноны оддоос юмуу баатруудаас олж авсан байж болох.”

Бодитой бус хүсэл найдлага нь таны гэрлэлтийн аль ч талбарт байж болно. Мөнгө, харилцаа, ахуйн асуудал, хүүхдийн хүмүүжил, найз нөхдийн харилцаа, секс гэх мэт. Одоо түр зогсоод “Эзэн минь, би гэрлэлтдээ бодитой бус хүсэл найдлага тээж явна

уу? Тийм бол тэдгээр нь юу вэ?” гэж асууна уу.

Ариун Сүнс танд юу илчилж байна? Илчилсэн зүйлийг нь хэрэгжүүлэхийг сануулж буй алхамтай нь хамт бичнэ үү.

Бодит бус хүсэл найдлагыг яаж бодитой хүсэл найдлагаар солих вэ? Патрик Морли ингэж хэлжээ:

“Бид хариу горьдолгүй өгч сурах хэрэгтэй. Бид хань ижилдээ хүсэн хүлээлтээ ойлгуулж мэдүүлж, дараа нь тэднийг сонсож сурах хэрэгтэй. Энэ чинь л бодитой хүсэн хүлээлт юм.”

Хань ижлээсээ “Би чамаас боломжгүй юм шаарддаг уу?” гэж асуу. Хариултыг нь таслалгүй, анхааралтай бас хүндэтгэлтэй сонс. Хэлсэн зүйлсийг нь бич.

Хэрэв та хань ижлээсээ бодитой бус зүйл шаардсан бол, тэднийг дарамтанд оруулсандаа чин сэтгэлээсээ уучлал хүс. Та хоёрын гэрлэлтэд эдгэрэл авчирч, хэн хэний чинь дотор бодитой хүсэн хүлээлтээ хөгжүүлэхийг Эзэнээс гүй.

Эцсийн эцэст бидний хүсэл найдлага Бурханд бөгөөд Түүний амлалтад л байх ёстой. Тэр итгэмжтэй учраас хэзээ ч биднийг хөсөрдүүлэхгүй! “Эзэн минь, би гагцхүү Танаас л хүсэн хүлээх ёстой хэрэгцээгээ хань ижлээсээ шаардаад байна уу? Хэрэв тийм бол надад харуулаач. Танд хүсэл найдлагаа тавихад минь туслаач” гэж залбир. Тэгээд чимээгүй хүлээж, сонс. Ариун Сүнс танд юу харуулж байна?

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

Мессенжер Интернэйшнэлийн “Гэрлэлтийн түүх” сургалтын хөтөлбөрийн 3-р видео хичээлийг үзнэ үү.

1. Гэрлэлтэд санал зөрөх явдал бишгүй гардаг ч, тэдгээрийг хэрхэн шийдэж байгаа маань л бүхнийг шийднэ. Бодоод үз. Нөхөр эхнэр хоёр нь нэгдэх үйл явц дунд байгаа тэс өөр хоёр хүн юм. Тус бүр давтагдашгүй хүмүүс. Тэд тус бүр өөр өөрөөр бодож, боловсруулж, сэтгэл мэдрэмжээ илэрхийлдэг. Тэд аливаа хүн, үйл явдал, нөхцлийг өөр өөрөөр харна. Энэ талаар бодож байсан уу? Хань ижлийнхээ онцгой байдлыг ойлгох нь тэднийг үнэлж, эерэгээр харахад хэрхэн туслах вэ?

2. Христээр дамжуулан гуйсан хүн бүрт өршөөл боломжтой болжээ. Гэхдээ хэрэв та Бурханаас ямар нэг зүйлийн төлөө уучлал гуйтал Тэрбээр “Би чамайг уучлахыг хүсч буй эсэхээ мэдэхгүй байна. Учир нь чи наадахаа дахиад л хийнэ шүү дээ. Эхлээд чи жаахан өөрчлөгдчих” гэж хариулбал, танд ямар байх уу? Хань ижил чинь танаас уучлал гуйхад, та ингэж бодож, хариулж байгаагүй гэж үү? Ийм хариулт сонссон тэдэнд ямар байх уу?

3. Бурханы уучлал нь өөрчлөгдсөн зан үйлдэлд өгдөг шагнал биш юм. Энэ нь Бурханы Өөртөө итгэл дүүрэн байдлын сонголт юм. Бурханы болзолгүй хайр болон уучлал таныг өөрчлөгдөхөд

хэрхэн хүчирхэгжүүлж, хөдөлгөдөг вэ? Тэгвэл уучлалын тухайд та хань ижилдээ яаж хандах болж байна? Ийм хандлага тэднийг яаж вэ?

“Уучлал нь харилцаан дахь ялын - зовиурын тойргийг эвдэх цорын ганц арга зам юм... Уучлал нь бүх ял шударга байдал, үнэн зөвийн асуудлыг шийдэж чадахгүй ч, харилцааг цоо шинээр эхлүүлэх боломж олгоно.”

- Филипп Янси

4. Айдас нь бидний амьдрал дахь Бурханы хайр, хамгаалалтын тэс эсрэг чигтэй сүнслэг хүч юм. Айдсыг таньж, шийдэхгүй аваас энэ нь бидний гэрлэлтийг өсч өргөжих чадваргүй болгон хөлдөөдөг. Нөхрүүд ээ, эрчүүд эхнэртэйгээ тогтоох харилцаандаа юунаас хамгийн их айдаг вэ? Эхнэрүүд ээ, эмэгтэйчүүд нөхөртэйгээ тогтоох харилцаандаа юунаас хамгийн их айдаг вэ? Эдгээр айдсыг ялах нарийн арга зам юу вэ?

Нөхөрт байдаг айдас

Эхнэрт байдаг айдас

5. Гэрлэлт дэхь бодитой бус хүсэн хүлээлт нь гомдол, гутрал, зовнилын хөрс болдог. Дайсан хэвлэл мэдээлэл, интэртэйментээр дамжуулан бидэнд харилцааны бодитой бус үзэл бодол суулгаж, сэтгэл дундуур байдлын үрийг тарьсаар байна. Тэгвэл бодоод үз: кино, хөгжим, зурагтын нэвтрүүлэг, сэтгүүл, ном, интернет нь бидний хань ижилдээ хандах үзэл бодолд хэрхэн нөлөөлж, халдваржуулж байна? Бид энэ бодитой бус хүсэн хүлээлтээс

зүрхээ болон тархиа хамгаалахын тулд ямар бодитой алхам хийх ёстой вэ?

Удирдагч нарт: Филиппой 4:8 Эцэст нь, ах дүү нар аа, юу нь үнэн, юу нь хүндэтгэлтэй, юу нь зөв, юу нь цэвэр ариун, юу нь сайхан, юу нь сайшаалтай байна, хэрэв аливаа сайн үйл байгаа бол, хэрэв магтууштай ямар нэгэн юм байгаа бол тэдгээр юмсыг бодож санацгаа.

Учир нь тэр дотроо боддогтойгоо адил юм.

- Сургаалт үгс 23:7

6. Танд хадмуудын асуудал тулгарч байсан уу? Тулгарч байсан бол нэр усыг нь дурьдалгүйгээр хуваалцана уу. Энэ бэрхшээлийг давсан бол, Бурхан танд хэрхэн тусласан талаар хуваалцана уу. Харин одоо ч үргэлжлүүлэн шийдсээр яваа бол, Бурханы нигүүлсэл байж, үүнийг зөв зүйтэй шийдэх хүчээр хангахын төлөө бүлгийнхэнээрээ залбируулна уу.

Бүлгийн хураангуй:

- Та гэрлэлтийнхээ тавцанг цэвэрлэснээр Бурханы танд зориулсан гэрлэлтийн өргөжилтөд хүрэх боломжтой.
- Уучлал нь гомдоосон болон гомдсон хүний хувьд чөлөөлөлт юм. Бурханы нигүүлслээр бид бусдыг хэмжээ хязгааргүй, эрх чөлөөтэй уучилж, Бурханы уучлалыг хүртэж чадна.
- Бид биш, гагцхүү Бурхан л хүнийг өөрчилдөг. Гэхдээ бид Бурхантай гар нийлэн ажиллаж, Түүгээр өөрийгөө өөрчлүүлж чадна.
- Хань ижлийнхээ төлөө талархах хандлага нь бидний зүрхийг хайр, уучлалд нээж, Бурханы нигүүлсэлийг тэднийг хүргэнэ. Ийнхүү тэр ч та ч өөрчлөгдөнө.
- Та уучлахыг сонгоход гэр бүлийн чинь бүх хүн ялагч болно. Учир нь хайр биднийг цэцэглүүлдэг.
- Бурханы хайрыг мэдрэх нь бидний амьдрал дахь айдсыг зайлуулдаг. Түүний хайрыг өөрийнхөө дотор болон өөрөөрөө дамжуулан ажиллуулах нь ханийнхаа доторх айдсыг үлдэн хөөж, алдаа эндлийг нь хаацайлна.
- Та шинэ өвийг байгуулахаасаа өмнө танай гэр бүлийг нэрвэсэн хараалтай нүүр тулах хэрэгтэй. Христийн бүрэн төгс загалмайн үйлсээр бүх хараал үйрсэн!
- Танай гэрлэлтийн нөхцөл байдал ямар байсан ч, Бурхан үүнийг чинь өөрчилнө. Учир нь Тэр хамт байгаа. Түүнтэй байхад бүх юм боломжтой!



— ДӨРӨВ —

Босогтун байгуулагтун!

... Харь үндэстний захирагчид тэднийг ноёрхдог бөгөөд ихэс дээдэс нь тэднийг захирах эрх мэдэл эдэлдгийг та нар мэднэ. Та нар тэгжэ болохгүй. Харин та нарын дунд хэн чинь агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог. Үүнчлэн Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд амиа олны төлөө золиос болгон өгөхөөр ирсэн билээ гэв.

- Матай 20:25-28

Нэгдүгээр өдөр

Эрүүл саруул гэрлэлтийг босгон байгуулах ганц л үр дүнтэй арга бий. Энэ арга барил нь баясмаар бас амархан биш гэдгийг анхааруулъя. Гэхдээ энэ нь гэрлэлтийн амьдралыг

бүрэн бүтэн, хайраар дүүрэн, зорилготой байлгах цорын ганц арга юм. Та энэ аугаа нууцыг мэдэхэд бэлэн байна уу? Тэгвэл энэ: үйлчил. Мөрөөдлийнхөө гэрлэлийг байгуулах цорын ганц арга зам нь ханьдаа үйлчлэхэд амьдралаа зориулах юм.

Номоо хаах юмуу дараагийн бүлэг рүү үсэрчихэж болохгүй шүү. Үйлчлэх гэдэг ойлголт нь нэг их сайхан зүйл биш гэдгийг бид мэднэ. Энэ нь голдуу ундууцсан, дургүйцсэн мэдрэмж төрүүлдэг. Гэвч Бурханы Хүү, хаадын Хаан Есүс бидний сайн сайхны төлөө зарц болохоор ирсэн юм. Бидний сайн сайхан Түүний хамгийн том сонирхол болжээ. Тэрбээр Бурхан хүн хоёрын хоорондох ангалыг холбохын тулд эдлэх ёстой эрхээсээ татгалзжээ. Тийнхүү Тэрбээр биднийг Бурхантай эвлэрүүлэх зам болжээ. Есүс биднийг Өөртэйгээ улам адилхан болгохын төлөө биднийг ер бусын амьдралаар аж төрүүлж, зүрхний маань мөрөөдөл, хүсэл, баяр хөөрийг биелүүлэхдээ дуртай байдаг. Есүс Өөрийнхөө амийг өгөхдөө, бидэнд дүүрэн амьдралыг санал болгосон юм. Түүний энэхүү хязгааргүй, эгнэшгүй үйлчлэл нь бидний хувьд бүх харилцаагаа тэр дундаа гэрлэлтийн харилцаагаа жолоодох жишиг билээ.

Өдгөө та тавцангаа цэвэрлэсэн учраас мөрөөдлийнхөө гэрлэлтийг цогцлоох боломжтой боллоо. Гэхдээ мөрөөдлийн гэрлэлтийг цогцлоох цорын ганц арга зам нь гэрлэлтийнхээ төлөө амьдралаа зориулах юм. Чөлөөтэй өгч чадаж байгаа зүйл чинь л таных болдог нь Бурханы хаанчлалын зарчим билээ. Та ханийнхаа сайн сайхны төлөө золиос гаргасан нөхцөлд л гэрлэлтийн амьдралдаа хүсч буй баяр хөөр, хайр, ололт амжилтаа олно.

Өөрийнхөө эрх ашгийг хайдаг Христэд итгэгчид хамгийн хөөрхийлөлтэй хүмүүс байдгийг та анзаарсан уу? Бусдын төлөө юу ч хийдэггүй хүмүүс л хамгийн тахир татуу болдог. Учир нь Христийн дотор Есүсийн сүнсний үйлчлэлийн ДНК бидний дотор явж байдаг. Есүс бол төгс зарц. Бид Түүн дотор өөрийгөө хэн болохыг хүлээж авахаас татгалзбал, Түүний өөрчлөгч хүчээс өөрийгөө салгана. Үүнд нь үйлчлэл ч багтана. Бид гагцхүү Есүс шиг аж төрсөн нөхцөлд л бурханлаг амьдрал, гэрлэлтийг цогцлоох хүчийг хүлээж авна. Үйлчлэхгүй аваас хүссэн гэрлэлтээ байгуулж чадахгүй.

Хамгийн дорд нь болох

Есүс дагалдагч нартайгаа хамгийн сүүлийн удаа зоог барихдаа удахгүй Түүнээс хүмүүс урван тэрсэлж, Тэрбээр алуулна гэдгээ хэлжээ. Харин дагалдагч нар нь юу гэж хариулсан бэ? Эхлээд тэд Есүсээс урвана гэдэг байж болшгүй хэмээн тас зөрсөн. Тэгмэгцээ шууд л хэн нь мундаг болох талаар маргалдаж гарсан.

Аймшигтай! Есүс удахгүй болох үхлийнхээ талаар хэлж байхад, хамгийн дотны хүмүүс нь өөрийгөө ямар аугаа болох талаар хэрэлдэж байдаг. Есүс тэдний мунхаглалд юу гэж хариулсаныг харна уу:

Харин та нар тийм байж болохгүй. Та нарын дотроос хамгийн агуу нь хамгийн өчүүхэн нь мэт болог, удирдагч нь зарц мэт байг. Ширээнд тухлагч, үйлчлэгч хоёрын хэн нь агуу вэ? Ширээнд тухлагч нь биш гэж үү? Харин Би та нарын дунд үйлчлэгч мэт байдаг. (Лук 22:26-27)

Есүсийн үг дагалдагч нарын нүүрэн дээр бөмбөгөөр цохичих шиг л болов. Тэд мундаг болохын төлөө л улайрч байсан. Гэтэл Есүс аугаа баймаар байвал, аугаа үйлчлэх хэрэгтэй гэжээ. Гэхдээ Есүс энэ хатуу үгээр дуусгасангүй. Есүс дагалдагч нартаа бүр их эргэлзэж, самуурмаар үг хэлжээ:

Эцэг нь бүх юмаа Өөрийнх нь мутарт өгснийг болон Бурханаас ирээд Бурхан уруу буцан явж байгаагаа Есүс мэдээд, тийнхүү зоогийн ширээнээс босч, гадуур хувцсаа тайлаад, алчуур авч бүслэв. Тэгээд саванд ус хийж, шавь нарынхаа хөлийг угаагаад, бүсэлсэн алчуураараа арчиж эхлэв. (Иохан 13:3-5)

Энэ хэсгийн хамгийн зог тусмаар хэсэг нь Есүс дагалдагч нарынхаа хөлийг угаасан хэсэг юм. Яагаад? Хариулт нь тийнхүү гэдэг үгт бий. Есүст бүх эрх мэдэл өгөгдсөн. Тийнхүү Есүс Өөрийгөө даруу болгож, дорд зарцын үүрэг хариуцлагыг

хүлээн авчээ. Есүс худлаа даруу болж маяглаагүй. Тэрбээр ямар эрх хүчтэй болохоо мэдэж байсан. Гэхдээ Есүс эрх мэдлээрээ далайлгаж, сүрдүүлэхийн оронд байр сууриа санаанд оромгүй үйлчлэлийн суурь болгон ашиглажээ.

Засмал зам, Nike гутал байхгүй Нэгдүгээр зуунд хүмүүс онгорхой углааштай (эсвэл хөл нүцгэн) явдаг байсан учраас шавхай шороо, малын ялгадсаар будуулчихсан өмхий, заваан хөлтэй явдаг байжээ.

Ийм бохир учраас зарц боолууд эзэнийхээ болон зочдын хөлийг угааж цэвэрлэх үүрэгтэй байв. Чинээлэг гэр бүлийн зарц нар маш их ажил үүрэгтэй байсан: малын саравч янзлах, хоол хүнс бэлтгэх, гэр цэвэрлэх. Гэхдээ хөл угаах ажлыг хамгийн дорд боол гүйцэтгэдэг байв. Зарим хүрээнийхний дунд хамгийн бузар муухай гэж үзэгддэг, өөр юу ч хийх зохисгүй эмэгтэй зарц нар л хөл угаадаг байжээ.

Есүс үйлчлэх сэтгэлээр үүнийг үйлдсэн. Яагаад? Учир нь Тэрбээр дагалдагч нартаа үйлчлэлийн ач холбогдлыг заахыг хүсчээ. Есүс тэр ч бүү хэл Багшийн байр суурийг нь илтгэх орхимжоо тайлж, зарцын өмсгөлийг илтгэн алчуур бүслэжээ. Есүс тун удахгүй Өөрөөс нь урваж, үгүйсгэж, хаяж явах хүмүүсийн хөлийг угаасан гэдгийг бүү мартаарай.

Тэгээд Тэр тэдний хөлийг угаасны дараа гадуур хувцсаа авч, дахин тухлан суугаад тэдэнд:

—Та нарт Би юу хийж өгснийг мэдэж байна уу? Та нар Намайг Багш, Эзэн гэж дууддаг. Та нар зөв ярьж байна. Учир нь Би үнэхээр мөн. Тэгвэл Би Эзэн, Багш байтлаа та нарын хөлийг угаасан бол та нар мөн нэг нэгнийхээ хөлийг угаах ёстой. Учир нь Миний та нарт юу хийснийг та нар бас хийх хэрэгтэй гэж Би ийм жишээ үзүүлсэн юм. Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Боол нь эзнээсээ агуу биш, мөн илгээгдэгч нь илгээгчээсээ агуу биш юм. Хэрэв та нар эдгээрийг мэдэж, үйлдвэл ерөөлтэй хэмээн айлджээ.

(Иохан 13:12-17)

Дагалдагч нарынхаа хөлийг угаасныхаа дараа Есүс Багшийн эрх мэдлийг илтгэх орхимжоо дахин зүүгээд, дагалдагч нарын хэзээ ч марташгүй хамгийн гол зүйлээ зааж өгчээ. Түүний сургамжийг үндсэн дөрөв ангилж болно:

1. Эзэн бөгөөд Багшийнхаа хувьд Би та нарын төгс үлгэр жишээ.
2. Би энэ дорд үйлдлийг сайн дураараа хийсэн тул та нар бусдын төлөө үйлчлэхдээ өөрийгөө доош орчихлоо гэж бүү сана.
3. Би чамаас аугаа боловч, чиний төлөө хамгийн дорд боол шиг үйлчлэх хүсэлтэй чиний Эзэн.
4. Миний үйлчлэлийн үлгэр жишээг дагадаг хүмүүсийг Би ерөөдөг.

Үйлчлэхээр дуудагдсан

Түүний үлгэр жишээг дагасан хүмүүс ерөөгдөнө гэж Есүс айлдсан. Энэ нь хэрэв бид ханьдаа Түүний жишгээр үйлчилбэл бидний гэрлэлт дээр Түүний ерөөл байна гэсэн үг.

Бид таныг шөнө бүр ханийхаа хөлийг угааж өг гэж хэлээгүй. Хамгийн гол нь бид амьдралдаа Түүний үйлчлэлийн үлгэр загварыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Паул ингэж бичжээ:

Юуг ч өрсөлдөх сэтгэлээр, эсвэл бардам зангаар бүү хий. Харин даруугаар бие биеэ өөрөөсөө дээр гэж үзэж... Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай. (Филиппой 2:3-5)

Есүс ямар хандлагатай байсан? Тэрбээр Өөрийнхөө ашиг сонирхлоос илүү бусдын ашиг сонирхлыг дээр үздэг зарц байхаар шийджээ. Тэгээд ч зогсохгүй хайртай хүмүүсийнхээ төлөө эцсээ хүртэл явж, амиа хүртэл өгсөн. Ихэнх хүн хань ижлийнхээ төлөө

ийм золиос гаргахаар дуудагдаагүй ч, тэдний төлөө амиа хичээсэн зангаа хаяхаар дуудагдсан юм.

Тэгвэл үйлчлэх нь Бурханы ерөөлийг далладаг тийм аугаа зүйл юм бол, яагаад хүмүүс бүгдээрээ үүнийг хийдэггүй юм бэ? Асуудал нь цаг үргэлж Бурханы Сүнсстэй тэмцэлдэж, өөрийнхөө ашиг сонирхлыг дээдлэхийг урамшуулдаг гэмт мөн чанартай маань холбоотой. Бидний махан бие өөрийнхөө хүслийг хүлээн зөвшөөрч, дур тачаалаа биелүүлэхийг шаарддаг. Гэхдээ бид махан биеэ хичнээн тэжээсэн ч, хүний мөн чанар улам л ихийг шаарддаг.

Нүгэлт мөн чанар нь цаг үргэлж амиа бодсон байдлыг, сэтгэл ханамжгүй байдлыг суртчилдаг бол, Ариун Сүнс амиа боддоггүй байдлаар хүчирхэгжүүлж, урт удаан биелэмжийг хүчирхэгжүүлдэг. Эгшин тутамд бид Ариун Сүнсээр удирдуулах уу эсвэл махан биеийнхээ ханаж цадашгүй хүслээр удирдуулах уу гэдгээ сонгоно:

Учир нь махан бие Сүнсний эсрэг хүсдэг, Сүнс махан биеийн эсрэг хүсдэг юм. Яагаад гэвэл хүссэн юмсыг чинь хийлгэхгүйн тулд махан бие ба Сүнс нь нэг нэгнээ эсэргүүцдэг ажээ. (Галат 5:17)

Есүс биднийг нүгэлт мөн чанараас чөлөөлсөн учраас өдгөө бид амиа чөлөөтэй өргөж чадна. Аврал биднийг улам ихийг хураахын тулд чөлөөлөөгүй; харин улам ихийг өгүүлэхийн тулд чөлөөлсөн! Паул ч энэ тухай айлдсан: “Та нар эрх чөлөө уруу дуудагдсан юм. Гэхдээ та нар эрх чөлөөгөө махан биеийн төлөөх таатай боломж болгож бүү ашигла. Харин бие биедээ хайраар үйлчил” (Галат 5:13).

Бид амиа зориулахын төлөө эрх чөлөө олжээ. Хэрэв бид өөрийнхөө төлөө л амьдраад байвал, Христ доторх эрх чөлөөгөө үрэн таран хийж, Христ биднийг чөлөөлөхийн тулд үхсэн тэр л амиа бодсон чанар, нүгэлд захирагдана.

Харин бусдад буюу нэн ялангуяа ханьдаа үйлчлэхийг сурсанаараа, Есүсийн бидэнд өгсөн бүрэн дүүрэн амьдралын салшгүй хэсэг болно.

Хоёрдугаар өдөр

Сүнсээр дүүрэн

Хүмүүс Ефес 5-р бүлэг дэхь “гэрлэлтийн хэсгийг” дурьдахдаа, ерөнхийдөө эхнэрүүдийг үгэнд орох тухай өгүүлдэг 22-р ишлэлээс эхэлдэг. Гэхдээ Паулын ятгалга нь үүнээс ч өмнө эхэлж байгаа юм. Бидний гэрлэлт хэрхэн Христ Чуулган хоёрын харилцааг дүрсэлдгийг бүрэн ойлгохын тулд 18-р ишлэлийг дахин харцгаая:

...Сүнсээр дүүрэн бай... (Ефес 5:18).

Дүүрэн гэдэг үг нь Грекээрээ Сүнсээр тасралтгүй дүүргэгдэх үйл явцсыг дүрсэлж байгаа юм. Нэг удаа дүүрэх нь хангалтгүй. Бурханы Сүнсээр тасралтгүй дүүрдэггүй хүн гагцхүү Бурханы л дүүргэдэг хэрэгцээг хань ижлээсээ хайж эхэлдэг. Гэтэл таны хань хичнээн мундаг хүн байсан ч, Бурханыг орлож чадахгүй. Хэрэв та гагцхүү Бурханы л өгдөг зорилго, утга учир, ерөөлийг хань ижлээсээ шаардбал, Бурханы хайрыг харуулах чадваргүй, цөхөрч, гомдсон хэвээрээ л үлдэнэ.

Бид Бурханы Сүнсийг амьдралдаа хүлээж авсан хэмжээгээрээ л Христийг тусган харуулдаг. Христ бидний авралын булангийн чулуу боловч, Ариун Сүнс нь өөрчлөгч төлөөлөгч юм. Амьдралаа Ариун Сүнсээр байнга дүүрэн байлгаснаараа бид оюун санааны шинэчлэлийг үзэж, зан авирын өөрчлөлтийг үзнэ. Бурхан айлдруун:

... чиний амьдралын урьдын хэв маягт хамаарах заль мэхийн тачаалын дагуу ялзарч буй хуучин хүнээ та нар тайлж, оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгдэж, зөвт байдал болон үнэний ариун байдал дотор Бурханы дагуу бүтээгдсэн шинэ хүнийг өөртөө өмс. (Ефес 4:22-24)

Ариун Сүнснээс тусгаар байдлаар Христ шиг хайрлаж, үйлчлэх гэж оролдох нь цорготой нь холбоогүй хоолойгоос ус авах

гэж оролдохтой ижил юм. Хоолой өөрөө ус гаргахгүй. Хоолой нь зүгээр л суваг юм. Үүнтэй адилхан зөвхөн Ариун Сүнсний хүчийг хүлээн авсан хүн л Бурханы хүссэн арга замаар хайрлаж, үйлчилж чадна.

Сэтгэлийн хат болон зан үйлдэл нь өөрийн гэсэн хүчтэй ч, эдгээр нь бидний оюун санааг шинэчилж, махан биеийн хүслийг ялан дийлж чадахгүй. Гагцхүү Бурханы Сүнсийг, Бурханы Сүнсний хүчийг хүлээж авсан хүн л Бурханы амьдрал өөрчлөх нөлөөг амьдралдаа болон амьдралаараа дамжуулан харуулж чадна. Ариун Сүнсний оролцоогүйгээр зан авираа өөрчлөх оролдлого бүр нь цөхрөл, самууралд л хүргэнэ.

Бид маш олон эрэгтэй, эмэгтэй хүнээс ноёрхол, дарамтлалаас болж гэрлэлт нь сөнөсөн тухай сонсдог. Ихэнх тохиолдолд тэдгээр хүмүүс нь Бичээсийг мэддэг ч, Сүнсний хайр ба нигүүлслээр дутсан байдаг. Үүний үр дүнд чөлөөлж, хүчирхэгжүүлэх учиртай яг тэр үг нь чөдөрлөж, доош хийж, ичгүүрт оруулахын тулд ашиглагддаг. Амиа хичээсэн байдал шургалсан бүх газар иймэрхүү муу ёрын зүйлс байдаг. Бурханы Сүнсэнд ажлаа хийх бололцоо олгохгүй, үйлчлэлийг гэрлэлтийнхээ хамгийн гол үүргийг болгохоос татгалзсан газар амиа бодсон байдал цэцэглэдэг.

Тус бүлгийн үлдсэн хэсэгт гэрлэлтийн амьдралд үйлчилнэ гэдэг нь юу болохыг тайлбарлана. Бид танд үйлчлэлээр дамжуулан хэрхэн гэрлэлтээ байгуулах Библийн дүр зургийг гаргаж өгөхийг хүсч байна. Та энэ бүлгээр далимдуулан хань ижлийнхээ өнгөрсөний юмуу одоогийн алдааг чичлэх эрхгүй. Харин ч үйлчлэлийг хамтдаа урагшлах хөдөлгүүрээ болго.

Үүний тулд мэдээж эхнэр нөхрийн аль аль нь гэрлэлтэд хандсан Бурханы төлөвлөгөөг хүндэтгэх хүсэлтэй байх ёстой. Гэхдээ дандаа ийм байдаггүйг бид мэднэ. Нөхцөл байдал ямар ч байсан, та ханиа өөрчилж чадахгүй гэдгийг санаарай. Өөрчлөх гэж оролдсон хүн Бурханд л саад хийнэ. Ариун Сүнсний ажилд зүрхээ нээж өгөөд, таны хань дотор ажлаа хийх боломжийг нь Ариун Сүнсэнд олго.

Дүр ба үүрэг

Гэрлэлтийн амьдралд эзлэх үүрэг хариуцлагаа ойлгохын тулд бид Едений үеийг дахин нэг харах хэрэгтэй:

Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж,
Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.
(Эхлэл 1:27)

Эрчүүд ч, эмэгтэйчүүд ч Бурханы дүр төрхийн тусгал юм. Хэдийгээр тэд өөр хоорондоо ялгаатай ч гэсэн, газар дээр Бурханы мөн чанарыг харуулахдаа эн тэнцүү чухал юм.

Нөхөр ба эхнэр байх нь үүрэг юм. Эдгээр нь онцгой үүрэг бөгөөд Библи энэ талаар тодорхой заавар өгсөн ч, эдгээр үүрэг нь биднийг хэн болохыг тодорхойлохгүй. Тэгвэл бид хэн бэ гэж үү? Бид газар дээр Бурханы дүр төрхийг тээхээр бүтээгдсэн юм. Гэм энэ зорилгыг нураасан ч, Христийн тахил үүнийг сэргээсэн буюу. Христ биднийг аврахдаа нэн тэргүүнд бидний тодорхойлолтыг өөрчилдөг.

Нөхөр, эхнэр, мэргэжилтэн, үйлчлэгч, аав ээж, найзын аль нь ч таны хэн болохыг тодорхойлж чадахгүй бөгөөд та ганц биеэ гэрлэсэн хүн болж, үүрэг чинь өөрчлөгдсөн ч гэрлэхээсээ өмнө Бурханы нүдэнд үзэгдэж байсан үнэ цэнээ алдахгүй.

Харамсалтай нь маш олон хүн (ялангуяа эмэгтэйчүүд) гэрлэснийхээ дараа үнэ цэнээ алдсан гэж боддог. Нөхрөө хүндэтгэнэ гэдэг нь хоёрдугаар зэргийн хүн боллоо гэсэн үг биш юм. Энэ буруу ойлголтын урхагаар эмэгтэй хүн босоод, хайраар үйлчлэхийн оронд хэн ч биш болтлоо боолын ажилд нухлагддаг.

Энэ зүй зохицлын дагуу, эр нөхөр нь завшиж байгаа мэт харагдавч, үнэндээ үгүй юм. Үнэндээ амиа бодсон чанар гол дүрд тоглож эхлэхэд эхнэр, нөхрийн аль аль нь ялагддаг. Эхнэрээ гэрлэлтийнхээ эн тэнцүү түншээ гэж үздэггүй нөхөр дотны хамтран зүтгэгчээ алдаад зогсохгүй, өсөх маш том боломжоо алддаг. Есүс Чуулгандаа үйлчилж байсан шиг эр хүн ханьдаа үйлчлэхдээ Христтэй улам адилхан болдог. Есүс удирдаж буй хүмүүстээ үйлчилснээрээ тэргүүний үүргээ үлгэрлэн харуулсан гэдгийг бүү мартаарай.

Хайр, хүндэтгэл, алдар нь эхнэр нөхрийн хэн хэнд чухал. Эхнэр нөхрийн хэн хэн нь чухал бөгөөд хэн хэн нь үйлчлэх үүрэгтэй. Гэрлэлтэд ийм байдлаар хандах хандлага нь эрэгтэй, эмэгтэй хүнд эзэн байх хүчийг нь буюу биднийг бүтээгдэх үед даалгагдсан Бурханы эрх мэдлийн бэлэг, хүчийг нь сэргээж өгдөг.

Ноёрхол ноёрхлын эсрэг

Бурхан тэднийг адислаж, тэдэнд
—Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэн, газрыг эзэмш! Далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дэлхий дээр хөдөлдөг бүх амьтдыг захир хэмээн айлдав. ...Бурхан Өөрийнхөө бүтээсэн бүгдийг харахад нэн сайхан байжээ. Үдэш болоод, өглөө болов. Тэр нь зургаа дахь өдөр болой.
(Эхлэл 1:28, 31)

Анхандаа эрэгтэй эмэгтэй хүмүүс дайсан биш байжээ. Тэд дотно түнш, хамтран зүтгэгч, нэгэн зүрхээр нэгдсэн хоёр өөр хүн байжээ. Тэд үржиж, газар дэлхийг дүүргэх үүрэг хүлээсэн. Бурхан тэдэнд захирамж өгсөн бөгөөд (үр жимстэй байж, үржих) нарийн ширийнийг нь өөрсдөд нь даалгажээ. Бурхан тэдэнд эзэн байх эрх олгожээ.

Эзэн байх гэдэг нь захирах эрх хүч, эрх мэдэл, хяналттай холбоотой. Энэ нь нөлөөний талбарыг дүрсэлдэг бөгөөд эрх хүчийг эзэгнэхийг хэлнэ. Эрэгтэй эмэгтэй бүх хүнд даалгагдсан эрх хүч нь бусдыг өсгөхийн төлөө, бусдын тусын тулд өгөгдсөн байдгийг бид Сүүлийн зоогоос сурсан буюу.

Харин нүглийн дараагаас хүйсийн дайн эхэлсэн юм. Бурхан Түүний бүтээл хоёрын хооронд гарсан ёроолгүй ангальн улмаас эзэний эрх нь дарангуйлал ба ноёрхол болон хувирчээ. Бурханаас өгөгдсөн энэ хүч нь завхрахдаа, нэгдлийн төлөө Бурханы урласан дизайнтай тасралтгүй дайсагнах болжээ. Гэрлэлт нь үржлийн оронд хуваагдлын зэмсэг болжээ.

Гэрлэлт нь хэзээ ч эрх хүчний төлөөх тэмцэл биш, эрх хүчний нэгдэл байхаар бүтээгдсэн юм. Гэрлэлт нь тэс өөр хоёр хүнийг нэгтгээд, тэр ялгааг нь үржих боломж болгон ашигладаг.

Энэ бүхэн нь эвлэрэх ямар ч боломжгүй харагдах зүйлсийг эвлэрүүлэх Бурханы төлөвлөгөөний нэгээхэн хэсэг юм. Есүс ийнхүү айлдруун:

Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ... (Лук 19:10)

Бид энэ ишлэлийг ихэвчлэн сайн мэдээ дэлгэрүүлэхтэй холбож ойлгодог ч, энэ нь хавьгүй гүн утгатай билээ. Есүс гагцхүү төөрөгдсөн хүмүүсийг аврахаар ирээгүй. Хүн төрөлхтөн нүгэл үйлдэхдээ Бурхантай тогтоох харилцаагаа алдсан. Түүгээр барахгүй бид өөр хоорондоо тогтоох харилцааны нэгдлээ алдсан. Энэ нь ахан дүүсийн, эгч дүүсийн, аав хүүгийн, эхнэр нөхрийн харилцаа юм. Түүнчлэн бид бусад бүх бүтээлтэй харилцах харилцааныхаа хамаг л сайн сайхныг алдсан.

Есүсийн авралын үйлс нь тэнгэрийн улс бууж ирэх хүртэл тэсэх тухай биш юм. Энэ нь яг одоо өрнөх эдгэрлийн тухай юм. Загалмайн ачаар алдагдсан харилцаа бүр сэргэх боломжтой болжээ. Энэ нь бидний гэрлэлт яг одоо эдгэрэх боломжтой гэсэн үг. Эрэгтэй эмэгтэй хүмүүс дахин нэгэн хүн шиг амьдарч чадна!

Бид зүрхээрээ болон зорилгоороо нэгдэхдээ үрждэг; Учир нь Бурхан эв нэгдэл байгаа газар ерөөлөө тушаасан хэмээжээ (Дуулал 133). Бидний сүнсний дайсан бидэнд Бурханы ерөөлийг үзүүлэхийг бас биднийг үржүүлэхийг хүсдэггүй. Тиймээс бидний нэгдлийг устгахын тулд чадах бүхнээ хийдэг. Дарангуйллын худал хуурмагтай тэмцэж, “эзэн байхын” жинхэнэ мөн чанарыг хүлээж авсанаараа бид Бурханы хүслийг газар дээр биелэл болгохын төлөө Бурхантай түншилдэг.

Харин одоо гэрлэлтэд эхнэр нөхрийн хүлээсэн үүргийн талаар дэлгэрэнгүй ярилцъя. Бурхан биднийг эзэн байх эрхтэй, ямар үнэ цэнэтэй, хэн байлгахаар бүтээснийг мэдэхгүй хүн эдгээр тэнгэрлэг үүрэг оройл нь эхнэр нөхрийн нэгийг нь нөгөөгөөс нь дээр болгосон хэмээн андуу ташаа бодоход хүрдэг. Эхлээд гэрлэлтэд хандсан Бурханы мандатыг сурч, хэн байх, юу хийх хоёр нь ялгаатай болохыг мэдсэнээрээ та эхнэр нөхөрт олгогдсон үүрэг оройлыг баяртайгаар хүлээж авна!

Нөхөр: Эхнэрээ хүндэтгэ

Нөхрүүд ээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг өөрөөсөө сул дорой сав мэт үзэн та нар ч мөн адил эхнэртэйгээ ойлголцож амьдар. Амийн нигүүлслийн хамтран өвлөгчийнх нь хувьд түүнийг хүндэтгэ. Ингэвэл та нарын залбиралд саад тоггор учрахгүй. (1Петр 3:7)

Хүндэтгэл нь хэн хэнд хамаатай юм. Эхнэр нөхрийн хэн хэн нь бие биеэ хүндэтгэх ёстойг Библи хэлсэн бөгөөд эхнэрийн тухайд бид хожим ярина. Харин одоо эрчүүдийн үүрэг оройл дээр төвлөрө.

Нөхөр минь, эхнэр чинь танаас дорд нэгэн биш. Эхнэр чинь Христ доторх таны хамтран өвлөгч бөгөөд та түүнд зохих ёсоор хандах ёстой. Петр эхнэрийг чинь танаас сул дорой гэж хэлэхдээ, бие махбодын хүчин чадлын талаар хэлсэнээс биш, сүнслэг хүч юмуу ялгах харааны хүчин чадлын талаар хэлээгүй юм. Энэ маш чухал зүйл шүү. Учир нь хүн хүндэтгээгүй зүйлээсээ үйлчлэлийг нэхэмжилдэг. Эхнэрийнхээ төлөө амьдралаа өгөхөөсөө өмнө, түүнийхээ ер бусын үнэ цэнийг мэдэх хэрэгтэй.

Бид таныг гэргийгээ доош нь хийдэг гэж хэлээгүй. Зүгээр л бөөрөнхийлөөд орхиж болдоггүй зүйлс гэж байдаг учраас л ийнхүү шулуухан ярьж байгаа юм. Эрэгтэй ч хүн, эмэгтэй ч хүн Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Тиймээс эр хүн эмэгтэй хүнийг хүндэтгэж, үнэлж, хамгаалахгүй үед Аавын маань илэрхийлэл газар дээр зэрэмдэглэгддэг.

Эхэнд Бурхан эр хүн ганцаар байх нь сайнгүй хэмээн айлджээ (Эхлэл 2:18). Дэлхий дээр үүссэн анхны асуудал болох хүний ганцаардлын шийдэл болгож Бурхан Еваг бүтээв. Эмэгтэйчүүд бол хоёрдагч бүтээл биш, харин Бурханаас ирсэн шийдэл юм. Бурханы эр хүн бүр эхнэрээ хайрлаж, дэмжиж, хөрөнгө оруулах завшаантай.

Петр түүнчлэн эр хүн эхнэрээ ойлгох ёстой гэжээ. Бид

өөртэйгээ адилгүй хүнийг ойлгохыг хичээх учиртай. Эрчүүд ч хоорондоо ялгаатай, эмэгтэйчүүд ч хоорондоо ялгаатай, эрэгтэй эмэгтэй хүмүүс хоорондоо бүр их ялгаатай. Жон миний бие Лизага надаас өөр байлаа гэж хүндэтгэлгүй ханддаггүй. Харин ч өөр байдалд нь баясаж, ойлгохыг хичээдэг.

Лиза бид хоёр яг адилхан байсан бол миний амьдрал юутай уйтай байх байлаа. Хэдийгээр бидний ялгаа заримдаа бэрхшээл авчирдаг ч, бидний сул талыг ил гаргаж, уриалж, хүчирхэгжүүлэх боломж олгодог юм. Лиза надаас зайлшгүй өөр байх хэрэгтэй. Би түүнийг хүндэтгэж, түүний ялгаатай талаас өөртөө ч, гэр бүлдээ ч ач тус хүртдэг.

Эцэст нь 1Петр 3:7 дээр эхнэрээ хүндэтгэдэггүй хүний залбиралд нь саад ирнэ гэж хэлсэнийг анхаарна уу. Эхнэрээ хүндэтгэх нь эр хүний залбирлын амьдралын суурь хүчин зүйл аж! Эмэгтэй хүний сайн сайхан Бурханд ийм л чухал байдаг аж.

Нэгдлийн тэргүүн

Учир нь Христ чуулганы толгой байдгийн адил нөхөр нь эхнэрийнхээ толгой юм. Христ Өөрөө тэр биеийн Аврагч мөн. (Ефес 5:23)

Энэ нь дарга цэргийн тухай биш юм. Энэ нь гэрлэлтийн билэгдэл болсон Христ болон Түүний Сүйт бүсгүйн зураглалын илэрхийлэл юм. Энэхүү ойлголтод нөхөр нь Христтэй эгнэж байгаа учраас, нэгдлээ тэргүүлэх үүрэг оройл хүлээж байгаа юм. Үл итгэгч дэлхий Есүсийн мөн чанарыг гэрчлэн харж чадахын тулд эр нөхрүүд Христ шиг үйлчлэн удирдах гайхамшигтай үүрэг хариуцлагыг хүлээж буй юм. (Есүс Чуулганыг хөл алдан хайрладгийг ойлгобол, Тэрбээр эхнэрүүдийг дорд үзсэн бол хэрхэвч Сүйт бүсгүйнхээ үүрэг оройлтой эгнээхгүй байсан гэдгийг ойлгоно).

Нөхөр нь тэргүүн учраас эхнэрийн үг хамаагүй гэсэн үг биш юм. Харин ч эсрэгээр ухаантай нөхөр эхнэрийнхээ хувь нэмрийг хэзээ ч гадуурхалгүй, шийдвэр гаргах үйл явцдаа амин чухал хэмээн үзэж чих тавин хүлээж авна.




Бид дөнгөж гэрлээд байхдаа, Жон миний бие өдөрт цаг хагас залбирдаг байлаа. Харин бүтэн цагаар ажилладаг Лиза шүршүүрт ороод гарахдаа эсвэл жолоо барьж явахдаа гялс манс залбирчихдаг юм шиг санагддаг байлаа. Тэгээд бид аливаа шийдвэр дээр санал зөрөх үед би өөрийгөө хамаагүй их залбирдаг бас дээрээс нь тэргүүн гэдгээрээ түрүү барих алдаа гаргадаг байсан юм. Тийм боловч тийм маргааны бараг тэн хагаст нь миний эрх мэдлээрээ далайлгаж гаргасан шийдвэр маань биш, харин Лизагийн зөв байсныг хожим мэддэг байлаа!

Үнэнийг хэлэхэд миний уур хүрдэг байв. Яахаараа дандаа Лизагийн зөв байдаг байна аа? Би тийм их залбирдаг байтал? Тэгээд нэг өдөр залбирлаа: “Бурхан минь, би өдөр бүр цаг хагас залбирдаг. Лиза шүршүүрт арван минут залбирдаг. Гэтэл бараг тэн хагаст нь Лизагийн зөв байж таарах юм.”

Гэтэл Бурхан надад тойрог зур гэлээ. Би цаас олоод, тойрог зурлаа.

“Одоо тойргоо “Х” тэмдгээр дүүргэж зур хэмээн Бурхан заавар өглөө. Намайг “Х” зурсаны дараа Бурхан “Одоо тэг дундуур нь дээрээс доош зураас тат” гэлээ.

“Жон, зураасын хоёр талд байгаа “Х” тэмдгийн тоо адилхан байгааг чи харж байна уу? Жон минь, чи ганц бие байхдаа Миний дотор ганцаараа бүрэн бүтэн болж байсан. Чи бүтэн тойрог байсан. Харин Лизатай гэрлэхдээ чи түүнтэй нэгэн бие болсон. Одоо та хоёр нийлээд нэг бүтэн тойрог гэсэн үг. Тойргийн нэг тал нь чи, нөгөө тал нь Лиза. Харин “Х” тэмдэг нь юу болохыг мэдэх үү? Тэдгээр нь чи зөв шийдвэр гаргахын төлөө Надаас авах хэрэгтэй мэдээлэл юм. Гол асуудал нь чи өөрийнхөө хэсэгт байгаа мэдээлэл дээрээ л тулгуурлан шийдвэрээ гаргаад байна. Чи өрхийн тэргүүнийхээ хувьд зөв шийдвэр гаргахын тулд Надаас ирсэн бүх



мэдээллийг цуглуулж шийдвэр гаргахын тулд эхнэрийнхээ талд байгаа мэдээллийг бас хүлээж авах ёстой.”

Энэ илчлэл надад өрхийн тэргүүн байх талаар цоо шинэ ухаарал хайрлаж билээ. Үүнээс хойш би Лизагийн зөвлөгөөг сонсолгүйгээр хэзээ ч дур мэдэн шийдвэр гаргаагүй юм. Өдгөө би Лизагаар дамжин Бурханы үгийг сонсож, хамтарч шийдвэр гаргахдаа тун их баясдаг.

Удирдагч Зарц

Эр хүний үүрэг нь ноёрхол биш гэдгийг дахиад хэлье. Ноёрхол нь удирдахаас тэс өөр юм. Удирдлага нь зохистой сонголт бол, ноёрхол нь ямар ч сонголт олголгүй, тулган шаарддаг. Эрчүүдийн хувьд, гэртээ бурханлаг удирдагч байх гол түлхүүр нь эрх мэдлийн байр сууриа эзлэх юм. Есүс “Харин та нар тийм байж болохгүй. Та нарын дотроос хамгийн агуу нь хамгийн өчүүхэн нь мэт болог, удирдагч нь зарц мэт байг” (Лук 22:26) гэж хэлсэнийг санаарай. Нэгдлийн тэргүүнийхээ хувьд нөхөр нь удирдагч зарц байх ёстой.

Эрчүүд эмэгтэй хүнийг зарцладаг дарга биш юм. Тэрбээр эхнэртэйгээ хамт ажилладаг удирдагч юм. Үнэндээ ухаантай нөхөр аваас эхнэртээ “Би чамгүйгээр юу ч хийж чадахгүй” гэдэг үгийг байн байн хэлнэ. Нөхөрт маань миний тус хэрэгтэй гэдгийг Лиза миний бие сонсох дуртай. Түүнд дутагдсан бүхнийг нөхнө гэхээр надад урам орж, хүч амтагддаг. Тэгээд хэрэв би аливаа зүйлийг хэрхэн хийхээ мэдэхгүй бол, мэдэхийн төлөө тэмүүлдэг. Жон намайг амин чухал гэж хэлэхэд, би цэцэглэдэг.

Нөхрүүд ээ, эхнэртээ үйлчлэх нь түүний хүссэн бүхнийг нь өгөөд байхын нэр биш юм. Харин амьдралаа тавьж, түүний сайн сайхны төлөө шийдвэр гаргана гэсэн үг. Есүс биднийг удирдсан газар руу бид эхнэрээ дагуулна гэсэн үг. Бидний сайн сайхны төлөө Есүсийн үйлдэж буй зүйлст бид ихэвчлэн дургүйцдэг. Заримдаа эхнэрийн чинь сайн сайхан таны дур хүсэлтэй зөрчилдөх үе зөндөө гарна. Ийм нөхцөлд бид тавтай тухтай, дуртай дургүй зүйлсээсээ илүү Есүсийн үлгэр загварыг дагаж юу нь сайн болохыг л сонгох учиртай. Харин эхнэртээ хамгийн сайныг хийхийн тулд урьдаар эхнэрээ Христ Чуулганыг хайрлаж, хүндэтгэсэн шиг хайрлаж хүндэтгэх ёстой.

Дагалдагч нарынхаа хөлийг угаасныхаа дараа Есүс Өөрийгөө Эзэн хэвээрээ гэдгээ мэдэгджээ. Тэр хэзээ ч эрх хүчний байр сууриасаа буугаагүй. Гэхдээ эрх хүчний зорилгыг цоо шинээр тодорхойлжээ. Бидэнд эрх хүч өгөгдсөн нь бие биедээ үйлчлэхийн төлөө гэдгийг Есүс бидэнд харуулсан. Эрчүүд ээ, бид хань ижлийнхээ ашиг сонирхолд үйлчлэх уур амьсгал бүтээхийн тулд тэргүүнийхээ эрх мэдлийг ашиглах үүрэгтэй. Бид энэ нэгдлийн тэргүүн учраас гол зарц болж үйлчлэх нь бидний үүрэг хариуцлага билээ. Үүнийг хийснээрээ бид өөрийгөө эхнэртээ захируулж байгаа юм.

Христээс эмээн нэг нэгэндээ захирагд. (Ефес 5:21)

Ефес 5:18 дээр хэлсэн Паулын тушаалыг санаж байна уу? “Харин Сүнсээр дүүрэн бай.” Дараа нь Паул Ариун Сүнсээр дүүрэн хүн ямар байдгийг дүрслэн хэлжээ. Тэгээд 21-р ишлэлд “Бие биедээ захирагд” гэсэн. Паул энэ үгээр л гэрлэлтийн талаарх яриагаа эхэлсэн гэж хэлж болно. Гэрлэлтийн утга учир гэдэг номдоо Тимоти болон Кэйти Келлер ингэж бичжээ:

Англи Библи дээр 21-р ишлэлийг салгаж бичдэг бөгөөд үүнээс болж уншигч нар Паулын хэлсэн нэгэн зүйлийн ойлголтыг мэдэхгүй өнгөрдөг. Грек Библи дээр 21-р ишлэл нь өмнөх урт өгүүлбэрийнхээ хавсарсан нийлмэл бүтэц байгаа бөгөөд энд Паул “Сүнсээр дүүрэн” хүний хэд хэдэн шинжийг дүрслэсэн байдаг. Тиймээс Сүнсээр дүүрэн хүний сүүлийн шинж нь бусдад даруугаар үйлчлэхийн төлөө өөрийгөө бодсон зан, бардам зангаа гээх юм.

Гэрлэлтийн амьдрал дээр энэ нь Сүнсний хүчээр аж төрдөг нөхөр юмуу эхнэр нь нөхөртөө юмуу эхнэртээ захирагддаг байдлаараа мэдэгдэнэ.

Олон хүн эхнэр нь нөхөртөө захирагдахыг л цохон тэмдэглээд байдаг. Гэтэл Паул нөхөр ба эхнэрийн аль алийг нь бие биедээ захирагдахыг зааварлажээ. Паул энд эхнэр нь нөхөртөө захирагд

гэж хэлэхдээ хэрэглэсэн яг л адилхан Грек үгийг хэрэглэсэн байна. Энэ үг нь захирагдах, харъяалагдах гэсэн утга илэрхийлдэг.

Паул биднийг Христийг эмээн хүндэтгэ гэжээ. Хүндэтгэхийг Грекээр phobos гэдэг. Энэ нь айж сүрдэх, эмээх гэсэн утга илэрхийлдэг. Хүндэтгэл гэдэг үг нь Паулын үгийн жинхэнэ утгыг гаргаж чадахгүй байна. Тиймээс үүнийг “Христийг эмээн хүндэтгэж, бие биедээ захирагд” гэвэл илүү ононо.

Нэгэн өдөр Жон миний бие Лизад муухай хандахад, Бурхан надад “Лиза нэгдүгээрт - Миний охин, хоёрдугаарт - чиний гэргий” гэж хэлсэн юм. Үүнээс хойш би үнэхээр Эзэнээс эмээсэн!

Нөхөр минь, Бурхан хэзээд бидний дэргэд байдаг. Бурхан Өөрийнх нь охинд хэрхэн хандаж, хэрхэн ярьж байгааг чинь харж л байгаа. Тэрбээр таны үгийг нэвтлэн зүрхний чинь сэдлийг хардаг. Та сүйт бүсгүйдээ хэрхэн хандсанаараа л Бурханыг хүндэтгэнэ. Хэрэв та сүйт бүсгүйгээ хүндэтгэхгүй байгаа бол, Аавыг нь ч бас хүндэтгэхгүй. Үлэмж их айдас чичрэлээр Аавын охиныг хайрлаарай.

Паул цааш нь эр хүн гэргийнхээ төлөө амиа зориулсанаараа эхнэртээ захирагддаг хэмээн тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, тэрбээр эхнэрийнхээ сайн сайхны төлөө өөрийгөө зориулсанаараа эхнэртээ захирагдана.

Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө
Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла.
(Ефес 5:25)

Христ байр суурь, эрх мэдлээ хэзээ ч Өөрийнхөө ашиг сонирхлын төлөө ашигладаггүй. Тэрбээр үүнийгээ биднийг хүчирхэгжүүлэхийн төлөө ашигласан. Үүнтэй адилхан нөхрүүд бид эрх мэдлийн байр сууриа гэргийнхээ тус, хүчийн төлөө ашиглахаар дуудагдсан юм. Христ Сүйт бүсгүйгээ алдаршуулж, ариусгахын төлөө амиа өгсөн. Түүний гүн гүнзгий баяр хөөр - амар сайхан төгсгөл нь Сүйт бүсгүйн сүр жавхлан гэж хэлж болно. Есүсийн мөрөөр явж буй хүнд амиа бодох зай байхгүй. Нөхөр таны үүрэг оройл нь гэргийдээ болон дэлхийд Христийг илчлэх туйлын зорилгын төлөө тэдэнд үйлчлэх юм. Ийм замаар

гэргийгээ удирдахад, гэргий чинь таны Бурханаас томилсон эрх мэдлийн байр суурьт дуртайяа захирагдана.

Дөрөвдүгээр өдөр

Гэргий: Нөхрөө дэмж

Эхнэрүүд ээ, Эзэнд захирагддаг шиг нөхрүүддээ захирагд. Учир нь Христ чуулганы толгой байдгийн адил нөхөр нь эхнэрийнхээ толгой юм. Христ Өөрөө тэр биеийн Аврагч мөн. Чуулган Христэд захирагддагийн адил түүнчлэн эхнэрүүд нөхрүүддээ бүх талаар захирагд. (Ефес 5:22-24)

Паул нөхөрт ч, эхнэрт ч “Христийн төлөө бие биедээ захирагд” гэж айлдсаныг та санаж байгаа байх (Ефес 5:21). Дараагийн ишлэлд тэрбээр “Эхнэрүүд ээ, Эзэнд захирагддаг шиг нөхрүүддээ захирагд” (и22) хэмээжээ. Олон хүн үүнийг эмэгтэйчүүдийн хувьд гай барцад гэж үздэг ч, тийм биш юм.

Гэрлэлт нь ноёрхол биш учраас эхнэр нь эзэний эрхийг нөхөртэйгээ эн тэгш эдэлнэ. Энэ нь эр нөхрийн тэргүүнчлэлтэй зөрчилдөхгүй. Учир нь нөхөр ч, эхнэр ч гэрлэлтийнхээ хил хязгаарт эрх мэдэл, нөлөөний онцгой талбартай. Эзэн байх эрх нь “Би эрх мэдэл, нөлөөгөө чиний тусын тулд эдэлнэ, чи эрх мэдэл, нөлөөгөө миний тусын тулд эдэлнэ” гэдэг.

Нөхрөө дэмжих нь эхнэрийн үйлчлэл юм. Эхнэр ээ, танд нөхрийн чинь зүрх даатгагдсан байгаа. Үнэнийг хайр хүндэтгэлээр хэлснээрээ нөхрийнхөө зүрхийг хамгаалах нь хамгийн аугаа үйлчлэл юм. Түүнд зүрхээ илэрхийлэх боломж олгосноор үйлчилж сур. Дүгнэлт хийх гэж яарахын оронд харилцаагаар тэтгэснээр нөхрийгөө алсын хараа, зорилгоор өсгө.

Эмэгтэйчүүд тамир тэнхээн хувьд дорой ч, хүний зүрх рүү довтолходоо чадамгай байдаг. Эр хүн бяр тэнхээгээрээ эмэгтэйгээ хамгаалах учиртай байдаг шиг, эр хүний зүрх эхнэрийнхээ гарт байдаг. Зүрхийг хамгаалах шиг хүндтэй чухал үүрэг бий гэж үү?

Нөхөр нь үйлчлэлийг санаачилж, эхнэртээ амиа зориулдаг шиг, эхнэр нь нэгдлийнхээ тэргүүн болох нөхрөө хүндэтгэх хэрэгтэй. Энэ нь Христийн хайрыг дэлхийд илчлэхийн төлөө түүний хийх ёстой хэсэг юм. Эхнэрийн хайр, хүндэтгэл нь түүнийг Есүсийг дагаж буйг нь харуулна. Бурхан эмэгтэйчүүдийг хоёрдагч учраас захирагд гээгүй. Бурхан Чуулган ямар байх ёстойг эмэгтэйчүүдээр харуулахыг хүсдэг. Сайн, итгэмжтэй, хайрын, өгөөмөр Эзэн бөгөөд Аврагчаар хөтлүүлдэг амьдрал нь ямар байдгийг дэлхийд харуулах завшаан эхнэрт бий. Харин энэ нь дорд бөгөөд харамсмаар үүрэг оройл гэж завхруулахыг дайсандаа зөвшөөрөх нь юутай эмгэнэлтэй. Бурхан энэ үүргийг эмэгтэйчүүдэд өгөхдөө, Түүнийг ямар Бурхан болохыг дэлхийд харуулаад аль гэжээ.

Бурхан эмэгтэйчүүдийг хүчирхэг бөгөөд хүчин чадалтай болгож бүтээснээ мэднэ. Бурхан олон эмэгтэйг удирдагч, шүүгч, эш үзүүлэгч, зуучлагч, тэр бүү хэл Өөрийнх нь цорын ганц Хүүг тээж төрүүлж, өсгөх үүрэг хүлээлгэхээр сонгосныг түүхээс харж болно. Тиймээс Бурхан эмэгтэйчүүдэд нөхөртөө захирагдахыг тушаахдаа, сул дорой зохисгүй учраас тэр биш, харин “Чи Миний охин учраас хүчтэй чадалтай гэдгийг Би мэднэ. Гэхдээ Надад захирагдахын сайн сайхныг би чиний гэрлэлтээр дамжуулан дэлхийд харуулахыг хүсч байна. Чи үүнийг харуулахын тулд сайн дураараа дэмжих болон захирагдах үүргийг хүлээж авах уу?” гэж буй юм.

Удирдлагын ачаа

Бурханаас ялгаатай нь нөхрүүд төгс биш юм. Тэд дандаа зөв шийдвэр гаргахгүй, тэд дандаа гэргийдээ үйлчлэхгүй. Тиймээс эр нөхрөө хүндэтгэж, захирагдах хүсэлтэй эмэгтэйд ч үүнийг хийх хэцүү болдог. Тэгээд цагийн урсгалаар эхнэр нь асуудлыг өөрийнхөөрөө шийдэх өдөөлтөд орно. Нөхрийнхөө удирдлагын байр суурийг эсэргүүцэх нь эрх чөлөө шиг үзэгдэвч, эцэстээ эмэгтэйчүүдийг зовиур, шарх руу л аваачих зүйл юм.

Ууган хүү маань мэндлээд удаагүй байхад Лиза миний бие амралтын өдрийг үл харгалзан илүү цагаар маш их ажиллах шаардлагатай байсан юм. Би хувь хүнийхээ хувьд ч, мэргэжлийн хүнийхээ хувьд ч олон асуудалтай тулгарахын хажуугаар төгс

сайн ээж, гэргий байх гэж байдгаараа хичээж байлаа. Энэ үед Жоны ажил шилжилтийн үедээ байсан юм. Би ажилдаа дарагдаж, хүүгээ санаж байхад Жон хагас цагаар ажиллаж, залбирч, мацаг барьж, найз нөхөдтэйгээ уулзаж, гольф тоглож байв. Надад асар дарамттай байсан тул би Жоныг хайр найргүй буруутгаж байлаа. Надад яг л би амьдралаа босгох гэж гүйж байхад, Жон бүгдийг үрэн таран хийж байгаа юм шиг л санагдаж байв.

Би Жоныг надтай хамт санаа зовоосой гэж хүссэн ч, Жон тэгэхгүй байлаа. Би хамаг зовлонгоо Жонд тоочтол тэрбээр “Лиза, энэ бүхнийг зүгээр л тавиад, Бурханд даатгая” гэдэг байгаа.

“Хэрхэвч үгүй! Бид л үүнийг цэгцлэхгүй бол, өөр хэн ч үүнийг хийхгүй” гэж би бодлоо.

Нэгэн орой шүршүүрт орж байхдаа би Бурханд ачааныхаа талаар гомдоллов. “Жон бидний ачаанаас үүрэлцэхгүй байна. Би түүнийг хогоо хаяхыг хүртэл сануулдаг. Ийм хүнд чинь би яаж илүү чухал зүйл даалгах юм бэ?” хэмээн хяналтаа тавьж чадахгүй учраа зөвтгөн, урагш хойш саван, тэмцэв.

Гэтэл Эзэн надаас “Лиза, чи Жоныг сайн удирдагч гэж боддог уу?” хэмээн маш зөөлөн асуув.

“Үгүй, тэр сайн удирдагч биш. Би түүнд итгэхгүй байна!”

“Лиза, чи Жонд итгэх шаардлагагүй. Чи Надад итгэ. Чи Жоныг сайн өрхийн тэргүүн гэж боддоггүй. Чи өөрийгөө илүү сайн хийж чадна гэж бодож байна. Чамд байгаа хурцадмал байдал, дарамт нь өрхийн тэргүүн байх дарамт, жин юм. Энэ нь чамд буулга болж байна. Гэтэл би үүнийг Жонд даалгасан. Үүнийг тавь Лиза.”

Тэгэхэд л би ачааныхаа эх үүсвэрийг ойлгов. Миний үүрэх гэж зүдэрсэн, манай гэрийн тэргүүний үүрэг нь миний байр суурь ч, үүрэг ч биш учраас надад хүнддэж байжээ. Харин нөхрийг маань Бурхан энэ байр суурьт тослосон учраас энэ нь түүнд хүнд биш байв.

Бурханы өмнө даруулгатай болсон би шүршүүрээ хаагаад, алчуураа авлаа. Би унтлагын өрөөнд байсан Жон дээр очоод, тэр даруй уйлан байж уучлал гуйв. “Намайг уучлаарай би чамтай юм болгон дээр маргалддаг. Би чамд итгэхээсээ айсан. Хэрэв чи хүсбэл би маргааш ажлаасаа гаръя. Гол нь би дахиад л чамтай нэг баймаар байна.”

Гэтэл Жон “Би чамайг ажлаасаа гараасай гэж хүсэхгүй байна. Гол нь үүндээ биш. Гэхдээ чи өөрийгөө эх үүсвэр гэж боддогоо болих хэрэгтэй. Гол нь үүнд л байна” гэж хэлсэн юм.

Жоны зөв байлаа. Би эх үүсвэр биш, Бурхан эх үүсвэр. Энэ үнэнийг хараагүйгээсээ болж би асар их стресстэй, түшиггүй амьтан болжээ. Жаал ярилцсаны эцэст би Жонд “Би чиний ард байж, чамайг дэмжинэ ээ. Би чамд итгэж байна” гэж амласан юм.

Тэр үед би Жоныг дэмжиж байгаагаа ч, итгэж байгаагаа ч мэдэхгүй байлаа. Гэхдээ Жонд энэ дэмжлэг юу юунаас илүү хэрэгтэй гэдгийг л мэдэж байлаа. Манай гэрт бүх зүйл ямар ч эмх цэгц, эрэмбэ дараагүй байгааг би ухаарсан юм. Тэгээд миний самарсан асуудлыг цэгцэлж өгөхийг Бурханаас гуйв. Жон ч бас надаас хөндийрч, гэр бүлээ удирдаагүйдээ уучлал гуйв. Бид бие биеэ хайрлаж, дэмжиж, хайрлах гэрээ байгуулав.

Тэр шөнө би анх удаа сүүлийн хэдэн жил унтаж амраагүйгээрээ сайхан унтаж амрав. Намайг хүлж байсан буулга тасарчээ.

Бурхан биднийг үүрээрэй гэж хэлээгүй зүйлийг үүрэх бүртээ бид хүлээсийн буулганд ордог. Нөгөөтэйгүүр Бурхан биднийг хийгээрэй гэж тослосон бүх зүйл нь яг л байр суурь, хүчний тэмдэг шиг бидний хамгаалалт, хангамжийн бүрхүүл болдог.

Өрхийн тэргүүний үүргийг өөр дээрээ авсанаараа би буулганд орж, Жон байр сууриасаа мултарчээ. Аймшигтай байсан! Харин Бурханы томилсон байр суурьт бууж өгөх үед миний буулга эвдэрч, Жон Бурханы удирдлагын бүрхүүлд оров. Түүнчлэн бас тэр бүрхүүл нь Жоны халамжин дор байгаа намайг болон бүх хүнийг бүрхэж хамгаалдгийг би мэдэж авсан билээ.

Тавдугаар өдөр

Чаддаг нь чаддагаа, дуртай нь дуртайгаа хийг

Библи гэрлэлтэд эзлэх эрэгтэй, эмэгтэй хүний үүрэг оройлын талаар маш их ярьдаг ч бас хэлээгүй зүйл маш их бий. Бурхан Адам, Ева хоёрт өсч, үржиж дэлхийг дүүргэ гэхдээ нарийн

ширийн зүйлийг нь хэлэхгүй өнгөрөөсөн байдаг шиг, биднийг хайрцагт хийлгүйгээр гэрлэлтийн хил хязгаарыг тогтоож өгсөн байдаг. Бурхан хүрээг нь тогтоож, хэрхэн үйлчлэхийг нь үлгэрлэн харуулсан атлаа нарийн ширийн зүйлийг нь хэлээгүй юм.

Яг л өөрийнхөө хүссэнээр барьж байгуулж, аж төрөөрэй гэж хэлээд том газар өгөхтэй адил юм. Зарим хүн нь усан сан хүснэ, зарим нь сагсан бөмбөгийн талбай, зарим нь хоёуланг нь хүснэ. Үүнтэй адилхан гэрлэлт нь таны барьж байгуулах “гэр болон талбай” юм. Хэрэв эхнэр нь газрын зураглалдаа сайн бол, тэрбээр газраа хэрхэн тохижуулахаа шийддэг. Нөхөр нь цэцэрлэгээ арчлахдаа дуртай бол, арчлаг. Хоёулаа л бие биеийнхээ үйлчлэлээс ашиг тус хүртэнэ. Эрчүүд нь газраа тэгшилж, эхнэр нь цэцэрлэгээ арчилна гэсэн хууль байхгүй. Үйлчлэлийнхээ хэмжээ хязгаар дотроо л байвал, дуртай нь дуртайгаа хийг. Харин нарийн ширийнээ таны хань та хоёр болон Ариун Сүнсний удирдамжаар шийдэгдэнэ.

Гэрлэлт дэхь үйлчлэлийн санал зөрөлдөөн нь бид ханийгаа өөртөө яг өөрөө түүнд үйлчилдэг шигээ үйлчлүүлэх гээд байдгаас болдог. Учир нь тийм зүйл дандаа болно гэж байхгүй. Жон өөрийгөө зарц гэж хэлэх үед би хөвгүүдтэйгээ хөхөрдөг байлаа. Тэрбээр хоол дуусмагц л намайг хөвгүүдтэй минь орхичихоод гал тогооноос арилдаг хүн шүү дээ. Тэгээд бид л угааж, цэвэрлэнэ. Жон зарц шиг харагдахгүй байлаа.

Гэхдээ Жон өөр хүчин чадлаар үйлчилж байсныг бид ойлгохгүй байсан юм. Бид ширээ цэвэрлэж байсан бол, Жон мөнгө олж, хүмүүстэй харилцаж, төлбөрөөр төлж байв.

Энэ жишээ нь бидэнд нэгэн чухал зүйлийг зааж өгнө: үүрэг хариуцлагын хуваарилалт. Гэрлэлтийнхээ амьдралд үйлчлэлийн соёл байгуулахад хамгийн тустай нэгэн зүйл бол хэн юуны төлөө хариуцлагатай болохоо тодорхойлох юм. Харилцан зөвшилцсөн үүрэг хариуцлагын хуваарь нь танд хоёр тус хүргэнэ. Нэгдүгээрт- үүрэг хариуцлагынхаа сайн нярав байх нь хань ижилдээ үйлчлэхийн амин чухал хэсэг юм. Үүрэг хариуцлагаа харгалзах нь таны хань ижилд цаг хугацаа, амар тайван өгнө. Хоёрдугаарт- хань ижлийнхээ хийх үүрэгт ажлыг мэддэг хүн түүний юунд туслаж, юуных нь төлөө үйлчлэхээ мэддэг.

Ефес 5-р бүлгийн аль ч ишлэлд эрчүүд, эмэгтэйчүүдийн сонирхол, ур чадварын талаар яриагүй байгааг та хараа байх. “Уламжлал” эсвэл “хэвийн” хэмээн үздэг зүйлст бүү баригд. Зарим нөхөр хоол хийх дуртай байдаг. Зарим эхнэр машинаа арчлах дуртай байдаг. Нэг нь хүүхдийнхээ даалгаварт тусладаг бол, нөгөө нь хүүхдээ хөл бөмбөгийн бэлтгэлд нь хүргэж өгч, авах дуртай байдаг.

Санхүүгээ хамгийн сайн барьдаг нь мөнгөө зохицуулаг. Тэрбээр хань ижилдээ мөнгөө зохицуулахад нь, гэр бүлээ өргүй байлгахад нь туслаг.

Түүнчлэн та өөртөө хамаг мөнгөө нааж, найз нөхдийнхөө нөлөөгөөр, эр нөхрийнхөө өртгөөр дураараа дургихгүй байснаараа хань ижилдээ үйлчилж чадна. Та үгээрээ бас үйлдлээрээ үйлчилж чадна. Гэрлэлт нь том орон зайтай учраас үйлчлэх боломж ч их бий.

Ерөөлийг эдлэхүй

Хэрэв та нар эдгээрийг мэдэж, үйлдвэл ерөөлтэй.
(Иохан 13:17)

Үйлчлэл нь хүлээн авч буй хүнийг ерөөдөг ч, хамгийн том ерөөлийг үйлчилж буй хүн хүлээн авдаг.

Эмх цэгцтэй тавцантай, тодорхой алсын хараатай таны гэрлэлт нь газар дээрх Бурханы үзэсгэлэнтэй дүрслэл болох юм. Үүнийг сайн барьж босгох таны шилдэг хандлага нь үйлчлэх боломж бүрийг барьж авах юм. Бие биеэ босгон байгуулж, Бурханы ерөөл цутгахыг үзээрэй.

Бид бие биеэ байгуулж эхлэх үед Бурхан биднийг байгуулж эхэлсэн юм. Тэрбээр биднийг дэлхийн хил хязгаарыг тэлж, Түүний хайр, нигүүлслийг эргэн тойрон дахь хүмүүстэйгээ хуваалцахыг зөвшөөрдөг. Үйлчлэлээрээ бие биеэ байгуулахад, өөрийнхөө нөлөөний давхаргад буй хүмүүст үйлчлэх боломжийг Бурхан нээж өгнө. Бурхан таны гэрлэлтийг хамгийн итгэлгүй хүмүүс хүртэл эргэж харахаар тийм шилдэг бүтээл болгохыг хүсдэг.

Үйлчлэл нь хандлага болон үйлдлийн аль алийг багтаана. Хань ижилдээ үйлчлэх боломж гарах бүрийд танд сонголт бий:

үйлчлэхээс татгалзаж, амиа бодох; дургүй байгаа ч, үйлчлэх ёстой гэж үйлчлэх; эвсэл хань ижлээ дэмждэг учраас баяр хөөртэйгээр үйлчлэх.

Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай. Тэрээр хэдийгээр Бурханы мөн чанараар оршин байсан боловч, Бурхантай тэгш байх явдлыг Өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй, харин Өөрийгөө хоосолж, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ.
(Филиппой 2:5-7)

Та хүнтэй гэрлэхдээ, үндсэндээ түүний төлөө насан турш үйлчлэхээр гарын үсэг зурж байгаа юм. Таны “зөвшөөрч байна” гэдэг үг нь үнэндээ “Би чинийхээ сайн сайхны төлөө амьдралаа зориулна. Чиний төлөө амиа зориулж байгаа нь миний аз жаргал. Чиний мөрөөдөл, хүсэл, зорилго нь өдгөө миний хамгийн том зорилго. Би чамтай хамт Бурханы хайрыг харуулахад суралцмаар байна” гэдэг үгийг л арай өөрөөр л хэлэх юм.

Хэрэв та гэрлэлтэд жинхэнэ зарцын даруу байр сууриас хандбал, та хоёр тэнгэрлэг нэгдлийг мэдэрнэ. Энэ нь мэдээж дандаа амархан биш ч, хэрэв та Бурханы хамгийн шилдгийн төлөө зорьж, амиа бодолгүй амьдрахаар шийдсэн бол, таны гэр бүл хайр, баяр хөөр, амар тайван, аз жаргал, бүрэн дүүрэн байдлаар халгиж - та дэлхийд Бурханы хайрын зургийг харуулна.

Нэгдүгээр өдрийн судлал

АМЖИЛТАНД ХҮРЭХ НУУЦ

Би та нарын дунд үйлчлэгч мэт байдаг.

- Лук 22:27

Ах дүү нар аа, та нар эрх чөлөө уруу дуудагдсан юм. Гэхдээ та нар эрх чөлөөгөө махан биеийн төлөөх таатай боломж болгож бүү ашигла. Харин бие биедээ хайраар үйлчил.

- Галат 5:13

“Бурханыг хайрлах, бусдыг хайрлах хайр нь гэрлэлтийн суурь юм. Бусад хүмүүс хүртэх зохистой байсан ч, зохисгүй байсан ч, хайр түүний сайн сайхны төлөө байдгаараа илэрдэг. Хайр нь өөрийнхөө ашиг сонирхлоос өрөөлийн ашиг сонирхлыг дээгүүр тавьдаг. Хайр нь золиос гаргаж, өгч, зовдог. Хайр нь насан турш үргэлжлэх гэрээний болзлоо биелүүлж, ямар ч шарх, шуургыг тэвчин туулдаг” хэмээн **Др. Хенри Клауд, Др. Жон Таунсенд** тайлбарлажээ.

Хань жилийнхээ хамаг л сайн сайхны төлөө зүтгэж, тэдний ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж, золиос гарган өгөх нь нэг л зүйлийг цогцлоодог: үйлчлэлийг. Энэ нь амжилттай гэрлэлтийн нууц юм.

Түр зогсоод эргэцүүлнэ үү: Миний ханийн сонирхол юу билээ? Юунд баярладаг билээ? Сонирхол хобби нь юу билээ? Юу хийхээрээ алжаалаа тайлж, инээж, жаргалтай байдаг билээ?

Тэдний сонирхлыг нь урамшуулан дэмжих үүднээс ямар энгийн бодитой алхам хийж болох вэ?

Өөрөөсөө болон Ариун Сүнснээс ингэж асуу: Би юунаас болоод ханьдаа үйлчлэхгүй байна вэ? Миний амиа бодсон занг хөхиүлэн дэмждэг ямар нэг тодорхой зүйл надад байна уу? Өөрийгөө даруу болгож үйлчлэхээс намайг юу айлгадаг вэ? Зүрхийг тань илчлэхийг Ариун Сүнснээс залбиран асуу.

Есүс төгс зарц бөгөөд Бурханы хүүхэд болсон та Есүсийн ДНК-г өвлөжээ. Тийм ээ! Танд Есүсийн сүнслэг гени явж байгаа - үйлчлэх гени. Дараах ишлэлийг тунгаан бодно уу.

Бурханаас төрөгч ямар ч хүн нүгэл үйлддэггүй.
Учир нь Бурханы үр түүний дотор байгаа. Тэр хүн
Бурханаас төрсөн тул нүгэл үйлдэж чаддаггүй.

- 1Иохан 3:9

Учир нь та нар устах үрээс бус, харин үл устах үрээс
буюу Бурханы амьд, оршин буй үгээр дамжуулан
дахин төрсөн билээ.

- 1Петр 1:23

Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд
Над уруу ир. Би та нарыг амраая. Буулгыг минь өөр

дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ
дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ
амралтыг олох болно. Миний буулга амархан, Миний
ачаа хөнгөн гэв.

- Матай 11:28-30

Ариун Сүнс танд юу илчилж байна? Эдгээр ишлэл нь таныг
залбиралд хэрхэн урамшуулж байна?

Хоёрдугаар өдрийн судлал

ЭЗЭН БАЙХ ЭРХЭЭ ЭДЛЭХ

*Хүн гэгч юу болоод Та түүнд санаа тавьж,
Хүний хүү гэгч юу болоод Та түүнийг халамжилна вэ?
Та түүнийг Бурханаас арай дор болгож,
Алдар ба хүндэтгэлийн титмийг түүнд өмсгөжээ.*

- Дуулал 8:4,5

Амиа бодохгүй байж үйлчлэх зүрх нь Христ доторх итгэгчид бидний өвийн нэг хэсэг юм. Бид Түүнтэй харилцаж, цаг өнгөрөөхөд, Тэнгэрлэг Аавын маань эдгээр гайхалтай зан чанар бидний дотор хөгжиж, бодитой болдог. Бид Ариун Сүнсэнд өөрийгөө дүүргэхийг зөвшөөрсөн хэм хэмжээгээр л бидний амьдрал болон гэрлэлт Есүсийн үйлчлэлийг тусган харуулна.

Эзэнтэй харилцаж, цаг өнгөрөөдөг болсон тэр үеэс хойшх харилцаагаа эргэцүүлэн бодно уу. Ариун Сүнс таныг яг ямар тодорхой арга замаар өөрчилсөн бэ? Тэр таны гэрлэлтийг хэрхэн өөрчилсөн бэ?

Ариун Сүнснийхээ оршихуйгаар Бурхан танд болон таны хань ижилд Түүний танд даалгасан бүхий л зүйлсийн дээр эрх дархаа эдлээсэй гэж хүсдэг. 1828 оны Вебстерийн анхдагч толь бичигт “эзэн байх” гэдэг үгийг “засаглах эсвэл хянах хүч; удирдах, хянах, хэрэглэх хүч; ер бусын эрх мэдэл” хэмээн тайлбарлажээ.

“Эзэн байх” гэдэг үгийн утгыг дахин унш. Тэгээд түр зогсоод эргэцүүлэн бод: хувь хүнийхээ хувьд болон хосынхоо хувьд таны эрх мэдлийн доор хэн эсвэл юу тавигдсан байна? Та эдгээр талбар дээр хэр зэрэг эзэн байж чадаж байна?

Таны эрх мэдлийн дорх ямар нэгэн талбар өдгөө таны дээр ноёрхож, хянан захирдаг зүйл болчихсон байна уу? Тийм бол, тайлбарлана уу.

Эдгээр талбараа Ариун Сүнсэнд өргөж залбирна уу. Таныг өршөөж, Өөрийнхөө нигүүлсэл (хүчийг) өгөхийг асууж, тэдгээр талбартаа эзэн байх эрх мэдлээ эргүүлж олж ав.

Хань ижилтэйгээ дайсан биш, түнш шиг ажиллахын тулд ямар бодитой алхам хийж болох вэ? Үр хүүхэд, эх үүсвэр, ажил, үйлчлэлийнхээ дээр яаж сайн эзэн байх вэ?

Таны хань та хоёр зүрх сэтгэлээрээ болон зорилгоороо нэг болсон үедээ үрждэг. Нэгдэл байгаа газар Бурхан ерөөлөө тушаадаг (Дуулал 133-г үзнэ үү). Та хоёрыг эвдрэлцүүлэхийн тулд дайсан ямар талбар дээр хагарал бутрал авчрахаар ажиллаж байна? Өөрийгөө даруу болгож, эдгээр асуудлыг Бурханд өргө. Ариун Сүнсийг угтаж, хань ижилтэйгээ тогтоох нэгдлийн төлөө Бурханаас асууж, Эзэний ерөөлийг хүсэн хүлээ.

Гуравдугаар өдрийн судлал

БИЕ БИЕЭ ЭН ТЭГШ ХҮНДЭТГЭ

Та нарын нэг бүр чинь өөрийгөө хайрладгийн адил эхнэрээ хайрла. Эхнэр нь нөхрөөсөө эмээж бай.

- Ефес 5:33

Нөхрүүд ээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг өөрөөсөө сул дорой сав мэт үзэн та нар ч мөн адил эхнэртэйгээ ойлголцож амьдар. Амийн нигүүлслийн хамтран өвлөгчийнх нь хувьд түүнийг хүндэтгэ. Ингэвэл та нарын залбиралд саад тотгор учрахгүй.

- 1Петр 3:7

Гэрлэлтэд эрчүүд, эмэгтэйчүүд тэнцүү юм. Эхнэр нь хоёрдагч биш, нөхөр нь ч хоёрдагч биш. Тэд хоёулаа хамтран өвлөгчид бөгөөд Бурханы нигүүлсэлийг эн тэгш хуваалцдаг. Бид хоёр биеэ яаж эн тэгш хүндэтгэх вэ? Бурханаас өгөгдсөн үүрэг оройлоо сурч, амьдарснаараа.

Пастор Жимми Эванс энэ талаар ийнхүү хэлжээ:

“Эр хүний гэрлэлт дэхь хамгийн чухал хэрэгцээ нь хүндэтгэл юм. Эмэгтэй хүн эр нөхөртөө “Эзэнд захирагддаг шиг захирагд” гэж хэлсэн нь сонирхолтой бус уу? Эмэгтэй нь нөхрөө хүндэтгэж, түүндээ баяртайгаар захирагдахдаа тэрбээр гэрлэлтийн хамгийн гүн гүнзгий хэрэгцээг хангана.

Үүнтэй адилхан эр хүн эхнэрээ нандигнан тордож, амиа зориулахдаа эмэгтэй хүний гэрлэлтийн хамгийн гүн гүнзгий хэрэгцээг хангана - аюулгүй байдал, хамгаалалтын хэрэгцээ. Эмэгтэй хүнд өөрийг нь хамгаалж, хангах удирдагч хэрэгтэй. Эр хүн үүнийг баяртайгаар хийхэд, эмэгтэй хүний дотоод хэрэгцээ хангагддаг.”

Эрчүүд ээ, эхнэр чинь эхлээд Бурханы охин, зөвхөн үүний дараа л таны гэргий юм. Эмэгтэйчүүд ээ, нөхөр чинь эхлээд Бурханы хүү, зөвхөн үүний дараа л таны нөхөр юм. Ханиа Бурханы дүр төрхийг тээгч хэмээн тэнгэрийн Аавтайгаа эн тэгш хүндэтгэх ёстой. Дараах хэсэгт хэлсэн Бурханы зааврыг анхааралтай унш:

Эхнэрүүд ээ, Эзэнд захирагддаг шиг нөхрүүддээ захирагд. Учир нь Христ чуулганы толгой байдгийн адил нөхөр нь эхнэрийнхээ толгой юм. Христ Өөрөө тэр биеийн Аврагч мөн. Чуулган Христэд захирагддагийн адил түүнчлэн эхнэрүүд нөхрүүддээ бүх талаар захирагд. Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла. Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад түүнийг ямар ч толбогүй, ямар ч үрчлээсгүй бөгөөд тиймэрхүү ямар ч зүйлгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн ажээ. Тиймээс нөхрүүд ч эхнэрүүдээ өөрийн бие адил хайрлах ёстой. Эхнэрээ хайрладаг хүн өөрийгөө хайрладаг.

Учир нь хэн ч хэзээ ч өөрийн махан биеийг үзэн ядаж байгаагүй. Харин тэжээж, хамгаалдаг. Христ мөн чуулганд ийнхүү ханддаг. Яагаад гэвэл бид Түүний биеийн эрхтнүүд юм. “Тиймээс эр хүн эцэг эхээ орхиж, эхнэртэйгээ нийлдэг. Тэр хоёр нэг махан бие болно”

Нөхрийн үүрэг хариуцлагын талаар Ариун Сүнс танд юу харуулж байна?

Та Бурханаас өгөгдсөн үүрэг оройлоо биелүүлсэнээрээ хань ижлээ хүндэтгэж байна уу? Та аль талбарт өсөх хэрэгтэй байна?

Түр зогсоод залбирна уу: Ариун Сүнс минь, хань ижлээ хүндэтгэхэд минь надад юу саад хийж байна? Би хүндэтгэхгүй учраас алдаа гаргаж байна уу? Би хань ижлийнхээ ямар давуу талыг хайхралгүй өнгөрч байна? Надад түүнийхээ гайхамшигтай талыг харахад туслаач." Тэгээд чимээгүй байж, Түүнийг сонсоно уу? Ариун Сүнс танд юу илчилж байна?

Дөрөвдүгээр өдрийн судлал

ЕСҮСИЙН ДҮР ЗУРАГ

“Тиймээс эр хүн эцэг эхээ орхиж, эхнэртэйгээ нийлдэг. Тэр хоёр нэг махан бие болно”. Энэ нууц бол агуу билээ. Гэвч би Христ болон чуулганы тухай хэлж байна.

- Ефес 5:31-32

Бурхан нөхөр ба эхнэрийн үүрэг оройлыг бүтээсэн. Эдгээр үүрэг оройл нь ноёрхлын төлөө биш, эзэн байхын төлөө өгөгджээ. Эдгээр нь эцсийн эцэст Христ, Чуулган хоёрын харилцааны дүрслэл юм.

Тэгэхээр та нөхөр эхнэрийн үүрэг оройлын талаар уншсан болохоор, энэ бүлгээс сурсан зүйлээ өмнө сонссон эсвэл мэддэг байсан зүйлтэйгээ харьцуул. Энэ бүлэгт таны бодож эсвэл итгэж явсан зүйлээс чинь ялгаатай зүйл байна уу? Бэрхшээл нь юундаа байна? Юу урамшуулж байна? Цаашид юу сурахыг хүсч байна?

Гэргийгээ удирдаж, түүндээ Есүст үйлчилдэг шиг үйлчлэх нөхрийн үүрэг оройлын талаар эргэцүүлнэ үү. Гэрлэлтэд нөхөр нь Есүсийн удирдагчийн, үйлчлэлийн, хайрын зургийг төлөөлнө. Эрчүүд ээ, та үүрэг оройлынхоо юунд хамгийн дуртай вэ? Танд тодорхойгүй ямар нэг зүйл байна уу?

Та энэ оройлыг хэзээ ч өөрийнхөө хүчээр биелүүлэх учиргүй. Түр зогсоод залбирна уу: „Ариун Сүнс минь, Та бол Есүс Христийн Сүнс бөгөөд Та миний дотор амьдардаг. Надад Есүс шиг хайрлаж, үйлчлэхэд туслаач. Надад сайн удирдаж, ухаантай шийдвэр гаргахад туслаж, гэргийгээ нэгдлийнхээ эн тэгш хамтран зүтгэгч шиг хүндэтгэхэд туслаач.

Эмэгтэйчүүд ээ, нөхрийн үүрэг оройлын юу нь таныг хамгийн их баясгадаг вэ? Гэрлэлтдээ нэгдэл авчрахын төлөө нөхрийнхөө үүрэг оройлыг хэрхэн хүндэтгэх вэ?

Дараа нь эхнэрийн үүрэг оройлыг эргэцүүлнэ үү: Чуулганы дэмжлэг, Христэд захирагдахуйг төлөөлсөн захирагдах ба дэмжих үүрэг оройлоо сэтгэлтэйгээр биелүүлнэ үү. Эмэгтэйчүүд ээ, та өөрийнхөө үүргийн юунд дуртай вэ? Юу нь танд айдас, хүйдэс төрүүлдэг вэ? Яагаад?

Таны дуу хоолой, бэлэг, хувь нэмэр үнэ цэнэтэй бөгөөд чухал юм. Залбирах цаг гаргана уу: Бурхан минь, Танд захирагдахын сайн сайхныг харуулах үлгэр жишээ болохыг асуусанд баярлалаа. Би Таны үгээс өөр юугаар ч өөрийгөө тодорхойлуулахгүй. Танд үйлчилдэг шигээ эр нөхөртөө үйлчилж, дэмжих нигүүлсэл хайрлаач.

Эрчүүд ээ, та нар эхнэрийн ямар үүрэг оройлд хамгийн дуртай вэ? Гэрлэлтдээ эв нэгдэл авчрахын тулд эхнэрийнхээ үүрэг оройлыг хэрхэн хүндэтгэж чадах вэ?

Эдгээр асуултын хариултыг ханьтайгаа ярилц. Гэрлэлтдээ эв нэгдэл авчрахын тулд хэрэгжүүлж болох алсын хараагаа ярилцахдаа, хэрэгжүүлэх хэрэгтэй ямар нэгэн зайлшгүй зохицуулалт байгаа эсэхийг ярилц. Та хоёрын хэн нэгэнд айдас юмуу тодорхой бус зүйл байвал, Бурханы Үг рүү оч. Бурханы үг энэ талаар юу хэлж байна?

Энэ талаар хамтдаа залбир:

“Аав аа, Та бид хоёрт хоёуланд нь үзэсгэлэнтэй, жинтэй, хүндэтгэлтэй гэр бүлийн үүрэг хүлээлгэсэнд баярлалаа. Таны алдрын төлөө эв нэгдлийг харуулахын тулд бие биедээ үйлчилж, хайрлахад туслаач. Есүсийн нэрээр. Амень.”

Тавдугаар өдрийн судлал

БАГ БОЛОХ

*Өөр хоорондоо нэг санаатай байцгаа. Ухаан бодолдоо ч бүү
ихэрх. Харин төлөв даруу байхыг эрхэмлэ.
Өөрөө өөрийгөө мэргэн бүү болго.*

- Ром 12:16

“Багт “би” гэсэн ойлголт байхгүй” гэдэг үгийг та сонссон байх. Энэ үг нь зөвхөн спортод биш, гэрлэлтэд ч хамаатай. Танай багийн хүн бүр маш чухал, хэрэгтэй гүйцэтгэнэ. Гэрлэлтэд зан чанарын ялгаанаас болж асуудал гарах ёсгүй. Хэрэв хань чинь хүүхдийн хүмүүжил дээр эсвэл тавилга сонгох тал дээр танаас өөр саналтай байвал, та улам л баяжлаа гэсэн үг. Таны ертөнц тэлж байгаа нь тэр” хэмээн **Др. Хенри Клауд, Др. Жон Таунсенд** бичжээ.

Тиймээс гэрлэлтэд хэн нь дүрдээ хамгийн сайн тоглож байна? Үүрэг хариуцлагаа хуваах шаардлага зайлшгүй гарах бөгөөд эдгээр даалгавар нь цаг хугацааны аясаар дасан зохицоно. Гэхдээ ерөнхийдөө хэн нь юунд дуртай байна - тэр нь түүнийгээ хийг.

Багийн санаачилга гарга. Гэртээ зориулж жагсаалт гарга. Дүүргэгдэх ёстой үүрэг даалгавраа жагсааж бичээд, үүрэг тус бүрт хамгийн сайн тоглогчийнх нь нэрийг тохируулж бич. Зарим даалгаврыг нь эхнэр нь юмуу нөхөр нь бүхэлд нь биелүүлж болно. Заримыг нь хувааж болно.

Зарим нэг жишээ өгье.

| | |
|-------------------------------|--------------------|
| Машин угаах, арчлах | Амралт төлөвлөх |
| Төсөв | Төлбөр тооцоо хийх |
| Угаалга | Хог гаргаж хаях |
| Хүүхдийнхээ даалгаварт туслах | |
| Хүүхдүүдээ зөөх | Хоол хүнс бэлтгэх |
| Аяга таваг угаах | Тоос соруулах |
| Тоос арчих | Цэцэрлэгээ арчлах |
| Дэлгүүр явах | |

Та хоёр гэрлэхээсээ өмнө аль даалгаврыг хэн нь хийх талаар ямар нэгэн санаа бодолтой байсан уу? Тийм бол, тэдгээр нь юу байсан? Хариултаа жагсаалттайгаа харьцуулж цэгнэнэ үү. Зохицуулалт хийх шаардлагатай тал байна уу?

Гэрлэлтийнхээ эдгээр нарийн ширийн зүйлсийг бусдаар бүү шийдүүл.

Өөрийнхөө жагсаалтыг ханийнхаа бичсэн жагсаалттай харьцуулна уу. Хариултаа хамтдаа ярилц. Тэгээд үүрэг хариуцлагын харилцан тохиролцсон жагсаалт гарга.

***Бие биеэ хайр болон сайн үйлсэд хөхүүлэн
урамшуулахад анхааръя.***

- Еврей 10:24

Та ханийнхаа үүрэг хариуцлагыг дэмжих үүднээс хандлага, үг, үйлдлээ хэрхэн хэрэглэх вэ?

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

Мессенжер Интернэйшнэлийн “Гэрлэлтийн түүх” сургалтын хөтөлбөрийн 4-р видео хичээлийг үзнэ үү.

1. Есүс хамгийн дорд зарцын үүргийг хүлээж, дагалдагч нарынхаа хөлийг угаахдаа бидэнд аугаа үлгэр жишээ үзүүлсэн юм (Иохан 13:1-17). Манай барууны ертөнцөд хөл угаах ёс байхгүй ч, бие биедээ үйлчлэх хэрэгцээ нь байж л байгаа. Бид Есүсийг даган дуурайж, билэгдлээр “хөл угаахын” тулд ямар бодитой алхам хийж болох вэ?

2. Эрчүүд ээ, эхнэрээ гэрлэлтийнхээ эн тэгш хамтрагч гэж үзэх нь яагаад тийм чухал вэ?(1Петр 3:7-г үзнэ үү). Тэгж үзэхгүй бол, юу болох вэ? Эмэгтэйчүүд ээ, нөхрөөсөө хүндэтгэлээ харамлахгүй байх нь яагаад чухал вэ? Хүндэтгэбэл юу болох вэ?

3. Эр, эм хоёрын гэрлэлтийн харилцаа нь Түүний сүйт бүсгүй болох бидэнтэй харилцах Есүсийн дүр төрхийг тусгах үүрэгтэй юм. Гэрлэлтийн харилцаанд нөхөр ба эхнэр нь хэнийг билэгддэг болохыг дүрслэн хэлнэ үү. Нөхөр, эхнэрийн үүрэг оройл нь Есүсийн Чуулгандаа болон үл итгэгчдэд хандсан хайрыг хэрхэн илчилдэг вэ? Бид даалгавраа хэрхэн биелүүлэх хүчтэй вэ?

Удирдагч нарт: Уг асуултын хоёрдахь хэсэгт Ефес 5:18 дээр болон Үйлс 1:8, Зехариа 4:6, Иаков 4:6, Филиппой 4:13 дээр төвлөрнө үү.

4. Бурхан биднийг ялгаатай талаараа нэгдэлтэй байлгахыг хүсдэг. Хэсэг зуур бодож үзнэ үү: Хэрэв танай хань та хоёр яг адилхан давуу бөгөөд сул талтай - яг адилхан байсан бол ямар байх байсан бол? Энэ байдлыг дүрслэн хэлээд, ялгаатай талаа үнэлж, тэмдэглэх зарим нэг шинэ арга замаас хуваалцана уу.

5. Гэрийнхээ хамтран зөвшилцсөн үүрэг хариуцлагаа мэдэх нь маш тустай бөгөөд чухал юм. Танай гэр бүлд ийм зүйл байдаг уу? Энэ мэдлэг нь танай гэр бүлд үйлчлэлийн орчин бүтээхийн зэрэгцээ яаж хань ижлийг тань хүчирхэгжүүлэх вэ?

Бүлгийн хураангуй:

- Эрүүл гэрлэлт байгуулахын хамгийн үр дүнтэй арга барил нь хань ижилдээ үйлчлэх юм- түүний ашиг сонирхлын төлөө өөрийнхөө ашиг сонирхлыг золиослох.
- Бид Ариун Сүнсийг амьдралдаа урьсан хэм хэмжээгээр л бидний гэрлэлт Христийг харуулна. Тиймээс Ариун Сүнсээр амьдралаа тасралтгүй дүүргэснээрээ бид оюун санаагаа шинэчилж, зан үйлдлээ өөрчлүүлнэ.
- Эрчүүд, эмэгтэйчүүд нь газар дээр Бурханы мөн чанарыг тусган харуулах дүр төрхийг тээгч нар юм. Тэдний аль аль нь л чухал бөгөөд аль альд нь бие биедээ үйлчлэх эрх мэдэл итгэмжлэгдсэн.
- Нөхрүүд ээ, Бурхан та нарт эхнэрээ хүчирхэгжүүлж, хамгаалж, хангах үүрэг итгэмжилсэн. Та гэргийнхээ ашиг сонирхлыг нэгдүгээрт тавьж, амьдралаа зориулсанаараа гэргийгээ хайрлаж, хүндэтгэх үүрэгтэй.
- Эхнэрүүд ээ, Бурхан та нарт нөхрийнхөө зүрхийг харгалзаж, хамгаалах үүрэг хүлээлгэсэн. Та Христэд захирагддаг шигээ нөхрийнхөө удирдлагад захирагдаж, хүндэтгэх ёстой.
- Гэр орондоо харилцан тохиролцож хуваасан үүрэг хариуцлагатай байх нь хэрүүл маргааныг багасгаж, амар тайвныг тогтоож, багийн сэтгэхүйг байгуулдаг.



ТАВ

ДОТНОСОЛ

Секс нь бүрэн зориулагдсан харилцаанд л зориулагдсан юм. Учир нь энэ нь Христээр дамжуулан Бурхантай бүрэн төгс нэгдэх нэгдлийн баяр хөөрийн амталгаа юм. Эр, эм хоёрын хоорондох хамгийн гайхамшигтай хайраас бид Бурхантай нэгдэх нэгдлийн хэлтэрхийг мэдэрнэ.

- Тимоти болон Кэйти Келлер. „Гэрлэлтийн үтгэ үчир“ номоос

... Идэцгээ, андууд аа.

Ууж, хөөрцгөө, амраг хайртууд аа.

- Соломоны дуун 5:1

Нэгдүгээр өдөр

Бичээс Бурханы бэлгийн амьдралд хандсан зүйлсийн талаар ичэж зоволгүй ярьдаг. Заримдаа бүр маш дэлгэрэнгүй бөгөөд эротик ч гэмээр хэлдэг. Бидэнд итгэхгүй байвал, ханьтайгаа хамт Соломоны дуун номыг хэсэг уншаад үз.

Бурхан сексээс ичдэггүйгээрээ биднээс ялгаатай. Бурхан сексийн гоо үзэсгэлэнд хайртай бөгөөд үүний зорилгод ч баясдаг. Бурхан биднийг дотносоосой гэж хүсдэг. Гэр бүлийн харилцаа доторх секс нь сайнаар барахгүй, байх ёстой, дээдлэгдсэн, урамшуулагдсан зүйл юм!

“Хайраа том том залгил!” хэмээн Соломоны дуун хэлжээ. Өөрөөр хэлбэл секс нь нууцлаг бөгөөд гүн гүнзгий зүйл учраас гүехэн мэдрэх учир байхгүй. Дотносолын хосгүй ханамжийг амталж, эдлэ.

Секс нь яг л харилцааны дахин сэргээх товчийг дараад авахтай адил юм. Тиймээс Бичээс сексийн таалал биелэмжийг усаар дүрсэлдэг нь ч гайхах зүйл биш. Ус нь амьдрал тэтгэдэг. Ус нь сэргэлт ба амийг авчирдаг. Эрүүл саруул бэлгийн амьдрал нь гэрлэлтийн бүхэл амь биш боловч, үүний үнэ цэнийг хэтрүүлээ гэж хэзээ ч хэлж болохгүй. Бурхан бэлгийн харилцааг баярт явдал болгож, хоёр амийг сүлжсэн, гүн гүнзгий гэрээний гайхамшигтай дурсгал болгожээ.

Мөн секс нь эрүүл мэндэд тустай гэдгийг та мэдэх үү? Энэ нь та хоёрын харилцааг гүнзгийрүүлээд зогсохгүй, дархлааг сайжруулж, эрүүл жингээ барихад чинь туслаж, цусны даралтыг бууруулж, өвчин намдааж, зүрхний шигдээсээс сэргийлнэ. Хэдхэнийг дурьдахад л ийм байна.

Зарим чуулганы фракц бэлгийн харилцааны дотнослыг хүсэх дур хүслийг махан биеийн бузар дур хүсэл гэж үздэг. Үүнээс болж гэрлэлт доторх сексийг хүртэл муу муухай яриа гэж үздэг. Зарим хүн үүнийг нөхрийнхөө төлөө үйлдэж буй эмэгтэй хүний үүрэгт ажил гэж үздэг. Гэхдээ үнэнийг хэлэхэд, секс нь эхнэр, нөхрийн хоёулангийнх нь төлөө юм! Зарим хүн сексийг үржлийн төлөө зайлшгүй хүлцэн үйлдэх ёстой, бузар үйл гэдэг. Энэхүү буруу ташаа ойлголт нь энэхүү ариун үйлийг бузарласан Сатаны бусармаг үйлтэй нийлэхээрээ сексийг асар аюултай зүйл мэт хандахад хүргэдэг.

Үржил нь сексийн маш чухал зорилго гэдэг нь үнэн боловч, Бурхан сексийг анхнаасаа л сайн сайхан таашаалын эх үүсвэр болгон бүтээжээ. “Булгийн чинь ундарга ерөөгдөх болтугай! Залуудаа гэрлэсэн эхнэртээ баярлан баяс. Энхрийхэн марал болон нигүүлсэлт согоотой адил, эхнэрийн чинь хөх ямар ч үед сэтгэлийг чинь хангах болтугай (Сургаалт үгс 5:18-19).

Бурхан огт ичэхгүй байна. Бурхан бэлэг эрхтнийг бүтээсэн бөгөөд үйл ажиллагаанаас нь ичдэггүй. Бурхан сексийг бүтээж, мэдрэмжийг нь суулгажээ. Бидний таашаал нь Түүний таалал юм. Бурхан бидний бэлгийн дур хүслийг тастаж хаях биш, харин ариун байлгахыг хүсдэг. Ариусал гэдэг нь ариун амьдралын аян юм. Үүнийг Бурханаас бидэнд зориулсан хамгийн сайн сайханд хүрэх аян зам гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл хүний мөн чанарыг гадагшлуулж, тэнгэрлэг мөн чанараар дүүргэгдэх гэж ойлгож болно. Гайхамшигтай сексийн амьдралыг хөгжүүлэх нь (энэ нь бидэнд зориулсан Бурханы шилдгийн нэг хэсэг) унтлагын өрөөнд зориулсан Бурханы ариун байдлын дуудлагыг хүлээж авахаас эхэлнэ. Ингэснээрээ бид хүний төсөөллийн хязгаарыг давсан сексийн таашаалыг хүртэнэ.

Гэхдээ Бурхан бидний Түүнд өргөсөн зүйлийг л ариусгаж, ариун болгоно. Харамсалтай нь олон хүн өнгөрсөн алдаа, үзсэн хүчирхийллээсээ болоод сексийн амьдралаа Бурханд өгөхөөс татгалздаг. Эдгээр явдлаас болж бид сексийн мөн чанарыг ариун бус гэж үзэхэд хүрсэн учраас сүүдэрлэгдсэн талбараа Ариун Нэгэнээс нуухыг хичээдэг. Бүтээгч нь үүнийг аварч, ариун болгох хүчтэй гэдгийг бид мартжээ.

Ичгүүр нь Бурхан дээр биш, бидэн дээр төвлөрдөг. Ичгүүр нь биднийг Бурханы өршөөл нигүүлслээс татгалзахад хүргэхийн тулд хавханд оруулдаг. Тэгээд анхандаа ичгүүр шиг харагдсан зүйл нь яваандаа бардамнал болж хувирна. Бид Бурханы хийсэн зүйл нь бидний амьдралын энэ дотно талбарыг эдгээх чадалгүй юм шиг, Түүний өршөөлийг доромжилдог. Бид зовиураа гэрэлд гарган, хаяхын оронд зовиураа хадгалсаар байдаг. Бурхан тэднийг сексийн ичгүүрээс хамгаалж чадаагүй гэж боддог хүмүүс Бурханыг одоогийн бэлгийн амьдралдаа урихаас айдаг. Үнэндээ Бурхан хамгаалж чадаагүй биш, тэр нь нүгэлт хүний үр дагавар байжээ. Нүглийн ичгүүр, хүчирхийллээс болж гэрлэлтийнхээ дотнослын сайн сайхан, аз жаргалыг бүү алд. Бурхан эвдэрсэн хэсэг бүрийг эдгээж, бүрэн бүтэн болгохыг хүсдэг.

Бид анх гэрлэхдээ олон итгэгч нарын нэгэн адил бидний гэрлэлтийн амлалт нь бидний өнгөрсөн амьдралын бузар булайг цэмцийтэл арчиж, диваажингийн зам дээр тавина гэж бодсон юм. Бие биеэ хайрлаж, бие биедээ зориулагдсан учраас бидний

ирээдүйг ямар ч сүүдэр бүрхэхгүй, тогтмол бэлгийн харилцаа нь амиа бодсон байдал, хар мөртэй ичгүүрийг алга болгоно гэж итгэсэн юм. Гэхдээ бид андуурсан байлаа. Тун харамсалтай! Бид энд биднийг эрх чөлөөтэй болгосон сонголт, илчлэлийг хуваалцах үүднээс амьдралынхаа түүхээс хуваалцах болно.

Өмнөх амьдрал маань биднийг Бурханы байгуулсан цоо шинэ бэлгийн харилцааны амьдралыг байгуулахаас хорьж чадахгүй. Зөвхөн Бурхан л бидний бэлгийн амьдралыг ариусгаж, өнгөрсөн, одоо, ирээдүйн алдаанаас маань биднийг аварч чадна. Тэгээд гэрлэлтийн ор нь гагцхүү Бурханы нигүүлслээр л бүрэн бүтэн байдал, хайрын хамгаалалт болно.

Таны өнгөрсөн ямар байсан ч, Бурхан таны бэлгийн амьдралыг эрс тэс бөгөөд бүрэн төгс сэргээхийг хүснэ. Түүний нигүүлсэл нь таны урьд хожид хийсэн эсвэл хүлцсэн ямар ч зүйлээс аугаа юм. Гэхдээ та Түүнийг бэлгийн амьдралынхаа Эзэн болгохоос нааш Түүний нигүүлсэлийг хүртэж чадахгүй. Өөрийнхөө эмтэрхий байдлыг хүлээн зөвшөөрч, Бурханд өргө. Тэрбээр таны бэлгийн хар дарсан зүүдийг гайхамшигтай сайхан зүүд болгон өөрчилж чадна.

Гэрлэлтийнхээ орыг хүндэтгэх

Бүгд гэрлэлтийг хүндлэгтүн. Ор дэр нь ч бузартаагүй байг. Учир нь янхан эрчүүдийг болон завхайрагчдыг Бурхан шүүнэ. (Еврей 13:4)

Таны гэрлэлтэд асуудал байгаа бол, энэ нь хамгийн түрүүнд орон дотор чинь л илэрнэ. Гэрлэлтийн оронд дутагдах сэтгэл нь сексийн идэвхигүй амьдралын шинж биш, ерөнхийдөө өөр бусад асуудлын тэмдэг байдаг. Далд асуудал нь эзмэг мэдрэг газарт илэрдэг бөгөөд бэлгийн харилцаа нь хүний хамгийн эмзэг нөхцөл байдал юм.

Бэлгийн дотнослын хамгийн чухал зарчим нь хүндэтгэл юм. Олон хүн гэрлэлтийн орыг хүндэтгэхгүй байх юмуу бузарлах боломжгүй гэж боддог. Гэхдээ үүн шиг худал юм үгүй.

Бид ганц бие юмуу сүй тавьсан байхдаа цэвэр байж, өөрийгөө ирээдүйн ханьдаа хадгалах замаар гэрлэлтээ хүндэтгэдэг. Бид

гэрлэлтийнхээ дараа бусдыг оролцуулахгүй (завхайрахгүй байснаараа) юунд ч бидний бэлгийн дотнослын гоо үзэсгэлэнг бохирлохыг зөвшөөрөхгүй байснаараа (порнограф, завхрал, цэвэр бус байдал зэрэг) гэрлэлтийн ороо хүндэтгэнэ. Гэрлэлтийн ор нь бурханлаг бус бэлгийн таашаалыг ариусгахгүй, харин бурханлаг бус үйлдэл нь гэрлэлтийн орыг бузарлаж, биднийг жинхэнэ дотнослоос салгадаг. Түүнчлэн гэрлэлтийнхээ орыг ханийнхаа ашиг сонирхлын төлөө үйлчилдэг газар гэж үзэх нь гэрлэлтийнхээ орыг хүндэтгэх явдал юм. Ханьдаа бэлгийн харилцаагаар үйлчилнэ гэдэг нь тэдний хэрэгцээг Бурханы ариун байдал дотор хүндэтгэнэ гэсэн үг.

Заримдаа бид өөрсдөө унтмааргүй байсан ч, унтаж ханьдаа үйлчилдэг. Нас ахих тусам хүний бэлгийн дур хүсэл багасдаг. Та бэлгийн харилцаанд гагцхүү махан биеийн хувьд татагдахыг чинь батлах таталцаа шиг хандахаа больж, энэ нь зүгээр нэг дотно таталцлаас илүү том зүйл болно. Бурхан эхнэр нөхрийг бие биетэй нь холбохын тулд сексийг бүтээсэн учраас айдсаасаа болж энэ холбооны аз жаргалыг бүү үгүй хий.

Бид хоёр гэрлэлтийнхээ орыг хүндэтгэлийн газар болгосон учраас, тавин насны маань бэлгийн амьдрал хорин настай байснаас маань хавьгүй сайхан байдаг (хэдийгээр бид хоёр хорин настайдаа одоогийнхоосоо хавьгүй дээр харагддаг байсан ч). Сайхан бэлгийн ажил нь гоо үзэсгэлэнтэй байх юмуу бэлгийн ажилдаа сайн байхтай ямар ч хамаагүй. Хамаг учир нь та хоёр хамтдаа хэн бэ гэдэгт л бий.

Бид бэлгийн харилцаанд орохдоо, гуч гаруй жил ханилсанаа тэмдэглэн баярладаг. Бидний баяр хөөр, зовиур, зөрчил, ялалт нь бидний дотносолд үнэ цэнэ нэмдэг. Бидний сүнс, сэтгэл мэдрэмж, бие махбодын дотносол нь бурханлаг таашаал ба ханамжийн оргилд хүрдэг. Бид гэрлэлтдээ байгуулсан бэлгийн соёлоороо Бурханы авралын хүчийг гэрчилдэг.

Лизагийн түүх

Жон бид хоёр гэрлэлтийнхээ амьдралд өөр өөр хэлбэрээр сексийн нүгэл, сүйрэл авчирсан юм. Жон өөрийн гэсэн тулаанаа хийж байхад, би өөрийнхөө үхэл амьдралын төлөөх дайнаа хийж байлаа. Коллежийн арван есхөн настай оюутан байхдаа гаргасан, гэмгүй цайлган гэмээр сексийн сонголт нь хорин хоёр насандаа хүний эхнэр болоход эрх чөлөөг минь боомилохоор дахин гарч ирнэ гэж яахан санах билээ?

Аав, ээж минь надад анх сексийн талаар ярихдаа, энэ нь гэрлэлтэд зориулагдсан зүйл гэдгийг хэлсэн атлаа яагаад гэдгийг нь хэлээгүй юм. Миний санаж байгаагаар, гэрлээгүй байж жирэмслэх юмуу эсвэл бэлгийн замын халдварт өвчин авчих вий л гэж зовнисон байх.

Аав, ээж хоёрын маань гэрлэлт маш хэврэг байсан бөгөөд тэдний ярьдаг болон хийдэг зүйлс нь газар тэнгэр шиг л ялгаатай байв. Тухайлбал манай эмээ, аав хоёр маш олон хүнтэй явалддаг байлаа. Тэдэнд ариун байх талаар ямар ч ойлголт байгаагүй. Гол нь хариуцлагатай бөгөөд баригдахгүй л байвал, хүссэнээ хийж болох аж.

Ийм ойлголт дор хүмүүжсэн миний бие коллежд ороод ингэж шийдэв: би зөвхөн хайртай хүнтэйгээ л унтаж, бэлгийн үүрэг хариуцлагаа үүрнэ. “Үүрэг хариуцлагад” маань жирэмслэлт зохицуулах эм багтана. Заримдаа би зарим нэг хариуцлагагүй эгч дүүстээ эм бичүүлэхийн тулд эмч дээрээ дагуулж авчирдаг байлаа.

Тэгээд би Жонтой учирсан бөгөөд Жон намайг анхныхаа болзоон дээр л Эзэн рүү дагуулав. Би ганцхан шөнийн дотор дахин төрж, эдгэрч, Ариун Сүнсээр дүүрсэн, хорин нэгхэн настай охин болов. Тэгээд яриан дээрээ би Жонд хачин инээдтэй зүйл хэлчихэв. Би: “Би өөрийгөө ёс суртахуунтай хүн гэдэгтээ баяртай байна” гээд хэлчихсэн юм.

Би яагаад тийм тэнэг зүйл хэлсэнээ мэдэхгүй. Мэдээж би ёс суртахуунтай бөгөөд ариун гэдгийн ялгааг мэдэхгүй байсан. Хайртай хүнтэйгээ унтахыг би ёс суртахуунтайд тооцож байсныг

минь санаарай. Дахин төрөөд хэдхэн цаг болж байсан миний тархи шинэчлэгдэх өдий байжээ.

Хожим би Жонтой “жинхэнээсээ” болж эхлэхдээ, Жон миний хэлсэн үгийг маргаасай гэж үнэн голоосоо хүсч байлаа. Тэгтэл Жон “бид хоёр биеэ ариунаар хадгалсан нь яасан сайн хэрэг вэ!” гэж хэлэх үед хамаг бие арзайгаад л явчихав.

Тэгээд Жон миний гарыг гуйх тэр өдөр би Жонд үнэнийг хэлэх хэрэгтэй гэдгээ ухаарсан юм.

Би Жонтой суухад зохисгүй юм шиг, Бурханд хайртай, намайг хайрладаг хүнтэй амьдралаа зохиох нандин боломжийг алдсан юм шиг л санагдаж байлаа. Би гадуур алхаж явахдаа, Бурхан руу хашхирч байлаа. Би уучлагдсан гэдгээ мэдсэн ч, бэлгийн сонголтынхоо үр дагавартаа харамсаад барахгүй байлаа.

Би Жонтой ярилцахаар тэднийд очив. Гэхдээ намайг ичгүүрт нууцаа дэлгэхээс өмнө Жон надад “Би чамд нэгэн бичээс уншиж өгөх гэсэн юм. Чамтай хуваалцах хэрэгтэй юм шиг байна” гэлээ.

Толгой дохитол Жон уншив: “Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна” (2 Коринт 5:17).

“Энэ жаахан хачин сонсдож байгаа хэдий ч, Бурхан чамд өнгөрсөн зүйлс өнгөрсөн. Өдгөө чи яг л онгон эмэгтэй шиг цоо шинэ болсон” гэж Жон хэлэв.

Би бөөлжмөөр болов: “Би онгон биш. Би үүнийг л чамд хэлэх гэсэн юм.”

Гэтэл Жон миний мөрөөс атгаж, нүд рүү хараад: “Бурхан чамайг онгон гэж хэлж байгаа бол, бид Түүнтэй маргах хэн билээ?” гэлээ. Тэр эгшинд миний бүх ичгүүр угаагдсан юм.

Сүйрсэн сексийн амьдралаа сэргээн босгох

Гэхдээ л би хайраас болж биш, тачаалаас болж л бэлгийн харилцаанд орсон байв. Би хүнтэй гэрлэхдээ хайрыг хүсч байсан ч, яаж хайрлаж, хайрлуулахаа мэдэхгүй байлаа. Би сексийг хориотой, буруу, маш муухай зүйл гэж үзэж байв. Гэтэл гэрлэсний дараа секс нь гэнэт л бурханлаг, баяртай, сайн сайхан зүйл болж

хувирав. Энэ шилжилтийг хэрхэн хийхээ би мэдэхгүй байлаа.

Жон бид хоёр хоёулханаа байх үед надад гэнэт л таван жилийн өмнө коллежд байхдаа үзэж байсан томчуудын киноны дур гутам, аймшигт кадрууд харван орж ирнэ. Эсвэл би өнгөрсөн бэлгийн харилцааныхаа ичгүүрт автдаг байлаа. Үнэхээр муухай байв.

Би эр нөхөртэйгээ эрх чөлөөтэй байх ёстой атал, өнгөрсөн амьдралынхаа хар дарсан зүүдэнд автдаг байсан юм. Би Жонд өөрийгөө бүхлээр нь өгөх ёстой байтал өнгөрсөн амьдралынхаа хүчирхийллээс болоод надад сексийн эрх чөлөө гэж байсангүй. Би бохир бодол, дүр зураг, харьцуулалт, ичгүүртэйгээ тэмцэж байлаа. Гэхдээ тэмцэж байсан ч, ямар ч тусгүй мэт байв. Тэгээд амьдралынхаа яг энэ улиралд би удам дамжсан хараал, сүнсний гинжин холбоог таслахыг сурсан юм.

Би өмнө гэр бүлийн хараалын талаар, манай удамд байсан ёс суртахуунгүй, итгэмжгүй явдлын талаар ярьсан билээ. Би үүнийг хүчингүй болгож, таслах ёстой байлаа. Гэхдээ би сексийн амьдралаа бүрэн сэргээн босгохын тулд бас өөрийн биеэр тогтоосон янз бүрийн харилцаагаа таслаж, хүчингүй болгох хэрэгтэй байлаа. Энэ талаар хэлсэн Бичээсийг үзье:

Та нарын биес Христийн эрхтнүүд гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгвэл би Христийн эрхтнүүдийг авч, тэдгээрийг янхны эрхтнүүд болгох уу? Огт үгүй. Янхантай нийлсэн хүн түүнтэй нэг бие болно гэдгийг та нар мэдэхгүй юу? Учир нь Тэр “Хоёр нь нэг махан бие болно” гэж айлддаг. (1Коринт 6:15-16)

Би өмнөх найз залуусаа янхан гэж хэлээгүй ч, зарчим нь адилхан юм. Би тэдэнтэй байсан атлаа одоо өөр хүнтэй гэрээ байгуулсан. Янз бүрийн залуутай нийлж салах бүрт миний сүнс тасарсаар, эцэстээ миний сексийн амьдрал сэг болжээ. Бэлгийн амьдрал нь сэг болсон хүн бүрэн бүтэн биш учраас, өөрийгөө хань ижилдээ бүхлээр нь зориулж чаддаггүй.

Цэвэр амьдралаар алхаж, дотнослын баяр хөөрийг эдлэхийн тулд бид бүрэн бүтэн байх ёстой агаад эвдэрсэн хэсгийг маань зөвхөн Бурхан л бүрэн бүтэн болгож эдгээж чадна. Хүчирхийлэгдэж, доромжлуулсан бидний бэлгийн амьдралд

гагцхүү Бурхан л хүндэтгэлийг буцааж чадна. Гагцхүү Бурхан л цэвэр бус, бузарлагдсан зүйлийг аваад, дахин цэвэр, ариун болгож чадна. Гагцхүү Бурхан л Өөр дээр нь авчирсан үнс нурмыг гоо үзэсгэлэн болгон хувиргаж чадна.

Хэрэв таны бэлгийн амьдрал өнгөрсөн ёс бус явдлаас (замбараагүй явдал, порнограф, гар хангалга зэрэг бүх төрлийн ёс бус явдлаас) болж сүйрсэн бол, бид таныг дахин сэргээн босгох залбиралд цаг гаргахыг урьж байна. Залбирахаасаа өмнө өөрийгөө сүнсээр бэлтгэж, зөвхөн хань ижилтэйгээ юмуу дотны найз, залбирлын хамтрагчтайгаа юмуу эсвэл зөвхөн Бурханы Сүнсний оршихуйд чангаар залбирна уу:

Тэнгэрлэг Аав минь ээ,

Миний нүглийн шийтгэлийн төлөө Хүүгээ илгээсэнд баярлалаа. Учир нь би Христийн дотор байгаа бөгөөд хуучин зүйлс миний амьдралаас өнгөрч, бүх зүйл шинэ болжээ. 2Коринт 5:21-р ишлэлийн дагуу, намайг зөвтгөхийн тулд Есүс миний нүглийг авчээ. Тиймээс л би өнөөдөр энд байна.

Одоо би өөрийнхөө болон эцэг өвгийнхөө бэлгийн бүх нүгэл, бохир байдал, завхрал, замбараагүй байдлыг мэдэгдэн, хүчингүй болгож байна (хүчингүй болгож байгаа бүх нүглээ Бурханы өмнө ичэж зоволгүй, нарийн няхуур нэг бүрчлэн нэрлээрэй. Бурханаас нууц зүйл гэж байхгүй. Бурхан тэдгээрийг хэдийнээ мэдэж байгаа бөгөөд тэр ичгүүр, дарамтыг танаас зайлуулахыг хүсч байгаа. Тэгээд бэлэн болсон бол эхлээрэй).

Аав аа, Сүнснийхээ сэлмийг далайж, ... (Ариун Сүнсийг сонсож, сонссон нэр бүрээ чангаар хэл) бид хоёрын хоорондох бурханлаг бус, бэлгийн холбоог тас татаарай. Магадгүй тэр дунд та бодитоор бэлгийн харилцаанд ороогүй боловч, сэтгэл санаагаар эсвэл бодол

төсөөллөөрөө бэлгийн харилцаанд орсон хүмүүсийн нэрс ч байж мэднэ.

Тэр хүмүүсийн нэрийг нэг бүрчлэн хэлсэнийхээ дараа ийнхүү залбирна уу:

Аав аа, тэдгээр хүмүүст таслаж өгсөн миний сүнсний хэсэг бүрийг буцааж авчрахаар тэнгэрэлч нараа явуулаач. Намайг дахин бүрэн бүтэн, ариун, Таны таалал руу тусгаарлагдсан болгохын тулд сүнсийг минь Ариун Сүнсээрээ бүрэн бүтэн болгооч.

Аав аа, би дотроо байгаа аливаа нэг завхарсан дүр төрхийг хүчингүй болгож байна. Намайг тийм завхарсан юм үзсэнд уучлаарай. Дуулал 101:3-р ишлэлийн дагуу, нүдтэйгээ гэрээ байгуулж, сахихад минь туслаач. Би дахиж нүдээрээ бузар муу зүйл үзэхгүй. Би энэ цэвэр бус сүнсийг болон үүний нөлөөг хүчингүй болгож, миний амьдралаас зайлахыг тушааж байна.

Аав аа, намайг Есүсийн ариусгагч цусанд угаагаач. Намайг цэвэрлэж, худалдаж авах хүч Есүсийн цусанд л бий. Би өөрийгөө Таны сүм болгон ариулъя. Ариун Сүнсний хүчээр миний сүнс, сэтгэл, биеийн бүх бохирыг цэвэрлээч. Ариун Сүнсээрээ намайг дүүргээч. Таны надад зориулсан бүхнийг харах нүд, сонсох чих, хүлээж авах зүрхийг өгөөч. Би Таных. Амьдралд минь Өөрийнхөөрөө үйлдээч.

Хайртай хүү чинь.

Гуравдугаар өдөр

Жоны түүх

Хэдийгээр би биеэ гэргийдээ хадгалж байсан ч, порнограф болон гар хангалгад донтсон байлаа. Тэгээд энэ донгоо гэрлэлтийнхээ амьдралд дүүрч орохдоо, үзэсгэлэнтэй эхнэртэйгээ бэлгийн харилцаанд орохоор миний бохир байдал эдгэрнэ гэж найдав. Гэтэл тийм зүйл болсонгүй. Би хурим хийснээсээ хойш энэ тачаалтайгаа хэдэн жил тэмцэв. Миний донтолт бидний бэлгийн амьдрал маш том тотгор болж байлаа. Би ичгүүрт идэгдэж, самуурч гүйцэв. Би тачаалд хүлэгдэхийг хүсээгүй боловч, хичнээн хичээсэн ч, чөлөөлөгдөж чадахгүй байлаа. Надад өөрчлөлт хэрэгтэй байлаа.

1984 онд би манай чуулганд ирсэн зочин номлогчдод унаагаар үйлчилдэг байсан юм. Тэгээд нэг удаа би гүнээ хүндэтгэж явдаг Бурханы нэгэн хүнд зөрчлөө илчлэв. Тэрбээр чөлөөлөх үйлчлэлээрээ алдартай хүн байсан юм. Надад түүнээс өөр хэн ч туслаж чадахгүй гэж бодсон учраас, би түүнд нууцаа уудлав.

Гэтэл тэр надад: “Жон, зүгээр л боль!” гэж хэлсэн нь намайг зог тусгав.

- “За, гэхдээ та миний төлөө залбирч өгөөч!”

Тэр залбирсан боловч, юу ч болсонгүй. Тиймээс би: “Магадгүй надад арай хүчтэй бэлэгтэй хүн хэрэгтэй юм шиг байна” гэж бодсон ч, чөлөөлөх үйлчлэлээрээ тэр хүнтэй эгнэх хүн үнэндээ санаанд орохгүй байлаа. Би ч “Нэг насаараа энэ нүгэлд дарлуулах нь дээ” гэж бодлоо.

Есөн сарын дараа манай нэг найз надад дөрвөн өдөр байшиндаа байхыг зөвшөөрсөн бөгөөд тэнд би донтойгоо халз тулж: “Бурхан минь, боллоо! Энэ бүхэн дуусах ёстой!” гэж хэлсэн юм. Тэгээд 1985 оны 5-р сарын 6-ны тэр өдөр би гайхамшигтайгаар бүрэн чөлөөлөгдөв.

Түүнээс хойш хэдэн сарын дараа би Бурханаас: “Ойлгохгүй байна. Бияагаад тэр мундаг хүнээр залбируулахдаа чөлөөлөгдөөгүй юм бэ? Би тэр аугаа бурханлаг хүнд өөрийгөө даруугаар илчилсэн шүү дээ. Яагаад ингэж их удаж байж, чөлөөлөгдөж байгаа юм бэ?” гэж асуусан юм.

Бурхан тэр даруй миний анхаарлыг залбирлын минь амьдралд гарсан өөрчлөлт рүү хандуулав. Би өмнө нь дандаа: “Бурхан минь, намайг хэрэглээч, намайг хэрэглээч” гэж залбирдаг байв. Өөрөөр хэлбэл миний залбирлын төвд би өөрөө заларч байжээ. Миний залбирал тэр чигээрээ миний сайн сайхан, миний дуудлагыг тойрон эргэлдэж байв. Би тачаалаас л чөлөөлөгдөхийг хүссэн болохоос биш, Бурханыг хайрлах, тэр бүү хэл Лизаг хайрлах талаар огт бодохгүй явжээ. Энэ донгоос болж хувь заяагаа алдчих вий гэдгээс өөр айх юм надад байсангүй. Хар амиа хичээсэн энэ байдлаасаа болж би Бурхантай дотно байж чадаагүй бөгөөд дотно байдал үгүй учраас би Түүний өөрчлөгч хүчийг мэдэрч чадаагүй юмсанж.

Тэгтэл миний зүрх сэтгэл өөрчлөгдөж, залбирлын маань үндэс “Бурхан минь, би Таныг мэдэхийг хүсч байна. Бидний хооронд юу ч бүү байг” болж өөрчлөгджээ. Би амиа хичээсэн хүнээс Бурхан дээр төвлөрсөн хүн болж хувирав. Би харцаа өөрөөсөө холдуулж, Бурхан дээр тавихдаа, амьдралаа Түүний нигүүлсэлд нээж өгчээ. Тэрбээр намайг чөлөөлж, миний бэлгийн амьдралыг бүрэн бүтэн болгож өгсөн юм. Би Бичээсийн бурханлаг гашуудлаар гашууджээ.

Бурханлаг гашуудал

Бурханы хүслийн дагуух гашуудал нь үл харамсах гэмшлийг бий болгон авралд хүргэдэг аж. Харин ертөнцийн гашуудал нь үхлийг бий болгодог. (2Коринт 7:10)

Би донтолтоосоо болж маш олон жил гашуудсан юм. Би хийж буй зүйлдээ ой гутаж, тачаалаас чөлөөлөгдөхийг хүссэн гэдгээ өмнө хэлсэн. Олон хүн нүглээсээ болж гашууддаг. Гэхдээ зөвхөн бурханлаг гашуудал л гэмшил ба өөрчлөлт рүү хөтөлдөг бол, дэлхийн гашуудал ямар ч өөрчлөлт дагуулахгүй, зөвхөн ял мэдрүүлдэг юм.

Дэлхийн гашуудал нь өөр дээрээ төвлөрдөг бөгөөд бардамналаар сагадаг. Дэлхийн гашуудал нь хүний хязгаарт баригдсан шийдэл л хардаг учраас цөхрөл ба өөрийгөө үзэн

ядах мэдрэмжээр дүүрдэг. Энэ нь Бурханы хүчийг мэдэх мэдлэгт орших найдварыг харах нүдгүй бөгөөд зайлшгүй сүнсний үхэлд хүргэнэ.

Нөгөөтэйгүүр бурханлаг гашуудал нь өөрийгөө жигшдэг ч үгүй, өөр дээрээ төвлөрдөг ч үгүй, энэ нь гагцхүү Бурхан дээр төвлөрдөг. Хэдийгээр зовиуртай байдаг ч, бурханлаг гашуудал нь ирээдүйг харах найдвар тээдэг. Учир нь бурханлаг гашуудлын хүч нь Бурханы ариулах болон аврах чадварт буй. Бурханлаг гашуудал хүчтэй хатгадаг ч, дараа нь амь бөгөөд баяр хөөр ирдэг.

Дэлхийн гашуудал болон ял нь миний амьдрал дахь тачаалын атгыг улам л чангалсан юм. Бурхан минь намайг хэрэглээрэй хэмээн залбирч байхдаа би, өөрийгөө ихэд бурханлаг зан чанар гаргаж байна гэж бодож байсан ч, үнэндээ бардам л байжээ. Эрх чөлөөг хүссэн маань гагцхүү өөрийнхөө ашиг сонирхлын төлөө л байв. Би Бурханы элгийг эмтэлж байгаагаа ерөөсөө бодохгүй байлаа.

Олон хүн гэм нүглээсээ болж амьдралаа сүйд хийж, харуусч, ирээдүйн амжилтаа баллаж, эцэстээ яллагдах вий гэсэндээ л эрх чөлөөг хүсдэг. Энэхүү өөрийгөө хамгаалсан айдастай байр суурь нь хэзээ ч өөрчлөх хүчийг авчрахгүй.

Бид Бурханы зүрхийг хуваалцахгүйгээр Түүнтэй адилхан болохгүй. Түүнтэй тогтоох дотносол нь ямагт өөрчлөлтийн өмнө орно. Бид Бурхантай хамт байснаараа нүглээс эрх чөлөөтэй байх эрх чөлөөг олж авдаг. Бид даруухнаар Бурхан руу ойртох тусам, Тэрбээр бидэнд Өөрийгөө илчилж, биднийг ариун байлгахаар хүчирхэгжүүлдэг.

Гэвч Тэр илүү их нигүүлсэлийг өгдөг. Тиймээс л “Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, харин даруу хүнд нигүүлсэл өгдөг” гэдэг. Тиймээс Бурханд захирагдагтун. Дяволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна. Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт хүмүүс та нар гараа цэвэрлэ. Хоёр санаатай хүмүүс та нар зүрхээ ариусга. Шанал, гашууд, уйл. Инээд чинь гашуудал болог. Баяр хөөр чинь уйтгар гуниг болог. Эзэний оршихуйд

өөрсдийгөө даруу болго. Тэгвэл Тэр та нарыг өргөмжлөх болно. (Иаков 4:6-10)

Бурхан биднийг нүгэлт мөн чанарын хавх, шуналаас чөлөөлсөнөөрөө өргөмжилдөг. Тэр биднийг чөлөөлөхийн тулд чөлөөлдөг. Гэхдээ бид Чөлөөлөгчийг таньж мэдэхээс нааш чөлөөлөгдөхгүй. Чөлөөлөлтийг хүсч байгаа бол, Бурханы зүрхийг мөшги. Энэ ойр байдал нь таныг Түүний замаас гажих бүрийд гүн гүнзгий бурханлаг гашуудлаар дүүргэнэ. Үүний үр дүнд та Бурхантай улам дотно харилцаж, эрх чөлөөтэй алхах хүчтэй болно.

Та Бурханы хүүхэд мөн бөгөөд танд ял байхгүй гэдгийг санаарай. Хэрэв та эрх чөлөөтэй болно гэдэгтээ эргэлзэж байгаа бол, өөрийнхөө чадварт суурьшихыг бүү зөвшөөр. Өөрийнхөө алдааны үр дагавараас бүү ай. Харин ч Бурханы аугаа байдал, Түүний өршөөлийн аврах хүчийг бод.

Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ. (Ром 8:1-2)

Порно ба дотносол

Жон миний бие гэрлэсний дараа донтолт арилна хэмээн гэнэхнээр итгэж явсан ч, харин ч эсрэг нь үнэн болж таарсан юм. Порно нь зөвхөн ганц бие хүнийг биш, гэр бүлтэй эрэгтэй, эмэгтэй хүнийг олзолдгийг олон хос мэдэж байгаа. Порно нь хосод жинхэнэ дотнослыг эдлүүлэхгүй, гэрлэлтийг маш хүчтэй шархлуулдаг.

Бүр бэлгийн амьдралаа сэргээхийн тулд хамтдаа порно үздэг итгэгчдийн талаар Христчин зөвлөхүүдээс сонсдог нь даанч харамсалтай. Энэ нь мөхөлд хүргэдэг алдаа юм. Ийм зүйл бүү хий. Та хоёр тун удахгүй жинхэнэ дотнослыг чинь тачаалын галаар залгих унтаж байгаа лууг сэрээнэ. Үхэгсдийн орон ба Сүйрэл хэзээ ч цаддаггүй шиг хүмүүний нүд хэзээ ч ханахгүй. (Сургаалт үгс 27:20). Порно нь гэрлэлтийн амьдралд ноцтой аюул

занал болдог. Бид хамтдаа ч, ганцаараа ч бусдын ичгүүрийг харах ёсгүй.

Порно нь махан биеийн хүсэлд маань нийцдэг учраас түр хугацааны сэрэл, ханамж өгдөг ч, хань ижилтэйгээ болон Бурхантай дотно байх чадварыг маань хэмлэж иддэг. Тэгээд эцэстээ бид хань ижилдээ ч, өөртөө ч сэтгэл гонсгор үлдэнэ. Порно нь сексийн туршилтыг сэргээж болох ч, харилцааны асуудлыг шийдэхгүй. Түргэн засвар нь хэдийнээ ганхаад эхэлчихсэн суурь дээр улам л жин дарна. Порно нь амийг асааж буй мэт харагдавч, энэ нь эргэлзээ, үл итгэлцэл, аюултай байдлыг тэслэх үхлийн тэслэгчийг асааж байгаа юм.

Хүн амьдралаа зориулсан нэгэндээ өөрийгөө бүрэн өгсөнөөрөө л сексийн таашаал хүлээж авдаг байх зохицолдоог Бурхан бүтээсэн юм. Дотносол нь гэрлэлтийн орноос хавьгүй гүн гүнзгий утгатай бөгөөд гэрлэлтийн харилцааг бүхлээр нь дэмждэгийг үүнээс бид харж болно. Гэтэл порнод дурлах нь доторх ташаалтайгаа хөөцөлдөх явдал юм. Энэ нь дотнослыг шаардахгүй, зүгээр татагдах объектыг л шаардана. Порногийн таашаал нь Бурханаар урлагдсан дотнослыг эдлэх сэргээшийн түр зуурын сүүдэр юм.

Хос нэгдэл дундаа порно оруулах үедээ дотносолдоо бусдыг оролцуулж, гэрлэлтээ бохирлодог. Бурхан үүнийг төлөвлөөгүй. Бэлгийн ажил нь хоёр амийг холбосон гэрээний сануулга болох ёстой бөгөөд гэрлэлтийн гэрээ нь гуравдагч этгээдэд зориулагдаагүй юм. Хоёр хүнд зориулагдсан ариун нандин зүйл нь олон хүний дунд бохирлогдоно. Бурхан биднийг гэрлэлтийнхээ орыг болон үүний төлөөлдөг гэрээг хүндэтгээсэй гэж хүсдэг. Учир нь Бурхан үүнийг гайхамшигтай таашаал, урт настай ханамжийн газар байгаасай гэж хүсдэг.

Дөрөвдүгээр өдөр

Зүрхээ хамгаалах

Саяхан хүртэл порно нь хамгийн дуртай цахим “жуулчлалын” газар байжээ. Арван цахим хуудас тутмын нэгээс олон нь порно

агууламжтай байна. Дочин сая Америкчууд эдгээр хуудаст зочилж, секунд тутам 28,258 интернет хэрэглэгч порно үздэг гэнэ. Сексийн дур ингэтлээ хөгжиж, хуйлруулсан үе бараг байгаагүй байх. Ийм хуурамч сэргээш газар авсаны улмаас бэлгийн харилцаа нь тачаалаар орлуулагджээ. Кибер - секс нь дотнослыг устгаж, гэрлэлтийг сүйтгэж байна. Тэр бүү хэл залуус ч интернет порнод донтсон учраас бэлгийн дур хүсэл нь доголджээ. Тэдний байнгын хийсвэр үйлдэл нь жинхэнэ махан биеийн бодит туршлагаас анги байдаг тул бодитой эмэгтэйчүүд тэдний дур хүслийг хангахаа больдог.

Энэ нь гэхдээ дан эрчүүдийн асуудал биш юм. Таван эмэгтэйн нэг нь долоо хоног тутам онлайнээр порно үздэг. Сэтгүүл, эротик ном зохиолоор донтолтоо хангах явдал нь сүүлийн үед нэн ялангуяа эмэгтэйчүүдийн дунд газар авч байна.

Порно болон бүх төрлийн сексийн нүгэл нь Бурханы анхдагч төлөвлөгөөнөөс гадуур нэмэлт таашаал санал болгодог. Гэхдээ дэлгэцийн өмнө зөвхөн тархинд өрнөж буй хууль бус зан үйлдэл нь таашаалын завхралаас хамаагүй гүн гүнзгий үр дагавартай юм. Есүс “Харин Би та нарт хэлье, эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм” (Матай 5:28) гэж айлдсан.

Бүх нүгэл нь эцэстээ бидний амь руу довтолдог. Бид Христэд итгэдэг, харин дайсан бидний сүнсний төлөөх тулаанд ялагдсан учраас л бидний сэтгэл рүү тийнхүү үхэн хатан дайрдаг. Дайсан биднийг нүглийн үр дагавартаа живээсэй гэж хүсдэг. Дайсан биднийг амьдралаа бүрэн дүүрэн амьдраасай гэж хүсдэггүй (Иохан 10:10-г үзнэ үү).

Христ биднийг нүглээс чөлөөлсөн ч, бид нүгэлд амьдралаа захируулбал тэр эрх чөлөөг эдлэж чадахгүй. Иймээс л Паул ингэж бичжээ:

Тиймээс биеийнхээ тачаангуй хүслүүдэд дуулгавартай байх ёстой хэмээдэг үхлийн биед чинь нүгэл бүү ноёрхог. Биеийнхээ эрхтнүүдийг зөвт бус байдлын зэвсэг болгон нүгэлд бүү өргө. Харин Бурханд өөрсдийгөө үхэгсдээс амьд болгогсод мэт,

мөн биеийнхээ эрхтнүүдийг зөвт байдлын зэвсэг болгон Бурханд өргө. (Ром 6:12-13)

Бүхэл биед секс ч багтана. Бид өөрийгөө Бурханд бүрэн өргөж, Түүний Сүнсэнд өөрийнхөө сексийн сонголтыг олгохдоо, Бурханыг алдаршуулдаг. Биднийг хүлж, Бурханы бидэнд өгөхийг хүссэн бүхнийг хулгайлдаг бүхнээс Бурхан биднийг чөлөөлнө. Бурхан биднийг эрх чөлөө, дотносол, таашаал авчирдаг сексийн илэрхийлэл рүү хөтөлнө.

Бэлгийн зуршсан нүглийн дарлалаас чөлөөлөгдөх амархан гэж хэлээгүй байна. Паул “Иймээс хайрт хүмүүс минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад бүр ч илүү өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр биелүүлэгтүн” гэж хэлсэн (Филиппой 2:12). Хэдийгээр ариусгал нь Бурханы нигүүлслийн ажил боловч, махан биеийг цовдлох нь зовиуртай үйл явц юм. Гэхдээ хэрэв бид Сүнсэнд бидэн доторх ариусгалын ажлыг хийхийг зөвшөөрбөл, бид зөрчлийн зовиураас хол давсан сүнсний баяр хөөрт орно.

Ариун байдлын төлөөх алсын хараа

Би бурханлаг хардалтаар та нарыг хардаж байна. Учир нь би та нарыг ариун онгон охин мэт Христийн өмнө аваачихаар ганц нөхөртэй сүй тавиулсан. Гэвч могой залиараа Еваг мэхэлсэн шигээ Христ уруу хандсан [цэвэр,] энгийн байдлаас та нарын санаа бодлуудыг төөрүүлчих вий гэхээс би айж байна. (2Коринт 11:2-3)

Гэрлэлт дэхь ариун байдал нь биднээс хавьгүй том зүйл юм. Энэ нь цэвэр сүйт бүсгүйн төлөөх Христийн алсын хараа юм.

Яг одоогоор Чуулган дотор тачаал дэгдэж байна. Саяхны судалгаа Христчин эрчүүдийн тавин хувь, Христчин эмэгтэйчүүдийн хорин хувь нь порнод донтсон гэдгийг харуулжээ. Энэ асуудалтай тэмцэж, бэлгийн донгоо багасгахын тулд маш олон эрэгтэй, эмэгтэй хүн үүрэг хариуцлагын тогтолцоо гэдэг

арга барил руу шилжжээ. Хэдийгээр энэ нь өөрчлөлтийн төлөөх маш үнэ цэнэтэй тэмдэг бөгөөд чухал боловч, энэ нүглийг дан ганц үүрэг хариуцлага ба сахилга батаар ялахгүй. Үнэндээ сексийн ёс бус зүйлд хутгалдахаар нэгэнт шийдчихсэн хүнийг юу ч зогсоож дийлэхгүй. Гаднах зан үйлдэл нь хэсэгтээ хяналттай боловч, дотоод амьдрал нь тачаал бас ялаар удирдуулсаар л байна.

Оюун санаа маань л шинэчлэгдэж байж л бидний зан үйлдлийн үлгэр загвар жинхэнээсээ өөрчлөгдөнө. “Зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж Бурханы хүсэл юу болохыг, тухайлбал сайн, тааламжит, төгс төгөлдөр хүслийг баглагтун” (Ром 12:2). Бурханы хүүхдүүд бид нүглийн хүчнээс эрх чөлөөтэй (Ром 6:19-23). Гэхдээ энэ эрх чөлөөг эдлэхийн тулд бид зан үйлдлээ ариусгаж, оюун санааг маань ариусгахыг Бурханд зөвшөөрөх ёстой.

Бид Бурханы Үгт болон оршихуйд цаг өнгөрөөхөд бидний сэтгэлгээ шинэчлэгддэг. Өөр зам байхгүй. Ариун Сүнс зүрхэнд маань Бурханы үгийг суулгаж, нүглээс чөлөөлөгдөх эрх чөлөөг өгнө (Дуулал 119:11, Иаков 1:21-г үзнэ үү). Олон итгэгч сексийн ичгүүртээ гашууддаг ч, ичгүүрээ биднийг чөлөөлдөг Нэгэний өмнө авчирдаггүй.

Маш олон шашны институци ёс бус байдлыг засахын тулд айлган сүрдүүлэх механизмыг хэрэгжүүлэх гэж оролддог ч бүтэлгүйтдэг. Ийм хүчин зүтгэл нь бүтээгүй бөгөөд хоёр нүүртэй байдал руу хөтөлж, нүглийн арга замыг улам л нарийсгадаг. Ичгүүрээс болж сүүдрийн хэлбэрт шилжсэн нүгэл нь тэндээ улам гаарна.

Шашны хууль, хүний бүтээсэн дүрэм журам нь биднийг нүглээс чөлөөлөхгүй. Үнэндээ хууль дүрэм нь нүгэлд харин ч сайн хөрс болдог (Ром 7, 2Коринт 3:6-р ишлэлийг үзнэ үү). Бурхан биднийг дүрэм журамд дурлаасай гэж хүсдэггүй. Тэрбээр биднийг Өөрийгөө хайрлаасай гэж хүсдэг. Бид Аавынхаа хайраар төгс болж, Түүнтэй тогтоох харилцаагаар бүрэн бүтэн болдог.

Нүглүүдийг зайлуулахын тулд Тэр үзэгдсэн гэдгийг та нар мэднэ. Түүнд ямар ч нүгэл байхгүй. Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй. (1Иохан 3:5-6)

Мэдээгүй хэмээн орчуулсан ginosko хэмээх Грек үг нь “хүнийг хувьчлан таньж мэдэхийг буюу байнгын тогтмол харилцааг” хэлнэ. Нүгэлт мөн чанараас сул байх эрх чөлөө нь Бурхантай тогтоох хувийн харилцаанд оршихоос биш, Бурханы талаар хэн нэгнээр дамжуулж мэдэхэд оршихгүй.

Христэй хувийн харилцаа тогтоогоогүй хүн л нүгэлд донтдогийг элч Иохан Ариун Сүнсээр хэлжээ. Тиймээс гэрлэлтийнхээ дотно байдлыг аюул заналаас хамгаалахын тулд Эзэнтэй дотно байх ёстой.

Хэрэв нүгэл амьдралыг чинь хянаж байвал, Бурхан руу гүй. Бурханы хайр, нигүүлслийг биеэр мэдсэн хүн л нүглээс эрх чөлөөтэй байна. Хэрэв та даруухнаар Бурхан руу эргэбэл, Бурхан оюун санааг чинь шинэчилж, Христ доторх эрх чөлөөний мэдлэгт саад хийх хөшгийг зайлуулна.

Гэвч хүн Эзэнд хандаж эргэх бүрд бүтээлэг авагддаг. Эзэн бол Сүнс мөн. Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг. Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээр Эзэний алдрын тусгалыг хардаг. Бид энэхүү Түүний дүрд алдраас алдарт өөрчлөгддөг. Энэ нь Эзэний Сүнсээр болдог. (2Коринт 3:16-18)

Бурхан биднийг сексийн нүгэлтэй тэмцээсэй гэж хүсдэггүй. Бурхан биднийг бүрэн бүтэн, ариун амьдраасай гэж хүсдэг. Таны Бурханыг хайрлах хайр өсөхөд, амьдрал чинь шинэчлэгдсэн үзэл бодол, Түүнийг хүндэтгэх хүслээр дүүрнэ. Та Бурханы хүсэл, арга замд захирагдахдаа, Есүс шиг хүчтэй амьдрахын хүчийг үзнэ. Паул Филиппой хотын итгэгчдийн төлөө залбирсан шиг бид ч бас таны төлөө залбиръя:

Та нарын хайр жинхэнэ мэдлэг ба бүх ойлгоцоор улам бүр бялхсаар байх болтугай гэж би залбирдаг. Ингэснээр та нар Христийн өдрийг хүртэл цэвэр, гэм зэмгүй байхын тулд аль нь сайн болохыг ялгах чадвартай болох юм. Ингэхдээ Бурханы магтаал болоод алдрын төлөө Есүс Христээр ирэх зөвт байдлын үр жимсээр дүүрэн байгтун.

(Филиппой 1:9-11)

Бид бэлгийн амьдралдаа Христэд таалагдах сэтгэлгээгээр хандаж эхэлбэл, амьдралынхаа аль ч улиралд хань ижилтэйгээ дотносол эдлэхийг сурна.

Тавдугаар өдөр

Сексийн улирал

Тэнгэрийн доорх бүх юмс цаг хугацаатай бөгөөд бүх юм тогтоогдсон цаг мөчтэй ажээ.
(Номлогчийн үгс 3:1)

Амьдралын маш олон талбарт цаг хугацаа чухлаар барахгүй, амин чухал байх үе бий. Хэрэв амьдрал дахь бүх зүйл улирлын чанартай бөгөөд зорилготой байдаг юм бол, сексийн амьдрал ч ялгаагүй юм. Жил бүр дөрвөн улирлаас бүтдэг бөгөөд гэрлэлт ч ялгаагүй гэдэгт бид итгэдэг. Тиймээс яг энэ ойлголтоор сексийг авч үзье.

Хавар: Эхний арван жил

Бид сексийн нэг улирлыг гэрлэлтийн арван жилээр тооцож дүрсэлмээр байна. Тэгэхээр орчин цагийн дунджаар хорин найман насандаа гэрлэсэн хосыг авч үзье. Тэгээд эхний арван жилийг (28-38 нас) эхлэл бөгөөд гэнэн насны улирал буюу хавар гэж үзье. Хавар цагт амьдрал зүйл бүрийн боломжоор үр тогтоход бэлэн байдаг.

Та амьдралд сексийн талаар цоо шинэ үзэл бодолтой хөл тавина. Гэрлэлтийн эхний арван жил нь хүсэн хүлээлт, шинийг нээх улирал болдог. Тэсэн ядан хүлээж байх үед чинь нойрсож байсан зүйлс нь таны гэрлэлтийн хаврын улиралд сэржээ. Та хоёр бие биеэ танин мэдэж, хамтдаа амьдрал босгоно гэдэг нь ямар утгатай болохыг танин мэдсээр байна. Та хоёрын бэлгийн амьдралын хэсэг бүр шинэ бөгөөд сэргэг байна.

Хэрэв та хоёр үр хүүхэдтэй болох гэж байгаа бол, үр хүүхэд

тээхийн баяр хөөр аз жаргалыг мэдэрнэ. Үр хүүхэдтэй болсоны дараа сексийн амьдрал чинь тэс өөрөөр харагдаж, мэдрэгдэнэ. Та хоёр одоо хоёр биедээ дурласан хүмүүс төдийгүй, хүний аав, ээж болжээ. Үр хүүхэд чинь та хоёртой хамт унтаж, амралтыг чинь нураана.

Энэ нь маш сонирхолтой бэрхшээлийн улирал байх болно. Лиза миний бие залуухан ээж болохдоо их дуртай байж билээ. Би үр хүүхдээ асарч, хөвгүүн бүрээ 1-2 нас хүртэл нь хөхөөрөө хооллосон. Үүгээрээ би юу хэлэх гээд байна вэ гэхээр: миний хувьд үр хүүхдээ өсгөх нь Жоныг хайхрахаас хавьгүй амархан байсан юм. Залуухан ээжүүд хэзээ ч нэг бол нөхрөө эсвэл үр хүүхдээ сонгоход хүчлэгдэж болохгүй ч, тэвэрт чинь байгаа хүүхэд нөхрийн чинь орыг булаачих вий гэхээс болгоомжлоорой.

Би үр хүүхэддээ дурлаад, нөхөртөө цаг гаргахаа мартчихдаг байв. Мэдээж Жон хүүхдүүддээ хайртай ч, юу гэж эх хүү хоёр шиг дотно байх билээ. Жонд би хэрэгтэй байсан ч, миний хувьд Жоны хэрэгцээнээс илүү нялх хүүхдийн маань хэрэгцээ хавьгүй ил тод харагддаг байв. Яг үүнтэй адилхан зарим нөхөр охидоо эрхлүүлж, бал бурам шиг үгээр магтаад, гэргийгээ мартчихдаг.

Үр хүүхдээ асрахын хажуугаар, хоёр бие эрхлүүл. Бие биедээ хөрөнгө оруул. Үр хүүхдээ эртхэн шиг унтуулаад, бие биедээ цаг гарга. Бие биеийнхээ ачаанаас үүрэлцбэл, орондоо хамтдаа хурхирахаас илүү цагийг бие биедээ зориулж болно. Хэрэгцээ, зовнилынхоо талаар нээлттэй ярилцаж бай. Заримдаа зүгээр л “Би урьдынхаа дотно байдлыг санаж байна. Хоёулаа явал дахиж тийм болох уу?” гэж хэлсэнээрээ цаашдын гутрал цөхрөлөөс сэргийлж чадна.

Эхний арван жилээ зориуд хоёр биеийнхээ нандин хэрэгцээг таньж мэдэхэд зориул. Хэн нэг чинь хожим харуусах бэлгийн харилцааны үлгэр загварыг бүү зөвшөөр. Хоорондоо ярилц. Зун, намар сагсайтал хураах ургацынхаа төлөө хаврын цэцэрлэгээ арчилж тордоорой.

Зун: Гэрлэлтийн хоёр дахь арван жил*Зун бол яахын аргагүй хамгийн сайхан улирал*

-Чарльз Бовден

Хавар найдварыг түгээдэг бол, зун нь алсын хараанд амьсгал оруулж, амьдруулдаг. Энэ улиралд амьдрал буцалдаг. Энэ улиралд ажил мэргэжил маань тогтож, гэр бүл маань өнөр өтгөн болно. Үр хүүхэд маань өсч торниод хөөрхөн болж, үүнийгээ дагаад аав ээж нь ч өөрсдийгөө хэн болохыг танин мэднэ.

Та зуны энэ улирлын алтан эгшинг алдахгүйг хичээнэ! Сургууль, идэвхитэй амьдрал, ажил мэргэжлийнхээ хажуугаар та хоёрт дотносох цаг хэрэгтэй. Хэрэв хаврын улиралд сайн тариалж чадсан бол, та хоёр энэ улирлын сайн сайхныг бүр ч ихээр эдэлнэ. Хэрэв эхний арван жилдээ цэцэрлэгээ сайн арчилж чадаагүй бол, одоо ч тариалахад оройтоогүй байна.

Зуны улиралд бүх зүйл маш хурдан ургадаг - тэр дундаа хогийн ургамал. Тиймээс дотносолдоо байгаа эрүүл зүйлсийг тордбол, тэр нь улам л сайхан ургана. Учир нь та хоёрын дунд хэдийнээ арван жил бордсон итгэлцэл байгаа.

Зун гэдэг нь урт өдрүүд, инээд хөөр, зугаалга, цахилгаантай бороо гэсэн үг. Бидний туршлагаар зуны улиралд сексийг үдээс хойш хийхэд хамгийн тохиромжтой байв. Шөнө гэхээр дэндүү ядарчихсан байна. Тиймээс хүүхдүүд гадаа юмуу сургууль дээрээ байх, үдшийн цаг хамгийн тохиромжтой байлаа.

Намар: Гэрлэлтийн гурав дахь арван жил

Дараагийн улирал нь намар бөгөөд энэ нь бидний хамгийн дуртай улирал юм. Намрын халуун өдөр, сэрүүн үдэш бие ч, сэтгэл санаа ч амар тайван, жаргалтай байна.

Намар бол навчис бүр нь цэцэг байдаг хоёр дахь хавар юм.

- Альберт Камус

Бид намарт дуртай! Залуу насныхаа араас санааширахын оронд налгар намрын сайхныг эдлэ. Энэ улиралд ч дотносол байдаг. Тавин нас гарсан хойно амьдрал өөр хэмнэлээр өрнөдөг. Бид гэрийн даалгаварт туслаж, сургууль дээр очиж, спорт өдөрлөгт оролцдоггүй. Бид бие биедээ зориулах цаг ихтэй болдог.

Бид өвлийн улиралд цохиулахгүйн тулд одоо ч намрын улиралд хийх зүйлсээ бичдэг. Тэдгээр зүйлсийн нэг нь эрүүл зөв хоол, тогтмол дасгал хөдөлгөөнөөр биеэ тордсоноороо бэлгийн эрүүл мэндээ эрүүл байлгах юм. Бид хоёр зориуд маш их хамт алхдаг. Яг л анх болзож байсан шигээ.

Маш олон хосын харилцаа холбоо намрын улиралд тасарчихдаг. Үр хүүхэд нь тусдаа гарах үед тэд шал танихгүй хүнтэй хамт аж төрж байгаагаа ухаарна. Энэ улиралд бидэнд сонголт байна. Бид байсан зүйлийнхээ араас гашуудах эсвэл айсуу зүйлсийн төлөө баясах. Энэ улирлыг гэрлэлтээ дахин байгуулах боломж гэж хараарай. Та хоёр дахиад л шинээр гэрлэсэн хос шиг болж чадна. Гэхдээ энэ удаа та хоёр арай жаахан хөгшин бас цэц ухаантай болжээ.

ӨВӨЛ: ҮЛДСЭН ОН ЖИЛ

*Идэр гурван ес тачигнаж байх үед миний дотор
зун цэцэглэж байхыг би ухаарлаа.*

- Альберт Камүс

Бид өтлөж буй зүс царайгаа гунигтайяа ажин, хүндээр санаа алдан, хажуулдаж хэвтэхгүй. Жоны аав, ээж хоёр энэ насыг маш сайн туулсан шүү. Хэдийгээр насны элэгдлээр эрүүл мэндэд нь өөрчлөлт гарсан, тэд алхсаар, дасгал хөдөлгөөн хийсээр, найз нөхөдтэйгээ уулзаж нөхөрлөсөөр, нэг оронд унтсаар. Хамтдаа өтлөх шиг сайхан юм байхгүй. Сексийн амьдрал ч улирлаараа явбал хамгийн сайхан.

Номлогчийн үгс 3:11-р ишлэлд зохиолч: “Бүх юмыг Тэр тухайн цагт нь сайн сайхнаар бүтээсэн” гэж хэлжээ. Юмыг зөв улиралд нь хийх шиг сайхан юм байхгүй. Бид хоёр хамтдаа өтлөж, улиралтайгаа хөл нийлүүлэн бүжмээр байна.

Хамгийн сүүлд нь нэгэн жишээ хэлье. Speedo гэдэг усны хувцас байдаг. Энэ усны хувцас тамирчдад үнэхээр зохидог ч, заримдаа настай хүмүүс үүгээр гангарчихсан явдаг. Нэгэн цагт та усанд шумбахдаа Speedo-гоор гангардаг байж. Харин одоо тайван сэлж, голдуу хөвж байгаа болохоор уужуу хувцас өмсөх хэрэгтэй. Гэхдээ цаашид бикини өмсөх аргагүй болсон учраас усанд сэлэхээ болилоо гэж болохгүй. Сэлэх ба сексийг аль ч улиралд хийж болно. Гэхдээ цаг хугацааны аясаар тэдгээр нь өөр харагддаг болно.

Би гэрлэлтийнхээ хаврын улирлыг бикинитэй эхэлсэн бол, зун болоход ээж нарын өмсдөг битүү усны хувцастай, харин өдгөө намрын улиралд шорт болон майк л өмсөж байна. Удахгүй өвөл болохоор гадуураа хормойтой усны хувцас өмсөхийг хэн байг гэхэв. Гэхдээ би усанд сэлсээр л байна.

Магадгүй бид хавар сэлдэг байсан шигээ их сэлэхгүй байж болно эсвэл зуны улирал шиг хүүхэдтэйгээ хамт сэлж байгаагаа санаж сэлэх шаардлагагүй болно. Гэхдээ бид намар ч, өвөл ч сэлсээр байна. Секс нь үнэндээ мөнхийн зун юм.

Бодитой хэрэгжүүлж болох санал

Та хоёр ямар ч улиралд байсан, хоорондоо ярилцах хэрэгтэй. Хэрэв та ганцаараа байвал, бодол хүслээ Бурхантай хуваалц. Таны санаа бодлыг хуваалцдаг найзтайгаа ярилцаж, бие биеэ урамшуул. Хэрэв та гэрлэсэн бол, бие биетэйгээ ярилц. Санаа бодлоо хуваалц.

Үнэндээ бидний бэлгийн амьдрал ч сайжирдаг. Гагцхүү суралцах хэрэгтэй. Эрчүүд арга барилаа сахидаг. Тэд өнгөрсөн арван жил хэрэгжүүлсээр ирсэн энэ сайхан зүйлээ өөрчилж яах юм? гэж боддог. Эмэгтэйчүүд ээ, өөрчилмөөр байгаа юм байвал, өөрчил. Нөхөртөө: “Миний хүзүүг үнсэхэд чинь би дуртай” гэж хэл. Нөхөртөө тааварт тэмцээн зохион байгуулах хэрэггүй. Өөрийнхөө хүсэл бодлыг нээлттэй хуваалц.

Бие биедээ чөлөөтэй хүрч, тэвэрч бай. Бие биедээ эрхэлж наад. Сексийн талаар ярилцмаар байвал, хамтдаа алх. Ном сэтгүүлд хэлж байгаа зүйлд бүү итгэ; та гэрлэлтийнхээ аль ч хэсгийг өөртөө тааруулж янзалдаг шигээ сексийн амьдралаа ч янзалж болно.

Тусламж хэрэгтэй байгаа бол, туслалцаа ав. Гэрлэлтийнхээ амьдралын ийм нарийн нандин зүйлийг аз завшаанд бүү даатга.

Бид сексийн мэргэжилтнүүд биш бөгөөд зүгээр л амьдралынхаа туршлагаас л хуваалцаж байгаа минь энэ. Гэхдээ бидний туршлага хүн бүрт ач тусаа өгч чадна. Заримдаа хосын нэг нь нөгөөгөө огт сонирхохгүй үе байдаг. Ийм байдлаар ад үзэгдэх нь маш их зовиуртай байдгийг бид мэднэ. Энэ үед хүнд биш; Бурханд ханд. Түүнд хамаг сэтгэл зүрхээ уудлаж, та хоёрын нэгдлийг эдгээнэ гэдэгт итгэ.

Түүнчлэн хань ижил нь сэтгэл санааны хямралд орсон эсвэл дотносож болохгүй эрүүл мэндийн нөхцөл байдалд орсон, хүнд хэцүү улирал байдгийг ч бид бас мэднэ. Тэр үед эмчтэй ярилцаж, юу хийх ёстойг мэд.

Ямар ч байсан та хоёр насан турш бие биедээ татагдаж, өнгөрсөнийхөө алдаа шархаас чөлөөтэй, Бурханы бүтээсэн, ариун үлгэр загвар дээр байгуулагдсан, бэлгийн өвийг бүтээхийн төлөө бид залбирч байна. Та хоёр насан турш хайрын халуунд жаргах болтугай!

Нэгдүгээр өдрийн судлал

ДОТНОСОЛЫГ ЭДЛЭХ

Залуудаа гэрлэсэн эхнэртээ баярлан баяс.

*Энхрийхэн марал болон нигүүлсэлт согоотой адил,
эхнэрийн чинь хөх ямар ч үед сэтгэлийг чинь хангах болтугай.*

Түүний хайранд үргэлж сэргэн хөгж.

- Сургаалт үгс 5:18-19

Бурхан хүнийг нүгэлд унахаас өмнө сексийг бүтээжээ. Гэрлэлт дотор секс нь маш сайхан, үнэндээ гайхалтай сайхан зүйл мөн! Эрэгтэй, эмэгтэй хоёр хүний хооронд үүнээс хүчтэй хайрын холбоо байхгүй.

Та сексийн амьдралдаа яаж ханддаг вэ? Та үүнийг Бурханы бүтээсэн цэвэр, эерэг дүр төрхөөр хардаг уу? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?

Та өнгөрсөн амьдралдаа сексийн талаар ямар ойлголт авсанаас үл хамааран, тэнгэрлэг Аав тань таны хань, та хоёрын сексийн дотнослыг таалдаг гэдгийг мэдээрэй. Сексийн талаар заасан Бурханы Үгийг эргэцүүлэн бодох цаг гарга.

Булгийн чинь ундарга ерөөгдөх болтугай!

Залуудаа гэрлэсэн эхнэртээ баярлан баяс.

Энхрийхэн марал болон нигүүлсэлт согоотой адил,

эхнэрийн чинь хөх ямар ч үед сэтгэлийг чинь хангах болтугай. Түүний хайранд үргэлж сэргэн хөгж.

- Сургаалт үгс 5:18-19

Нөхөр эхнэрийн аль аль нь хоёр биеийнхээ бэлгийн хэрэгцээг хангах ёстой.

- 1Коринт 7:3

Бүгд гэрлэлтийг хүндлэгтүн. Ор дэр нь ч бузартаагүй байг. Учир нь янхан эрчүүдийг болон завхайрагчдыг Бурхан шүүнэ.

- Еврей 13:4

Шударга бай. Та сексийг гэрлэлтийнхээ амьдралд хэрхэн зураглаж байна? Та сексийг үл хайхардаг уу эсвэл таашаадаг уу? Дээрх ишлэл нь танд сексийг эерэгээр харахад чинь тус болж байна уу?

Бурхан Соломоны дуун номд эрүүл сексийн дотнослыг маш нарийн дүрслэсэн байдаг. Ялангуяа 4 болон 7-р бүлгээс сексийн харилцааны сайн сайхныг танин мэдэж, сексийн талаарх алсын хараа болон хүсэн хүлээлтийг чинь Өөрийнхтэйгээ адилхан болгож өгөхийг Бурханаас залбиран гуй.

Бэлгийн дотносолын хамгийн чухал зарчим нь хүндэтгэл юм. Та гэрлэлтийнхээ орыг хүндэтгэдэг үү?

Хүндэтгэх гэдэг нь гэрлэлтийнхээ орыг бузарлахгүй байхаас гадна гэрлэлтээ зохистой, нандин, үнэт тэгээд хүндэтгэлтэй гэж үзэхийг хэлнэ (Еврей 13:4). Гэрлэлтийнхээ дотнослыг хамгаалж бас сайн

сайхныг нь эдлэхийн тулд ямар бодитой алхам хийж болох вэ?

Хоёрдугаар өдрийн судлал

ЭМТЭРСЭН ЗҮРХ ЭДГЭНЭ

*Тэр эмтэрсэн зүрхтэй хүмүүсийг анагааж,
Тэдний шархыг боодог.*

- Дуулал 147:3

Бидний ихэнх маань өнгөрсөн буруу сонголт - сексийн гэм нүглээсээ болж шархласан байгаа. Гэхдээ бидэнтэй харилцаа тогтоохын хүслэн болдог цэц ухаант тэнгэрлэг Аав маань Хүү Есүсээрээ дамжуулан бидний амьдралыг эдгээж сэргээх арга замыг ээлтгэжээ. Паул Бурханы хайрын түүхийг Титэд хандсан захидалдаа товч бичжээ:

Учир нь бид бас өөрсдөө урьд нь мунхаг, дуулгаваргүй, мэхлэгдсэн, зүсэн бүрийн хүсэл тачаал хийгээд зугаа цэнгэлд боолчлогдсон, муучлал болон атаа жетөө дотор амьдралаа өнгөрөөн, бие биеэ үзэн ядаж, жигшүүрт байсан. Харин бидний Аврагч Бурханы энэрэл болон хүн төрөлхтний төлөө гэсэн хайр нь ил болоход Тэр биднийг зөвт байдлын дотор хийсэн үйлсээр минь бус, харин Өөрийнхөө өршөөлийн дагуу шинэтгэлийн угаал ба Ариун Сүнсний сэргээлтээр аварсан юм. Ариун Сүнсийг бидэн дээр Тэр бидний Аврагч Есүс Христээр дамжуулан арвин асгав. Түүний нигүүлслээр зөвтгөгдсөнөөр бид мөнхийн амийн найдварын дагуу өв залгамжлагчид болгогдох юм.

- Тит 3:3-7

Та хоёр өнгөрсөн амьдралаасаа болоод бие биедээ зохисгүй юм шиг эсвэл сексийн сайн сайхныг эдлэх зохисгүй юм шиг санагддаг уу? Хэсэг хугацаанд чимээгүй байж, энэ талаар залбирч бод. Хэрэв Ариун Сүнс ямар нэг юм сануулбал, үүнийг нь бичээд, залбирлаар Түүнд өргө.

Хань ижилтэйгээ хамт байж, энэ талаар зүрхнээсээ ярилц. Залбиран зүрхийг тань эдгээж, алдагдсан зүйлсийг эргүүлэн авчрахыг Ариун Сүнснээс гүй.

Бурхан гагцхүү Түүнд өргөсөн зүйлийг л ариусгадаг. Та сексийн амьдралынхаа ямар нэгэн зүйлийг Түүнээс харамлаж байна уу? Хил хязгаараа зөрчсөн ямар нэгэн зүйл бэлгийн амьдрал чинь байна уу? Яагаад энэ хэсгээ Бурханд өгч чадахгүй байгааг илчлэхийг Ариун Сүнснээс асуу. Түүний хэлсэн зүйлийг бич.

Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна.

- 2Коринт 5:17

Бид Бурханд зүрхээ өгбөл зүрх маань эдгэрч, бүрэн бүтэн болдог. Тэгэхээр яг одоо дараах ишлэлийг анхааралтай тунгаан бодно уу: Дэд хууль 6:5; Дуулал 119:2; Сургаалт үгс 3:5-8; Иеремиа 29:11-14; Марк 12:29-30. Эдгээр ишлэлээр дамжуулан Бурхан танд гэрлэлтийн талаар болон бэлгийн амьдралын талаар юу хэлж байна?

Гуравдугаар өдрийн судлал

ДОТНО НӨХӨРЛӨЛ ДЭХЬ ЭРХ ЧӨЛӨӨ

*Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй.
Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй.*

- Иохан 3:6

Ариун Сүнсээр дамжих Христтэй тогтоох дотносол нь бүх нүглээс эрх чөлөөтэй байх үндэс юм. Дотносол нь ойр дотно нөхөрлөл юм. Давид хаан, элч Паул, Мариа үүний араас л явсан. Дотно нөхөрлөл нь Христийн дотор байхын утга учир юм - Шинэ гэрээнд энэ үг 100 гаруй удаа бичигдсэн байдаг. Бид Христтэй хэрхэн дотно харилцаа тогтоож, харилцаагаа хадгалах вэ? Түүн дээр төвлөрч, Түүнд цагаа зориулсанаараа.

“Бурхантай хоёулханаа байх цаг нь бидний каледарь, цагийн хуваарьт хамгийн түрүүнд тэмдэглэгдэх ёстой. Учир тэр бол дотносол үрждэг газар юм. “... Хаанчлалын хүчийн хамгийн аугаа дөрвөн талт хэмжээс нь Эзэн Есүстэй тогтоох хувийн хайрын харилцаагаараа эрчлэгдэж, асдаг хүмүүсээр л хүрэлцэгддэг юм.”

- Боб Сорж

Нүглээс чөлөөлөгдөх эрх чөлөө нь Есүстэй тогтоох дотно нөхөрлөлд л оршино. Тэгэхээр та Түүнтэй тогтоох харилцаагаа юу гэж дүрслэх вэ? Та Түүнд хоёргүй цаг, анхаарлаа хэр зэрэг

зориулдаг вэ? Юу таныг Түүний оршихуйг эрэн хайхад хөдөлгөдөг вэ? Юу таны ихэнх залбирлыг - Бурханыг танин мэдэх болоод бусад зүйлийг гэх таны хүслийг удирдан чиглүүлдэг вэ?

Есүстэй тогтоох дотносолыг нэн тэргүүнд тавиагүй явсан бол, өөрийгөө бүү яллаарай. Зүгээр л Түүнтэй шударга байж, Түүний нигүүлсэлийг гуй: “Эзэн минь ээ, би Танд хайртай. Би Таныг таньж мэдмээр байна. Гэхдээ Тангай харилцах миний харилцаа Таны хүссэн шиг байж чадахгүй байгааг би мэдэж байна. Надад туслаач. Таныг таньж мэдэхийн юутай ч эгнэшгүй үнэ цэнийг надад харуулаач. Зүрхийг минь надад харуулаач. Таныг нэгдүгээрт тавихад надад юу саад хийж байна? Таныг гэх гал халуун хайрыг бадраахын тулд би юу хийх ёстой вэ? Би Таны ухаарал ба нигүүлслийг гуйж байна. Есүсийн нэрээр. Амень.”

Чимээгүй байж, Ариун Сүнсний үгийг сонс. Түүний хэлсэн зүйлийг бичиж аваад, биелүүлэх нигүүлслийг гуй.

Бурханыг нэгдүгээрт тавихаас намайг хорьдог зүйлс:

Түүнтэй дотно харилцаа тогтоохын төлөө миний талаас хийж чадах зүйлс:

БУРХАНТАЙ ХОЁУЛХАНАА БАЙХ ЦАГ ГАРГА

Бурхантай хоёулханаа байж, Түүнд залбирч, Түүнийг сонсож, Түүнтэй зүрх зүрхээрээ уулзах тусгай цаг гарга. Чуулгантайгаа хамт амралтанд явж болно эсвэл ханьтайгаа хоёулханаа хаа нэг газар руу явж болно. Өдөр тутмын амьдралаасаа түр салаад, хотоос гадагш гарч Бурхантай хоёулханаа хэдэн өдрийг өнгөрөө. Ямар нэгэн саад, санаа бүү авч яв - зөвхөн Библи, дэвтэр, үзгээ л авч яв. Бурханы зүрхнээс ундрах сайн сайхныг л тосох саваа бэлд!

Түүнтэй хоёулхан уулзах, тусгай уулзалтын нууцыг таньж мэд. 1 Шастир 16:27; Дуулал 16:11; 27:4-6; 31:19-20; 91:1-16; Исаиа 40:31; Иохан 15:4-8; Еврей 4:16

Дөрөвдүгээр өдрийн судлал

ЗӨВ ХҮСЭЛ ХӨГЖҮҮЛЭХ

*Харин Сүнсээр яв, тэгвэл та нар махан биеийн хүслээ
гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ.*

- Галат 5:16

Гэрлэлт дэхь ариун байдал нь Христ Сүйт бүсгүйдээ байлгахыг хүсдэг тэр ариун байдал юм. Сексийн хүсэл нь муу биш - тэдгээр нь Бурханы бүтээл бөгөөд Бурхан үүнийг хайрладаг! Гэхдээ бидний гэрлэлтийн нэгдлийг нүгэл бузарлахдаа дотнослыг маань устгаж, Бурханы сайн гэсэн зүйлийг бохирлодог. Зөв хүслийг хөгжүүлэх оньс нь хүмүүний мөн чанараа өлсгөж, сүнсээ тэжээх юм.

“Библи секст эерэгээр бөгөөд таалалтай ханддагийг тухайлбал Соломоны дуун номоос харж болох ч, библийн бичээч нар мөн сексийн нүгэл нь Бурханаас бидэнд өгөгдсөн энэхүү бэлгийг бузарлах аюултай бөгөөд сул талтай байдгийг тун нухацтай анхааруулдаг. Иймийн улмаас л сексийн хүслийн далайд зөв залуурдахад маань гэрлэлтийн институци нь амин чухал юм. Бэлгийн амьдрал нь сүнсний хувьд утга учиртай бөгөөд тустай байдаг цорын ганц агуулга нь гэрлэлт билээ.”

- Гарри Томас

Түр зогсоод эргэцүүлнэ үү. Та махан биеийн мөн чанараа яаж тэжээж байна? Та огцом дур хүсэл бадраадаг кино, хөгжим, нэвтрүүлэг үздэг үү? Тархи, зүрхийг чинь бохирлох ном, сэтгүүл,

цахим хуудсаар өөрийгөө “тэжээж” байна уу? Найз нөхөд болон бусад нөлөөний хувьд - тэдгээр нь таныг буруу хандлага үйлдэл рүү хөтөлдөг үү?

Ямар нэг эрүүл бус нөлөө байгаа эсэхийг Ариун Сүнснээс асуу. Таныг хэнээс болон юунаас хол байхыг хэлж байна?

Бид Бурханы үгээр оюун санаагаа шинэчлэх үед зан үйлдлийн өөрчлөлт ирдэг. Дараах ишлэлийг тунгаан бодно уу.

Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхитэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог бөгөөд зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм.

- Еврей 4:12

Тиймээс та нар бүх бузар байдал, хорон санааныхаа бүх л үлдэгдлийг хаяж, өөрсдийн чинь дотор суулгагдсан үгийг даруухнаар хүлээж авагтун. Тэр үг та нарын сэтгэлийг аврах чадалтай.

- Иаков 1:21

“Миний үг галтай адил биш гэж үү?” гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Чулууг бутлах алхтай адил биш гэж үү?”

- Иеремиа 23:29

ТҮҮНЧЛЭН Иошуа 1:8; Дуулал 1:1-3; 119:103; Иеремиа 15:16; Ром 12:1-2; Колоссай 3:1-5; 1Петр 2:2-г үзнэ үү.

Ямар тодорхой арга замаар та сүнсээ секс, дотносол, ариун байдлын талаарх Бурханы үгийн үнэнээр тэжээж байна. Үнэний

хэрэглээгээ та яаж илүү ихээр өсгөж болох вэ? Танд сүнсээ хооллож, зөв хүслийг хөгжүүлэх тодорхой арга замыг заахыг Ариун Сүнснээс асуу.

Ариун Сүнснээс асуубал, Тэрбээр ариун байдлын сахих хүслийг яаж хөгжүүлж, нэгдлээ хэрхэн гүнзгийрүүлэхийг зааж өгнө.

Тавдугаар өдрийн судлал

ХАРИЛЦАА БА ДОТНОСОЛ

*... харин хайр дотор үнэнийг ярин, тэргүүн болох Түүн уруу,
Христ уруу бүх талаар өсөх ёстой.*

- Ефес 4:15

Гэрлэлтийн улирал бүрт гайхамшигтай сексийн амьдралыг эдлэх оньс нь харилцаа юм. Маш олон гэрлэлтэд дотносол нь “мэдлэггүй байдлаас болж устдаг” (Хосеа 4:6). Хэрэв хос хоорондоо хүсэл бодлоо байнга хуваалцахгүй бол, асуудал үүснэ. Сексийн хүслийнхээ талаар өөр хоорондоо хайраар нээлттэй ярилцсанаар та хоёрын гэрлэлт Бурханы хүссэн тэр тэлэлтэд хүрнэ. Зохиолч, илтгэгч **Боб болон Одри Мэйер** ийн тайлбарлажээ:

“Хамгийн сайн найз байж, бие биедээ “шилэн” байх нь бэлгийн амьдралд гайхалтай ач тус авчирдаг. ...Хүсэл, зөрчил, бэрхшээлийнхээ талаар ил тод ярих нь бэлгийн харилцаанд халуун дулаан байдал, зөвшөөрөл дагуулдаг. Өөрийнхөө бус, ханийнхаа бэлгийн дур хүсэл, эрч хүч, илэрхийллийг нэн тэргүүнд тавь. Тэгээд тэвчээртэй бай. Бие биеийнхээ хамгийн нарийн нандин зүйлсийг таньж мэдэхэд бүх нас хэрэгтэй.

Эдгээр өгүүлбэрийг дуусга:

“Бидний хувьд бэлгийн амьдралын хамгийн сайхан улирал нь _____

“Миний ханийн хамгийн аюулгүй, биеэ барилгүй, чөлөөтэй байдаг үе нь _____

“Миний бодлоор бидний бэлгийн харилцаанд хамгийн их саадтай байсан/байгаа улирал нь _____

“Яг одоо бэлгийн харилцааны талаар би ханьдаа ингэж хэлмээр байна _____

Би ханийхаа бэлгийн тал дээр хамгийн дуртай зүйл нь

Би ханийхаа бэлгийн тал дээр хамгийн дургүй зүйл нь

Та хань ижилтэйгээ дуртай, дургүй зүйлсээ нээлтэй хуваалцаж байсан уу? Хань ижил чинь таны тархийг уншиж чадахгүй учраас та хоёр энэ талаар сэтгэлээ уудлан ярилцаж чадах тусгай газар, цаг гаргаж байгаад яриарай. Ханийхаа хэрэгцээ, хүслийг ойлгож, үнэлэх Бурханы нигүүлслийн төлөө залбирч, үнэнийг хайр, үнэнээр хэлээрэй.

Нөхрүүд ээ, та нар гэргийдээ бус, харин ажилдаа юмуу үр хүүхэддээ их цаг гаргаж байна уу? Эхнэрийнхээ бэлгийн хэрэгцээг хангахын тулд та юу хийж чадах вэ? Гэргийнхээ өмнө даруу байж, түүнээс туслалцаа гуйгаад, энэ талаар хамтдаа залбирна уу.

Эхнэрүүд ээ, та нар гэр бүл эсвэл ажилдаа түүртээд, нөхөртэйгээ тогтоох бэлгийн амьдралаа тордохоо мартсан уу? Эр нөхрийнхөө бэлгийн хэрэгцээг хангахын тулд та юу хийж чадах вэ? Нөхрийнхөө өмнө даруу байж, түүнээс туслалцаа гуйгаад, энэ талаар хамтдаа залбирна уу.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

*Мессенжер Интернэйшнэлийн “Гэрлэлтийн түүх”
сургалтын хөтөлбөрийн 5-р видео хичээлийг үзнэ үү*

1. Эхлэл номоос үзбэл, Бурхан эр хүнийг газрын шорооноос бүтээж, дараа нь эмэгтэй хүнийг бүтээгээд, эр хүн дээр авчирсан. Эхлэл 2:21-25-р ишлэлийг анхааралтай уншина уу. Эр хүн эхнэрээ хараад гаргасан үйлдлээс юу нь танд хамгийн сонин содон санагддаг вэ? Тэд Бурханыг үл дагасны дараа юу өөрчлөгдсөн бэ? (Эхлэл 3:6-8)

2. Бурханы өршөөл, уучлал, нигүүлсэл ямар ч нүглийг уучилж, шийдвэрлэх чадалтай бөгөөд хангалттай гэдэгт та итгэдэг үү? Хангалттай юм бол, яагаад тийм олон хүн сексийн нүглээс чөлөөлөгдөж чадахгүй явдаг юм бол? Та хэрэв тийм хүнтэй тааралдбал, нүглээсээ чөлөөлөгдөж, Бурханы өршөөл, нигүүлсэлийг хүлээж авахад нь юу гэж урамшуулах вэ?

3. “Гэрлэлтийн ороо хүндэтгэх” гэдэг үгийг өөрийнхөө ойлголтоор тайлбарлана уу? Энэ нь яг яана гэсэн үг вэ? Хүмүүс гэрлэлтийнхээ орыг яаж үл хүндэтгэдэг вэ?

4. Бичээс хоёр төрлийн гашуудлын талаар ярьсан: дэлхийн гашуудал, бурханлаг гашуудал. Ялгааг нь хэл - тухай бүрийнх нь мөн чанар, эцсийн үр дүн юу вэ?

Дэлхийн гашуудал

Бурханлаг гашуудал

5. Бурхантай тогтоох дотно харилцаа нь бүх төрлийн нүглээс - тэр дундаа бэлгийн харилцааны нүглээс эр чөлөөтэй байх нөхцөл юм. Тэгэхээр түр зогсоод, эргэцүүлэн бодно уу. Бид өөрийнхөө чадлаар эрх чөлөөтэй болж, нүглээс чөлөөлөгдөж чаддаг байсан бол яах вэ? Үүнээс болж Бурхантай болоод бусадтай тогтоох бидний харилцаа яаж өөрчлөгдөх вэ?

Бидний махан биеийн чадварт ямарваа үнэ цэнэ бүй эсэхийг бодолц. Ром 7:18, Иохан 15:5; Филиппой 3:3; 1Коринт 10:12-г уншина уу.

6. Бурхантай тогтоох дотно харилцаан дээр бид нийгмийн хөхиүлэн дэмждэг бохир дүр зураг, жишиг бохир дүр зураг, завхралаас нүд, чих, тархи, зүрхээ яаж хамгаалах вэ? Нийгэм дунд болон ганцаараа байхдаа юу хийж болох талаар ярилц.

Эдгээр бичээсийг ярилц:

„Би нүднийхээ өмнө ямар ч хорон юмыг байлгахгүй“
(Дуулал 101:3).

„Би нүдтэйгээ гэрээ хийсэн билээ. Тэгвэл би онгон охиныг хэрхэн бодож зүрхлэх байсан бэ? (Иов 31:1).

7. Бэлгийн амьдралын хувьд цэвэр байх түлхүүр нь гэрлэлтдээ сэтгэл хангалуун байх юм. 1Коринт 7:2-5 дээр Паулаар дамжуулж Бурханы өгсөн илэн далангүй зааврыг анхааралтай уншина уу. Эдгээр ишлэлд Ариун Сүнс юу илчилж байна? Энэ хэсэг нь сексийн талаарх бидний ерөнхий үзэл бодлыг хэрхэн өөрчилж байна? Түүнчлэн бэлгийн харилцаагаар хань ижилдээ үйлчлэх үзэл бодлыг маань хэрхэн өөрчилж байна?

Бүлгийн хураангуй:

- Бурхан таны хань та хоёрыг гайхамшигтай сексийн амьдралтай байгаасай гэж хүсдэг. Энэ нь унтлагынхаа өрөөнд Бурханы хүндэтгэж, цэвэр байлгах дуудлагыг хүлээн авахаас эхэлнэ.
- Урьдын нүглийн ичгүүр, хүчирхийлэлд гэр бүлийнхээ дотносол, бэлгийн аз жаргалаа бүү алд.
- Хосын аль аль нь бие биедээ таалагдахыг хүссэн цагт бэлгийн амьдрал амьд байдаг. Бэлгийн ажил та хоёрыг махан бие, сэтгэл санаа, оюун, сүнсээр холбож, бурханлаг таашаал, сэтгэл ханамж хөгжүүлдэг.
- Амиа бодсон чанар нь Бурхантай тогтоох дотносолд саад хийж, Бурханы өөрчлөгч хүчийг хорьдог бол, Бурхан дээр төвлөрсөн, Бурхантай тогтоох дотно байдал нь бидний амьдралд Түүний хүчийг идэвхижүүлдэг.
- Бид Бурханы Үг, оршихуй дотор байх тусам, тархи маань шинэчлэгдэж, зүрх маань ариусдаг. Зүрхэнд маань Бурханы Үг Ариун Сүнсээр таригдаж, бэлгийн нүглээс чөлөөтэй байх эрх чөлөө олгодог.
- Гэрлэлтийн улирал бүр өөр байдаг. Энэ нь таны сексийн амьдрал ч өөр өөр улирлаар туулна гэсэн үг. Улирал бүр өөрийн гэсэн баяр хөөр, асуудал бэрхшээлтэй. Тиймээс улирал бүр сексийн талаар нээлттэй ярилцаж, бие биетэйгээ тогтоох дотносолдоо хөрөнгө оруул.



ЗУРГАА

Шинээр эхлэ

Амар сайхандаа жаргах нь өдөр тутам хийх ёстой зүйл юм.

- Маргарет Боннано

Нэгдүгээр өдөр

Хөвгүүдээ жаахан байхад, Лиза миний бие хөвгүүддээ алимны модон дороос алт эрдэнэ олж байна гэж зүүдэлдэг ядуу хүний тухай үлгэр уншиж өгдөг байсан юм. Тэрбээр эрдэнэ нуусан мод яг хаа байдгийг мэдээгүй ч, ямартаа ч тэр зүүд залуугийн зүрхэнд найдвар бялхаажээ.

Уг нь тэрбээр эрт дээр үеэс өвлөгдөж ирсэн, өргөн уудам цэцэрлэгийн эзэн боловч, цэцэрлэг нь ургац өгөхөө больсон учраас ядуурлын туйлд хүрсэн юмсанж. Залуу зүүд зүүдлэхээсээ өмнө цэцэрлэгээ зарах санаатай байсан ч, болиод моддоо тойруулан хичээнгүйлэн ухаж эхэлжээ. Хоосон нүх болгон үлдсэн моддын

дор эрдэнэ байх боломжийг улам л өсгөж байв. Гэтэл сүүлийн модыг тойруулан ухсан ч, ямар ч эрдэнэ гараагүй тул залуу цөхрөн унажээ.

Гэвч залуу эрэл сурал болоод байсан эрдэнэсээ хавар нь олсон юм. Тэрбээр цэцэрлэгийнхээ дундуур алимны моддын анхилуун үнэрээр цээж дүүрэн амьсгалж явав. Эртний модод бүгдээрээ цэцгэн дээлээр гоёж, анхилам үнэр нь намар ургах алимны ургацыг амлаж байлаа.

Эрээд байсан эрдэнэ нь гарт нь байсныг ядуу хүн ухаарчээ. Тэрбээр моддыг тойруулан ухахдаа үндсийг нь боловсруулж, хөрсийг нь эргүүлсэн юмсанж. Үүнээс болж модод цоо шинэ ургацын улиралтай золгожээ. Нэгэн цагт үржилгүй байсан зүйл дахин амилав. Залуу насан турш жилээс жилд өндөр ургац хурааж, мөрөөдлөөсөө ч томоор амьдарчээ!

Энэ номоор хийх аялалаа эхлэхдээ бид гэрлэлтийг модтой зүйрлэсэн. Модны эргэн тойрон дахь хөрс нягтаршсан бол, үндэс нь боогдож, шаардлагатай ус болон бусад шим тэжээлдээ хүрэхээр салаалж чадахгүй. Энэ номын эхний таван бүлэг танд үндсийг чинь боож байгаа гомдол, айдас, амиа бодох чанараас хөрсөө хэрхэн цэвэрлэж, сийрүүлэхийг заасан. Та мөрөөдөх зоригтой байж, үнэ цэнэ, үүрэг, зорилго байгуулах сонголт хийсэн учраас ирээдүйд мөчир бүр дээрээ найдварын амлалт ургахыг харах л болно.

Гэрлэлт бүр хараахан хураагаагүй байгаа ургацын амлалтыг тээдэг. Бид зүрхээ болон гэрээ хамгаалах үүргээ биелүүлэхэд, Бурхан хийх ёстойгоо хийж, бидний нэгдэл дээр ерөөл тушаана. Нялх мөчиртэй залуу мод, хүчирхэг мөчиртэй боловсорсон мод эсвэл хараахан ургаагүй байгаа үр нь бүгдээрээ маш их хүчин чадалтай. Бурхан амьгүй зүйлийг цэцэглүүлдэг. Бурхан хуучныг шинэ болгож, үхсэнийг амилуулдаг.

Бүх зүйлийг шинэ болгох

Хайр өнгөрсөнийг арилгахгүй, гэхдээ ирээдүйг өөр болгодог.

-Гарри Чапман

Аялалын гараагаа эхэлсэн цэцэрлэгтээ дахин нэг очъё.

Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж,
Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.
Бурхан тэднийг адислаж, тэдэнд
—Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг
дүүргэн, газрыг эзэмш! Далайн загас, огторгуйн
шувууд хийгээд газар дэлхий дээр хөдөлдөг бүх
амьтдыг захир хэмээн айлдав. (Эхлэл 1:27-28)

Бурхан бидэнд ийм л зорилго тээдэг. Гэтэл Бүтээгчийн анхдагч санааг бидний өнгөрсөн, айдас, дарамт, ахуй орчны завхрал хордуулах юмуу шингэлдэг. Магадгүй та Едений даалгавраас итгэхийн аргагүй хол байж болох ч, зоригтой бай. Амьдрал, гэрлэлт бүр дахин төрж, шинэ эхлэл тавигдаж болно.

Сэнтийд Залрагч

—Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна гээд...
(Илчлэл 21:5)

Бурхан өнгөрсөнийг засварладаггүй. Бурхан шинийг бүтээдэг. Бурхан бидний уналтын тэмдэг болох Едений моддыг аваад, дахин шинээр бүтээсэн. Бурхан Хүүгээ үхлийн модон дээр тавьсан нь биднийг Өөрийнхөө мөнхийн хот, гэр, амийн модонд оруулахын тулд байв. Алдагдсан зүйлийн алийг нь ч Бурхан эдгээх чадалтай. Үүнд бидний гэрлэлт ч багтана. Тэрбээр биднийг бүхнийг шинээр эхлүүлээсэй гэсэндээ бүх зүйлийг шинэчилдэг.

Таны өнгөрсөн “өнгөрсөн”. Энэ нь хүний хүчин зүтгэлээр хүрэшгүй цаг хугацааны бичээст цементлэгджээ. Гэхдээ цаг хугацаанд баригдахгүй Нэгэн байдаг бөгөөд Тэрбээр цаг

хугацааны хязгаарт баригдахгүй. Тэрбээр “өндөр дээд” бөгөөд “мөнхөд амьдардаг (Исаиа 57:15). Бурхан таны ирээдүйн түүхийг бичихдээ, өнгөрсөний чинь түүхийг авардаг. Өдөр бүр Бурханы өршөөл шинэ бөгөөд Түүний амлалт таныг хүлээнэ. Бурхан таны төлөө боломжгүй зүйлийг боломжтой болгохыг хүсдэг бөгөөд үүндээ ч дуртай байдаг.

Эдүгээ, бидний дотор ажилладаг хүчний дагуу гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд... (Ефес 3:20)

Танд болон таны гэр бүлд Бурханы авчирч чадах үр жимс, нөлөө, биелэмж нь таны бодож төсөөлөхөөс хол давна. Өнгөрсөн өдрүүдэд гэр бүлдээ зориулж гаргасан мөрөөдөл, зорилго, хүслээ эргэцүүлэн бод. Бурхан таныг тэр алсын хараанаас чинь өндөр аваачихыг хүсч байгаа. Бурхан та хоёроор дамжуулж газар дээр тэнгэрийн хаанчлалыг байгуулахын тулд та хоёрын дотносолыг гүнзгийрүүлж, үр нөлөөг чинь тэлэхийг хүснэ. Тэрбээр та хоёрын дотор санаанд оромгүй, эрс арга замаар ажиллахыг хүснэ. Магадгүй та өмнөх бүлгүүдийг уншиж байхдаа, том мөрөөдөж зүрхлэхгүй байсан байх. Гэхдээ одоо зүрхлэн мөрөөд!

Бурхан аливааг үйлдэхдээ бидний зөвшөөрлийг авдаггүй ч, бидэнтэй түншлэхийг хүсдэг. Түүнд бидний тус хэрэггүй ч, Тэр бидний оролцоог хүсдэг. Гэрлэлтээ дахин эхлүүлж буй танаас бид үүнийг л хүснэ: одоогоор боломжгүй харагдаж буй зүйлийг зорь.

Боломжгүй зүйл яаж боломжтой болдгийг харуулсан нэгэн түүх бий. Энэ явдал хүн төрөлхтөн газар дэлхийг дүүргэ гэсэн Бурханы тушаалын өөдөөс тэрсэлсэн, тийм л хүнд хэцүү үед болжээ.

Бидний эцэг өвгөд тархахын оронд, нэг дор суурьшиж, Адам Ева хоёрын амьдран сууж байсан Еден шиг тэнгэрлэг газар сүндэрлүүлэхийг хүсчээ. Тэгээд Бурхан Бабел цамхагийн ажилд хэрхэн хөндлөнгөөс оролцсон түүхийг та мэдэх буй за.

ЭЗЭН хүний хөвгүүдийн барьж байгуулсан хот ба цамхгийг үзэхээр бууж иржээ. ЭЗЭН айлдсан нь —Эдгээр хүмүүс нэг үндэстэн, бас нэг хэлтэн учир

тэд үүнийг хийж эхэлсэн бөгөөд хойшид тэдний хийхээр төлөвлөсөн ямар ч зүйл тэдний хувьд боломжтой болно. Бид бууцгааж, тэдний хэлийг тэнд нь хутгалдуулан самууруулъя. Ингэснээр тэд бие биенийхээ яриаг ойлгохгүй болно гэжээ. Тэгээд ЭЗЭН тэднийг тэндээс бүх дэлхийгээр тараасанд тэд хот байгуулахаа зогсоожээ.... (Эхлэл 11:5-8)

Энэ бүтээн байгуулалтыг Бурхан эхлүүлээгүй бөгөөд хэрэв Бурхан зогсоогоогүй бол, хоёр хүчин зүтгэлийн улмаас энэ нь биелэх байлаа: нэгэн хэл, эв нэгдэл. Хэрэв энэ хоёр элемент нь дуулгаваргүй хүмүүсийн хувьд боломжтой байсан юм бол, Христийн дотор нэгэн бие болсон хүмүүсийн хүч ямар байх бол?

Хоёрдугаар өдөр

Тэнгэрийн хэл

“Учир нь зүрх нь юугаар дүүрснийг ам нь ярьдаг.
(Лук 6:45)

Бид номынхоо турш Бурханыг зүрхэндээ ажиллуулах талаар ахин дахин ярилаа. Та өөрийгөө Ариун Сүнсэнд захируулж, Түүний үгд захирагдахад, өөрчлөлт ирнэ. Зан авирын түр зуурын өөрчлөлт нь дотоод өөрчлөлтийг орлохгүй гэдгийг бид өмнө хэлсэн. Хүн дотроосоо өөрчлөгдөхөд, гадаад ертөнц нь цоо шинээр бүтээгддэг. Бурхан зүрхэнд чинь ажиллаж буйн эхний нотолгоог таны амны үгээс харж болно.

Нөхцөл байдал бүр бидэнд тэнгэрийн хэлээр ярих уу эсвэл газрын хэлээр ярих уу гэсэн сонголт олгодог.

“Учир нь Миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр” гэж ЭЗЭН айлдаж байна. Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол та

нарын бодлоос өндөр билээ. Бороо, цас тэнгэрээс бууж ирээд, газрыг услахгүйгээр буцдаггүй шиг, (харин газрыг ургуулж цэцэглүүлж, тариачинд үрийг, идэгчид талхыг нь хангадаг.) Миний амнаас гарсан Миний үг хүслийг минь гүйцэтгэхгүйгээр, илгээсэн зорилгыг минь хэрэгжүүлэхгүйгээр Над уруу хоосон буцаж ирэхгүй. (Исаиа 55:8-11)

Бурханы хэлээр ярихын тулд бид Түүний Үгийг мэддэг байх ёстой. Энэ нь бидний алсын харааг өөрчилж, хараахан байхгүй зүйлийг харж, тунхаглахад хүргэнэ. Энэ нь бидний амнаас унах үгийг эерэг хандлага юмуу сэтгэл санааны өөдрөг байдлаас хавьгүй том итгэлийн хэл рүү хөрвүүлнэ. Энэ нь амлагдсан зүйлд бат итгэх бат итгэл юм.

Тэнгэр болон газрын хэлийн ялгааг жишээгээр харуулъя:

Дэлхийн хэл “Сал” гэдэг бол, тэнгэрийн хэл “Нэгд” гэдэг.
Дэлхийн хэл “Найдваргүй” гэдэг бол, тэнгэрийн хэл “Бүх зүйл боломжтой” гэдэг.

Дэлхийн хэл “Бүү хүлээж ав” гэдэг бол, тэнгэрийн хэл “Хүлээж ав” гэдэг.

Дэлхийн хэл “Чи надад өртэй!” гэдэг бол, тэнгэрийн хэл “Би чамд зүгээр л өгнө” гэдэг.

Дэлхийн хэл “Өшөө” гэдэг бол, тэнгэрийн хэл “Өршөөл” гэдэг.

Дэлхийн хэл “Би чиний зарц болохгүй” гэдэг бол, тэнгэрийн хэл “Би чиний зарц болно” гэдэг.

Дэлхийн хэл “Би чиний сул дорой байдлыг үзэн ядаж байна” гэдэг бол, тэнгэрийн хэл “Миний хайр чиний сул доройг хаацайлна. Би чиний хүчин чадлыг харж байна” гэдэг.

Дэлхийн хэл “Чи миний хэрэгцээг хангахгүй байна” гэдэг бол, тэнгэрийн хэл “Би чиний хэрэгцээг хангамаар байна” гэдэг.

Эдгээр нь зүгээр нэг сонсголонтой үгс биш, харин Бурханы Үгийн үнэнд гүн үндэслэхээрээ насан турш ургаж, хүчирхэгждэг үгс юм. Бид таныг тэнгэрийн хэлээр ярьж сурахыг ятгаж байна.

Хэлд амь бөгөөд үхлийн хүч байдаг бөгөөд итгэлээр бид харахан байхгүй зүйлсийг ч байгаа гэж хэлж чадна (Сургаалт үгс 18:21, Ром 4:17). Бурханы Үг таны ертөнцийг хэлбэршүүлэх болтугай.

Үнэнийг ярих

... харин хайр дотор үнэнийг ярин, тэргүүн болох
Түүн уруу, Христ уруу бүх талаар өсөх ёстой.
(Ефес 4:15)

Тэнгэрийн хэлээр ярина гэдэг нь үнэнийг ярина гэсэн үг. Гэхдээ үнэнийг ямар байдлаар ярьж байгаа нь чухал юм. Бурханы хэлээр ярина гэдэг нь үнэнийг хайраар ярих юм.

Ихэнх хос эрс тэс хоёр хандлагын аль нэгийг нь л хэрэглээд байдаг. Зарим хүн хань ижлээ доош хийж, довтлохын тулд Бурханы үгийг хэрэглэдэг. Тэд үнэнийг хэлдэг ч, гомдол, уур, өшөө, хорслоор хэлдэг. Зарим хүн зовлон учруулж, зөрчил гаргахыг хүсэхгүй учраас хэлэх ёстой үнэнийг хав дарж, маш гүехэн хайрын давхарга дээр л амьдардаг. Цаг хугацааны явцад энэ нь цөхрөл гомдлын ан цавыг лавшруулж, яваандаа их бага хэмжээний тэсрэлтэд хүргэнэ. Энэ хоёрын аль нь ч Христтэй улам бүр адилхан болгох гэсэн Бурханы санаанд хүргэхгүй.

Та хань ижлийнхээ сул талыг хэнээс ч илүү сайн мэднэ. Тиймээс энэ мэдлэгээ хань ижлээ шархлуулж, яллаж, ичгүүрт оруулах зэвсэг болгон ашиглаж чадна. Гэхдээ бид илүү дээд дуудлагатай биш үү? Бид хань ижлийнхээ ашиг сонирхлыг дээдлэж, түүнийхээ хамгийн сайн зарц байх шийдвэр гаргасан хүмүүс. Бидний үнэний үг хань ижилд маань Христтэй улам бүр адилхан болоход туслах учиртай. Харин би энэ хэлээ шархлуулах зэвсэг болгоод байвал, хэзээ ч мөнхийн үнэ цэнэтэй үг хэлж чадахгүй.

Гэрлэлтээ эрүүл саруул байлгахыг хүсбэл, бид буруу, сүйтгэгч зан авираа шийдэх хэрэгтэй ч, үүнийг хийх зөв цаг, зөв газар гэж

байна. Маргааны дунд хань ижлийнхээ сул талыг чичлэх нь хэзээ ч эерэг өөрчлөлтөд хүргэхгүй. Үүний оронд энэ нь хамгийн дорд зан авир, хортой хариу үйлдлийг төрүүлнэ. Ярилцах ёстой юм байвал, хоёр биеэ тайвширтал хүлээ. Хэрэв энэ нь ноцтой асуудал бол, бүрэн дүүрэн ярилцаж, шийдэхийн тулд тусгай цаг гаргаж байгаад нэг мөр болго.

Лиза миний бие Бурханы хэлсэн нэг үгийг хэзээ ч мартдаггүй юм. Тэр надад “Лиза, хэрэв чи чамайг сонсоосой гэж хүсч байгаа бол, өөрийнхөө сонсмоор байгаа арга байдлаараа ярь” гэж айлдсан юм. Яг үүнтэй адилхан “Та ямар үед сонсмоор байдаг - яг тийм үедээ ярьж бай.” Хэрүүл маргаан нь амин чухал асуудал авч хэлэлцэх зохистой цаг биш юм. Харин хань ижил чинь тайвширсан, ухаан санаа нь тогтуун үед л засвараа хийсэн нь дээр. Та ядарсан үедээ амарсан нь дээр. Бие биеэ уучилж, тэвэрч, маргааш өглөө нь ч юмуу ярилцахаар тохиролц.

Бид эмзэг үнэнийг хайраар өлгийдөж, илэрхийлэх ёстой юм шүү. Хэн ч муу муухайгаараа дуудуулах дургүй ч, сонсох чихтэй хүн өсч төлөвших боломжтой талаа мэдэх үүднээс чих тавин сонсдог.

Зөвлөгөө өгөхөөсөө өмнө санаа сэдлээ шалга. Өөрөөсөө “Би үүнийг хайраар хэлж байна уу эсвэл өөрийнхөө төлөө, өөрийгөө хамгаалах гэж хэлж байна уу? Би ханийхаа сайн сайхныг эрэлхийлж байна уу эсвэл өшөө авах гэж байна уу? Хэрэв хэрүүл маргаан ид өрнөж байхад та ханьдаа зан авираа өөрчлөхийг сануулж байгаа бол, санаа чинь амиа хичээсэн байдал дээр үндэслэсэн байх магадлалтай.

Сэтгэл санаагаар хямарсан үед үнэнийг хайраар ярих тун хэцүү. Энэ үед та хэлээ хазаад өнгөрбөл, та дараа нь 1. Өөрийнхөө буруу байсныг ухаарч, дэмий балай юм хэлчихээгүйдээ талархана; 2. Дараа нь ханийхаа сонсох хэрэгтэй зүйлийг хожим тайвнаар оновчтой хэлнэ.

Жижиг зөрчилд нүдээ аньж, Бурханд даатгах нь хамгийн сайн сонголт байдгийг бид сурсан билээ. Гэхдээ зарим шарх нь мартагын аргагүй зовиуртай байдгийг бид сайн мэднэ. Хань чинь байнгын, аюултай зан авир гаргаж буй нөхцөлд хэлээ тас хазаад өнгөрөх нь эрүүл биш ч, ярилцаж байна гээд хань ижлээ

шархлуулах эрх танд байхгүй. Тиймээс та үнэнийг хайраар хэлэхдээ дараах зүйлийг нягтлаарай:

- Өөрийнхөө санаа сэдлийг Бурханы Үгийн гэрлээр шалга.
- Зөрчлийг хань руугаа дайрч биш, асуудал руугаа довтолж шийд.
- Хамаа намаагүй зүйл хэлж ярихгүйн тулд хэл амаа хазаарла.
- Нигүүлсэнгүй бай.
- Шударга бай.
- Эелдгээр хариул.
- Цаг үргэлж найдвар тээ.
- Тантай яаж яриасай гэж хүснэ - яг л тэгж ярь.
- Нүүр тулах үг, цаг, газраа сонго.

Соломон “төмөр төмрөө хурцалдаг шиг, найз нь найзаа хурцалдаг” гэж хэлсэн байдаг (Сургаалт үгс 27:17). Санал зөрж, үл зөвшилцөх нь ямар ч харилцаанд байдаг л зүйл. Зөвөөр шийдэж чадбал, эдгээр зөрчил нь бидний амьдралд бурханлаг байдлыг суулгана.

Гэрлэлтийн чинь нэгдэлд саад хийх асуудлыг нэг мөр шийдэх нь чухал юм. Зөв зүйтэй эмчлэхгүй аваас бяцхан шархууд нь яван явсаар гүн гүнзгий шарх болох агаад ихэвчлэн хань ижил маань бидэнд учруулж буй өвчин зовиураа мэдэхгүй явдаг. Асуудлаа Бурханыг болон бие биеэ гэх хайраар шийдэх нь биднийг эв нэгдлээр өсгөж, илүү сайн хос болгоно.

Гуравдугаар өдөр

Хайрын хэл

Бид ханьдаа үйлчилдэг шиг хань маань бидэнд үйлчлэхгүй байж болох талаар бид дөрөвдүгээр бүлэгт ярьсан. Үүнтэй адилхан хүмүүсийн хайраа өгч, хүлээж авах арга зам өөр өөр байдаг.

Хайрын төрөл бүрийн аялгыг танд хөрвүүлж өгөх, онцсайн ном бол (энэ ном бидний гэрлэлтэд ч ач тусаа өгсөн) Гарри Чапманы “Хайрын таван хэл” юм.

Энэ нь яагаад тийм чухал болохыг ойлгуулахын тулд бид өөрсдийнхөө амьдралаас жишээ татах болно. Лиза миний хувьд цагийг хамтдаа өнгөрөөж, үйлчилсэнээр хайраа гол төлөв илэрхийлдэг. Тухайлбал би Жонд хайртайгаа харуулахын тулд тасралтгүй юм хийдэг байв (угаалга, хоол хийх, цэвэрлэх, үр хүүхдээ өсгөх, будах, цэцэрлэгээ арчлах). Түүнчлэн юм хийж байх зуураа Жонтой гүн гүнзгий, утга учиртай яриа өрнүүлэх нь миний хувьд хайртай гэж хэлэхийн илэрхийлэл байлаа.

Харин Жон миний бие Лизагаас тэс өөр хүн. Би хайраа хүрэлтээр, хайрын үгсээр хүргэдэг. Лиза амттай хоол хийж, хивсээ цэвэрлэвч, би түүнээс “Би чамд хайртай!” гэдэг үг сонсдоггүй байлаа. Би Лизад магтаалын үгс хайрлаж, илж таалавч, үүнийг маань Лиза “Би чамд хайртай!” гэж сонсохгүй байлаа. Яг л хоёулаа харь хэлээр яриад байгаа мэт.

Гэрлэлт эрүүд саруул байхын тулд хоёр хүн хүсч буй арга замаараа хайрлагдаж, баяртай байх учиртай. Тиймээс бие биедээ хайрыг ямар арга замаар сонсдог мэдүүлэх нь буруу биш юм. Та хоёр Гарри Чапманы “Хайрын таван хэл” номыг уншаад, ярилцаасай гэж хүсч байна. Та хоёр яаж бие биеийнхээ хайрын хэлээр ярих вэ? Энэ яриаг хэн хэнээ яллаагүй, эелдэг байдлаар өрнүүлэх хэрэгтэй. Тухайлбал “Чи намайг тэврэхэд, би хайр мэдэрдэг эсвэл надад сайхан байдаг” гэх мэтээр хоорондоо ярилц.

Зориуд ханийнхаа хайрын хэлд таарсан үг юмуу үйлдэл хэрэглэх нь та хоёрын хайрын үгсийн санг чинь баяжуулна. Тэнгэрийн хэлээр, хайраар үнэнийг ярьсанаар та хоёрын суурь бэхжинэ. Нэгтгэн дүгнэбэл, эдгээр нь та хоёрын дунд өөрийн гэсэн хэл бүтээнэ.

Даалгавар дор

Эв нэгдэлтэй байхын ач тусыг Есүс үйлчлэлийнхээ турш цохон тэмдэглэсэн байдаг. Жишээлбэл Иохан ном дээр тэмдэглэсэн түүхийг үзнэ үү. Есүс цовдлуулахынхаа өмнөх шөнө бидний нэгдлийн төлөө залбирсан юм:

Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гуйж байна. Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ. Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Таны Надад өгсөн сүр жавхланг Би тэдэнд өгсөн билээ. Би тэдний дотор, Та Миний дотор байдаг. Ингэснээр тэд төгс нэгдэн, Таны Намайг илгээснийг болон Намайг хайрласны адил тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно.
(Иохан 17:20-23)

Эв нэгдэл нь Бурханы алдрыг харуулдаг. Бурханы Хүүгийн эвлэрлийн ажлын хүчинд захирагдах нь эв нэгдэл юм. Олон хүн Сайн мэдээг учир зүйн ухаанаар юмуу хүчтэй мэтгэлцээнээр батлах гэж оролддог ч, дэлхийг хайрлах Бурханы хайрыг гэрчлэн харуулах хамгийн эхний бөгөөд шилдэг гэрчлэл нь хүмүүсийнхээ дунд харуулсан Бурханы хайр юм.

Эв нэгдэл нь Бурханы хаанчлалын гаднах хүмүүст хандсан үг биш; энэ нь бидэнд ч ач тустай юм. Эв нэгдэлтэй газар л Бурхан ерөөлөө тушаадаг (Дуулал 133). Ийм замаар эв нэгдэл нь харанхуйн хаанчлалд аюул занал болдог: энэ нь Бурханы хүмүүст таалал авчирч, үүнийхээ хажуугаар алдагдсан хүмүүст өөрсдийнх нь гэх Бурханы хайрын тэмдэг болдог.

Дайсан та хоёрын гэрлэлтэд эв нэгдэлгүй байдал авчрахын төлөө бүхнийг хийдэг нь ч гайхах зүйл биш ажээ. Үүнд өчүүхэн ч амиа хичээсэн явдал, айдас дусал нэмэр болно. Эв нэгдэлтэй байх нь дайсантай болон өөрийнхөө махан биетэй дайтахад хүргэдэг учраас хүнд хүчир хөдөлмөр юм. Тиймээс бид Бурханы Сүнсний нигүүлслийг болон бэрхшээлийг сарниадаг зорилгоо ухаарч байх шаардлагатай. Одоо Ефес 5:21-г дахин харъя:

Христээс эмээн нэг нэгэндээ захирагд.

Өмнөх бүлэгт бид бие биедээ үйлчлэн захирагдах хосын тус бүрийн үүрэг оройлын талаар ярьсан. Харин одоо бид захирагдах

талаар болон энэ нь бидэнд яаж нэг байхад тусладаг талаарх таны ойлголтыг улам лавшруулахыг хүсч байна.

Захирагдахуй буюу англиар submission гэдэг үгийн sub гэдэг утгвар нь “доор” гэсэн утгатай болно. Дүгнэбэл

submission буюу захирагдахуй гэдэг үг нь “даалгавар эсвэл илгээлт дор” гэсэн утгатай ажээ. Та магадгүй хэдийнээ гэрлэлтийнхээ зорилгыг баримтжуулж, түүндээ хүрэх алхмаа төлөвлөө байх. Тиймээс захирагдах дуудлага нь таны гэрлэлтдээ хүсч буй зорилго бүр нь Бурханы хайр ба алдрыг харуулах туйлын зорилго дор орно гэдгийг сануулах санамж юм. Хосын аль аль нь Бурханаас өгөгдсөн энэ даалгарын эрх мэдэлд захирагдах ёстой бөгөөд иймээс л бид нэг байх ёстой аж.

Энэ үзэл бодол нь хосын аль алийг гэрлэлтдээ хүчтэй байх чадвартай болгож байгаа юм. Захирагдах нь хосын нэгийг нь хүчтэй, нөгөөг нь дорой байхыг шаардахгүй. Гэрлэлт нь биднээс хавьгүй том даалгавартай учраас хүчтэй нэгдлийг байгуулахын тулд хоёр хүчтэй хүн хэрэгтэй. Хүчтэй гэдэг нь хүчтэй зантай эсвэл тамирын хүчтэй байхыг хэлээгүй гэдгийг ойлгоорой. Бид хувь нэмрийн талаар ярьж байна. Гэрлэлт нь ноёрхох бус, эзэн байх асуудал гэдгийг өмнө ярьсан билээ.

Жон миний бие зарим талаараа гэргийгээсээ хавьгүй илүү ур чадвар, нөлөөтэй байдаг. Гэргий минь ч үүнийг баяртайяа дэмждэг. Лизад ч надаас хавьгүй чадалтай чадвартай тал олон бий. Би ч Лизагийнхаа тэр ухаан, ур, туршлагыг бишэрдэг. Бид хоёр нэгэн даалгавар дор нэгдсэн бөгөөд даалгавар маань биднээс хамгийн шилдгийг шаардана.

Жон санхүүгээ барихдаа үргэлж сайн байсан. Бурхан бидний хэрэгцээг хангана гэдэгт Жон хэзээ ч эргэлзэж байгаагүй. Бидний аж төрж байсан байшин болгоныг Жон л олдог байсан. Төлбөр тооцоогоо Жон хийдэг болсоноос хойш Лиза миний мөр хичнээн хөнгөрсөн гэж санана. Өмнө нь Жоны зогсоо зайгүй аялал, албан ажлаас бол би энэ ажлыг хийдэг байлаа. Гэтэл Жон миний зовлонг хараад, өөрөө энэ ажлыг хийхээр болсон юм. Түүний хувьд амархан байсан зүйл надад зовлонтой байв. Жон байшин, машин зэрэг худалдаа наймаа хийхдээ мундаг. Жон тэмцээн, тоглоомоор хөвгүүдтэйгээ нөхөрлөхдөө сайн.

Харин Лиза миний бие орон гэрээ авч явна. Би гэрээ халуун бүлээрээ ширээгээ тойрон хооллодог, дулаан газар байлгахыг эрмэлздэг байлаа. Хөвгүүд маань гэртээ найзуудаа авчирдаг байгаасай гэж хүсдэг байлаа. Түүнчлэн Жон маань аялалаас эргэж ирээд гэртээ тухладаг байгаасай гэж хүсдэг байлаа.

Та хоёрын хэн нь юундаа хамгийн сайн болохыг тодорхойлоод, бие биеийнхээ хийж чаддаг ажилд орон зай тавьж өгөөрэй. Бие биедээ сайн дураараа захирагдсанаараа та хоёр даалгавраа хавьгүй сайн гүйцэтгэнэ.

Дөрөвдүгээр өдөр

Амьдралын эрэмбэ

Ганцаараа байснаас хоёул байх нь илүү дээр болой.
Тэгвэл тэд ажил үйлсээ сайнаар эргүүлэх болно.
(Номлогчийн үгс 4:9)

Даалгавар болон амьдралын эрэмбэ нь нэг ижил зүйл биш боловч, хөтлөлцөн алхдаг юм. Хос ижил зүйлийг чухалчилж, дэмжих нь эв нэгдлийг сахихад амин чухал билээ.

Бидний амьдралын эрэмбэ нь Бурханы хайрыг мэдэж, илчлэх аугаа зорилгоор хөтлүүлнэ. Энэ нь итгэгч бүрийн даалгавар билээ. Хэдийгээр хос нэг бүр тухайн улирлаасаа шалтгаалаад өөр өөр стратегиэр даалгавраа биелүүлдэг ч, бидний амьдралын эрэмбэ ижил байх хэрэгтэй. Бидний амьдралын эрэмбэ дараах байдлаар эгнэх ёстой:

1. *Бурхан*. Үнэндээ Бурхан “нэгдүгээрт” биш, харин бүхний дээр байдаг бөгөөд Бурхантай тогтоох харилцаанаас л амьдралын маань бусад бүх зүйл хамаарна. Бурхан бидний амьдралын бүх эрэмбийн тэргүүнд залрах ёстой. Зүгээр ойлгомжтой болгох үүднээс л бид Бурханыг “нэгдүгээрт” жагсаалаа. Тэгэхээр юу гэж хэлдэг билээ? Хамгийн түрүүнд Бурхан!

Гэхдээ бидний Бурхантай тогтоох харилцаа нь бидний Бурханы төлөө хийдэг ажлаас өөр юм. Нэн ялангуяа чуулганд үйлчилдэг хүмүүс үйлчлэлийн ажлаа гэр бүлээсээ тэргүүнд тавих өдөөлттэй байнга тулгардаг. Гэр бүлээ ийм завхралын идэш бүү болгоорой.

2. *Хань ижил.* Энд ч бас өндөр төлөөстэй завхрал явагдах боломжтой. Хүүхдүүд чухал боловч, ханийхаа дээр тавьж болохгүй. Үр хүүхэд чинь нас биед хүрээд, яваад өгнө. Харин таны хань та хоёр насан турш хүчинтэй байх гэрээний харилцаа байгуулсан хүмүүс. Үр хүүхэд чинь явсан ч, та хоёр хамгийн сайн найз хэвээрээ үлдэх, тийм арга замаар л амьдралаа байгуулаарай.

3. *Үр хүүхэд.* Хүүхдээ хүн болгох ажилд аав, ээжийн гүйцэтгэх үүрэг оройл дуудлагаас хамааран улирал бүр өөр байж болно. Хэрэв эхнэр нөхрийн нэг нь гадуур ажилладаг бол, та хоёр нэмэлт ажил бизнес эсвэл үйлчлэлийн үүрэг хариуцлагатай болно гэсэн үг.

4. *Дуудлага.* Үнэндээ дуудлагад энэ жагсаалт дээрх бүх зүйл болон таны амьдралын бүх зүйл орно. Гэхдээ тодорхой байлгах үүднээс бид энэ нэр томъёонд хил хязгаар тогтоож өгье. “Дуудлага” гэдэг нь Бурхан таныг болон таны ханийг засаг захиргаа, бизнес, эрүүл мэнд, боловсрол, үйлчлэл, урлаг, хэвлэл мэдээ зэрэг талбарт хувь хүнийхээ хувьд хийлгэхээр дуудсан зүйлийг хэлж байгаа юм.

Бид хоёр нэг талбарт үйлчилдэг. Гэхдээ маш олон хос хамтдаа нэг талбарт ажиллаж, үйлчилдэггүй. Та хоёр өөр өөр салбарын хүмүүс ч гэсэн, хоёр биеийнхээ ажлыг сонирхож, бие биедээ чухал дэмжлэг өгсөөр байж чадна. Хоёр хүн хамтдаа ажиллабал, бие биеэ амжилтанд хүргэж чадна гэж Соломон хэлсэн билээ.

5. *Амралт.* Саббат нь хүнээр биш, Бурханаар тогтоогдсон юм. Амрах үед нэн чухал зүйл бүр маань цэцэглэдэг. Бурхан биднийг тогтмол амарч, зугаацаж байгаасай гэж хүсдэг. Бид сүнс, бие, сэтгэл санаагаар биднийг дахин сэргээх зүйлсэд цаг гаргахын төлөө амардаг. Гэхдээ гэр бүлийн амралтын онцлог нь бид ганцаараа амрах биш, харин хамтдаа амарч зугаацах арга зам олох учиртай. Өөрөөр хэлбэл хоёулаа дурлаж, сонирхдог зүйлээ ол. Жишээлбэл: салхинд хамт гарч, гэр бүл, үйлчлэлд маань хандсан хүсэл мөрөөдлийн талаар ярилцах. Хамт амарч, зугаацаж сурах нь хоёр хүн нэг болох үйл явцсын амин чухал хэсэг юм.

6. *Нийгэм.* Маш олон гэрлэлтэд, эхнэр нөхөр тэс өөр нийгмийн амьдралтай байдаг. Хэдийгээр бид эхнэр юмуу нөхрөөсөө өөр хүмүүстэй харилцаа байгуулж, хөвгүүд, охидын цаг гаргаж байх нь эрүүл гэрлэлтэд чухал боловч, хосын нийгмийн амьдрал заавал огтлолцож байх ёстой. Биднийг урамшуулж, дэмжиж, хүчирхэгжүүлэхэд найз нөхөд маань чухал үүрэг гүйцэтгэдэг. Бид нэгэн бие учраас бидэнд биднийг хоёуланг маань мэддэг, хайрладаг олон найз хэрэгтэй.

Найз нөхөд чинь та хоёрын нэгдлийг ерөөдөг байх нь чухал шүү. Бид хоёрт бидний амьдралд өөр өөр үүрэг оройл гүйцэтгэдэг найзууд бий. Жон миний бие гольф тоглодог найзуудтай. Тэдний дунд зүрх сэтгэлээ уудалдаг дотно найзууд ч бий. Бэрхшээл болон сул талаа хуваалцдаг тэдгээр эрчүүд Лиза бид хоёрт хоёуланд нь хайртай.

Харин Лиза би завгүй учраас гольф тоглодоггүй ч, надад хайрын тал дээр илүү гүн гүнзгий өсөхөд уриалдаг зүрхний найзууд бий. Тэдний зарим нь үйлчлэлд гарсан бэрхшээлийн үед миний хамгийн дотны нөхөд болдог, харин зарим нь харилцааны асуудал дунд сайн нөхөд болдог. Тэд бидэнд алтнаас ч үнэтэй.

Нэгэн цагт бидний нөхөд байсан ч, холдохоос өөр аргагүй болсон хүмүүс ч бидний амьдралд бий. Тэд бид хоёрыг хоёуланг маань биш, хэн нэгийг маань таалсан учраас бидний гэрлэлтэд

эв нэгдэл авчраагүй юм. Хэрэв найз чинь та хоёрын хоёулангийн төлөө биш бол, түүнтэй бүү харилц. Тэд та хоёрын нэгдэлд заавал хагарал авчирна.

Хайрлахыг сонгох

Тиймээс Бурханаар сонгогдсон, ариун хийгээд хайрлагдсан хүмүүсийнхээ хувьд та нар өрөвч зүрх, энэрэл, даруу байдал, дөлгөөн зан, тэвчээрийг өмс. Ингэхдээ нэг нэгнээ хүлцэж, бие биеэ уучилж, хэрэв хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал та нарыг Эзэн уучилсны адил та нар бас уучил. Энэ бүгдийн дээр хайрыг өмс. Хайр бол эв нэгдлийн төгс холбоос юм. (Колоссай 3:12-14)

Хайр биднийг хослон зохицлоор зангиддаг. Энэ нь эв нэгдлийн суурь бөгөөд боломжгүй зүйлсийг боломжтой гэж харах жинхэнэ түлхүүр юм.

Ефес 5:28 дээр Паул “нөхрүүд эхнэрээ хайрлах ёстой” гэжээ. “Ёстой” гэдэг нь маш хүчирхэг үүрэг хариуцлагыг онцлон тэмдэглэсэн үг. Тиймээс бид бие биеэ хайрлах ёстой.

Манай соёл хайрыг хянах аргагүй, гагцхүү хариу үйлдэх ёстой сэтгэл мэдрэмж хэмээн дүрслэдэг. Бид хэрэв хайрыг мэдэрбэл, яг л дурласан хүн шиг үйлдэнэ. Гэхдээ төд удалгүй бид хайрын мэдрэмж төрөхгүй ч, хайрлаж болдгийг сурдаг. Бурхан биднийг хайрлахаар сонгосон. Хайрлах сонголт хийбэл, үйлдлийг маань дагаад төдөлгүй мэдрэмж ч төрнө. Хайрын тодорхой мэдрэмж байхгүй байсан ч, хайрлах сонголт хийх итгэлийн үйлдэл нь уулыг хөдөлгөдөг. Бурхан бидний үйлдлийг ерөөхийн хүслэн болдог. Детрих Бонховер:

“Хайр гэрлэлтийг авч явдаггүй, гэрлэлт хайрыг авч явдаг юм. Харин та сэтгэл санааны болон сүнслэг ханалаа Бурханы Сүнстэй харилцах харилцаанаас авдаг болсон цагт л гэрлэлт чинь хайрыг авч явдаг болно. Бид өөрийнхөө хүч чадал зэрэг буруу эх

үүсвэрээр хайрлах гэж оролдох үед мэдрэмж байхгүй бол хайрлаж чадахгүй. Харин Бурханы хайр дотор суурилсан бол, мэдрэмж төрөхгүй үед ч хайрын үйлс маань биднийг нэг байлгаж дийлнэ” гэжээ.

Бүү эндүүрээрэй. Гэрлэлт нь ямар ч мэдрэмжгүй хөндий хоосон зүйл биш юм. Гэхдээ Си. Эс. Льюис ийнхүү хэлжээ:

“Бидний дүрэм маш энгийн. Та хөршөө “хайрлаж” чадаж буй эсэх дээр цагаа бүү үр. Үүний оронд хайртай юм шиг үйлд. Үүнийг хийбэл төдөлгүй бид нэгэн том нууцыг мэднэ. Та хэн нэгэнд хайртай юм шиг үйлдбэл, төдөлгүй түүнийг хайрлаж эхэлнэ.”

Хайр мэдрэгдэхгүй байсан ч, та хань ижилдээ хайраа харуулсаар, үйлчилж, баярлаж, дэмжсээр байж чадна. Амьдрал чинь хайртай эгнэхэд, сэтгэл мэдрэмж чинь эцэстээ үйлдлийн чинь харуулж буй зүйлийг батлах болно.

Тавдугаар өдөр

Ханиа цэцэглүүл

Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад түүнийг ямар ч толбогүй, ямар ч үрчлээсгүй бөгөөд тиймэрхүү ямар ч зүйлгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн ажээ. (Ефес 5:26-27)

“Мэргэн эмэгтэй орон гэрээ төвхнүүлдэг” (Сургаалт үгс 14:1) гэж Соломон хэлсэн. Мэргэн эмэгтэй гэрээ төвхнүүлдэг бол, мэргэн эр эхнэрээ барьж байгуулдаг! Бие биеэ байгуулсанаараа бид бие биедээ Христтэй адил байдлыг харуулж байгаа юм. Гэрлэлтэд маань хандсан Бурханы хамгийн сайныг таньж мэдэх нь бие биеийнхээ хамгийн сайныг олборлоно гэсэн үг.

Хань ижлээ хайрлах хайр нь тэнгэртэй түншлэх үйлдэл, Бурханы таалалтай зөвшилцөх зөвшилцөл юм. Бурхан таны хань ижлийг хэн болохыг сул талаар нь биш, харин Өөрийнхөө нигүүлсэл хайраар тодорхойлдог. Бурхан таны хань ижлийн хүчин чадлыг хардаг бөгөөд таныг ч бас тэгээсэй гэж хүснэ.

Лиза жаахан байхдаа хорт хавдраас болж нэг нүдээ алдсан учраас үүнээсээ болж, хүмүүсээс ихэд айж ичдэг байлаа. Жон миний бие Лизагийн энэ айдсыг мэддэг ч, Бурхан түүнд ер бусын цэц ухаан хайрласныг бас мэддэг байлаа.

Би залуусын пастор байхдаа, Лизагаас охидын бүлэгт хичээл зааж өгөхийг гуйдаг байв. Гэтэл тэрбээр “Яасан ч үгүй! Чуулган чинь чамайг хөлсөлсөн болохоос биш, намайг хөлслөөгүй” хэмээн дургүйцдэг байв.

Лиза Бурханы бэлгийг эсэргүүцсэндээ биш, харин хүмүүсийн өмнө гарахаас айсандаа ингэж байгааг би мэддэг байлаа. Лиза олны өмнө гарахаас маш их айдаг байсан ч, хааяа нэг ярьсаных нь дараа хүмүүс надад Лизагийн үгээр хичээн их ерөөгдсөнөө хэлдэг байсан юм. Тиймээс Лизаг эсэргүүцэх үед би түүнд: “Орой бэлэн байгаарай” гэж хэлдэг байв.

Лиза миний бие Жон намайг шал өөр хүн болгох гэж хүчлээд байна гэж харддаг байлаа. Залуусын бүлгийн охидод эмэгтэй хүний дуу хоолой хэрэгтэй гэдгийг Жон мэдэж байсан ч, би өөрийгөө багшид огт тэнцэхгүй гэж үздэг байлаа. Жон бүлгийнхээ охидод үлгэр жишээ болох хүнийг хайхаас гадна миний бэлэг авъяасыг цэцэглүүлэх орчин хайж байсныг би ойлгодоггүй байв. Миний өөрийн харж чадахгүй байсан зүйлийг Жон надаас олж харжээ. Заримдаа би өөрөө олж харсан ч гэсэн, намайг битгий яриулаач гэж шөнөжин Жоноос гуйдаг байлаа. Би үнэхээр дургүй байлаа. Гэхдээ одоо бодоход Жон намайг айдас, хүлээсээ тасар татан чөлөөлөгдөөсэй гэсэндээ хайраар түлхэж өгдөг байжээ.

Жон надад тусласан шиг би ч бас түүнд өөр өөр арга замаар туслдаг байв. Гэрлээд удаагүй байхдаа би түүний номыг хянан засах ажлыг маш сайн хийдэг байлаа. Тийнхүү тэдгээр нь яг түүний зүрхийг илэрхийлдэг байв. Бид бие биеэ өсгөхийг хүссэн учраас л хамтдаа үйлчлэх боломжтой болсон юм.

Магадгүй таны хань ижил та хоёр бие биеэ яаж дэмжихээ мэдэхгүй байж болно. Магадгүй бүр дотно байдал, нөлөөгөөрөө

бие биеэ унагаж, нураадаг ч байж болно. Тэгвэл өнөөдөр та хоёрын шинэ эхлэл юм. Та хоёр шинэ жишиг тогтоож чадна.

Шинээр эхлэхэд хэзээ ч оройтохгүй. Хэрэв та хань ижилдээ тусламаар байгаа бол, хань ижилтэйгээ Бурханд хандан ийнхүү залбирна уу:

Тэнгэрлэг Аав минь ээ, бидний дунд Таны тогтоосон нэгдэлд буруу ташаа хандсандаа би гэмшиж байна. Бидний гэрлэлт Таны шилдэг бүтээл боловч, бид хүндэтгэлтэй, зохистой хандсангүй. Гэхдээ бүхнийг шинээр эхлэх чадвартай болгосон Таны шинэ нигүүлсэлд баярлалаа. Ариун Сүнс минь, бие биеэ Таны хайраар харахад нигүүлсэлээ хайрлахыг гуйж байна. Бие биедээ баясаж, үйлчлэхийг бидэнд зааж өгөөч. Бидэнд өгсөн Таны бэлэг, хүчийг харах нүдийг өгөөч. Бид ганцаараа биш, хамтдаа байхдаа илүү дээр. Өөрийнхөө алдрын төлөө бидний амьдрал, нэгдэлд зориулсан бүрэн дүүрэн байдалд биднийг өсгөөч. Есүсийн нэрээр. Амень.

Харин одоо ханийнхаа нүд рүү харж байгаад ингэж хэлнэ үү:

Нөхөр:

Чамайг дарамталж, доош нь хийхэд л хамаг хүчээ зарсанд уучлаарай. Чиний сайн сайхан зан чанар, гоо үзэсгэлэн, цэц ухаан, эелдэг чанарт хандаж яриагүйд уучлаарай. Чамайг цэцэглүүлэх орчин бүтээгээгүйд уучлаарай. Ярилцахдаа, хамт байхдаа, орондоо амиа бодож байсанд минь уучлаарай. Бурхан бидний нэгдлийг эдгээж, сэргээж, алдаршуулна гэдэгт би итгэж байна. Бидэнд хүчийг өгөгч Түүгээр бид бүгдийг хийж чадна. Бид Есүсийн нэр дор хамтдаа эзэн байж, үржиж, үр жимстэй байна.

Эхнэр:

Чиний сул талыг чичлэхэд хамаг хүчээ зарсанд уучлаарай. Чамайг хүндэтгэхгүй, амиа бодсонд уучлаарай. Одооноос эхлэн би үгээрээ чамайг байгуулна. Чиний зүрхийг

аюулгүйгээр сахин хамгаалж чадаагүйд уучлаарай. Би чамд итгэж байна, бидэнд итгэж байна. Бурхан бүх зүйлийг шинэ болгоно гэдэгт итгэж байна. Би чамайг хайрлаж, уучлахыг сонгож байна. Энэ бол нигүүлсэл, үнэнээр дүүрэн шинэ өдөр. Хамтдаа хайрлаж, мөрөөдье.

Найзууд минь, та хоёрын хамаг сайн сайхан өмнө чинь байгаа гэдэгт бид итгэж байна. Бурханы нигүүлсэлээр та хоёрын өв, дотносол, нөлөө бодож санааснаас чинь давах болтугай. Бие биетэйгээ тогтоох эв нэгдэл, Бурханы Сүнсний хүч ба онгодоор та хоёр газар дээр Бурханы хайрыг харуулж, сэнтийд заларсан Нэгэнд таалагдах түүхийг бичих болтугай.

Бүхнийг шинээр эхлүүлэх тушаал нь бат итгэлтэй байдлын санал юм. Энэ нь амьдралд ганц тохиох боломж биш, харин амьдрал байгаа цагт оршсоор байх боломж юм. Бүхнийг шинээр эхлэ гэдэг нь зүрхээ ирээдүй рүү чиглүүлж, өнгөрсөнөө тавьж, одоогоор амьдрах юм.

Нэгдлээ төгс чадвартай Нэгэнд өгөхөөс нааш энэ номд бичсэн бүхэн нь зүгээр л сайхан санаа төдий болно. Иуда 1:24-25 энэ талаар илчилжээ:

Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйдүлэмжийнбаярхөөртэйгөөр,гэмзэмгүйгээр зогсоож чадах Түүнд, бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, ноёрхол, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амень.

Бурхан бидний сахин хамгаалагч. Зөвхөн Бурхан л бидний гэрлэлтийг сүүдэр дороос гаргаж чадна. Тэр биднээр дамжуулан Өөрийгөө алдаршуулахын тулд бидэнд гэрлэлтийн баяр хөөр, алдрыг итгэмжилдэг. Бидний амьдрал нь биднийг яаж хайрлаж, өтлөж буйг харж буй хүмүүсийн хувьд амийн амьсгалтай, амьд үг юм.

Хавар бүр шинэ эхлэл ирнэ.

Хараач, өвөл өнгөрч, бороо зогсож арилав.
Газарт цэцэгс хэдийн ургаж,
Дуу хуурын цаг ирж, нутагт маань
хүүрзгэнийн дуу сонсогдоно.
(Соломоны дуун 2:11-12)

Нэгдүгээр өдрийн судлал

АУГАА ЗҮЙЛСИЙГ ХҮСЭН ХҮЛЭЭ

*Амьдын газарт ЭЗЭНий сайн сайхныг харна гэж би итгэсэн.
ЭЗЭНийг хүсэн хүлээгтүн. Хүчтэй байж, зүрхээ зоригтой
болгогтун. Тийм ээ, ЭЗЭНийг хүсэн хүлээгтүн.*

- Дуулал 27:13-14

Тэнгэрлэг Аав чинь таны хань ижил та хоёрт маш маш их хайртай. Тэр та хоёрын гэрлэлтийг бүтээсэй гэж хүсдэг. “ЭЗЭН та нарт нигүүлсэнгүй хандан хүлээж байна. Тиймээс Тэр та нарт өршөөл үзүүлэн өндөрт байж байна (Исаиа 30:18).

Харин та өөрөө гэрлэлтээсээ юу хүсэн хүлээж байна? Бурханаар сэргээгдсэн ямар боломжийн төлөө та залбирч, итгэж байна?

Хүсэн хүлээлтийн талаар хэлсэн Бурханы Үгийг эргэцүүлэн бодох цаг гарга.

Учир нь бидний хүсээгүй аймшигт үйлсийг Та хийх үед, Таныг доош буухад уулс Таны оршихуйд чичрэв. Өөрийг нь итгэн хүлээгч нэгний төлөө үйлддэг Танаас

өөр Бурханыг эртнээс нааш тэд сонсоогүй, чихээрээ
сонсоогүй бөгөөд нэг ч нүд хараагүй

- Исаиа 64:3-4

Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг.

Тэдгээр нь энгийн хүмүүст ухаарлыг хайрладаг.

Би Таны тушаалуудад тэмүүлсэн учир

Амаа том ангайн аахилсан.

Таны нэрийг хайрлагсдад үйлддэг шигээ

Над уруу эргэж, намайг нигүүлсээч

- Дуулал 119:130-132

Бидний Эзэн Есүс Христийн Бурхан болон Эцэг
магтагдах болтугай. Учир нь Бурхан Өөрийн агуу
их өршөөлөөрөө Есүс Христийн үхэгсдээс амилсан
амилалтаар дамжуулан биднийг амьд найдвар уруу,
мөхөшгүй, бузартаагүй, алга болчихгүй бөгөөд та
нарын төлөө тэнгэрт хадгалагдсан өв уруу дахин
төрүүлсэн.

- 1Петр 1:3-4

ЭЗЭН та нарт нигүүлсэнгүй хандан хүлээж байна.

Тиймээс Тэр та нарт өршөөл үзүүлэн өндөрт байж
байна. Учир нь ЭЗЭН бол шударга ёсны Бурхан.

Түүнийг хүлээгчид нь бүгдээрээ ерөөгдсөн ажээ!

- Исаиа 30:18

Энэ номын эхэнд бид бодит бус хүсэн хүлээлтийн талаар ярьсан.
Тэгвэл саяын ишлэлүүдээс та зөв зүйтэй хүсэн хүлээлтийн талаар
юу сурав?

Аугаа хүсэн хүлээлт нь Бурханы амлалт, зан чанар, төлөвлөгөөг
мэдэх мэдлэгээр бүрэлддэг.

Бурханд дэндүү хэцүү эсвэл боломжгүй зүйл гэж үгүй. Эхлэл 18:13-14, Матай 19:26; Марк 9:23-24; Лук 1:36-37; Ефес 3:20-р ишлэлийг уншина уу. Эзэн Өөрийнхөө хязгааргүй хүч, чадлын талаар танд юу зааж байна?

Үзэгтүн, Би шинэ зүйл хийнэ.

Одоо тэр нь бий болно.

Та нар үүнийг мэдээгүй гэж үү?

Би хээр талд зам тавьж, цөлд гол урсгана

- Исаиа 43:19

Бид бүхнийг шинээр бүтээдэг Эзэнд үйлчилдэг. Та гэрлэлтийнхээ ямар нэгэн зүйлийг шинэчлэхийг хүсч байна уу? Танд шинэ хайр, мөрөөдөл, нэгдэл эсвэл дотносол хэрэгтэй байна уу? Та Ааваасаа ямар нэгэн зүйл асуухдаа, Түүнээс шинэ зүйлийг хүсэн хүлээж болно. Шинэчлэмээр байгаа зүйлээ бичээд, залбиран Бурханд даатга.

Хоёрдугаар өдрийн судлал

АМИЙГ ЯРЬ

*Амныхаа үр жимсээр хүмүүний ходоод дүүрэх бөгөөд
Тэрээр уруулаасаа гаргах бүтээгдэхүүнээр цадна.
Амь ба үхэл нь хэл ярианы хүчинд байдаг.
Түүнд дуртай хүн эдгээрийн үр жимсийг хүртдэг*

- Сургаалт үгс 18:20-21

Та газрын хэлээр их ярьдаг уу, тэнгэрийн хэлээр ярьдаг уу? Эхнийх нь үхлийг үйлдвэрлэдэг бол, хоёр дахь нь амь авчирдаг. Танд тохиолдож буй нөхцөл бүрт та аль нэгээр нь ярих сонголтоо хийнэ. **Пастор Жимми Эванс:**

“Харилцаа нь хоёр хүний амьдралыг холбож, нөгөө хүнийхээ тархи ба зүрхэнд чөлөөтэй нэвтрэх эрх олгодог гүүр юм. Гэрлэлтэд харилцаа чухлаар барахгүй, амин чухал юм. ... Үгэнд гайхамшигтай хүч бий - шархлуулах юмуу эдгээх хүч, устгах юмуу барьж байгуулах хүч. Бид байгуулдаг, хүчирхэгжүүлдэг, урамшуулдаг, эдгээдэг үгсийг ярих сахилга батад суралцах ёстой” гэжээ.

Юм бүхэн өөрийн гэсэн цагтай байдгийг бид сурсан. Тиймээс ярих болон чимээгүй байх цаг байна. Түр зогсоод, ханьтайгаа учраа олох хамгийн сайн цаг, хамгийн муу цаг нь хэзээ вэ? Яагаад гэдгийг бодно уу.

Таны хань та хоёрт яг одоо тулгарч байгаа хамгийн хэцүү асуудлыг товч дүрслэн хэлнэ үү. Энэ асуудлын талаар ярихаар танаас ямар үг гардаг вэ?

Одоо залбирах цаг гарга: “Ариун Сүнс минь, би цаашид сөрөг муу үг ярьмааргүй байна. Та миний үгсийн сангаас бүх айдас, уурын үгийг зайлуулаач. Надад гэрлэлтийнхээ дээр итгэл тунхаглах тэнгэрийн хэлийг буюу эерэг үгийг өгөөч. Есүсийн нэрээр. Амень.”

Та Бурханыг таньж мэдсэнээрээ тэнгэрийн хэлийнхээ үгсийн санг нэмэгдүүлнэ. Дараах хэсгийг анхааралтай уншина уу. Тэгээд доорх ишлэл бүрээс санаа аван, гэрлэлтээ ерөөх нэг, хоёр тунхаглал бичнэ үү. Жишээ болгох үүднээс эхний ишлэлийг нь бөглөж бичлээ.

БИЧЭЭС

ТЭНГЭРИЙН ХЭЛ?

Сургаалт үгс 5:18-19: “Миний хань бид хоёр бэлгийн харилцааны сайн сайхныг эдлэж, насан турш сэтгэл хангалуун байна.”

Ефес 4:15, 29

Ефес 4:26-27

БИЧЭЭС

ТЭНГЭРИЙН ХЭЛ?

Ефес 5:21-23

Филиппой 2:3-5

Дуулал 133

1Коринт 13:4-8

Гуравдугаар өдрийн судлал

ХАНИЙХАА ХЭЛЭЭР ЯРИХ

Та нар хайрыг мөшгөгтүн. Сүнслэг бэлгүүдийг авахыг хүсэж тэмүүл. Ялангуяа эш үзүүлэх бэлгийг хүс.

- 1Коринт 14:1

Хайр олон хэлтэй. Таны хань нэгээр нь чөлөөтэй ярьдаг бол, та өөр нэгээр нь чөлөөтэй ярьдаг байж болно. “Хайрын таван хэл” номын зохиогч **Др. Гарри Чапман** ийнхүү бичжээ:

“Таны сэтгэл санааны хайрын хэл болон ханийн чинь хэл Монгол, Англи хоёр хэл шиг өөр байгаа. Та англиар хайраар илэрхийлэх гэж хичнээн хичээсэн ч, хэрэв хань тань зөвхөн Монголоор ярьдаг бол, та хоёр бие биеэ хайрлахыг хэзээ ч сурахгүй. ... Тиймээс хэрэв хайраа ойлгуулж сурмаар байгаа бол, ханийнхаа гол хайрын хэлийг сурах хүсэлтэй байх ёстой. Эцэст нь хэлэхэд, хүмүүс сэтгэлээ илэрхийлж бас хүлээж авдаг таван арга зам буюу үндсэн таван сэтгэл мэдрэмжийн хайрын хэл байдаг юм.”

Др. Гарри Чапманы хэлсэнээр, хайрын таван хэл нь магтаал сайшаалын үг, хамтдаа цаг өнгөрөөх, бэлэг, үйлчлэлийн үйлс, махан биеийн хүрэлцээ байдаг ажээ. Олон хүн - тэр дундаа бид хоёр ч унаган бөгөөд хоёрдагч хайрын хэлтэй байдаг. Энэ талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүсбэл Др. Гарри Чапманы “Хайрын таван хэл” номоос уншаарай.

Түүнчлэн таны хайрын хэлний үүрэг оройл нь таны гэрлэлтийн динамикт тоглодгийг дараах асуултад хариулсанаар мэдэж болно: Ханийн маань үйлддэг ямар зүйл надад хамгийн их хайр мэдрүүлдэг вэ? Түүний хийдэггүй ямар зүйл нь намайг хамгийн их шархлуулдаг вэ? Би ханиасаа юуг хамгийн их хүсдэг вэ? Урам, талархлын үгс, хамтдаа байх, онцгой бэлэг, махан биеийн хүрэлцээ эсвэл орон гэртээ туслах? Би ханьдаа ямар замаар хайраа хамгийн их илэрхийлдэг вэ? Бодол, сэтгэгдлээ бичнэ үү.

Таны хань бас дээрх асуултад хариулах хэрэгтэй. Тэгээд хоорондоо ярилц. Хамгийн их ялгаатай зүйл чинь юу байна?

Таны хань та хоёр хайраа өөр өөр арга замаар харуулдгийг та хоёр мэддэг байсан уу? Ялгаа нь та хоёрын гэрлэлтэд нэмэр болсон уу? Нэмэр болоогүй бол, юу та хоёрын дунд үл ойлголцол, асуудал тарж байсныг одоо та хоёр ойлгосон уу?

Та хоёр яаж хайраа харуулж, хүлээж авах тухайгаа хоорондоо ярилц. Ханиасаа “Би чамд хайраа илэрхийлэхийн тулд яг ямар бодитой зүйл хийх ёстой вэ?” гэж асуугаад, хариултыг нь бичиж ав.

Ханьдаа хайраа илэрхийлэх хамгийн сайн арга замыг Ариун Сүнснээс асуу. Таны ханийг Ариун Сүнс шиг сайн мэддэг хүн үгүй!

Дөрөвдүгээр өдрийн судлал

АМЬДРАЛАА ТЭРГҮҮЛ

Ах дүү нар аа, та нар бүгд адилхан юм ярьж, хоорондоо хагарал гаргахгүй байж, харин адил бодол, адил шүүлт дотор нягт нэгдэхийг бидний Эзэн Есүс Христийн нэрээр би та нараас хүсэмжлэн гуйя.

- 1Коринт 1:10

Эв нэгдэлд маш их хүч бий! Бурхан бидний эв нэгдлээр Өөрийг нь мэдэхгүй хүмүүст хайраа харуулдаг. Харин эв нэгдлийн хамгийн өндөр төвшин нь гэрлэлт юм. Энэ номын хоёрдугаар бүлэгт бид таны гэрлэлтийн алсын хараа, зорилгыг байгуулсан бол, одоо бид “Гэрлэлтийн түүхээ” бараг дуусгах гэж байна. Тиймээс хүлээсэн даалгавраа өдөр тутам биелүүлэхэд чинь туслах өдөр тутмын амьдралынхаа эрэмбийн талаар бодно уу.

Таны амьдралын амин чухал зүйл бол Бурхантай тогтоох харилцаа юм. Яагаад Бурханыг нэгдүгээрт тавих нь чухал вэ? Бурханыг дээдлэн хүндэтгэх нь таны хувьд ямар утга илэрхийлэх вэ? Бурхантай тогтоох эрүүл саруул харилцаа нь таны гэрлэлт, гэр бүл, ажил болон бусад бүх зүйлд яаж нөлөөлөх вэ?

Бурханаас даалгасан даалгавар, зорилгоо биелүүлэх нь хань ижил, үр хүүхэд, дуудлага, амралт, нийгмээ зөв эрэмбэ дараагаар нь байршуулна гэсэн үг. Түр зогсоод залбирна уу: “Эзэн минь, миний амьдралын эрэмбэ алдагдсан байна уу? Би хэнд эсвэл юунд хэт анхаарч байна? Би хэнийг эсвэл юуг хэт үл тоож байна? Зөв зохистой дараалал гаргахын тулд би ямар бодитой алхам хийх ёстой вэ? Бурханы илчилсэн ухаарал болон үйлдлийг бичнэ үү.

Та насан турш хань ижлээ дэмжиж, түүнд баясахаар амьдралаа зориулсан. Хүүхдүүд гэрээ орхиж, ажил өөрчлөгдөж, нөхөрлөл ирж буцавч, гэрлэлтийн гэрээ нь аль ч улирлыг даван туулахаар бүтээгджээ.

Одоогийнхоо харилцаан дээр тулгуурлабал, таны хань та хоёр амьдралынхаа төгсгөлд сайн найз байж чадах болов уу? Та хоёр бие биеийнхээ дуудлага, ажлыг дэмжихэд хөрөнгө оруулдаг уу?

Та хоёрын гэрлэлтийн амьдралдаа үйлддэг ямар зүйл чинь үнэ цэнэ авчирч, эв нэгдлийг чинь тэтгэдэг вэ? Ямар зан байдал, үйлдэл чинь та хоёрын эв нэгдлийг үгүй хийж байна?

Номлогчийн үгс 4:9; Колоссай 3:12-14-г уншина уу. Тэгээд ингэж залбирна уу:

Бурхан минь ээ, Та бид хоёрыг ариун бөгөөд хайрлагдсан байхаар сонгосон. Таны Сүнсээр ханьдаа нигүүлсэл, эелдэг, даруу, зөөлөн, тэвчээртэй хандахаад туслаач. Үг болон үйлдлээрээ ханийнхаа амьдралыг сайн сайхан болгоход туслаач. Бид ганцаараа биш, хоёулаа байхдаа дээр. Учир нь бид бие биедээ амжилтад хүрэхэд нь туслаж чадна. Бидэнд амьдралынхаа дэс дарааг зөв байршуулах цэц ухаан хайрлаач. Тийнхүү бид Таныг илүү таньж мэдэж, бие биедээ сайн үйлчилж чадна. Есүсийн нэрээр. Амень.

Тавдугаар өдрийн судлал

ХАНИА ЦЭЦЭГЛҮҮЛ

Гаднах хүмүүстэй мэргэн ухаанаар цагийг үнэлж харьц. Та нарын яриа үргэлж нигүүлсэнгүй бөгөөд давсаар амт оруулсан мэт байг. Ингэснээр та нар хүн болгонд яаж хариулах ёстойгоо мэдэх юм.

- Колоссай 4:5-6

Таны хань та хоёр нэг юм. Энэ нь та хоёр байгаа бүхнээ хуваалцана гэсэн үг. Хань чинь амжилтанд хүрбэл, та амжилтанд хүрнэ. Хань чинь үр бүтээлтэй, сэтгэл хангалуун бол, та ч үр бүтээлтэй, сэтгэл хангалуун байна. Хань ижлийнхээ сайн сайхны төлөө явсанаараа, та өөрөө сайн сайхан явна. Есүс Сүйт бүсгүй болсон бидэндээ яг ингэж ханддаг. “Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла. Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад түүнийг ямар ч толбогүй, ямар ч үрчлээсгүй бөгөөд тиймэрхүү ямар ч зүйлгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн ажээ.” (Ефес 5:25-27)

Таны хань ямар бэлэг, авьяас, хүчтэй вэ? Түүний хамгийн сайн хийдэг зүйл, юунаас ололт амжилт, таашаал авдгийг нь бод. Хүмүүс ханийн чинь юунд хамгийн их талархаж сайшаадаг вэ?

Миний ханийн бэлэг, авьяас, хүч нь...

Та ханийнхаа бэлэг, авьяас, хүчийг улам цэцэглүүлэхийн тулд яаж туслах вэ? Хань чинь бэлэг авьяастай боловч, үүнийгээ ашиглаж чадахгүй байгаа бол, бэлэг авьяас нь ямар орчинд цэцэглэхийг та мэдэх үү?

Бие биеэ хайр болон сайн үйлсэд хөхүүлэн урамшуулахад анхааръя.

- Еврей 10:24

Тиймээс бид боломж завшаантай байх үедээ бүх хүнд, юуны түрүүнд итгэлийн гэр бүлийн гишүүдэд сайныг үйлдэцгээе.

- Галат 6:10

Еврей 10:24; Галат 6:10; Колоссай 4:5-6-р ишлэлийг анхааралтай тунгаан бодно уу. Та ханийгаа цэцэглэхэд туслахын тулд ямар бодитой ажил хийж болох вэ? Өөрөөр хэлбэл та түүнийг бэлэг хүчээ хэрэглэхэд нь ямар үг хэлж эсвэл юу хийж болох вэ?

Бүх хариултаа ханьтайгаа ярилцаарай. Тэдэнд зүрхээ уудлах боломж болгож, хариултыг нь анхааралтай сонсоорой. Та хоёр юун дээр зөвшилцөж байна? Та ханийнхаа талаар болон өөрийнхөө талаар ямар шинэ зүйл сурсан бэ? Түр зогсоод, ханийгаа ерөөж залбираарай.

“Ханиа судла. Өөрийгөө судла. ... Олж мэдсэн зүйлээ хараад та балмагдаж магадгүй. ... Үнэндээ ханиа хэн болохыг таньж мэдэх нь л гэрлэлтийн адал явдал юм. Гэрлэлтийн аялалын хамаг баяр хөөр нь ханийгаа хэн болохыг олж мэдэхэд оршино.”

- Норман Врайт

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

*Мессенжер Интернэйшнэлийн “Гэрлэлтийн түүх”
сургалтын хөтөлбөрийн 6-р видео хичээлийг үзнэ үү*

1. Бурхан Адам, Ева хоёрт үржиж, газар дэлхийг дүүргэх заавар өгсөн. Адам, Ева хоёроос хэдхэн үеийн дараа Бурханы уг тушаалыг мэдэхгүй нийгэм гарч иржээ. Эхлэл 11:1-6-р ишлэлийг анхааралтай уншина уу. Хүмүүс ямар талаараа нэгэн цул болж чадсан бэ? Хэрэв дуулгаваргүй хүмүүсийн эв нэгдэл нь тэднийг амжилтанд хүргэж чадсан бол, Бурханыг дагадаг, Христийн дотор бас гэрлэлт дотор байгаа хүмүүсийн тухайд яах бол?

2. Эв нэгдэл аугаа хүч шагналыг авчирдаг. Энэ талаар танин мэдэж, тэдгээрийг нэн ялангуяа гэрлэлтийнхээ харилцаанд хэрэгжүүл: Дуулал 133; Матай 18:19-20; Иохан 17:21; 23; 2 Коринт 13:11. Хань ижилтэйгээ эв нэгдэлтэй аж төрөхөд ямар ерөөл ирэх вэ?

3. Хүний сүүлийн үг маш чухал байдаг. Есүсийн сүүлийн үг нь маш хүчирхэг эш үзүүлэл бүхий үг байжээ. Иохан 17:9-11, 20-23. Есүс энэ үгээ загалмай дээр цовдлуулахынхаа өмнөхөн залбирсан юм. Есүсийн Аавтайгаа тогтоосон эв нэгдлийг онцлон тэмдэглэнэ үү. Үүгээр Ариун Сүнс танд юу илчилж байна? Энэ нь таныг ханьтайгаа нэг байх хүслээр хөдөлгөж байна уу?

4. Бурхан бол шинэ эхлэлийн Бурхан! Тэрбээр шинэ зүйлийг хийнэ гэж тунхагласан (Илчлэл 21:5). Бурхан биднийг гэрлэлтийнхээ амьдралд шинэчлэгдсэн нөхөрлөл, найдвар, итгэл, сексийн дотносол, мөрөөдөл тээгээсэй гэж хүсдэг. Тэгвэл бид харилцаандаа шинэ байдлыг авчрахын тулд ямар бодитой алхам хийж болох вэ?

5. Сургаалт үгс 14:1 дээр ухаантай эмэгтэй гэрээ байгуулдаг гэсэн. Тэгвэл ухаантай эр эхнэрээ байгуулдаг! Эмэгтэйчүүд ээ, та нар чухам яаж гэрээ байгуулдаг вэ? Эрчүүд ээ, та нар чухам яаж эхнэрээ байгуулдаг вэ?

6. Зарим хос нэг талбарт ажилладаг байхад, зарим нь өөр өөр талбарт ажилладаг. Энэ нь тэднийг хоорондоо холбоотой байж, бие биеийнхээ дуудлага, сонирхлыг урамшуулахыг улам л дэмжиж байна. Эхнэр, нөхрүүд ямар бодитой арга замаар бие биеэ дэмжиж, холбоотой байх вэ?

Бүлгийн хураангуй:

- Христ дотор ямар ч гэрлэлт шинэ болж чадна! Түүний Сүнс талбар бүр дээр ямагт шинэ боломж өгдөг.
- Бидэнд аливаа асуудал бүр дээр тэнгэрийн хэлээр ярих уу, газрын хэлээр ярих уу гэдэг сонголт тулгардаг. Итгэлээр бид Бурханы Үгийн амлалтын дагуу ярьж, тэнгэртэй зөвшилцөж чадна.
- Гэрлэлтийн зорилго нь эв нэгдэл юм. Бид амьдралын бүх талбар дээр нэг болохын төлөө ажиллах ёстой.
- Хань ижилтэйгээ нэг болох зорилгыг мөшгихөд - нэг хэлээр ярьж, нэг даалгаврыг мөшгих үед Бурханы ерөөл ирж, боломжгүй нь боломжтой болно.
- Эхнэр нөхрийн хоорондох жинхэнэ хайр нь Бурханы алдрыг дэлхийд харуулдаг. Бидний нэгдэл бусдыг Есүс рүү дагуулдаг.
- Ухаантай эмэгтэй гэрээ байгуулж, ухаантай эр эхнэрээ байгуулдаг. Эхнэр, нөхрийн аль аль нь бие биедээ амийг ярихдаа амьдралаа тэлж, дэлхий дээр Бурханы хүслийг авчирдаг.

ХАВСРАЛТ

Авралыг хүлээн авах

*Хэрэв та Есүсийг Эзэнээ хэмээн амаараа хүлээн зөвшөөрч,
Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ
итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд
хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ.*

- Ром 10:9-10

Бурханы хайрыг ханьтайгаа хуваалцахын тулд та эхлээд Бурханы Хүү Есүс Христээр дамжуулан Бурханы хайр, авралыг хүлээн авах ёстой. Есүсийн үхэл, амилалаар дамжуулан Бурхан таныг Өөрийнхөө хайртай хүү, охин болгож Хаанчлалдаа оруулах үүд хаалгыг нээжээ. Есүсийн загалмай дээрх тахил нь танд мөнхийн, дүүрэн амийг хүлээн авах эрхийг олгосон. Аврал бол танд өгсөн Бурханы бэлэг: та үүнийг авахын тулд ямар ч гавьяа байгуулаад нэмэргүй.

Энэ үнэт бэлгийг хүлээж авахын тулд эхлээд Бүтээгчээсээ тусгаар амьдарсан гэм нүглээ хүлээн зөвшөөр (учир нь энэ нь таны хийсэн бүх нүглийн үндэс юм). Гэмшил нь аврал авахын амин чухал хэсэг юм. Үйлс ном дээр 5000 хүн аврал хүлээн авдаг тэр өдөр Петр: “Иймээс гэмшицгээ. Нүглүүдээсээ салахын тулд эргэцгээ” гэж хэлсэн (Үйлс 3:19). Хүн бүр нүглийн боол болж төрдгийг Бичээс мэдэгддэг. Энэ боолчлол нь дуулгаваргүй байдлын үлгэр загварыг тавьсан Адамын нүглээс үндэслэжээ. Гэмшил нь өөрийнхөө юмуу худлын эцэг болох Сатанаас явж, таны төлөө амиа өгсөн, шинэ Эзэн - Есүс дээр дуулгавартай ирэх сонголт юм.

Та Есүсийг амьдралынхаа Эзэн болгох ёстой. Есүсийг “Эзэн” болгоно гэдэг нь амьдралаа (сүнс, сэтгэл, бие), өөрийнхөө болон өөрт байгаа бүхнээ Есүсийн мэдэлд өгнө гэсэн үг юм. Тэр таны амьдрал дээр төгс эрх мэдлээ тогтооно. Та үхлээс амьдрал руу шилжиж - Түүний хүүхэд болно!

Хэрэв та Есүсээр дамжуулан аврал хүлээн авахыг хүсч байгаа бол, доорх залбирлыг хэлнэ үү:

“Тэнгэрийн Бурхан минь ээ, би нүгэлт хүн. Би таны зөвт жишигт хүрэшгүй, нүгэлт хүн. Нүглээсээ болж би мөнхөд шийтгүүлэх ёстой хүн. Гэхдээ намайг энэ чигээр маань орхиогүйд баярлалаа. Учир нь Та Өөрийнхөө цорын ганц хайртай Хүүг дэлхий рүү илгээж, онгон Мариагаас төрүүлж, миний ялыг үүрүүлэн загалмай дээр үхүүлсэн гэдэгт би итгэж байна. Гэхдээ Тэр гурав дахь өдрөө үхлээс амилуулагдаж, өдгөө миний Эзэн бөгөөд Аврагч болон Таны баруун гарт залран суугаа гэдэгт ч итгэж байна. Тиймээс энэ өдөр би Танаас тусгаар, дураараа амьдарсан явдлаа гэмшин, амьдралаа бүхлээр нь Есүсийн мэдэлд өгч байна.

Есүс ээ, Та бол миний Эзэн бөгөөд Аврагч! Ариун Сүнсээрээ миний амьдралд ирж, намайг Бурханы хүүхэд болгон өөрчлөөч. Би нэгэн цагт хийж явсан бүх харанхуйн явдлаа хүчингүй болгож, өнөөдрөөс эхлэн би өөрийнхөө төлөө биш, харин нигүүлслээрээ намайг амьдруулахын төлөө амиа өгсөн Таны төлөө амьдарна.

Эзэн минь, баярлалаа; миний амьдрал одоо бүхлээрээ Таны мутарт очлоо. Намайг ичгүүрт оруулахгүй гэж Таны үг хэлсэн. Есүсийн нэрээр. Амень.”

Бурханы гэрт тавтай морилно уу! Баярт мэдээгээ өөр нэг итгэгчтэй хуваалцаарай. Түүнчлэн Библид итгэдэг нутгийн чуулганд хамрагдаж, таныг итгэлийн дөрөөнд хүргэх хүмүүстэй холбогдоорой. Өдөр бүр Бурханыг болон Түүний хайрыг танин мэдэхийн төлөө бид таны төлөө залбирна!

АРИУН СҮНС



Дагалдагч нар Есүстэй гурван жил гаруй хамт байж, түүнтэй хамт алхаж, үг сургаалыг нь сонсож байлаа. Есүс дотны нөхөддөө удахгүй явах нь тэдэнд сайн гэдгийг хэлж Ариун Сүнсийг амласан байдаг (Иохан 16:7; 13-14). Дагалдагч нар өдөр бүр Есүстэй хамт байсан шиг, бид өдөр бүр Түүний Ариун Сүнтэй хамт байх нь ямар чухал вэ? Зарим хүн Ариун Сүнсийг “хачин” гэж боддог. Харин Ариун Сүнс бол ямар нэг зүйл биш харин бидний дотор байж үүрд хамт байх Нэгэн гэдгийг тодорхой хэлсэн байдаг. Чуулганд зарим талаар дутуу ойлгогдсон Ариун Сүнс Бурханыг таньж мэдэх аялалд Жон Бивэр таныг энэхүү интерактив номоороо урьж байна.

Энэхүү интерактив номд:

- Өдөр бүрийн чимээгүй цаг
- Бүлгээрээ судлах судлал
- Ариун Сүнсний талаарх сонирхолтой асуулт хариулт бүхий нэмэлт бүлэг багтсан буй.

СЭЛЭМТЭЙ ОХИД



Эмэгтэй хүнийг эд бараа шиг үзэж, бэлгийн мөлжлөг, хүний наймаа, хүчирхийллийн хохирогч болгох явдал газар авсаар байна. Сүнслэг дайсан, эмэгтэй хүнийг бүхий л талаар хүчгүй болгосоор байгаа цаг үед Лиза Бивэр Бурханы Үгийг хэрхэн судалж, түүнийг хэрэглэх талаар энэ номд өгүүлжээ. Хэрэв эмэгтэй хүн хүчирхэгжих ёстой цаг үе хэзээ вэ гэвэл одоо гэж хэлнэ.

Бурханы Үг болох сэлэм ба загалмайгаар сэлэмтэй охид хэрхэх талаар заах болно:

- Хэрхэн тэнгэрийн хэлээр газар дээр ярих
- Зуучлан залбирах гэж юу вэ
- Загалмайгаа үүрнэ гэж ямар утгатай вэ
- Ялгах чадвар гэж юуг хэлээд байна
- Дайсныхаа зэвсгийг хураана гэж юуг хэлж байна
- Яагаад эмэгтэй хүнд дайсны гол бай, харин Бурханы гол баатар болох ёстой сурах болно.

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

Таны гарт буй энэ ном бол “Гэрлэлтийн түүх” сургалтын хөтөлбөрийн гол ном юм. Энэ номыг уншиж, бусад дагалдах материалуудыг CD-ээс болон CloudLibrary.org цахим хуудаснаас татаж авч судалснаар амьдрал өөрчлөх хүчирхэг энэ сургаал таны амьдралд нөлөөлнө. Нягтлан судалж, амьдралдаа хэрэгжүүлснээр та Бурханыг улам дотно таньж мэдэх боломжтой болно.

Гэрлэлтийн түүх сургалтын хөтөлбөрт дараах материалууд багтсан болно:

- *Гэрлэлтийн түүх ном*

Энэ хөтөлбөрийн цорын ганц хэвлэмэл материал. Мөн .PDF цахим хэлбэрээр ном CD-д бий.

- *Гэрлэлтийн түүх DVD*

Сургалтын хөтөлбөрийн бүх материал зөвхөн компьютерт унших форматаар DVD дотор бичигдсэн байгаа болно. DVD доторх материалуудыг та ухаалаг төхөөрөмж болон таблет, гар утас, компьютертээ суулгаж үзэх боломжтой.

- *Гэрлэлтийн түүх сонсдог ном*

Гэрлэлтийн түүх ном .mp3 форматаар байгаа.

- *Гэрлэлтийн түүх видео хичээл*

Нийт 6 хичээл .mp4 форматаар байгаа.

- *Гэрлэлтийн түүх аудио хичээл*

Нийт 5 хичээл .mp3 форматаар байгаа.

- *Нэмэлт материал*

Ариун Сүнс сонсдог ном болон Жон Бивэрийн бусад цахим ном

ЭНЭ БҮХ НОМ МАТЕРИАЛ НЬ ТАНД ӨГЧ БҮЙ БЭЛЭГ ЮМ



DVD доторх материалыг худалдааны зорилго бусаар, чөлөөтэйгээр, бусдад тарааж, хуулж, олшруулж болно. Сургалтын алив материалдаа хуулж эш татаж ашиглаж болно. Цахим болон цаасан хэлбэрээр тарааж болно. Бурханы Үгээр цангаж байгаа бүхэнд та үүнийг дэлгэрүүлээрэй.

Гэрлэлтийн түүх сургалтын хөтөлбөрийн талаарх бусад мэдээлэл:

- *Гэрлэлтийн түүх ном*

Энэ хөтөлбөрийн цорын ганц хэвлэмэл материал. Мөн .PDF цахим хэлбэрээр ном CD-д бий.

- *Гэрлэлтийн түүх DVD*

Сургалтын хөтөлбөрийн бүх материал зөвхөн компьютерт унших форматаар DVD дотор бичигдсэн байгаа болно. DVD доторх материалуудыг та ухаалаг төхөөрөмж болон таблет, гар утас, компьютертээ суулгаж үзэх боломжтой.

- *Гэрлэлтийн түүх сонсдог ном*

Гэрлэлтийн түүх ном .mp3 форматаар байгаа.

- *Гэрлэлтийн түүх видео хичээл*

Нийт 6 хичээл .mp4 форматаар байгаа.

- *Гэрлэлтийн түүх аудио хичээл*

Нийт 5 хичээл .mp3 форматаар байгаа.

- *Нэмэлт материал*

Ариун Сүнс сонсдог ном болон Жон Бивэрийн бусад цахим ном

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

СУРГАЛТЫН ДИСК



Энэ дискэнд буй материалуудыг компьютерт үзэж болохыг гадна бусад материалуудыг та дорждохим хэлгээс татаж авах боломжтой.
www.CloudLibrary.org

Messenger
International
MessengerInternational.org
Зөвхөн компьютерт

ЖОН ба ЛИЗА БИВЭР



Энэхүү сургалтын материалтай диск нь Жон ба Лиза Бивэрээс танд хувиасаа өгч буй бэлэг юм. Илүү гүн гүнзгий суралцаж болох бусад материалуудыг энэ дискэнд багтаасан байгаа болно.

Та энэ дискэнд буй материалыг хүссэн хэмжээгээрээ, хүссэн хүндээ хувилж тарааж болохоос гадна энэхүү цахим материалыг емэйлээр, интернэтээр хүргэж боломжтой. Итгэгч хүн бүрт энэ сургаалыг хүргэх зорилгоор энэ дискийг бүтээсэн юм.

Та дараах цахим хуудаснаас Жон ба Лиза Бивэрийн бусад материалуудыг Монгол болон өөр олон хэлээр хүлээн авсарай.

www.MessengerInternational.org
www.CloudLibrary.org

Та нэмэлт материалуудыг Youtube.com болон Youku.com гэх мэт цахим хуудаснаас хүлээн авах боломжтой.

ЭРТ УРЬДЫН ЦАГТ ...

Гэрлэлт бол үүрд мөнхийн зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйд холбож зангиддаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоос тэднийг анх бүтээгдсэн зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй.

Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй нандин үйл явдал билээ. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөцсөн нөхөр эхнэр хоёр тааж мэдэх аргагүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа босгоно.

Гэхдээ бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл, „Гэрлэлтийн түүх“ номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, сүй тавьсан байна уу - Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг билээ.

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ СУРГАЛТЫН DVD ДОТОР БУЙ МАТЕРИАЛ:



Жон, Лиза хоёр нь шилдэг зохиолчид төдийгүй, Мессенжер Интернэйшнэл олон улсын байгууллагыг үүсгэн байгуулсан хос юм. Тэд гуч гаруй жил ханилжээ. Тэд энэхүү номоороо гэрлэлтийнхээ жаргал зовлон, ялалт ялагдлаа уншигч та бүхэнд дэлгэж байна. Жон, Лиза хоёр Колорадо Спрингст дөрвөн хүү, бэрүүд, гурван ачтайгаа аж төрөн суудаг.

Бусад материалуудыг татаж аваарай : www.CloudLibrary.org



Messenger
International®
CloudLibrary.org

Энэ ном бол бэлэг бөгөөд
худалдаахыг хориглоно.

